

Г.УЭЛЛС

ҮЛ ҮЗЭГДЭГЧ ХҮН

ХАЧИН ХҮН ИРЛЭЭ

Өвлийн сүүлчийн цас ордог хоёрдугаар сарын тэр нэгэн өдрийн өглөө цас будран , салхи сүүгэж байхад төмөр замын Брэмблхерст өртөөн дээрээс зузаан бээлийтэй гартаа жижигхэн хөвхөн хайрцаг барьсан нэг танихгүй хүн явган хүрч иржээ.Тэр хүн өвч биеэ бин битүү, жин тан дулаалсан тул гагцхүү нарийн цэмбэн малгайн дэлбэгэр хүрээн дотроос хамрых нь үзүүр л цухуйх ажээ. Дал мөр, энгэр заам, барьсан тээш нь нил цас. Тэр хүн “Сүйх тэрэг ба морьд” гэдэг буурчийн газар дөнгөж голтой юм орж ирээд

- Гал хөс, дулаан орон хайрлаач, осгох нь гэж чанга хэлээд хувцас хунарынхаа цасыг гүвлээ. Тэгээд байрны хөлс хэлэлцэн тохирохоор Холл авгайг даган зочных нь өрөөнд оров. Олон таван юм ярилцсан ч үгүй хоёр алтан зоос гаргаж өгөөд л байрлах боллоо.

Холл авгай галы нь ноцоож, өөрийн гараар хоол унд бэлдэж өгөхөөр гарлаа. Өвлийн цагаар Айпингэд гийчин ирж буух, тэгэх мөртлөө үнэ маргадаггүй тийм зочин ирнэ гэдэг урьд хожид дуулдаагүй их завшаан учир Холл авгай нэр төрөө бодохыг хичээжээ. Юуны өмнө гахайн мах шарж өгсөн байна.

Хэзээний мунгинуун шивгэчин хүүхэн Милли ч яахав эзэгтэйн амнаас егөөдсөн хорон үг баахан сонсоо л биз. Авгай өөрөө ширээний бүтээлэг, аяга таваг, хундага жүнз сэлтийг зэхэн зочныхоо өрөөнд орж, их л ёсорхож хичээнгүйлэн ширээ заслаа. Гал дүрэлзэн өрөөнд дулаан байвч гийчин нь малгай бээлийгээ авч, дээлээ тайлалгүй лавсах цасыг цонхоор ажиглан зогссоор байхыг Холл авгай ажаад баахан гайхав.

Бээлийгээ ч тайлахгүй нуруугаа үүрэн гүн бодолд автсан янзтай харагдана.Мөрөн дээрх цас нь хайлж шалны хивсэн дээр бөнжигнөн дуслахыг харсан эзэгтэй:

- Таны малгай, дээлийг гал тогооны өрөөнд аваачиж сайхан хатаагаад өгөх үү дээ, эрхэм ээ? гэхэд гийчин нь эргэж ч харалгүй
- Хэрэггүй ээ гэж ээ.

Хоол авгай чихэндээ ч итгэлгүй дахин асуухыг завдтал цаад хүн нь эргэн харж – Би хувцастайгаа л баймаар байна гэв.

Шанаавчтай, цэнхэр өнгийн нүдний шил зүүсэн байв. Нүүрий нь нэл бүрхсэн үс, хууз сахал пальтоных нь захан дороос ч цухуйна.

- Та дураараа бол, энэ өрөө маань ингээд бүр дулаахан болно гэж

авгай хэллээ. Цаадхи нь хариу үг дуугаралгүй цааш эргэсэн тул Холл авгай өдийд яриа хөөрөө болох цаг болоогүй юм байж дээ гэж бодоод бушуухан ширээг нь засаад гарч одлоо. Буцаад ороод ирэхэд нөгөө хүн түрүүчийн хэвээр чулуун хөшөө шиг бөгтөсхийн зогсож байжээ. Зах нь босгоостой, чих нүүрийг нь бараг тагласан бүрх малгайны дэлбэгэр хүрээнээс ус дусалсаар ажээ. Холл авгай өндөг, гахайн мах авчирч ширээн дээр нь их л хичээнгүйлэн тавиад:

- Таны хоол бэлэн боллоо шүү, эрхэм ээ гэж зориг муутайхан

хэлэхэд гийчин нь баярлалаа гэсэн боловч авгайг гаран гартал хөдлөлгүй зогссоор байж гармагц нь эргэн харж шүлсээ залгин ширээнд ирж суулаа. Халбага таваг хавиралдан тян –тан чимээ гарахыг гал зуухныхаа өрөөнөөс сонссон Холл авгай:

- Ай лүд! Таг мартчихаж. Энэ шивэгчин хүүхэн ийм л бөгсөө дааж ядсан

мунгинуу новш доо! гэж хэлээд гич, цуу бэлдэж дуусгах зуур Миллийг загнаад -Өндөг, гахайн мах шарж болгоод ширээ засаж цөмийг амжуулаад байхад ганцхан цуу ч бэлэн болгочихдоггүй мөн дүүрчихсэн амьтан шүү! Шинэ гийчин ирж, өнжиж хонох гэж байхад ингэж алах уу даа! гэнэ.

Тэгээд Холл авгай гийчний савыг дүүргээд алтадмал хар өнгийн цар дээрээ тавьж намбатайхан алхсаар гийчнийхээ үүдэнд очиж тогшсоноо бушуухан орж очвол гийчин нь ширээнийхээ цаад руу нэг цагаан юм сандруухан нууснаа, бөхийн шалан дээрээс юм авч буй дүр үзүүлэв. Холл авгай гичтэй саваа ширээн дээр тавиад ажиглавал гийчин нь малгай дээлээ тайлаад галын хажуу дахь сандал дээр тавьсан байна. Нойтон хос гутал нь зуухны хасгийг муухай болгох осолтой байлаа. Холл авгай хувцас хунар луу нь шийдэмгийхэн хүрч очоод хулгалгүйгээр:

- Би таны хувцсыг одоохон хатаагаад өгөх үү? гэв.
- Малгайгий минь орхичих гэж гийчин битүүлэг дуугаар хэлэхэд

авгай эргэж харвал тэр нь өлийсхийгээд өөрий нь ширтсэн байлаа.

Холл авгай гайхаж гөлрөөд нэг хэсэг юу ч хэлж чадсангүй.

Нөгөө хүн өөрийнхөө авчирсан цагаан даавуу, алчуураар ам хамраа таглавал уруул ам огт харагдахгүй, дуу нь бүдэг болов. Гэвч Холл авгай энүүнээс нь болж их гайхсан бус гэнэ.

Нүднийхээ шилнээс дээш, бас хоёр чихээ цагаан даавуугаар ороосон учир улаан шонтгор хамраас бусад нь харагдахгүй байгааг үзээд гайхсан ажээ. Гийчний хамар түрүүчийнх шигээ ув улаан, гялалзсан хэвээр байлаа.

Хар хүрэн хилэн гадартай богино дээлийнхээ өндөр хар захыг босгожээ. Ороосон даавууных нь завсар хоорондоос өтгөн хар үс дэл сүүл шиг цухуйж дүр байдлыг нь жигтэйнхэн болгожээ. Холл авгай зочны толгойг тийм гэж бодоогүй болохоор гэнэт үзээд нэг хэсэг мэл гайхжээ.

Алчуураа хүрэн бээлийтэй гараар барьсаар бөгөөд цэнхэр шилтэй нүдээрээ ширтэн байлаа. “Малгайгий минь орхичих” гэж гийчин амаа таглаастай хэвээр хүнгэнэв.

Холл авгайн айж тэвдэх жаал гайгүй болж сэхээ ороод малгайгий нь зуухны дэргэдэх сандал дээр буцааж тавиутаа

- Би мэдсэнгүй шүү, эрхэм ээ би ... гэж хэлээд зовсон байдалтай

дуугүй болов.

- Гялайлаа гэж өнөөх хүн жишим ч үгүй хэлээд үүд рүү харснаа дахин

өөрий нь харав.

- Би сайн хатаачих уу, эрхэм ээ гэж Холл авгай хэлээд хувцсыг нь авч

гарахдаа түүний цагаан боодолтой толгой, цэнхэр шил рүү харвал тэр хүн алчуурыг нүүрнээсээ салгалгүй хэвээр байх харагдана. Авгай үүд хаахдаа бүх бие нь чичирч сандарсан нь царайнаасаа андашгүй байв.

“Би ийм юм ер үзсэнгүй” гэж шивнэсээр гал тогооныхоо өрөөнд сэмхэн алхаж орохдоо элдвийн юм бодож байсан тул Миллигээсээ “ Чи одоо юу хийгээд мунгинаж байна“ ч гэж асуусангүй.

Гийчин Холл авгайн хөлийн чимээ чагнан суухдаа цонх руу сэжиглэсэн байдалтай хяламхийв. Алчуураа тайлж нэг зүсэм мах үмхсэнээ дахин цонх руу хяламхийгээд бас нэг огтолж үмхэв. Тэгснээ босож алчуураа барьсаар өрөөн дотуур холхисноо цонхны дэргэд очоод дээд талын хөшгийг цонхны доод талын цагаан хөшиг хүртэл татаж буулгав.

Ингэтэл өрөөнд нь бүдэг бадаг болсонд сая нэг сэтгэл амарсан бололтой эргэж ирээд хоолоо идэж гарав.

- Хөөрхий энэ хүн зовлонд учраад мэс засал хийлгэсэн байж

магадгүй. Толгойгоо ороосон боолтноос нь хичнээн айв! гээд Холл авгай галдаа жаахан нүүрс хаяж, дээлийн өлгүүр суллан гийчний дээлийг өлгөх зуураа “Нүдний нь шилийг! Энэ ер нь жирийн хүн биш усанд шумбадаг хүн шиг харагдах юм” гэж бодов. Холл авгай гийчний хүзүүний ороолтыг өлгүүрт өлгөөд “Амандаа алчуур бариад ер салахгүй юм. Ярьсан ч хэвээр байна... Ам нь гэмтсэн юм болов уу” гэж үглэснээ гэнэт мартсан юмаа санах мэт давхийн эргэж, эрс ондоо юм руу орж – Ай, үйлс нь харла! Төмсөө болгож бас л гүйцээгүй байна уу, Милли? гэв.

Холл авгай гийчний өрөөг арчиж цэвэрлэхээр орохдоо нөгөө хүний ам

нь гэмтэж муухай болсон байх гэж бодож, тааварласан нь улам лавшрав. Авгай гийчний өрөөнд ороход цаадхи нь тамхи татаж байлаа. Гэтэл эрүү амаа тагласан торгон алчуурыг авгайг гаран гартал ер авсангүй, соруулаа ч уруулдаа хавьтуулсангүй. Мартчихаад тэр үү гэхэд тийм биш, тамхиныхаа улалзаж байгаа гал

руу байн байн хяламхийх ажээ. Гийчин өрөөний буланд цонхны наахна сууж тэр тохилог дулаан өрөөнд хоол, унд ууж идээд дулаацсан хойноо түрүүчийнх шиг огцом ширүүн биш дуугаар яриа үүсгэв. Хүйтэнд ёозгүй гялалзаж байсан том шил нь галын улбар туяанд гэрэлтэж зүгээр ч юм шиг харагдана.

- Миний жаал зугаа юм Бремблхерст буудал дээр байгаа юмсан, хүн

явуулчих аргагүй юу? гэж гийчин асууснаа Холл авгайн хариуг сонсоод боолттой толгойгоо эелдэгээр дохиутаа

- Маргааш гэнээ? Маргаашнаас наана амжуулж болохгүй юу? гэснээ

авгайгаас бүтэмжгүй үг дуулж урам нь хугарах шиг боллоо.

- Т а л а в мэдэж байгаа биз дээ? Тэрэгтэй хүн явуулчихаж болохгүй гэж

үү?

Холл авгай асуусан юманд нь уйгагүй хариулж, жаал яриа дэлгэх

санаатай байв. Тэгээд тэрэгний тухай сонирхсны нь далимдуулан:

- Манхан дундуур дайрч наашаа ирдэг зам зарим газраа тун огцом

байдаг юм, эрхэм ээ, нэг жилийн өмнө бил үү, бүр урьд нь ч билүү энүүхэнд нэг тэрэг онхолдож орхисон юм. Сууж явсан хүн, улаач хоёулаа үхсэн. Гай ч ганцхан мөчийн дотор л дайрна шүү дээ. Тийм ээ, эрхэм ээ? гэлээ. Гэхдээ гийчинтэй илэн далангүй яриа дэлгэх гэдэг тийм ч амаргүй ажээ. Холл авгайн өөдөөс зузаан шилтэй нүдээрээ тайван хараад алчуураа амандаа барьсаар

- Гай дайрах явдал байдаг аа гэж дурамжхан дуугарав.

- Тэгж гэмтсэн улс амархан эдгэдэггүй!. Тийм ээ, эрхэм ээ? Миний

эгчийн хүү Томыг хар л даа. Тэргэн дээрээс хадуур дарж ойчоод гараа огтолчихсон юм. Тэгээд яасан гэж санана. Гурван сар боодолтой явсан шүү, эрхэм ээ. Үнэмшинэ гэхэд бэрх, түүнээс хойш хадуур гэхээс л үхтлээ айх болсон юм даа, эрхэм ээ.

- Аргагүй шүү дээ. тэгэлгүй яахав.

- Бие нь нэг үе их муу байсан болохоор бид хагалуулбал дээр байх

гэж боддог байлаа.

Гийчин гэнэт инээд алдаад болих нь нохой хуцах лугаа төстэй мэт

ажээ.

- Тэгсэн гэж үү?

- Нээрэн үнэн шүү, эрхэм ээ! Түүнээс болж би бүр ажилд дарагдаад

инээхтэй мантай байсан юм. Эгч минь хэдэн хүүхэдтэйгээ зууралдаад би л өнөөхийн чинь толгойг боож засаж аялуулдаг байсан. Ингэхлээр би болдогсон бол, ноёнтон минь, зүрх гаргаж анхааруулахад, эрхэм минь ... гэтэл гийчин үгий нь гэнэт таслан

- Танд шүдэнз байна уу? Тамхи минь унтарчихжээ гэв.

Холл авгай аягүйрхэн таг болов. Хүн ингэж байдаг чадлаараа санаа

тавьж байхад иймэрхүү зан гаргах дэндүү найгүй хэрэг биш үү? Авгайн зэвүү хүрч гийчнээ муухай харснаа өнөөх хоёр алтан зоос санаанд нь орж чүдэнз авчрахаар гарав. Чүдэнз авчраад өгөхөд гийчин гялайлаа гэж огцомхон дуугараад цааш эргэж дахин цонх руу харав. Хагалах, боох тухай яриа зочны сэтгэлд аятайхан санагдаагүй бололтой. Холл авгай дахин зүрх гарган анхааруулсан ч үгүй, гийчин ч үг дуугаралгүй тас дайраад байсанд авгайн дургүй хүрч, лайгий нь Милли л оройжингоо амсжээ. Гийчин дөрвөн цаг хүртэл өрөөнөөсөө гаралгүй суухдаа хүн орох шалтаг ер гаргасангүй. Өрөөндөө их төлөв чимээ аниргүй, бүрэнхий болж байхад галын дэргэд тамхиа татаж суугаа ч юм уу, зүүрмэглэж байгаа ч юм уу гэмээр байв. Сонирхсон хүнд бол нэг хоёр удаа гал засаад өрөөн дотуур таван минут хэртэй холхиж яваа чимээ дуулдсан билээ. Бас ганцаараа ярьж байх шиг, тэгээд сандал шархийх чимээ гарч дахин суух шиг болжээ.

ТЕДДИ ХЭНФРИЙН

АНХНЫ СЭТГЭГДЭЛ

Дөрвөн цагт их харанхуй болох үеэр гийчнийг цай уух уу, яах вэ гэж асуухаар оръё гэж Холл авгай зориг шийдээд байтал цагчин Хэнфри тэднийд орж ирээд:

- Яасан муухай өдөр вэ? Холл авгай минь би ядахнаа дулаан хувцас

өмсөөгүйг хэлэх үү гэв.

Цас улам ширүүсэж байлаа. Холл авгай тэнгэр үнэхээр муухай байгааг зөвшөөрөөд гартаа барьсан савы нь ажиглаж: - Тедди гуай, ирсэн тань сайн болж, манай зочны өрөөнд байдаг цагийг үзэж өгөхгүй юү? Явах нь явж, дуугарах нь гайгүй сайн байх юм, гэтэл зүү нь зургаа дээр зогсоод ердөө хөдлөхгүй юм гэв. Авгай цагчныг дагуулж очоод зочны өрөөний хаалгыг тогшин үүдийг нээхэд зочин нь галын дэргэдэх зөөлөн сандал дээр суучихсан, боолттой толгойгоо унжуулан зүүрмэглэж байх шиг байжээ. Гагцхүү галын улбар туяа өрөөг муухан гэрэлтүүлнэ. Бүрэг бараг улбар туяатай өрөөнд юм хум сайн харагдаж өгөхгүй, тэгээд ч Холл авгай сая өрөөнийхөө дэнг асаагаад гэрэлтэй газраас ирсэн болохоор нүд нь харанхуйд дасаагүй байв. Хартал, нөгөө хүн санаанд багтамгүй лут нүүрнийхээ доод хэсгийг эзэлсэн муухай том амаа ангайж байх шиг боллоо. Цагаан юмаар боосон толгой, аймаар муухай бүлтийсэн нүд, харанхуйлж харласан ам эл бүгд эгшин зуур харагдаад өнгөрөв. Гийчин ухасхийн хөдөлж сандал дээрээ эгцлэн суугаад нэг гараа дээш нь өргөв. Холл авгай тасалгааг улам гэрэлтэй болгох гэж хаалгыг цэлийтэл нээхэд гийчин нэлээд тод харагдан

түрүүнд нь амандаа алчуур барьж байсан бол одоо хүзүүнийхээ ороолтыг барьжээ. Харанхуй болоод л тэгж харагдсан байх даа гэж Холл авгай бодсоноо төдхөн сэхээрч:

- Цагчин орж, цаг үзвэл яах вэ? Та дургүйлхэхгүй биз? гэхэд

гийчин амаа таглан:

- Цаг үзэх ээ? гэж асуугаад нойрмог маягтай эргэн тойрон харснаа,

нойр нь нэлээд сэргэх бололтой: -тэг тэг гэв.

Холл авгай дэнлүү авчрахаар гарахад гийчин босож суниав. Гэрэл асаж Тедди Хенфри орж ирээд, толгойгоо боосон тэр хүнтэй яг тулгарав. Хожим цагчин өөрөө ярихдаа “яггүй цочсон” гэжээ.Танихгүй зочин өөдөөс нь хар шилнийхээ цаанаас “ хар алгана” шиг хачин ширтэж “Сайн байна уу?” гэсэн гэжээ.

- Би танд саад болоогүй байгаа даа? гэж Хенфри асуухад цаадхи

нь:

- Хаанаас даа гэснээ Холл авгай руу эргэж- Гэхдээ би энэ өрөөг миний мэдэлд байгаа гэж бодож байна шүү гэв.

Холл авгай

- Цаг явж байхад танд л зүгээр бол уу, ноёнтон... гэтэл гийчин авгайн үгийг тасалж:

- Тийм нь ч тийм. Гэсэн ч би ганцаараа баймаар байна. Ер нь тэгээд хэнийг ч гэсэн бүү саад болооч гэмээр байна гээд буруу харж нуруугаа үүрэн зогссоноо:- Цаг засаж дууссаны дараа цай уумаар байна. Цаг засаж дуусахаас нааш хэрэггүй шүү гэв.

Холл авгай энэ удаа гийчинтэйгээ яриа дэлгэх гэвэл Хенфрийн нүүрэн дээр эвгүй байдалд орж магадгүй гэж бодоод гарч одохыг завдтал, гийчин нь Бремблхерст буудлаас юмы минь авчруулсан уу гэж асуусанд авгай, шуудан зөөгчид хэлсэн л юмсан. Маргааш өглөө аваад ирнээ гэв.

- Тэрнээс нааш тун горьгүй юм биз дээ? Нэлээд ёозгүй байгааг нь авгай ажжээ.

- Би тун их даарч бээрээд юм ярихтай мантай байлаа. Уг нь би туршлага хийдэг эрдэм шинжилгээний хүн юм гэж: гийчин тайлбарлав.Түүний үг Холл авгайд сүртэй жинтэй санагдаж:

- Ээ тийм юм бий, ноёнтон минь гэв.

- Юман дотор маань аппарат сэлтээс өгсүүлэн элдэв багаж

хэрэгсэл бий.

- Лав их чухал юм байгааг нь би ойлгож байна, ноёнтон минь гэж Холл авгай хэлэв.

- Ажлаа бушуухан үргэлжлүүлэхсэн.

- Тэгэлгүй яах вэ, ноёнтон минь

- Айпингэд миний ирсэн учир гэвэл ... Ганцаараа байхыг эрмэлзсэн юм. Ажилд маань хүн саад болоход би дургүй байна. Ажлаас гадна гай болж ... гэж зочин үг бүрээ цэгнэн хэлэв.

“Би тэгэж бодсон юм” гэж Холл авгай дотроо бодов.

- Хааяа ганцаар байх хэрэг гарах юм. Нүд маань эдгэх яагаа ч үгүй, үе үе айхтар өвдөх нь харанхуй газар л түгжиж аваад удаан суухаас өөр аргагүй болдог. Тэр болгон арай ч тэгээд байдаггүй юмаа. Зарим үед ялимгүй юм болох, гаднаас хүн гэнэт ороод ирэх төдийд тун айхтар цочдог юм... Үүнийгээ л би танд сайн ойлгуулмаар байна гэлээ.

- Аргагүй байлгүй, эрхэм минь. Би нэг юм асуувал яана гэж Холл авгай хэлтэл, гийчин үгийг нь тас дайрч, түрүүчийнх шигээ маргахын эрхгүйгээр:

- Ингээд л болох биз ээ гэж эрсхэн дуугарав. Холл авгай юм

асуух тохиромжтой цагийг хүлээн хойшлуулж өрөвч сэтгэлээ илэрхийлэв.

Эзэгтэйг гарсан хойно тэр хүн галын хажууд зогссон хэвээрээ цаг засахыг ажиж байсан гэж Хенфри хожим ярьжээ. Цагчин дэнлүү ойртуулж тавиад ажиглахад дэнлүүний бүдэг ногоон гэрэлд цагны хүрээ, эрэг шураг, зүү, цагчны гарыг гийгүүлж тасалгааны бусад хэсэг бүрэг бараг болов. Цагчин дээш харвал нүдэнд янз бүрийн гэрэл цацарна. Цагчин угаас их сониуч, хэрэгт дуртай хүн байсан болохоор өрөөнд жаал саатах, чадвал нөгөө хүнтэйгээ яриа дэлгэх санаатай цагийн механизмийг дэмий задлав. Гэтэл цаад хүн урьд нь хөдлөхгүй дуугүй зогссоор л байна. Тэгж огт хөдлөхгүй байх нь Хенфрид аягүй санагдлаа. Тасалгаанд ганцаараа байгаа мэт санагдах болсонд нүдээ өргөж харвал боолттой толгой өмнө нь бараалан сүүмэлзэж, өөдөөс том хар шил гөлрөн ширтээд өөрийнх нь нүд эрээлжлэн шар туяа манарав. Хенфрийн биеэ зарсхийх шиг болж, хоёулаа хэсэг зуур бие биеэ ширтэхэд Хенфри дальдарч дахин доош харав. Яасан ч аягүй юм бэ! Нэг юм хэлэхсэн. Энэ жил цаг хатуу, хүйтэн байна гэж хэлдэг юм бил үү гэж бодоод туршиж үзэх санаатайгаар өөдөөс нь харж:

- Тэнгэр ... гэж эхэлтэл хөдөлгөөнгүй зогсох цаадхи хүн уураа арай ядан барьж байгаа бололтой:

- Та ажлаа бушуухан дуусгаад явахгүй яасан хүн бэ? Та наад

цагныхаа зүүг голтой нь бөхлөөд гүйцэх байсан, гэтэл дэмий энд мунгинаад байна шүү дээ гэв.

- Одоохон явлаа, эрхэм минь. Би бүр мартчихаж...

Хенфри ажлаа дуусгаад гарав. Гэвч гарсан хойноо маш их зэвүүрхжээ. Хенфри тосгон дотуур шуурга сөрж явахдаа:

“Хай бүү мэд, чөтгөр, цагий чинь хааяа засах л болно шүү дээ. Хүн харахад яагаад болдоггүй юм? Зэвүүн хог вэ?” гэж ганцаар үглэн алхана. “Болдоггүй байж ч болох юм даа. Хэрэв цагдаагийн газар чамайг мөрдөж байгаа бол үүнээс илүү яаж ч боож баглах билээ дээ.” гэж дахин үглэнэ.

Хенфри, Глисений байшингийг дэргэд саяын хүн суусан” Сүйх тэрэг,морьд” гэдэг буудлын эзэгтэйтэй гэрлээд удаагүй байгаа Холл байхыг олж харав. Холл одоо Айпингийн өртөөний тэргэнд улаач хийж, тохиолдсон хүмүүсийг замыг уулзвар буудал Сиддербрижд хүргэх болжээ. Одоо бас өртөөн дээрээс буцаж яваа нь энэ аж. Тэргээ жолоодож яваагийн нь харвал өртөөн дээр “жаахан балгасан” бололтой. Хажуугаар өнгөрөхдөө: За хө, юу байна, Тедди? гэж дуудав. Тедди хариуд нь – Танайд нэг хачин эр буужээ гэхэд Холл юу болсныг сонирхох гэж жолоогоо татан:

- Юу гэнээ? Гэхэд Тедди:

-Танайд хачин гийчин ирсэн байна.Зочин л юм даа хөөрхий! гээд Тедди тэднийд ирсэн хачин зочных нь дүр байдлы нь сүрхий гаргаж: - Үнэндээ зүсээ буруулсан гэмээр юм, хөөш! Манайд хүн ирж буулаа гэхэд би л лав царай зүсийг нь үзнэ гэх юм байна. Бүсгүйчүүд гэдэг чинь танихгүй хүнд итгэмтгий амьтан шүү дээ. Танайд ирээд бууж дээ. Тэгсэн мөртлөө нэр усаа ч хэлээгүй байх юм, Холлоо гэв.

Холл угаас сүрхий хурц ухаантай хүн биш болохоор:

- Та арай хэтрүүлж байгаа байлгүй гэхэд Тедди:

- Нээрэн, долоо хоногийн өмнө мөнгө төлсөн гэнэ.хэн ч байсан дүүрч дээ. Лав л долоо хоногтоо салж чадахаа өнгөрчээ. Их юмтай яваа хүн юм байх. Маргааш авчруулах юм гэнэ. Хайрцагт нь чулуу л битгий байгаасай. Ай бүү үзэгд, Холл минь гэв.

Тэгээд урьд хоосон хайрцаг савтай ирсэн нэг танихгүй хүнд Гастенгит суудаг эгчээ хэрхэн залилуулсныг, мань хүн Холлд ярьж өгөв.

Холл нэлээд сэжиг авч, хөдлөхдөө:

- За адсага минь явж үз. Очиж янзы нь үзэлгүй горигүй юм шиг

байна гээд морио турхирлаа.

Теддийн дотор овоо онгойх шиг болж цааш алхав. Холл очиж “янзы нь үзэх” нь бүү хэл харин Сиддербрижид их удлаа гэж эхнэртээ толгойгоо эргэтэл загнуулав. Нөгөө гийчний тухай жаахан асуугаад орхисон чинь бас баахан загнуулжээ. Гэсэн ч Теддийн төрүүлсэн сэжгийн үр Холлын санаанд хадагджээ. Холл гийчнийхээ учир байдлыг аль болох түргэн мэдэж авахыг бодож –Бүсгүйчүүд та нар ер юмны учрыг бүрэн мэдэх биш гэжээ.

Оройн есөн цаг хагасын үед гийчнийг нойрссон хойгуур Холл, унтлагын өрөөнд зоримог нь аргагүй орж, эхнэрийнхээ тавьц төхөөрөмж сэлтийг эндэхийн эзэн нь зочин биш би гэдгээ үзүүлэх гэсэн байртай хянуур гэгч эрэгцүүлэн хараад түүний орхисон нэг сэжигт тоо бодлого бодсон хуудсыг авч нэлээд харав. Холл унтахын өмнө тэр хүний маргааш өглөө ирэхээр сайн ажиглаарай гэж эхнэртээ захиад цаадхи нь: - Чи ч хувиа хичээ, би ч хувиа хичээе, Холл минь гэв

Гийчин үнэхээр хачин хүн, тэгээд чухам ямар хүн болохы нь Холл авгай сайн мэдэж чадахгүйдээ дотроо бухимдаж нөхөртөө ийнхүү ширүүн аашилж байлаа.

Холл авгай шөнө дунд лут том манжин хэлбэртэй толгойнууд учир тоймгүй урт хүзүүгээ сунган ойртоод, муухай том хар нүдээр өөдөөс ширтэж байна гэж зүүдлэн сэржээ. Гэвч яггүй ухаалаг хүн болохоор айдсаа дарж орондоо хөрвөснөө төдхөн дугжирчээ.

МЯНГА НЭГЭН ХОНХ

Тийнхүү хаврын урь дөнгөж орсон хоёрдугаар сарын есний тэр нэг өдөр энэ хачин хүн Айпингэд газрын хаанаас гараад ирэв гэмээр гэнэт хүрч ирсэн ажээ. Маргааш өглөө нь түүний юмыг шавар шавхайн дундуур арай чарай авч ирсэнийг бодоход овоо дорвитой ачаа байсан бололтой. Аливаа аяны хүний авч явдаг хоёр гурван хөвхө н хайрцагнаас гадна бас голдуу нэг их амар гаргагдахааргүй бичигтэй том том зузаан ном хийсэн хайрцаг байв. Тэгээд бас арваас цөөнгүй жижиг сагс, хайрцаг саванд сүрлээр ороосон юм хийжээ. Хэрэгт дурлан онгичиж үзэхэд дотор нь шил савууд л байх шиг санагджээ. Нөгөө хүн дээл, малгай, бээлийтэй хэвээр Фиренсайдын тэргийг угтан яаруу гарч ирэв. Холл юм хүмнээс нь оруулалцах санаатай улаачтай яриа дэлгэн зогслоо. Гийчин, Холлын хөлийг залхуу нь хүрсэн янзтай үнэрлэж байсан Фиренсайдын нохойг ч ажигласангүй.

- Бушуухан оруулалцаад өгөөч, хичнээн хүлээв дээ гэж хэлээд

тэрэгний хойд талд ачаастай байсан жижиг сагснаас өөрөө нэгийг оруулах гэсэн бололтой довжооноос буулаа.

Гэтэл нохой түүний барааг хармагц үс өрвийлгөн арзасхийн муухай архирснаа, ойртон ирмэгц нь хулгасан маягтай байснаа гэнэт ханцуйнаас нь хавхийн үмхлээ.

Холл нохойноос угийн их айдаг хүн болохоор уулга алдаж хашхираад гэдрэг огло харайв. Фиренсайд

- Хэвт! гэж зандраад ташуураа далайв.

Нохой бээлийтэй гары нь тавихад гийчин түүнийг өшиглөв. Нохой огло үсрэн, ухасхийн доогуур дайрахад нөгөө хүний өмд хүүрэх чимээ гарчээ. Фиренсайд ташуураараа ороолгоход нохой муухай гаслан тэргэн доогуур оров. Энэ бүх байдал агшин зуур л болох нь тэр. Хүн бүхэн хүүе хайя гэж байснаас биш, бүтэн үг хэлсэн хүн нэг ч үгүй. Гийчин хүү татуулсан бээлий, бас өмд рүүгээ бушуухан харав.

Бөхөсхийснээ больж яаран өрөө рүүгээ өгсөн явлаа. Түргэн алхсаар хвс дэвсээгүй шатаар гарч унтлагын өрөөнд орох чимээг хүн бүхэн сонсов. Фиренсайд ташуураа барьсан хэвээр суудал дээрээсээ: “Муу улианыг даа” хэмээн бууж ирэхэд нохой нь эзнээ хигээсний завсраар хялам хялам харна.

-Нааш ир, муу улиан! гэж Фиренсайд зандрав.

Холл мэл гайхан зогссоноо – Нохой урчихлаа, юу болсныг нь орж үзье гээд гийчний хойноос гэлдрэн явтал үүдний пинд гэргийтэйгээ тааралдаж:

-Улаачийн нохой гийчнийг урчихсан шүү гэж дуулгав. Холл шатаар шууд өгсөн гарч гийчний өрөөний хаалга дутуу хаалттай байсан болохоор өрөвдсөндөө зөвшөөрөл авах барих ч гэлгүй шууд оржээ.

Цонхны хөшиг буулгаатай, өрөөнд бүдэг бадаг байлаа. Холлын нүдэнд агшин зуур царвуугүй гар, бас цагаан дэвсгэр дээр алаг нүдэн цэцгэрхүү чухам юу нь үл мэдэгдэх гурван том толботой нүүр бүртэлзэх шиг хачин жигтэй юм харагджээ. Холл үүдээр үсрэн гартлаа хэнхдэг рүүгээ цохиулав. Хаалга хавхийн хаагдаж дангинатал цоожлох чимээ гарлаа. Энэ явдал агшин зуур болсон учраас Холл өөр юу ч ажиглаж чадсангүй. Тийм гэхийн тэмдэггүй нэг юм л хөдлөн цохиод түлхэн гаргасан ажээ. Холл шатны харанхуй тавцан дээр чухам юу харснаа ч мэдэхгүй мэл гайхан зогсов. Мань эр төдхөн буудлынхаа өмнө цугласан хэдэн хүнтэй нийлэв. Фиренсайд юу болж өнгөрсөн тухайг хоёр ч дахин нэгд нэгэнгүй ярьжээ. Холл авгай гийчнийг минь урж байх тийм эрх энэ нохойд хэн олгосон юм гэж загнана. Замын хажууд аар саар юм худалддаг мухлагийн эзэн Хекстер хүн болгоноос элдэв дээдийн олон юм шалгааж байна. Төмрийн дархан Сенди Волжерс, гүнээ бодлогошрон зогсож байхад хэдэн хүүхэд бүсгүйчүүл- Энэ нохой намайг хазсан бол ч, ийм нохой тэжээж болохгүй шүү дээ. Үгүй, ер нь энэ нохой тэр хүнийг яагаад урав аа? гэх мэтчилэн ярилцана.

Холл довжоон дээрээс тэдэн рүү гөлрөн яриагий нь чагнан саяхан тийм хачин юм харсан эсэхээ эргэлзэж байв. Тэрнээс гадна сэтгэгдлээ гаргаж ярина гэхэд хэлнийх нь баялаг даанч дулимхан хүн байлаа.

Эхнэрийнхээ асуухад – Туслалцаа хэрэггүй гэж буй бололтой, гэсэн ч юмы нь оруулалцаад өгчихсөн нь дээр биз гэв.

-Нохойд хазуулсани газры нь, ялангуяа хувилах янз байвал бушууан төөнөсөн нь дээр гэж Хекстер хэлэв.

-Би бол тэр муу нохойг буудчих байсан даа гэж нэг авгай хэлэх сонсогдоно. Гэтэл өнөө нохой дахин архирч эхэллээ.

-Түргэлж үзвэл зүгээр байна! гэж уурласан дуу хаалганы цаанаас гарч өнөөх боолттой хүн захаа босгож, бүрх малгайныхаа хүрээг доош нэлмийлгэн гарч ирээд, Юмы минь оруулчих болсон юм биш үү! гэв.

Тэнд байсан хүн хожим хэлэхдээ, тэр хачин хүн өмд, бээлий хоёроо сольж амжсаныг ажсан гэжээ.

-Та нохойд уруулчмхав уу? Айхтар аягүй юм боллоо. Миний нохой гэтэл нөгөө хүн:

-Зүв зүгээр. Шүд нь арьсанд ч хүрээгүй. Юмы минь л бушуулж үз! Гэлээ. Тэгээд аман дотроо хараал тавьсан гэж Холл хожим ярьжээ. Эхний хайрцагтай юмыг зочны өрөөнд оруултал нөгөө хүн тэсэлгүй яаран задалж, жииргэлсэн сүрлийг нь цацсаар нунтагтай пагдгар шил, өнгө бүрийн цэнхэр уусмалтай хуруу шил, хор гэсэн бичигтэй цэнхэр өнгийн барзгар шил, нарийн хоолойтой цолдгор шил, том том ногоон, цагаан шил, шилэн бөглөөтэй бүдэг бадаг бичигтэй, углаа модон бөглөөтэй, архи, тосны янз бүрийн шил сав гаргаж ирээд шүүгээ, зуух, цонх, ширээ, шал, номын ташинга дээр энд тэндгүй эгнүүлэн тавьжээ. Бремблхерстийн эмийн газар хүртэл өдий олон шил савтай байж чадаагүй дэг. Харууштай сонин юм байна. Зургаан хайрцагийг задлахад дандаа шил сав гарчээ. Ширээн дээр ч бөөн сүрэл боллоо. Хайрцагнуудаас нь шилтэй юмнаас гадна хоосон хуруун шил, нямбайлан багласан дэнс гарчээ. Гийчин хайрцагтай юмаа онгичин гаргаж дуусмагц гадаа байгаа номтой хайрцаг, оруулж ирсэн бусад юм хүмээ, гал унтарчихсан байгаа зэргийг огт анзааралгүй цонх руу ойртож очин ажилдаа даруй оров.

Холл авгай хоол унды нь оруулж өгөхөд цаадхи нь шилтэй юмнаас хуруу шил рүү шингэн зүйлийг тоолон дусааж, ажилдаа айхтар улайсан учир авгайг хог сүрэл арилгаж дуусан дуустал орж ирснийгнь анзаарсангүй. Шал муухай болгосонд дургүйцсэндээ Холл авгай хоолны тосгуураа ширээн дээр дуутай гэгч тавихад гийчин сая нэг эргэж харснаа, даруй дахин цааш харжээ. Гийчин нүднийхээ шилийг аваад хажуу дахь ширээн дээрээ тавьсан байв. Түүний нүдний ухархай авгайд гайхалтай гүнзгий юм шиг харагдав. Гэтэл нүднийхээ шилийг зүүгээд дахин эргэж харлаа. Холл авгай хог тарилаа гэж зэмлэх санаатай байжээ. Гэтэл зочин өрсөж, нөгөө л айхтар догшин байдлаараа:

-Таныг хаалга цохилгүйгээр битгий орж байгаасай гэж хүсмээр байна гэв.

-Би цохисон шүү, харин...

- Тийм ч байж болох юм. Миний энэ шинжилгээний ажил тун ч

яаруу, жаахан чимээ... хаалга тар хийсэн ч тэр ... ер нь би танаас гуйхад...

-Тэгэлгүй яах вэ, эрхэм минь. Таны мэдрэлд тийм муу юм болж байгаа бол та хаалгаа цоожилчихоод сууж болно шүү дээ. Хэзээ ч гэсэн тэр!

- Санадаг санаа байна шүү.

- Эрхэм ээ, энэ сүрэл чинь ... арай ч ...

- Хэлээд юу хийхэв. Танд сүрэл саад болоод байгаа бол миний

тооцоонд оруулаарай гэж гийчин хэлээд бас нэг юм аман дотроо бувтнах нь хараалын үг байсан байж мэднэ.

Нэг гартаа шилэн лонх, нөгөө гартаа хуруу шил барьчихаад

зоримог дайчин бөгөөд уурсангуй байдалтай зогсох ер бусын хүнээс Холл авгай баахан хулчийна. Гэхдээ Холл авгай угийн шийдмэг эмэгтэй болохоор:

-Тэгвэл, эрхэм минь, та хэдийг өгмөөр байна? Гэхэд:

Гийчин –нэг шиллэнг, нэг шиллэнг гээд биччих, нэг шиллэнг болно биз дээ? гэв.

-За та өөрөө л болно гэж байгаа бол, бололгүй яахав гэж авгай хэлээд ширээгээ засаж эхлэв.

Цаад хүн буруу харж суув. Тэр хүнийг үдээс хойш эх төлөв хаалга цоожлоод чив чимээгүй шахам суусан гэж Холл авгай ярьсан билээ. Харин нэг удаа түг гэх нүсэр чимээ гарч, шил савнууд харшин хангинах нь ширээгээ шаагаад лонх шидэх шиг санагджээ. Тасалгаан дотуур урагш хойш холжих хөлий чимээ гарахад Холл авгай юу болов хэмээн зовсондоо үүдэнд нь очсон боловч, үүдий нь тогшихоос зүрхшин чагнаж зогслоо.

-Ердөө ч болж өгөхгүй нь ээ! Тун болохгүй нь! Гурван бум! Дөрвөн бум! Булай их тоо ёо! Худлаа даа! Энэ насаараа ч барахгүй юм байна. Гэсэн ч тэвчээр, тэвчээр хэрэгтэй ... Ай би мөн их тэнэг хүн ээ! гэж гийчин солиотой хүн шиг үглэж байв.

Яг тэр үеэр архи пиво уух өрөөний хоосон шалан дээгүүр төмөр хадаасан тахтай савхин гуталтай хүн явах нүсэр чимээ гарсан тул Холл авгай тэр хүний ганцаар ярих үгийг дуустал чагнаж чадаагүйдээ гонсойжээ. Холл авгайг дахиж ирээд чагнахад гийчний өрөөнөөс сандал хааяа хяхтнах, сав шил харшихаас өөр юу ч дуулдахгүй байлаа. Ганцаараа ярихаа болиод ажлаа эхэлсэн бололтой. Холл авгай цай оруулж өгөхдөө өрөөний өнцөг дэх толины дор шил аяганы хагархай, хагас дутуу арчсан алтлаг өнгөтэй толбо байхыг ажиглав. Энэ тухай гийчиндээ сануулахад гийчин нь уцаарлангуй:

- Миний тооцоонд оруулчих. Битгий саад хийгээд байгаарай, гуйя! Хэрэв би танд хохирол учруулсан бол гайгүй, миний тооцоонд оруулаад биччихээрэй гээд өмнөө дэлгээстэй байх дэвтэртээ юм тэмдэглэн бичиж гарлаа.

Мөн өдрийн орой “Айпингийн татуурга” гэдэг пивоны мухлагт ороод сууж байсан Фиренсайд учиртай янзаар:

- Би чамд нэг юм ярьж гэхэд Тедди Хенфри –За юу хэлэх гээ вэ? гэв. Нөгөөдөх нь – таны өнөө ярьдаг, миний нохойд уруулдаг өнөөх гайхал чинь хар арьстан юм байна шүү. Лав л хөл нь хар өнгөтэй юм байна билээ. Нохой өмдийг нь хүү татахад тийм харагдсан. Хүний ягаан бие цухуйх ёстой байсан биз дээ? Тийм юм харагдаагүй, хав хар л юм харагдсан шүү! Миний малгай шиг хар юм байсан гэж би хэлж байна шүү дээ гэв.

-Аа, тийм бий! Хачин юм даа. Хамар нь будаг түрхчихсэн юм шиг улаан байсан шүү! гэж Хенфри гайхахад Фиренсайд: -Үнэн, мэдэж байна. Би тэгээд юу бодож байгаагаа танд хэлэх гэсэн юм. Тэр хүн цоохор арьстай юм. Тедди минь. Энд тэндээ хар цагаан толботой. Тэгээд л ичээд байгаа юм шиг байна. Эрлийз хүн дэг. Цус нь муу холилджээ. Тийм хүн байдаг гэж би урьд сонссон. Адуунд бол яахав, гайхах юм алга тийм зүстэй байх чинь ёс хойно яахав гэлээ.

КАСС НӨГӨӨ ХҮНТЭЙ ЯРИЛЦЖЭЭ

Тэр хүн Айпингэд хүрч ирсэн тухай тодорхой бичсэн учир гэвэл, хүмүүс түүнийг шохоорхон сонирхох болсон шалтгааныг уншигч авхай нарт ойлгуулахыг хичээснийх билээ. “Клубын баяр болох хүртэл түүний тэнд байсан тухайд гэвэл хоёр хачин явдлыг нь дурдаад бусдыг нь орхиж болох юм. Орон байрны эмх журмын талаар Холл авгай тэр хоёр хааяа хааяа муудалцах боловч дөрөвдүгээр сарын эцэс хүрч цаад хүн мөнгө цэнгийн талаар баахан бэрхшээлтэй болтлоо авгайг хялбархан аргалдаг, тухай бүр хангалттай мөнгө өгөөд салдаг байв. Холл авгайн нөхөр тэр гийчинд тун дургүй, бушуухан явуулах юмсан гэж хааяа зүрх гарган хэлдэг байж гэнэ. Гэхдээ түүнд муу байгаагаа үргэлж нууж, гийчинтэй нүүр учрахгүйг хичээж явдаг байв. “Зун болтол хүлээе, зураачид ирдэг цаг даа, тэр үед харъя” гэсэн цэцэн ухаан Холл авгайд төрөв.”Яахав жаахан ихэрхвэл ихэрхэж л байг.Юу ч гэсэн төлбөрөө нямбай өгнө гэдэг! Төлбөрөө нямбай төлнө гэдэг чинь бас нэг үг шүү дээ!” гэнэ.

Гийчин сүмд ч очиж мөргөхгүй, жирийн өдөр өмсөх хувцсаа ням гаригт ч сольдоггүй байв.

Холл авгайн бодоход тэр хүн жигдгүй ажилладаг. Заримдаа эрт босож зочны өрөөнд, ороод зогсоо зайгүй ажиллана. Заримдаа орой босож, дурамжхан байгаа янзтай тасалгаан дотуураа холхиж тав муутай байгаа нь илт, тамхи татах юм уу, задгай зуухны дэргэдэх зөөлөн сандал дээр зүүрмэглэн сууна. Өөр хүн хартай ч ярилцахгүй. Өнөө л адайр хэнтэг зан хэвээрээ. Ихэвчлэн бухимдан ундууцна. Хааяа уурандаа цухалдан бачимдаж гартаа тааралдсан юм хумаа эвдэж, урж, хаяж цацална. Ганцаараа аяархан ярьдаг зан нь бүр даамжирчээ. Холл авгай чих тавин мэрийн чагнавч юу ярьж буйг нь ойлгохгүй.

Тэр хүн өдрийн цагаар гадаа гарах нь ховор, харин үдэш бүрий болоход тэнгэр ямар ч байсан хамаагүй, толгойноосоо хөлөө хүртэл битүүлж боож гараад аль мод ихтэй бартаатай, буйд зөргөөр зугаална. Зэвүүн шил, нэлмэгэр малгайных нь дороос цухуйх боолт болсон чөтгөр аятай муухай зүс царай нь харанхуйгаас гэрэлд гэнэт гарч ирэхийг ажлаасаа харьж явсан зарим хүн хараад зэрхийн цочдог байж. Бас Тедди Хенфри нэг үдэш “Улаан дээл” гэдэг архины мухлагаас гарч гуйвсхийн явж байтал нь өнөө хүн эсгий малгайгаа гартаа барьж яваад гэнэт гэрэлд гарсанд толгой нь гавлын яс шиг харагдсанд мань хоёр үхтэлээ цочжээ. Үдэш оройн цагаар явж байгаад түүнтэй тааралдсан хүүхэд багачууд тэр шөнөдөө чөтгөр шулам зүүдэлдэг болжээ. Ер нь хүүхдүүд түүнд зэвүүцэх, түүний хүүхдэд зэвүүцэх хоёрын аль нь илүү байсныг хэлэхэд бэрх билээ. Юу ч гэсэн хоёр талаасаа л тун сүрхий зэвүүрдэг байв.

Айпинг шиг жижигхэн тосгонд, тийм хачин дүр байдалтай, зан авирта хүн бөөн яриа хөөрөө дэгдээх нь аргагүй. Ялангуяа түүний мэргэжлийн тухай хүн бүр тус тусдаа нэг юм бодно. Холл авгай энэ талаар баахан эмзэг байж. Хүмүүс асууж лавлахад “ туршлага хийж байгаа эрдэмтэн” гэж хэлнэ. Гэхдээ магадлахаас айж болгоомжилдог байв. Чухам ямар юмны шинжилгээ хийж байгаа юм дээ? гэж асуухад авгай мэдэмхий дуугаар – Эрдэм боловсролтой хүн андахгүй мэдэх ёстой, “Янз бүрийн нээлт хийж байгаа хүн” гэж хариулдаг байлаа. Цааш нь –Манай гийчинд гай тохиолдож нүүр гарых нь өнгө зүсийг муухай болгосон юм. Тэгээд угаасаа баахан нэрэлхүү хүн болохоор түүнийг нь сануулахад тун дургүй юм гэнэ. Зарим хүн, түүнийг

эрүүгийн гэмт хэрэгтэн этгээд байх, цагдаагаас нүүрээ буруулахыг оролдож байгаа хүн байх гэж Холл авгайгаас далдуур ярилцана. Хамгийн түрүүнд Тедди Хенфри тэгж бодсон ажээ. Хоёрдугаар сарын дундаас шувтарга болтол шальтай томгэмт хэрэг гарлаа гэж үнэндээ дуулдаагүй билээ. Гэвч ардын сургуулийн туслах багш сүрхий хэтрүүлдэг зантай Гульд энэ хүнийг тэслэн дэлбэлэх бодис бэлтгэж байгаа, зүсээ хувилгасан засаггүй үзэлтэн гэж боджээ. Зав чөлөөндөө түүнийг хянан мөрдөж байхаар шийджээ. Түүний хэрэглэсэн арга гэвэл нөгөө хүнтэй өөртэй нь тааралдахдаа нүүр рүү нь сүрхий ширтэх, бас гйичнийг ер үзээгүй хүмүүст өдөж сэдсэн асуулт тавьдаг байжээ. Гэвч түүнд олж мэдсэн юм огт үгүй байлаа.

Нэг хүн Фиренсайдын бодлыг баримталж тэр хачин хүнийг цоохор арьстай гэх буюу нөгөө нь бүр ч давсална. Жишээ нь: Сайлас Дерган ярихдаа “Тэр хүн зах зээл дээр гарч биеэ үзүүлэх юм бол дороо л хөлжих эр” гэхийн дээр өөрөө ялимгүй сүжигтэй хүн болохоороо тэр хачин хүнийг нэг л увдистай хүн гэж боддог байлаа. Бас зарим нь зүүдний л өвчтэй, гэмгүй амьтан байх гэнэ. Энэ таавар зөв бол юм бүхний учир шууд тайлагдах нэг сайн талтай байж. Ийм ийм гол бодолтой хүмүүсийн зэрэгцээгээр бас эргэлзэн тээнэгэлзсэн ч юм уу, аяндаа дагалдах хүмүүс ч байлаа. Сассекс нутгийнхан мухар сүсүг багатай учир зөвхөн дөрөвдүгээр сарын шинэдээр болсон хачин явдлуудаас хойш сая, нэг л биш гэж тосгоноороо шивэр авир ярилцах болжээ. Тэгэхдээ ч бас зөвхөн эмэгтэйчүүд нь тэгэж байв.

Ер нь түүний тухайд тэд юу гэж боддог байсан ч айпингийнхэн түүнд цөмөөрөө дургүй болжээ. Түүний уцаар түргэн зангийн зовлонг хот газрын оюуны хөдөлмөрийн хүн ойлгох боловч Сассескийн амарлангуй хүн ардад гайхалтай санагдана. Заримдаа тэр хүн гараараа учиргүй дохин занган яваа харагдана. Бас нар шингэсний дараа гудамжны өнцөг булангаар яах ийхийн зуургүй хурдан гарч ирээд өнгөрнө. Үг өдөж яриа үүсгэхийг оролдсон хүнийг огтхон ч халгаадаггүй байлаа. Бүрэг харанхуйд дуртай, үүд хаалгаа түгжиж цонхныхоо хөшгийг буулган, лаа дэнгээ унтраана. Энэ бүгд нь хэнд таатай байх билээ дээ. Гудамжаар явж байгаад тааралдсан хүмүүс түүнээс буруулж, доогтой залуучууд захаа босгож, малгайныхаа хүрээг нэлмийлгээд араас дагаж тэп тап алхаж гишгэхийг нь элэглэнэ.

Тэр үед “Хүн-буг” гэдэг нэг дуу их дэлгэрчээ. Сэтчель авгай тэр дууг сургуулийнхаа үдэшлэг дээр дуулж авсан шангаа сүмд чийдэнгийн шил авч өгөхөд зориулжээ. Тэрнээс хойш тэр тосгоныхон нөгөө хүний бараа харагдах болгонд заавал тэр дууны аль нэг бадгийн аяар ч юм уу, чангаар исгэрэн аялдаг болжээ. Харанхуй болтол тоглосон хүүхдүүд түүний хойноос “хүн-буг” гэж хашхиралдан айх, айлгүйтэх зэрэгцэн гэр гэрийн зүг хар хурдаараа гүйлддэг болжээ.

Тэндэхийн эмч Касс учры нь олж мэдэх юмсан гэхээс тэсэж суухаа больжээ. Тэгээд тэр хүний толгой түрүү үргэлж боолттой явдгийг эмч хүний хувьд сонирхож, үй түмэн шил савтаигий нь сонсоод атаархах сэтгэл төржээ. Түүнтэй нэг ярилцаад үзэх завшаан эрсээр амжилгүй дөрөв, тавдугаар сарыг өнгөрөөжээ. Сүүлдээ бүр тэсэхийг болиод улаан өндөгний баяр ёслол болохоос өмнөхөн тосгоны эмнэлгийн сувилагчийн цалин хэрэглэлийн талаар бадар барих хуудас аваад далим гарган очив. Холл авгай гийчнийхээ нэрийг мэлэхгүй байсанд эмч их гайхжээ.

-Нэрээ хэлж өгсөн л юмсан, би даанч дуулсангүй өнгөрөөчихсөн гэж Холл авгай худлаа хэлэв. Өөрийндөө сууж байгаа хүний нэрийг мэдэхгүй байна гэдэг авгайд ичгүүртэй юм шиг санагджээ.

Касс хүлээж авах өрөөний хаалгыг тогшоод ороход хараал тавих үг тод дуулджээ.

- Дайраад орчих шив дээ. Өршөөгөөрэй гэж Касс хэлэхэд үүд яг хаагдсан болохоор Холл авгай тэр хоёр юу юу ярилцсаныг дуулж чадсангүй. Арваад минут хир тэр хоёр дунгэр дүнгэр ярилцах чимээ дуулдаж байлаа. Дараа нь гайхаж дуу алдах сонсдож, хөлийн чимээ гараад сандал унав. Огцом муухай инээх дуулдаж, сандарч яваа хүний хөлийн чимээ ойртсоор Касс гараад ирлээ. Кассын царай зэвхий дааж, эргэн эргэн харсаар үүд хаалга ч хаалгүй задгай хаяж, эзэн авгай руу ч харах сэхээ сэтээгүй сандчин шатаар бууж, ум хумгүй гараад замаар орон хурдан хурдан алхан холдох хөлийн чимээ сонсджээ. Касс малгайгаа гартаа барьсан явна. Эзэгтэй лангууныхаа араас нөгөө задгай орхисон хаалга руу хартал нөгөө хүн аяархан инээгээд тасалгаан дотуураа хөлхөн яваа дуулджээ. Харин Холл авгайн зогсож байсан газраас гийчний царай харагдсангүй. Хаалга хаагдаж дахиад нам гүм болов. Касс тосгон дотуур шууд явсаар санваартан Бентингийн очиж жижиг өрөөнд нь орж тэвдэнгүйгээр:

- Би галзуурав бололтой! Яг солиотой хүн шиг байгаа биз? гэхэд номнол бичсэн хуудаснуудаа ангилж байсан санваартан хуудаснууд дээрээ дунгийн яс тавиад

- Юу болоо вэ? гэж асуув.
- Зочид буудалд буусан өнөөх... Тэгээд?
- Алив, уух юм байвал өгөөч гэж Касс хэлээд суув.

Санваартан өөртөө байдаг хямд дарснаас нэг хундага хийж

өгснийг эмч балгаж хүч сэлбэв бололтой саяхан болсон явдлынхаа тухай ярив.

-Өрөөнд нь ороод – гэж эмч хий залгиснаа- Манай сувилагчийн цалин хэрэглэлд зориулан бадар барьж явна, та оролцоно уу? гэлээ. Гэтэл тэр хачин хүн намайг орохтой зэрэг гараа халаасандаа хийж сандал дээрээ лүгхийн суугаад шуухитнаж гарлаа. Таныг би шинжлэх ухаан сонирхдог хүн гэж дуулсан юм гэлээ. Нөгөө хүн бас л “Тиймээ” гээд шуухитнав. Ер нь намайг байх зуур дандаа л шуухитнаад л байсан, сүрхий нусгай хүрсэн бололтой юм. Тэгэж их хучиж дулаалсан нь арга ч үгүй юм. Тэгээд би бадар барих болсон учраа ярьж, энэ зуур өрөөгий нь ажиг. Энд тэндгүй л сав химийн бодис, дэнс, хуруу шил зөндөөн. Нил цэцгийн үнэр шиг юм ханхалж байлаа. Гарын үсэг зурах уу, яахав? гэж асуухад тэр хүн бодъё гэв. Тэгээд би шуудхан та шинжилгээний ажил хийж байна уу гэж асуухад тийм гэж хариулав. Удах шинжилгээ юу? гэхэд уурлаж “Золиг шиг удаан шинжилгээ” гэв. Би хариуд нь “А тийм юм бий” гэлээ. Гэтэл нөгөө хүн гэнэт биеэ барьж чадахаа больсон янзтай элдвийн гомдол гаргаж эхлэв. Дургүй нь хүрээд тэсэж ядан байснаа намайг юм асуухтай зэрэг тэссэнгүй дэлбэрэх шиг болов. Нэг жор, маш чухал жор гаргаж авсан байж, юуны жор юм хэлсэнгүй. Эмийн жор уу гээд орхисон чинь “Чөтгөр алгад! Та энд юу туршаад байгаа хүн бэ?” гэж хашхирав. Би яахав уучлал гуйлаа. Тэр хүн сүртэй шуухитнаж ханиав. Тэгээд цааш нь ингэж ярив. Нэг жортой болоод байж гэнэ. Таван хэсгээс бүрдсэн жор байсан юм байх. Түүнийгээ ширээн дээр тавиад цааш эргэтэл цонхны салхи жортой цаасыг нь шажигнуулан хийсгэж орхижээ.

Задгай зууханд гал асаж байсан гэнэ. Цаас дүрсхийн асах харагдаад жор нь яах ийхийн зуургүй шатаад янданд сорогдон алга болжээ. Ухасхийсэн боловч амжаагүй юм гэлээ. Ингээд тэр хүн яриагаа тодотгох гэж гараа өргөлөө.

-Тэгээд

- Гар гэмээр юм үзэгдсэнгүй. Хоосон ханцуй харагдлаа! “Ай бурхан

минь! Хөөрхий зэрэмдэг хүн юм байх аа! Хиймэл гартай байснаа аваад тавьчихсан бололтой.” гэж би бодлоо. Гэсэн ч дараа нь нэг л хачин юм шиг санагдсан. Хоосон юм бол яаж ханцуй нь гартай юм шиг хэлбэртэй, бас дээш доош хөдөлж байдаг билээ. Ханцуй хоосон байх нь ч лав хоосон байсан. Юу ч байгаагүй. Тохойгоо хүртэл хоосон харагдсан, тэр хавьд нэг цоорхойтой, тэрүүгээр гэрэл нэвт тусаж байна билээ. Би: “Ай бурхан минь! “ гэж дуу алдчихав. Тэгтэл тэр хүн зогтусан, хөдөлгөөнгүй гөлийсөн нүдээр намайг ширтсэнээ ханцуй руугаа харав.

-Тэгээд?

- Тэгээд л тэр дээ. Өөр ч юм хэлсэнгүй ханцуй руугаа жаал

ширтэж байснаа халаасандаа бушуухан хийчихэв. Тэгж байснаа хоолой засаж “ Жор минь шатчихсан гэж би танд хэлсэн ярьсан байхаа.” гэлээ.

- Хоосон ханцуйг юуны хүчээр ингэж хөдөлгөнө вэ? гэж би асуув.

- Хоосон гэнэ ээ?

- Тийм ээ, хоосон ханцуйг гэж би давтан хэлэв.

- Таны санахад энэ хоосон ханцуй юу? Хоосон байхыг нь та харав

уу?

Тэр хүнийг түргэн гэгч босоход нь би ч бослоо. Над руу алгуурхан алхаагаар ойртож ирээд тулж зогсов. Аймаар муухай шуухитнана. Би хөдлөлгүй зогсож байсан боловч тэрний боолттой толгой, нүдний шил аажуухан ойртсоор байгааг харахад дотор аягүй болсон, нээрэн шүү. “Үүнийг та хоосон ханцуй гэсэн байх аа?” гэж мань эр лавлав.

-Тийм л байна шүү дээ! гэж би хариуллаа.

Хэрэв хүн таны өөдөөс ингэж ширтээд юу ч хэлэхгүй байвал та лав зодоо гаргах нь гэж бодох байх. Тэгвэл тэр хүн тун тайвнаар, гараа гаргаж ирээд надад үзүүлэх гэж байгаа мэт алгуур ойртуулав. Би дэмий л харлаа. Бүтэн жил болох шиг санагдлаа.

-Үгүй яахав дээ, хоосон л юм байна шүү дээ гэж хоолойгоо засаж хэлэв. Эрхбиш нэг юм хэлэх ёстой байлаа. Айдас хүрээд явчихлаа. Ханцуйны дотор тал цөм харагдах юм. Нөгөө хүний ханцуй над руу аажуухан дөхөөд байдаг. Тэгсээр бүр

зургаан ямхын төдийхөн зайтай болов. Хоосон ханцуй тэгж ойртоод байхыг харахад хичнээн аягүй санагдана! Тэгээд ...

- Тэгээд?
- Эрхий, нэг хуруурхуу юм хамраас чимхээд авлаа.

Бантин инээд алдав.

-Ханцуйд нь юу ч байгаагүй шүү дээ. гээд Кассын дуу хачин чангарав.

-Та ч яахав одоо ингэж л байна, харин би бүр айж сандрахдаа ханцуй руу нь чанга гэгчийн цохиж аваад, өрөөнөөс гараад харайчихсан, зугтаачихсан...

Касс түр дуугүй боллоо. Түүний үнэнээсээ айж сандарсанд эргэлзэх арга алга. Мань хүн яах ч учраа олохгүй эргэж, сайхан ааштай хуврагийн тааруухан дарснаас бас нэг жүнз ув. Тэгээд:- Ханцуйгий нь цохиод авахад миний гарт яг гар шиг юм тааралдсан. Гэтэл гар байгаагүй юм. Ерөөсөө гарын ор ч байгаагүй юм.

Бантин жаал бодол болсноо Касс руу сэжиглэсэн байдалтай хараад- Жигтэйхэн хачин хэрэг байна даа! гэж нухацтай дуугарав.

САНВААРТНЫД ХУЛГАЙ ОРОВ

Санваартны гэрт хулгай орсон тухай тодорхой мэдээг бид тэр санваартан гэргий хоёроос их төлөвийг нь дуулсан юм. Энэ хэрэг Айпингэд клубын баяр ёслол болдог Цагаан Сумъяа өдрийн өглөө хар үүрээр болсон ажээ. Бантины гэргий үүрээр нам гүмд гэнэт сэржээ. Унтлагынх нь өрөөний үүдийг хүн нээгээд хаах шиг боллоо. Анхандаа авгай нөхрөө сэрээсэнгүй, орон дээрээ босож суугаад чагнатал нэг хүн зэргэлдээ байгаа хувцасны өрөөнөөс гарч, гудмаар шатны зүг хөл нүцгэн пад падхийн яваа дуулджээ. Авгай үүнийг лавтай мэдмэгцээ Бантинг сэмээрхэн сэрээжээ. Бантин, гэрэл гаргалгүйгээр нүднийхээ шилийг зүүж, гэргийнхээ дээлийг нөмрөн гэрийн шаахай хөлдөө углаад гудмандаа гарч чагнавал бичгийнх нь ширээг хүн онгичиж байгаа чимээ тов тод сонсдов. Бас хүн чанга гэгчийн найтаах дуулджээ. Тэгэхлээр унтлагын өрөөнд эргэн орж хамгийн тохиромжтой зэвсэг гэж санасан галынхаа шилээврийг аваад чимээ анир гаргахгүйг аль болох хичээн шатаараа уруудав. Бантины гэргий ч хойноос нь гарч иржээ.

Дөрвөн цаг болж байсан тул үүрийн гэгээ бүрэлзэж гудамд нь гэрэл сүүмийсхийн гарсан боловч бичгийн өрөөний үүд хав харанхуй онгойж харагдав. Цөм нам гүм гагцхүү Бантины хөлийн дор шал яльгүй шажигнана, бас бичгийн өрөөнд нь хүн юм онгичих чимээ үл мэдэг сонсогдоно. Тэгтэл ширээний нүдийг тар хийтэл нээгээд цаас шаржигуулах чимээ гарав. Тэгээд тэр хүн хараал тавьж, чүдэнз зурахад өрөөнд нь шар гэрэл сүүмсхийв.

Бантин гудамаараа ороод бичгийн ширээний өрөөнийхөө үүдэн завсраар шагайвал ширээн дээр нь лаа асаатай, ширээнийх нь нүд онгорхой харагдсан ажээ. Гэтэл хулгайч нь харагдсангүй. Бантин тэндээ эргэлзэн зогсож байхад, айсандаа

царай нь зэвхийрсэн Бантины авгай араас нь сэмхэн хүрч иржээ. Хулгайч лав энэ хавийн хүн гэж бодоод л Бантин зориг оржээ.

Мөнгө хангинах чимээ гарахыг тэр хоёр сонсоод аж ахуйд зориулсан хоёр фунт, арван шиллингээ хулгай авч байна гэж мэджээ. Тэр чимээ гарахыг Бантин сонсмогцоо зүрх нь бүр чангарч дээ.

Бантин шилээврээ чанга атгаж, гэргийгээ дагуулсаар өрөөд ороод

- Боль хө, чи! гэж чанга хашхирснаа хүн ер байхгүй байхыг үзээд гайхаш нь тасрав.

Гэсэн ч дөнгөж сая энд хүн юм хөдөлгөх шиг санагдсан нь лавтай билээ. Хагас минутын төдий гайхан зогсож байснаа Бантин авгай өрөөн дундуур явж очоод хөшигний араар шагайхад, нөхөр нь бичгийнхээ ширээн доогуур шагайв. Бантины авгай цонхны хөшгийг ярав. Нөхөр нь задгай зуухныхаа яндангаар шагайж хараад шилээврээрээ төнхөв. Дараа нь Бантины авгай цаасны сагс онгичиход нөхөр нь нүүрснийхээ савыг нэгжив. Тэгснээ эр эм хоёр бие бие рүүгээ учрыг олж ядан мэл гайхан зогсов.

-Би тангараг өргөсөн ч ... гэж Бантин эхэлснээ- Лаа! Хэн асаасан байх вэ? гэхэд гэргий нь:

- Бас ширээний нүд! Мөнгө маань алга болж шүү дээ! гээд үүд рүү яарав.

- Ийм хачин юм насандаа үзсэнгүй...

Гудамд хүн чанга найтаах дулдав. Тэгмэгц нөгөө хоёр маань шууд

гүйн гарвал гал тогооны өрөөний үүд тас хийжээ.

- Лаа аваад ир! гэж Бантин хашхираад урагшаа дөхтөл хаалганы түгжээ яаран тайлах чимээ дуулджээ.

Гал тогооныхоо өрөөний үүдийг нээтэл арын хаалга нээгдэж үүрийн бүдэг бадагт хашаан дахь цэцэрлэгийн мод барайж харагдав. Тэрээр үүдээр гадагш юу ч хараагүйг санваартан лавтай мэдэж байтал үүд нь түр онгойж байгаад тар түрхийн хаагдсан ажээ. Үүнд бантины авгайн барьж байсан лаа салхинд цацлан сүүмэлзээд дахин тодров.

Тэр хоёр гал тогооныхоо өрөөнд орохыг зориглохгүй бүхэл минут хэртэй зогсжээ.

Өрөөнд ер хүн байсангүй. Хоул гадагш гарах хаалгаа түгжээд гал тогоо, пингээ цөмии нь нэгжиж, доошоо зоориндоо хүртэл орж үзэв. Хичнээн эрэвч хүн байсангүй.

Үүр цайж нэгэнт гэрэлтэй болсон байхад мань хоёр доод давхартаа нөгөө хачин хувцастайгаа, лаа барьсан хэвээр харанхуй шөнө болсон хачин явдлыг хачирхан хачирхан ярилцан зогсож байжээ.

-Ийм хачин юм насандаа үзсэнгүй гэж санваартан хорь дахь удаагаа хэлэв.

-ай хө, Сюзи ирж байна. Өнгөрөөд яваг, тийшээ орсон хойно нь хоёулаа дээшээ бушуухан гарья гэж гэргий нь хэлжээ.

ГЭРИЙН ТАВИЛ ГАЛЗУУРАВ

Цагаан Сумъяа өдрийн өглөө үүрээр шивэгчин Миллийг босоогүй байхад эр эм хоёр Холл босож зоориндоо сэм оров. Тэр хоёр пивонхоо чанарыг үзэх нууц ажилтай байлаа.

Тийшээ орсон хойноо унтлагынхаа өрөөнөөс лонхоо авчрахаа хоёул мартсанаа Холл авгай санав. Уг зорьсон хэрэгт Холл авгай дадамгай хүн байсан болохоор лонхонд нөхөр нь явах болов. Түүнийг шатны талбай дээр очтол нөгөө гийчний үүд ялимгүй онгорхой байхыг хараад гайхжээ. Холл цаашаа унтлагынхаа өрөөнд орж, бий гэсэн газраас нь лонхоо олж авав. Буцаж явтал нь гадаа хаалганы түгжээ тайлаастай зөвхөн оньслоотой байгааг харав. Холл гэнэт ухаарч энэ байдлыг өнөө гийчний хаалга онгорхой байсан, бас Тедди Хенфри таавар хоёртой холбон боджээ. Урьд орой гэргий нь түүний барьж байсан лааны гэрэлд хаалга түгжсэнийг Холл тодорхой саналаа. Холл хэсэг зуур яах ч учраа олохгүй зогсож байснаа лонх барьсаар буцаж өгсөн, нөгөө хүний үүдийг тогшвол хариу алга. Дахин тогшоод үүдий нь тэлэн нээн оров.

Мань эр зөв боджээ. Дэвсгэр нь ч хэвээр, өрөө нь ч хоосон. Харин сандал, орных нь хөл дээр нөгөө гийчний өмсдөг ганц костюм, толгойных нь боолт хааш яаш хаяастай байхыг Холл гуай үзээд хэдий гойд ухаантай биш ч гэлээ гайхах бодол төржээ. Гийчний өмсдөг зөөлөн том эсгий малгай хүртэл орны толгой дээр хазгайдуухан тохойтой байв.

Холл мэл гайхан тэнд зогсож байхад зоорин дотроос авгайн дуу дуулдана. Авгай баахан юм үглэж, үгийнхээ сүүлийг өргөн дуудах нь Өрнөд Сассексийн хүмүүст айхтар ундууцсаны тэмдэг билээ.

-Жо- орж оо! Чи миний захисан юмыг олов уу, үгүй юу? гэж хашхична.

Холл хариу хэлэхийн оронд доошоо сандран бууж бүр шатан дээрээс:

-Женни минь! Хенфрийн хэлдэг үнэн байна! Өнөөх чинь тасалгаандаа алга, алга! Ордог хаалганы түгжээ гаргаастай байна гэж хашхирав.

Холл авгай учрыг нь тэр даруйдаа олсонгүй. Гэсэн ч хоосон өрөөгий нь биеэр очиж үзэхээр шийдэв.

Холл өнөөх лонхоо барьсан хэвээр түрүүлэн явах зуур:

-Өөрөө алга хэр нь дээл нь байсан газраа байх юм. Яагаад дээлгүй нүцгэн явах билээ, хачнаа? гэв. Хожим тэр хоёрын ярьснаар бол зоориноос гараад явахад ордог хаалга нээгдээд дахин хаагдах чимээ гарах шиг болсон, гэтэл хаалга нэгэнт

хаалттай байсан хэн ч байгаагүй болохоор аль аль нь бие биедээ юу ч хэлээгүй өнгөрсөн гэнэ.

Холл авгай гудманд нөхрийнхөө хойноос гүйцэн ирж шатаар түрүүлэн өгсөв. Шатны тэртээ, нэг хүн найтаалгах сонсогдоход эхнэрийнхээ хойноос зургаан алхам зайтай явж байсан Холл, гэргийгээ найтаалгалаа гэж бодсон байтал гэргий нь өөрөө түрүүлж явсан болохоор хар хүнийгээ найтаалаа гэж бодсон ажээ. Холл авгай гийчний өрөөний хаалгыг цэлийтэл нээж доторхий нь ажиглан хараад- Жигтэйхэн хачин хэрэг байна даа! гэлээ.

Холл авгайн яг чихэнд нь нэг хүн найтаалгах шиг болмогц эргэн харвал нөхөр нь шатны дээд талын гишгүүр дээр өөрөөс нь арван хоёр алхмын зайтай хол байхыг үзээд гайхлаа. Гэвч нөхөр нь дэмий удалгүй хүрэлцэн ирлээ.

Холл авгай бөхийгөөд дэр, цагаан даавуугий нь тэмтэрч үзэв.

-Хүйтэн байна. Яваад лав л нэг цаг илүү болсон байна гэв.

Ингэж байтал маш гайхалтай юм болжээ. Орны цагаан даавуу өөрөө эвхэрч овоороод гэнэт орны хөндөл дээгүүр харайчихлаа. Хүний гар бүтээлэгний дундаас атгаж аваад хажуу тийшээ чулуудчих шиг. Цаашаа гийчний малгай байсан газраасаа дээш хөөрөн гарч хагас эргэлдэн Холл авгайн нүүр өөд цохиод авлаа. Тэгтэл угаалтуур дээрээс бие үрдэг хаймар бас дээшээ хөөрөв. Бас гийчний өмд цамцыг эвгүйхэн шиг салгаж хаяад түшлэгтэй сандал нь дээш дэгдэж гийчний дуутай тун төстэй дуугаар сөөнгөтөн инээд алдаад дөрвөн хөлөөрөө Холл авгайн зүг чиглэн дайрч ирэв. Холл авгай дуу алдан үүдний зүг эргэн зугттал өнөөх сандал хөлөөрөө араас нь аяар боловч шийдмэг түлхэн нөхөртэй нь хамт гаргачихлаа. Тэгээд өрөөний үүд тас хийтэл хаагдаад дуутай гэгч цоожлогдож орхив. Сандал, ор сэлт хэсэг зуур дийлсэндээ баярлах аятай тонгочсоноо төдхөн нам болов.

Холл авгай шатны талбар дээр гараад бараг ухаан алдан нөхрийнхөө гар дээр унав.

Холл авгайн дуу чимээгээр нойрноосоо сая сэрсэн Миллигийн туслалцаатайгаар гэргий юүгээ арай ядан доош оруулаад тайвшруулах эм өглөө.

-Албин чөтгөр байна, би мэдэж байна, сонинд тэгэж бичсэн байдаг юм, ширээ сандал үсэрч бүжиглэдэг юм гэнэ билээ гэж Холл авгай дөнгөж ухаан оронгоо хэлэхэд нөхөр нь:

- Дахиад балга, Женни минь, биед чинь сайн болно гэв.
- Үүдээ цоожил, дахиад түүнийг битгий оруул, би ер нь сэжиглээд

байсан юм... Би ер нь яагаад бодож үзсэнгүй вэ? Тэр бүлтийсэн нүд, боолттой толгой... Ганц ням гаригт сүмд очсон бол бас яана... тэр олон шил, сав тийм олныг хураах уу та минь! Хамаг сандал ширээнд чөтгөр шулам шүглүүлчихсэн байн. Хайран эд минь! Ээж минь намайг хүүхэд байхад дандаа суудаг байсан сандал юмсан. Одоо болохоор намайг дайраад байх болно гэдэг чинь юу гэсэн хэрэг вэ?

- Женни минь дахиад нэг жаахан балгачихаач, зүрх чинь хөөрсөн

байна шүү гэж Холл гуйв.

Тэр хоёр өглөөний ургах алтан шар нарны туяа гийсэн гудамжны нөгөө талд суудаг төмрийн дархан Вожерсийг сэрээхээр Миллиг явуулжээ.

“Холл авгай амры чинь эрж байна. Манай байшингийн дээд давхрын сандал ширээ нэг л хачин болоод байна. Вожерс та манайхаар морилохгүй юу?”

Вожерс их юм мэддэг айхтар ухаалаг хүн ажээ.

Уг хэргийг маш хянамгай сонсоод:

- Хараал хийгээд л тэр, би яг мэдэж байна гэж хэллээ.

Дархан, Холлынд сэтгэл нэлээд зовсоор ирж дээ.

Холл, гэргий хоёул түүнийг нөгөө гайхалтай өрөө рүү даруй аваачихыг завдсанд, дархан ер яарахгүй гудамд ярилцахыг эрхэмлэв.

Гудамжны нөгөө талд Хекстерийн шавь гарч ирээд тамхины мухлагын цонхны таглаа модыг авч байв. Түүнийг бас дуудаж, зөвлөгөөнд оролцуулав. Хекстер ч хэдэн минутын дараа өөрөө хүрэлцэн ирлээ. Англисаксын парламентч шинж тэмдэг тодорч хичнээн их ярилцавч шийдсэн юмаар дүльхан л байв.

Давын түрүүнд жинхэнэ баримтат явдал хэрэгтэй байна гэж Вожерс зүтгэн бид энэ үүдийг эвдэн орох ёстой боллоо гэдэгт итгэсэн байх ёстой. Эвдрээгүй үүдийг дуртай цагтаа эвдэж болно, харин эвдэрчихсэн үүдийг бол эвдрээгүй болгож болохгүй шүү дээ гэнэ.

Гэтэл дээд давхрын өрөөний хаалга өөрөө нээгдэхийг тэд үзээд маш их гайхан байтал гийчин дээл хувцсаа өмсчихөөд муухай шилэн нүдээрээ урагшаа ширтсээр улам ч баргар царайлан шатаар уруудан байгаа харагдлаа. Тэндээс нүд салгалгүй ширтэн алхсаар шатаар бууж, гудмаар явж ирээд зогсов.

-Тийшээ хараач! гэж бээлийтэй гараараа заасан зүгт харвал зоорины хаалганы яг дэргэд нэг шилэн лонх байгаа харагдана. Тэгээд зочны өрөөнд ороод тэднийг харсаар байтал хаалгы нь гэнэт түргэн, ууртайгаар ширүүн хаав. Тэд хаалга дуугараад цууриа тасартал нэг ч үг хэлэлгүй бие бие рүүгээ гайхан хараад дуугүй зогсов.

-Нээрэн хачнаас хачин юм байна! гэж Вожерс эхэлснээ үгээ таслав.

-Би л бол өрөөнд нь орж уулзаад энэ бүгдийн учрыг лавлан асууж шалгаах байна даа гэж Вожерс Холлд хэлэв.

Эзэн авгайн хар хүнийг бодон шийдтэл чамлахааргүй их цаг өнгөрчээ. Тэгсээр нэг шийдэгчээн болж үүдий нь тогшин нээгээд:

-Өршөөгөөрэй гэв. Гэтэл гийчин нь бүдүүн дуугаар:

- Чөтгөрт алгадуулмар минь! Хаалгаа хаа! Гэв. Тэр хоёрын яриа ингээд л дуусчээ.

ИЛЧЛЭВ

Хачин хүн, зочны жижигхэн өрөөнд өглөөний таван цаг хагасын алдад ороод үүдээ түгжиж цонхныхоо хөшгийг буулгаад бараг үд хүртэл цухасхийсэнгүй. Холлыг тэгж чадуулснаас хойш тийшээ орох зоригтой хүн ер олдсонгүй.

Тэр хүн энэ завсар ер нь юу ч идээгүй бололтой. Гурван удаа хонхоо дарж дуугаргасан, гурав дахь удаагаа бүр удаан, чанга дуугаргасан боловч хариу өгсөн хүнгүй байлаа."Тэгвэл тэгж л байг, гайгүй, чөтгөрт алгадуулмарыг" гэж Холл авгай амандаа хэлжээ. Яг тэр үеэр хүмүүсийн ярилцахыг сонсвол санваартны гэрт хулгай орсон там тум сураг гарч хүмүүсийн дотор нэг бодол өөрийн эрхгүй төрж байв. Холл Вожерс хоёр, шүүгч Шаклфортынд очиж зөвлөн ярилцахаар явав. Хоёрдугаар давхарт гарахыг хэн ч зориглохгүй байжээ. Тэр хачин хүн тэнд юу хийж байгаа нь ч мэдэгдэхгүй, өрөөн дотуураа гэнэ гэнэ, чанга чанга гишиглэн хөдлөх сонсдоно, бас харааж зүхэх, хоёр ч дахин цаас шажигнуулах, лонх саваа чанга чанга харшилдуулах чимээ гарчээ.

Аймхай ч гэсэн хэрэгт дуртай улс улам улам нэмэгдсээр байв. Хекстер авгай ч иржээ. Цагаан Сумъяа гаригийн баярын өдөр байсан тул бэлэн хувцасны газраас өнгийн цамц, зангиа авч зүүсэн хэдэн хөгжөөнтэй залуу хүрч ирээд элдэв шалдвын юм асууж эхлэв. Залуу Арчи Гаркер хашаан дотуур орж очоод тэр хүний байгаа өрөөний цонхны хөшгөн доогуур шагайж харснаараа бусдаас онцгойрчээ. Өөрөөр олж харсан юм огт үгүй байсан боловч юм олж харсан царай гаргаж бусад хэдэн залуугаа өдөж байлаа.

Цагаан сумъяа гаригийн баярын тэр өдөр тэнгэр ер бишийн сайхан, тосгоны гудамжаар өдий төдий олон бүхээг халх бариастай буудлагын нэгэн газар ажиллаж байхаас гадна төмрийн дархны ойролцоо зүлгэн дээр хүрэн шар алаг өнгийн бүхээгтэй голланд тэрэг зогсоно. Бас янзтай дэгжин хувцасласан эрэгтэй, эмэгтэй хэдэн хүн бэт самар чулуудаж наадах байр бэлтгэн байгаа харагдана. Эрчүүл нь хөх цэнхэр өнгийн богино дээл, бүсгүйчүүл цагаан элгэвч, том том өдтэй дэгжин маягийн эсгий малгай өмсчээ. "Улаан Марал" гэдэг диан буудлын Вүдер, гуталчин бөгөөд хуучин унадаг дугуй худалддаг Жэгерс хоёр зам дагуу үндэсний туг дадар, Виктор хатны үеэс уламжлал болсон хааны билэг тэмдэгтэй утсыг, гудамж хөндлөн татаж байлаа.

Нарны гэрэл ялихгүй орохоор зориуд бүдэг харанхуй болгосон зочны өрөөнд нөгөө хүн лав өлсөж цанган толгой хоргодож буй бололтой.

Нөгөө хүн аймаар эв хавгүй бодолдоо халууцан хардаж шилнийхээ цаанаас өмнөө байгаа цаасыг ширтэх, аль эсхүл заваан шил саваа оролдоно. Гадаа цонхны цаана бараа нь харагдахгүй бужигналдан шаагих багачуудад уурсан байн байн хараал тавих аж. Булан дахь задгай зуухны дэргэд хэдэн хагархай шилэн лонх харагдана, тасалгааны дотор хлорын нялуун үнэр ханхална. Энэ бүгдийг бид тэр үед

хүмүүсийн ярианаас дуулсны дээр хожим хойно түүний өрөөнд ороход тийм байсан юм.

Үдийн алдад өнөөх хүн гэнэт зочны өрөөний үүд нээж босоо ширээний дэргэд зогсож байсан гурав дөрвөн хүнийг ширтэн харснаа:

-Холл авгай байна уу? гэж дуудав. Нэг нь авгайг дуудахаар дурамжхан явав.

Холл авгай тэр даруй баахан амьсгаа дээр боловч зориг шийдэмгий байдалтай хүрч ирлээ. Харин Холл гуай гадагшаа яваад ирээгүй байж. Холл авгай тэр хүнтэй аль түрүүний уулзах гэж санаж байсан тул тооцооныхоо хуудсыг жижигхэн тосгуур дээр тавьчихаад орж ирэв.

-Та тооцоогоо хийх гээ юу эрхэм ээ? гэж асуув.

Цаадхи нь:

- Та яагаад өнөө өглөө хоол өгсөнгүй вэ? Та яагаад надад хоол хийхгүй, бас дуудаад байхад ирээгүй вэ? Намайг хоол ундгүй байж чадах хүн гэж бодоо юу? гэхэд Холл авгай жишимгүйгээр:

-Та яагаад мөнгө өгөөгүй вэ? Энүүний учрыг л би мэдэх гэсэн юм даа гэв.

-Мөнгө гуйвж ирэхийг хүлээж байна гэж би танд уржийн уржигдар хэлсэн шүү дээ...

-Уржийн уржигдар би танд мөнгө гуйвуулах муйвуулахыг чинь хүлээж чадахгүй гэж хэлсэн шүү дээ. Миний мөнгийг өгөхгүй таван хоног болсон байтлаа өглөөний хоол өгсөнгүй барьсангүй гэж ярих юм алга.

Гийчин товчхон боловч хорсолтойгоор хараалаа.

-Өө хөө! өө-хөө! гэж тэнд байсан хүмүүс дуугаралдав.

- Эрхэм минь хараал хэлэхээ тэвчвэл би танд баярламаар байна

гэж Холл авгай хэлэв.

Цаад хүн авгайн өмнө усанд шумбадаг хүн аятай зогсоно. Холл авгай гийчнээ дийлж байгаа нь тэнд байгаа хүмүүст илт байлаа. Тэр хүний цаашаа хэлсэн үгний байр ч ийм болсныг батлав.

-За хонгор минь, дулж л бай л даа гэж эхэлтэл Холл авгай тас дайрч:

-Би таны “хонгор” биш гэв.

-Надад гуйвж ирэх мөнгө маань гуйвж ирээгүй байна гэж би танд хэлсэн шүү дээ.

-Гуйвуулж ирэх мөнгө мөнгө гэнэ!

-Надад одоохондоо мөнгө гэх юм...

-Нэг алтан зоос хэртэй мөнгө бий гэж та чинь уржийн уржигдар хэлж байсан шүү дээ.

-Тийм ээ, арай илүү ч байна, Хүмүүс:-Ө-хө-хө! гэлцэв.

-Хачин юм даа, хаанаас олоо вэ? гэж Холл авгай асуухад өнөө гийчний уур маш их хүрсэн бололтой:

-Тэгээд та юу гэх гээд байгаа юм? гэж газар дэвслэн зандчив.

-Таныг хаанаас мөнгөтэй болчихоо юм бол гэж би гайхаж байна. Танаас би мөнгө авч танд би хоол өгөхийн наана би ч учрыг нь олохгүй байгаа, ер нь хүн бүр учры нь олохгүй байгаа, тэгээд хүн бүр учры нь мэдэхсэн гэж сэтгэл ихэд донслон байгаа хэдэн зүйлийг та надад талйж өг. Та дээд өрөөнд байхдаа миний сандлыг яаж оролдсон, намайг ороход хүнгүй байсан атлаа харин та хаанаас яагаад тэнд ороод ирсэн бэ? Энд ирж суудаг хүн болгон л орж гардаг хаалгаар нь орж гардаг байтал та юунд эс тэгнэ вэ? Чухам та ямар аргаар яагаад орж ирсэн учрыг би мэдэхсэн, Бас мэдэхсэн гэмээр юм... гэж Холл авгай ярьж байтал өнөөх хүн нь бээлийтэй гараа өөд болгож хөлөөр газар дэвсэлж, уур нь бадран, “Боль” гэж хашхиртал Холл авгай даруй дуугүй болов.

-Би ямар хүн, юу болохыг та мэдэхгүй байна уу? Гайгүй үзүүлээд өгье. Нээрээ бүр нэг үзүүлээд өгье! гээд гарынхаа алгаар нүүрээ дараад автал нүүрнийх нь тэхий дунд хар нүх онгойжээ. “Май хар” гэж хэлснээ урагш алхаж нэгэн юмыг Холл авгайд атгуулав. Холл авгай түүний хачин болсон нүүрнээс нүдээ салгаж чадалгүй ширтсээр өгсөн юмыг нь аяндаа авч үзмэгц дуу алдан хашхирч газар хаяв. Хамар, нөгөө хүний хамар байна гэнэ! Улаан ягаан хамар шалан дээр унаад картон цаасны дуу гарчээ. Дараа нь нүднийхээ шилийг авахад хүн бүр гайхан дуу алдлаа. Мөн малгайгаа авч хаян, хууз толгойн боолтыг хамаа намаагүй угз татан зулгааж эхлэхэд анхандаа дийлэхгүй байгаа юм шиг байлаа. Нэг айхтар аюултай юм болох нь гэдэг бодол хүмүүст төрж “Аяа бурхан минь” гэж нэг нь хэлэв.

Тэгтэл нөгөө хүн хууз, толгойн боолтоо хуу татлаа. Хэний ч санаанд үнэхээр багтамгүй аймшигтай хачин хэрэг болжээ. Холл авгай үхтэлээ айж дэмий л гагалзан зогсож байснаа муухай хашхираад хаалга дэлсэв. Хүн болгон сандран орох газраа олж ядав. Шарх сорви, гэмтэл согогийн ором огт алга! Толгойн боолт, хиймэл үс сэлт лангууны хайсан дээгүүр шидэгдэж тэнд байсан хүмүүсийг эгээ л оносонгүй. Хүн бүхэн шатаар бие биеийг түлхэн доош гүйлдэв. Юу гэвэл өнөөх хүн зочны өрөөний босгон дээр учрыг нь олоход нэн бэрх юм тайлбарлан гараа занган зогсоход хүзүүгээ хүртэл зүгээр биетэй барьцтай хүн ба хүзүүнээсээ юу ч үгүй зүгээр хоосон агаар байв.

Тосгоныхон хашхиралдаж бархиралдах дуу чимээ сонсоод тэр зүг харвал “Сүйх тэрэг ба морьд” буудлаас хүн амьтан нь гүйлдэн гарч байв. Холл авгай ойчиж, Тедди Хенфри түүнийг арай л дайрчихалгүй дээгүүр нь дүүлэн гарч, бас тэр их дуу чимээгээр гал тогооноосоо гүйн гарсан Милли хүүхэн толгойгүй хүний араас очиж мөргөчихөөд аймшигтай муухай орилов.

Тансаг идээний эзэн, бэт самран байтай тоглоомын эзэн, дүүжингийн эзэн, туслагчийн хамт охид хөвгүүд хөдөөний дэгжин эр, энэ нутгийн гангачуул, хэлхгэр нөмгөн цамцтай өвгөчүүл, цээжмэгтэй цигаан нар цөмөөрөө гадаа гарч зогсох нь зогсож, гүйлдэх нь гүйлдэж тэр зочид буудлын зүг хандав. Хоромхон зуурт дөчөөд хүн цуглажээ. Цугласан хүмүүс үйсэн шуугиж, хашхиралдах нь хашхиралдаж, түлхэлцэлдэн чихэлдэж, бие биеэс элдвийг асууж сураглан ийм байх, тийм байх гэж эдвээр тааж таамаглан хүн болгон зэрэг зэрэг ярьж, хэн юу ярьж байгааг нь мэдэх аргагүй байв. Хэдэн хүн муужирч унасан Холл авгайг түшиж бөөцийлнө. Үймж сандарсан тэр олон хүний дотор уг явдлыг нүдээр үзсэн нэг хүн ажигласан сонин юма хэлэх гэж бусдаас чанга дуугарахыг хичээн, “Гойд хачин хэргээ!”, “Юу болоо вэ?”, “Зарц хүүхнийг хутгалах гэсэн байхаа”, “Тоглоомгүй, нээрээ толгойгүй юм байна билээ”, “Үхсэн хойноо, илбэ л биз”, “Толгойн боолт энэ тэрээ аваад хаячихсан, чинь хөөш” ... гэх мэтээр шуугина.

Цугласан хүмүүс зочид буудлын онгорхой хаалгаар шагайж харах санаатай хошууран ханарахад хамгийн зүрхтэй нь түрүүлжээ.

Тэнд түр зогссоноо зарц хүүхнийг хашхирмагц түүний зүг эргэж, хүүхний банзал гялалзан өнгөрөхөд хойноос нь явж байгаа харагдсан! Дараа нь гартаа хутга, бөөрөнцөг талх барьчихсан буцаж ирээд гэнэт нэг юмтай тулгарсан юм шиг дороо зогсоод өгсөн. Тэгээд л ... үүд рүү явна билээ. Бүр нээрэн шүү. Бүр яах аргагүй толгойгүй юм байна билээ. Та нар ялимгүй түрүүн ирсэн бол өөрснөө үзэх байж... гэтэл ар талд дуу чимээ дэгдэхэд яригч дуугүй боллоо. Царай зүс нь баахан улайж эрэлхэг дайчин байдалтай болсон Холл тэргүүтэй тэр нутгийн цагдаагийн дарга Бобби Жефферс дараатай, хойноос нь хэрсүү хашир Вожерс олны дундуур зай тавиулан үлэмж зоримог орж ирэв. Тэд нөгөө хүнийг баривчлах хуудас барьжээ.

Хүмүүс сая болсон явдлын талаар янз янзаар ам булаалдан ярьцгаалаа.

-Толгойтой ч байсан толгойгүй ч байсан би барих л үүрэг авсан хүн! гэж Жеффер зарлахад Холл довжоон дээр гарч зочны өрөө рүү шууд хүрч очиход хаалга нь онгорхой байв.

-Дарга аа, та одоо зорьсноо биелүүл! гэж Холлыг хэлэхэд тэргүүнд нь Жефферс, дараа нь Холл, хойноос нь Вожерс оров. Тасалгааны дотор бараг харанхуй бөгөөд толгойгүй хүн бээлийтэй нэг гартаа хэсэг талх, нөгөөдөө жоохон бяслаг барьсан харагдахад Холл: - “Тэр байна” гэтэл толгойгүй хүний дээлийн захны дээхэн талаас

-Юун чөтгөр вэ? гэсэн дуу гарлаа.

-Та ер нь ямар жигтэйхэн хачин хүн бэ, эрхэм минь. Танд толгой чинь байсан ч, байгаагүй ч яахав, бие чинь байгаа хойно би одоо үүргээ биелүүлнэ дээ гэж Жефферс хэлэхэд

Толгойгүй хүн цааш болж:- Бүү халд, цаашаа! гээд талх бяслагийг шидэхэд, Холл ширээн дээр байсан хутгыг шүүрэн авч амжив. Толгойгүй хүн зүүн гарынхаа бээлийг авч Жефферсийн нүүр лүү хаяв. Төдхөн Жефферс баривчлах эрхийн тухай нэг хэдэн үг урсгаад тэр хүний үзэгдэхгүй болсон гарын царвуу, хоолой багалзуураас нь ухасхийн тэмтрэн барьж авав. Жефферс хөл рүүгээ маш чанга цохиулсан хэдий

боловч гар тавьсангүй. Энэ ноцолдооны үед яг хөл бөмбөгний хаалгач шиг байсан Холл өнөөх хутгаа ширээн дээгүүр дамжуулан өгөөд өөрөө Жефферс, тэр хачин хүн хоёрын зууралдан бие биеийг цохиж арай л ойччихоогүй ноцолдож байгаа зүг нэг алхав Зам дээр нь байсан сандал тар түрхийн өнхрөөд өнөөх хоёр маань шалан дээр ойчлоо.

-Хөлий нь бариад ав! гэж Жефферс шүд зууж хэлэхэд Холл зааврын ёсоор хийх санаатай оролдтол хавирга руугаа сүрхий цохиулж түр зуур жагсаалаас гарав. Толгойгүй этгээд нь дийлж Жефферс ноёны дээр гараад ирэхийг мэдсэн Вожерс хутга барьсан хэвээр үүдний зүг зугтаж, энэ үед хууль журмыг сахиулагч даргад туслахаар байсан Хекстер, Сиддербриджийн тээвэрчин хоёртой мөргөлдөв. Яг энэ үед тавиур дээрээс хэдэн шил сав унаж хахуун нялуун үнэр хамраар ханхийв. Өнөөх хачин хүн Жефферсийг дороо хийчихээд нухаж байсан атлаа:

-Би бууж өгье гэж хашхираад босов. Тулалдах үедээ баруун гарынхаа бээлийг ч аваад хаячихсан учир хоёр гар ч үгүй, толгой ч үгүй, аймаар харагдана. Их амьсгаадах бөгөөд “тун базаахгүй юм болж байна” гэж чичирхийлэн дуугарав.

Толгой гэмээр юм харагдахгүй хэр нь хүний дуу хоосон газраас гараад байх, энэ ертөнцөд даанч сонин хэрэг олон ч гэсэн Сассескын хүмүүс хэр баргийн юманд давхийхгүй орчлонгийн хамгийн догь улс юм байх аа. Жефферс босож ирээд гарын гав гаргаж ирснээ тэр даруй алмайран гайхаш тасарч энэ явдал ер бишийн байдалтайг бүүр түүр ухаарч эхлэн зогтуссанаа:

-Үгүй ер! Чөтгөр алгад! Харагдахгүй юманд чинь яаж гав зүүх билээ гэв.

Хачин хүн хоосон ханцуйгаараа цамцны энгэрийг илтэл товчууд нь илбийн хүчээр тайлагдаж, хөлийнхөө хавилдуу юм дуугарган бөхийж оймс гутлаа оролдох шиг боллоо.

-Хүүе! Энэ ерөөсөө хүн биш ээ. Хоосон хувцаснаас өөр юм алга. Хараач! Зах мах, ханцуй манцуй нь цулгай байна шүү. Гараа хийгээд үзсэн ч болмоор... гэж Хекстер гэнэт хашхираад гараа сунган явуултал хий хоосон нэг юм дайралдсан бололтой дуу алдан хашхирч гараа татав. “Гараа, миний нүднээс холхон байлгавал дээр байх шүү” гэж маш ууртай хилэнтэй дуу хий агаарт цууриатаж “Надад дутуу юм алга, миний гар, хөл, толгой түрүү цөм л байна, ганцхан л үзэгдэхээ больсон хүн байна. Тун эвгүй боловч яая гэх вэ, би ийм л болжээ. Ингэлээ гээд намайг Айпингийн аль нэг тэнэг бүхэн зоргоороо урж тасчих гээд байх чинь ямар вэ дээ? зөв үү? буруу юу? гэв.

Үл үзэгдэх юманд өмсөөтэй байгаа өмд цамц ер товчгүй, харагдахдаа бас ч хоёр ханцуй нь ташаа тулсан байна.

Хекстер, үл үзэгдэгчийн гомдонгуй байдалтай ярьж байгааг анзааралгүй:

-Юу гэнэ! Үзэгдэхгүй гэнэ үү? Ийм ёс хаана байсан юм! гэтэл:- Нээрээ хачин байж болох боловч үүнд гэм хор нь юу байсан юм? Цагдаагийн дарга яалаа гэж намайг дайрч довтлоод байгаа юм? гэх дуу гарав.

-За тэр ч яахав. Энд баахан гэрэл гэгээ муутай байгаа болохоор таныг олж үзэхэд жаахан хэцүү байна. Гэсэн ч би таныг баривчлах тушаал авсан хүн, яриан алга. Таныг үзэгдэхээ болилоо гэж баривчлах гээгүй. Харин айлын гэрт хүчээр орж мөнгө хулгай хийсэн хэрэгт баривчлах гэж байна гэж хэлэхэд цаадхи нь:

-Нээрэн үү? гэв.

-Батлах гэрч баримт байгаа юм.

-Үхсэн хойноо!

-Тийм байж болох юм, эрхэм минь. Гэсэн ч би тушаал биелүүлнэ дээ.

-За тэгвэл яахав, би явъя, явъя, харин гартаа гав хийлгэхгүй шүү.

-Тогтоосон ёсыг дагалгүй горьгүй.

- Гав л хийлгэхгүй дээ гэж үл үзэгдэх хүн зүтгэв.

- Өршөөгөөрэй, даанч болохгүй дээ гэж Жефферс хэлтэл нөгөө

үл үзэгдэгч нь гэнэт доош болоод юу болж байгааг нь хэн ч ухаараагүй байтал өмд, гутал, оймс нь ширээний доогуур орж төдхөн өнөөх дүрс дээш болж цамцаа аваад хаяв.

Жефферс юу болж байгааг гэнэт ухаарч:

-Хүүе болиорой! гэж хашхичин хантаазнаас нь шүүрэн барьж чангаатал тайлагдахгүй байсан дотуур цамц нь сугаран гарч гарт нь хоосон хантааз үлдлээ. Жефферс: Бариад аваарай! Хувцсаа л бүрэн тайлчихвал! гэж хашхирлаа.

-Бариарай, бариарай! гэж хүн болгон хашхираад одоо тэр хачин хүнээс үзэгдэж байгаа ганц цагаан цамцнаас нь барьж авах гэж оролдов.

Цамцны хойноос түрүүлэн хоёр гараа дэлгээд гүйж байсан Холлыг цамцны ханцуй сурамгай цохиж өвгөн тахилч Тутсомын зүг түлхчихэв. Төдхөн өнөөх цамц эвхрэлдэн хумиралдаад яг л тайлагдаж байгаа юм шиг хөдөлж байхад Жефферс тэрнээс барьж татсанаар харин тайлахад нь дөхөм болжээ.

Дараа нь хий хоосон газраас түүний шүдийг цохив. Тэгэхээр нь Жефферс мунаа шүүрэн авч Тедди Хенфрийн зулай руу хар хүчээрээ шавхуурдав.

-Мэдээрэй! Бариарай! Хаалгаа хаа! Битгий гарга! Би нэг юм бариад авлаа! Хүүе! Хүүе! Өнөөх чинь энэ байна! гэх мэтээр хүмүүс хашхиралдана.

Тасалгаан дотор учир зүггүй их үймээн дэгдэв.

Хүн бүр дэлсүүлж байгаа мэт байлаа.

Хамраа хайр найргүй цохиулснаас хойш угаас овжин ухаан нь улам хурц болсон Сенди Вожерс үүдийг дахин нээж өөрийн биеэр бусдад үлгэр үзүүлэв. Хүн бүхэн түүнийг дагалдан гүйтэл тасалгааны үүдэн дэх булан хүрээд шахцалдан зодоо үүсэж хүмүүс нэг нэгнээ балбах бөгөөд унитар шашны талын Фиппс гэдэг хүн нэг үүдэн шүдээ булга цохиулж, Хенфрийн чихний гэдэс хавджээ. Жефферсийг эрүү рүү нь нэг юм цохиод авахад эргэмцээ гар сарваймал Хекстер, тэр хоёрын хооронд саад болоод, гарах гэхэд тээглээд байгаа нэг юмнаас бариад авчээ. Тэгсэн чинь булчин ихтэй хүний хэнхдэг гарт нь тааралджээ. Төдхөн тэмцэлдэн, сэтгэл ихэд үймсэн олон хүн, тэртэй тэргүй пиг дүүрэн байгаа үүдний өрөө рүү чихэлдэн орж байв.

-Бариад авлаа! гэж Жефферс амьсгаа давхцан хашгирлаа. Царай нь барайж, чамархайных нь судас гүрийжээ. Олны дунд үл үзэгдэгч дайсантайгаа үзэлцэн ноцолдсоор гуйвчиж байв. Олон хүн зай тавин энэ хачин зодоонд орсон улс даруй довжоогоор урсан гудамжинд гарлаа. Жефферс бүдэг дуугаар хашгирах боловч гараа тавилгүй, харин ч хөлөөрөө өшигчиж явна. Гэнэт элсэрхэг газар савж унаад толгойгоо ихэд чанга цохив. Гараа ч тавив.

-Бариад аваарай! Гэж бачимдан хашгиралдаж байтал нэг залуу нэг юмнаас бариад авснаа тэр дорхноо алдаад, газар сунан хэвтэж байгаа цагдаа даргын биеэн дээр дарж унав. Гудамжны дунд зогсож байсан нэг бүсгүйн дэргэдүүр нэг юм сүр сар хийн өнгөрөхөд тэр бүсгүй дуу алдан хашгирчээ. Бас нэг нохой лав мөр дээр нь тээглэж хавирга руугаа цохиулсан бололтой гасалж гангинан Хекстерийн хашаанд зугадан орж яваа харагдана. Ингээд өнөөх үл үзэгдэгч хүн оргон зайлсан ажээ. Олон хүн нэг хэсэг гайхалдаж гар хөлөө занган шуугиж байснаа айж сүрдэн салхинд хөөгдөх хуурай навч шиг тосгоноор нэг бутран арилав.

ЗАМ ЗУУР

Энэ наймдугаар бүлэг тун товчхон бөгөөд нутгийн түмэн бодис судлагч Жиббинсийн тухай өгүүлнэ. Жиббинс томхон ухаа дээр зүүрмэглэн хэвтэж байхдаа хаашаа ч харсан өөрөөсөө хоёр бээр газар хүн лав байхгүй гэж бодож байжээ. Гэтэл яг дэргэд нь хүн ханиаж найтаагаад хараан зүхэх дуулдав. Жиббинс ийш тийш хараад юу ч олж үзсэнгүй. Гэтэл ойрхон газар нэг хүний дуу гарч тод үгээр, утга төгөлдөр хараал хэлэхийг нь сонсоход тийм хүн бол юм мэддэг боловсролтой хүн байж таарна гэж бодогдов. Хүний дуу бүүр ойртох шиг болж байснаа дахин холдон холдсоор Эддердиний зүг замхран дуулдахыг больжээ. Хүчтэй найтаах чимээ дахин нэг гараад дахин нам гүм болдог байж. Жиббинс өглөө болсон явдлыг дуулаагүй байсан учир энэ явдалд маш их гайхан, баахан зовниж гүн ухааны бясалгах тайван байдлаа даруй алдан босон харайж тэр эгц ухаа дээрээс тосгоныхоо зүг түргэн түргэн алхав.

ТОМАС МАРВЕЛ

Томас Марвел гэж ааш зан цайлгандуу, нүүр царай дугираг, баахан эв хавьгүй том хамартай, ёрвогор нойтон уруултай, сахал самбай нь сөрвийж сэрвийсэн, бие бүдүүн тарган мөртлөө дөрвөн мөч богино хүн билээ. үслэг нарийн эсгий малгай

өмсчээ. Хувцасных нь нилээд олон товч унаж оронд нь шаахай гутлын оосор бүч хийснийг үзвэл зайлшгүй ганц бие хүн байж таарна.

Томас Марвел Айпингээс бүтэн хагас бээр орчмын зайтай Эддирден ордог замаар хажуу гуу руу хөл жийн унжуулчихаад сууж байлаа. Тамтаггүй муудсан оймстойгоо л байжээ. Хөлийнхөө хурууг ээтийлгэсэн нь ийш тийш соотогнож байгаа нохойн чих мэт харагдана. Марвел ерөөс яарч сандрахыг мэддэггүй хүн болохоор хос гутлаа яарамгүй хэмжиж суулаа. Тэр гутал түүнд олсон хамгийн бөх бат гутал боловч бага зэрэг ихдээд байгаа ажээ. Түүнээс урьд өмсөж байсан гутлаа мөн дэргэдээ авч байлаа. Хуучин гутал нь хуурай цагт өмсөхөд аятайхан боловч бороо чийгтэй дэндүү амархан нэвтрэх нимгэн ултай юм байж. Томас Марвел чийг нойтныг үзэн ядах хэр нь өргөн зузаан гуталд дургүй. Ер нь чухам алинд нь даамай муугаа сайн ч бодож олоогүй байсан тул хоёр хос, дөрвөн ширэн гутлаа аятайхан зэрэгцүүлж тавьчихаад ширтэн сууж байтал өвсөн дотор байсан хоёр гутал нь тун муухай харагдах шиг болов.

Бараг дэргэд нь нэг хүн дуугарах чимээ гарахад давхийсэнгүй. Гэтэл – гутал л юм даа хөөрхий, яая гэх вэ! гэж хүн дуугарав.

- Сайнаас сайн гутал юм шүү гэж Марвел хариу дуугараад

толгойгоо баахан далжийлган гутлаа зэвүүрхэн харж байснаа:

-Золиг чинь аль нь дээр юм шүү юм бэ дээ! гэв.

-Х-м! гэх дуу дахин гарлаа.

Үнэндээ би муухай юм өмсдөг байсан, заримдаа хөл нүцгэн ч явдаг байсан. Гэсэн ч иймэрхүү балай юм надад байгаагүй юм шиг санагдаж байна. Би энэнээс болж өвчин олох байтлаа энүүнийг олж авах гэж бас хэдэн өдөр хөөцөлдснийг яана. Миний хуучин гутал ч бөх нь бөх сайн хэвээрээ байгаа юм, гэхдээ жуучлах дээр хүрвэл гутлынхаа царай харах явдал олон байдаг шүү. Энэ нутгаас энүүнээс өөр олигой сайныг олох гээд олоогүй л юм даа, би худал хэлэх хүн биш. Та үз л дээ! Ер нь энэ нутагт гутал нэлээд яггүй хийдэг юм шүү. Миний гутал шиг гутал ч ховор биз дээ! Би чухам энэ нутгаас сүүлийн арван гаруй жил гутал авч байна, тэгэхэд ингэнэ гэж байх уу даа! Гэтэл нөгөө хүний дуу:

-Энэ чинь хамгийн балай газар, эндэхийн улс гэдэг чинь гахайнаас өөрцгүй гэв.

-Нээрэн үү? Ай бүү үзэгд, ямар ч гутал байх вэ! энүүнээс дор юм гэж байхгүй байх аа гэж! гэж Марвел хэлээд нөгөө ярилцагч этгээдийнхээ өмссөн гутлыг харж өөрийнхтэйгээ зүйрлүүлэх гэж баруун тийш эргэн харвал хүний хөл ч үзэгдэхгүй, гутал ч үзэгдэхгүй байв. Гайхшаа барж- Та чинь хаана байна даа? гэж асуунгаа дөрвөн мөчлөн өндийв.

Салхи үлээсэн нүцгэн дов, нэлээн цаана ногоон бут сондуулаас өөр юм харагдсангүй.

-Би согтуу байна уу даа? Аль зүгээр ингэж санагдав уу, магадгүй ганцаараа ярьчихав уу? юу гэгч.. гэж Марвель гайхна.

-Битгий ай гэж хүн дуугарав.

-За, за та битгий даажигнаач гэж Марвель хэлээд бушуухан босож

-Та хаана байна вэ? Юунаас айх вэ, зүгээр гэв.

-Битгий ай

-Чи өөрөө мөд айх биз. Сайхан мэдээрэй мангуу минь. Чи хаана байна? Гайгүй, би чамд үзүүлээд өгье. Юу болохы чинь гэж Марвель омогдоод жаахан байзнаснаа:-Таныг чинь арай авсалчихаагүй юм байгаа биз? гэж асуув. Хариу гарсангүй. Томас Марвел мэл гайхаж, хөл нүцгэн хэвээр зогсож байлаа. Богинохон огтор дээл нь мултраад ойчих шахжээ.

-Шууг гэж нэлээд хол дуулдахад -Ёстой л шууг байна даа, битгий дэмийр гэж Марвел хэлэв. Дөрвөн зүг найман зовхист хүн амьтангүй, ухаа толгод л харагдлаа. Жижиг гуу, цагаан модон шонгоор эмжээрлэгдсэн зам өрнө, дорно зүг зурайн харагдана. Хөх огторгуйд хатгаалжин шувуунаас өөр юу ч үл үзэгдэнэ

Томас Марвел богино дээлээ ахин эгэлдэргэлснээ:

-Ай бурхан минь! Лав согтуугийн солио байж. Тэрнээс биш яалаа гэж ингэх билээ! гэв.

-Согтуугийн солио биш, та битгий зов гэж бас хүн дуугарахад Марвел-Ая-я гэж дуу алдаж, цоохор царай нь зэвхий дааж цайгаад- Лав архины цагаан солио байх гэж амандаа бувтнав.Марвел аяархан эргэн тойрч зүг зүг бүлтийн харж – аргагүй л хүний дуу гараад байна даа гэж шивнэхэд: -Та үнэхээр эндүүрээгүй шүү гэж цаанаас нвь дуугарав. –Дахиад! гэж Марвел дуу алдаж нүдээ таглан, гаслантайгаар өргөж духаа барив.

Гэнэт нэг хүн заамдан сэгсчихэд түүний дотор харанхуйлж, ухаан балартах шиг болжээ.

-Битгий дэмийр! гэж нэг хүн дуугарахад Марвел:

-Би лав... бүр... яах вэ дээ. Би энэ муусайн гутлыг даанч и х бодсон юм. Тэгээд л ийм солио тусдаг байна шүү. Хэн мэдэх вэ, чөтгөр ч юм билүү? гэхэд өнөөх дуу:

-Аль нь ч биш . Миний хэлэх үгийг та сонс! гэхэд Марвел:

- Надад солио тусчээ, хөөрхий! гэв.

-Жаахан хүлгэлз! гэж уурссан янзтай боловч биеэ барьсан янзтай дуугарахад Томас Марвел:

-За тэгээд? гэж хариу болтол нь нэг хүний хуруу хэнхдэг рүү нь хатгах шиг болжээ.

-Та өөрийгөө ухаан балартсан шалтгаар ийм юм болоод байна гэж санаж байна уу? гэхэд нь:

-Тэгвэл өөр юу байх билээ? гэж хариу хэлээд шилээ маажихад нөгөө хүний дуу:

-За тийм байж гэж сэтгэл тэнийсэн янзтай хэлээд –Би таныг өөрөөр бодохы чинь хүртэл таныг чулуугаар шидээд байя гэхэд Марвел:

-Та чинь чухам хаа байгаа хүн бэ? гэхэд дуу дахин гарсангүй.

Агаарт чулуу шунгинаж Марвелын дал мөрийг арай л оносонгүй. Марвел эргэж харвал газраас нэг чулуу дээш их л хурдан мушгиралдан дэгдэж, дээр түр тогтсоноо доош яах ийхийн завгүй эрчлэн бууж, хөлий нь цохив. Марвел тун их гайхсандаа чулуу унах газраас зайлъя ч гэж ухаарсангүй. Тэр чулуу шунгинан бууж Марвелын хөлийн эрхий хурууг оноод хальтран гуу ороход Марвел хэртхийн цочиж, ёолон чанга хашхирав. Тэгээд зугтсан боловч үзэгдэхгүй хий юманд тээглэн ойчоод өнхөрч хөрвөсөөр суугаа байдалд тогтов.

-Уухай гэж хүний дуу гартал бас нэг чулуу дээш хөөрч тэнүүлчийн толгой дээр тусахад, та намайг толгойдоо бодоод зохиочихож уу, эсвэл өөр юм байна уу? гэж хүний дуу асуув.

Марвел хариу үг хэлэлгүй арайхийн бостол бас л хий юм унагаачихав. Хэдэн минут хиртэй хөдөлгөөнгүй хэвтэж байтал:

-Таныг миний өөдөөс гар сарвайвал би толгойгий чинь энэ чулуугаар хагална шүү гэж хүн дуугарав.

-Тун ч магадгүй юм байна гээд Марвел хэлээд өндийн сууж, хөлийнхөө гэмтсэн хурууг гараараа барьж өнөөх гурав дахь удаагийн чулуун сумыг гөлрөн харсаар байв.

-Ухаан хүрэхгүй байна! Чулуу өөрөө нисэж, хүн шиг яриад байх болж... Доошоо буугаач, холхон зайлаач, би гар сарвайхаа бүр больё гэв.

Гуравдугаар чулуу унажээ.

-Ухаан хүрч ядаад байх юм ер алга, би бол үл үзэгдэх хүн байгаа юм гэсэн дуу гарав.

-За бүр ч болилоо гээд Марвел өвдсөндөө дуу тавив.

-Та хаана нуугдаад байна вэ? Яаж ингээд байгаа юм бэ? Миний ухаан хүрэхгүй байна!

-Би үзэгдэхээ л больсон хүн байна. Харин та юунд их тэсвэргүй загнана вэ?

-Та ер чухам хаана байгаагаа надад хэлж өгөөч дээ.

-Би үзэгдэхээ больсон хүн . Ийм л учиртай юм. Тан энэ учрыг ухаараасай гэж би хүсэж байна. Гэтэл Марвел үгий нь таслан:

-Үгүй та хаана байна вэ? гэв.

-Танаас зургаан алхмын төдий зайтай байна.

-За боль доо! Ямар сохор хүн байгаа биш. Аягүй бол та өөрийгөө агаараас бүтсэн хүн гэх вий. Би энгийн нэг тэнэг амьтан биш шүү. –Харин тийм гэм. Би хий агаар шиг болчихоод та намайг нэвт харж байна.

-Юу-уу? тэгэхээр таны дотор ямар ч юм байхгүй нь үү? Дэмий донгосдог ганц дуу л үлдээ юу, аа?

-Би махбодоор бүрдсэн жинхэнэ хүн, надад хоол унд хэрэгтэй байна. Хувцас ч хэрэгтэй байна....Гэвч би үзэгдэхгүй хүн болохоор... үзэгдэхгүй байгаа юм шүү дээ! Ердөө л үзэгдэхээ болиод байгаа юм шүү!

-Тэгэхээр та чинь амьд байх нь ээ?

- Амьд байлгүй яахав.

-Нээрээ амьд юм бол гараа өгөөч, тэгвэл итгэтлээ хачин санагдах нь жаал гайгүй болох болов уу?

- Ай шүтээн минь! Намайг огло харайлгалаа, хүнийг ингэж базаж болдог юм уу? гэж Марвел гэнэт хашхирав.

Нэг хүний гар сарвуунаас нь барьжээ. Марвел аргагүйн эрхэнд гар сарвайхад үл үзэгдэх хүний гар, булчин хэнхдэг, сахал самбай болсон нүүр тэмтрэгдэв.

Марвел маш гайхаж, царай зүс нь хачин болжээ.

-Чөтгөр аваг! Энэ чинь тахианы зодооноос ч илүү сонин юм гээч, хөөш, хачнаа! Тэртэй, тэр хагас бээрийн газар байгаа чандага таны биед халхлагдахгүй ганц л ... гээд мань хүн хоосон зай руу бүлтийн ширтлээ.Марвел тэр үл үзэгдэгч гарыг тавихгүй барьсаар байв.

-Та талх, бяслаг идсэн юм уу?

-Нээрэн тийм. Шингэж арай амжаагүй байна.

- Аа! Та ер нь хий ороолонтой л төстэй юм аа даа?

-Танд санагдаж байгаа шиг тийм их гайхмаар юм биш шүү.

-Над шиг мэдлэг нимгэн хүнд сүрхий хачин юм байна. Яаж т аиым болов оо? үгүй ер, яагаад ийм болж болоо вэ?

-Яриад байвал дэндүү их юм байна. Тэрнээс гадна ... тархи толгой минь ч эргэж гүйцлээ. Та одоо аан гэж бай. Надад тус хүргэ. Таныг тусыг заавал хүртэлгүй болохгүй нь. Тантай санаандгүй учирлаа. Бухимдаж, эцэж ядраад, нүцгэн явж байгаад алах хядахыг ч буцмааргүй байтал ... харин та тааралдлаа.

-Ай эх дагина минь! гэж Марвел дуу алдлаа.

-Би таны араас сэм хүрч ирэн жаал азнаж байгаад буцан явсан юм. Энэ үгийг сонссон Марвелын юу бодож байгаа нь нүүр царайд нь ил тод бөгөөд ганцаардаж ад үзэгдсэн хүн юм даа гэж бодоод таны дэргэд хүрч

-Ай эх дагина минь! Ухаанаа ч олохыг болилоо. Танд тэгээд яаж тус болох юм вэ? Үзэгдэхгүй хүнд

-Та надад өмсөх хувцас, хорогдох орон, цаашдаа хэрэгтэй юм хүмтэй болоход тусал. Хэрэгтэй юмаар гачигдсаар би их удлаа. Тус хүргэхийг эс бодвол ч яахав. Бодох хэрэгтэй дээ, бодох ч ёстой болно шүү! гэв.

-Эрхэм минь! Миний толгой эргэж гүйцлээ! Намайг загнахаа болиоч! Зүгээр байж үзээч. Би жаахан амсхийе. Та чинь миний хөлийн эрхий хурууг эгээ л няцалчихаагүй. дэндүү байна шүү. Хүн амьтан харагдахгүй дов толгод, хоосон тэнгэр л харагдах юм. газраас өөр эргэн тойрон юу ч үзэгдэхгүй байсан чинь гэнэт хүний дуу гараад, дээр агаар хийд л дуугарах шиг болох юм! Чулууг хэлэх үү! Зангидсан гар! Ай тэнгэр минь

-Биеэ барьж миний зорьсон ажлыг бүтээ.

Марвел хацраа түмбилйгэн, нүдээ бүлтийлгэв.

-Би таныг сонгож авсан шүү. Эндхийн тэнэгүүдээс гадна танаас өөр ганц ч хүн үл үзэгдэх хүн байдгийг мэдээгүй байх. Та надад туслах ёстой хүн. Надад тус хүргэ, би таны ачийг хариулна. Үзэгдэхгүй хүн гэдэг чинь сүрхий их хүч шүү гэж хэлснээ гэнэт тун чанга найтаалгаж –Хэрэв намайг бусдад мэдэгдвэл, миний үгэнд орохгүй байвал, миний үгнээс гажвал... гээд дуугүй болон Марвелийн мөрийг алгадав. Марвел ухаан алдах шахан гагалзав.

Марвел тэр хүний гарын чигээс бултаж:

-Би таныг бусдад хэлэхгүй. Хэлчихнэ байгаа гэж битгий зовоорой. Чухам би юу хийх вэ, та хэлж аль /Эх дагина минь/ таны хүссэн бүгдийг чинь би маш дуртай гүйцэтгэнэ гэв.

МАРВЕЛ АЙПИНГЭД ИРЭВ

Анхны айж мэгдэх явдал аажимдаа намдахад Айпингийхэн чухам юу болохыг эргэцүүлэн бодоцгоожээ. Үл итгэх санаа бодолтой хүн тун ч олон тэгэхдээ яг итгэхээ больчихоогүй, баахан эргэлзэж байв. Ер нь үл үзэгдэгч хүн байх үгүй амархнаас гадна тэр хүн агаарт алга байсныг нүдээр үзсэн буюу гарых нь хүчийг амссан хүн

гэвэл хуруу даран тоолж болох цөөн байлаа. Нүдээр үзэж, чихээр сонсогчдын дотроос Вожерс гэртээ орж цоож цуургаа ян тан бэхлэн суужээ. Ухаан алдтлаа дэлсүүлсэн Жефферс нөгөө зочид буудлынхаа үүдэнд хэвтсэн хэвээр байлаа. Бага боловч гарцаагүй баримттай аливаа юм, хэвийн байдлаас давсан ер бишийн суут санаа бодлоос голцуу илүү их сэтгэгдэл төрүүлдэг юм. Айпингэд өнгө бүрийн туг дарцаг алаглаж, хүн ард нь өөдтэй өнгөтэй хувцас хунараа өмсөөд гадаа гарчээ.

Цагаан сумъяа гаригийн баярт бэлтгэсээр бүхэл сар болжээ. үд хэвийх үед үл үзэгдэгч хүн байна хэмээ нитгэж байсан зарим хүн хүртэл түүнийг тосгоноосоо эгнэгт зайлж явсан гэж бодоод өчүүхэн зугаа цэнгэлдээ автаж эхлэв. Харин аливаа юманд үнэмшиж итгэх дургүй хүмүүс тэр тухайг бүр инээдмийн юм болгох болжээ. Гэлээ ч гэсэн тэдний аль аль нь тэр өдөр цуг, бие биеэ бараадах дуртай байлаа.

Хейсманы нугад шаасан майханд Бантин авгай өөр хэдэн авгайчуултай хамжин цай чанаж байхад хүүхдүүд Касс, Сэкбат гэдэг хоёр охины удирдлагаар янз бүрийн тоглоом тоглож шуугилдаж байлаа. Хэн хүнгүй сэтгэл бага зэрэг түгших боловч ихэнх нь түүнийг нууж байв. Нов ногоон нугын дунд талд зоосон хоёр багананд урт лдс уяж, түүнд бэхэлсэн гохыг үсрэн барьсан хүн бүр нэг талас нөгөө үзүүр рүү гулсан очиж, шуудайтай өвсөн дээр буух тоглоомонд улайрчээ. Залуучууд энэ олсон тоглоомыг дүүжин савлуур, бэтийн самар, бай онох тоглоомын нэг адил их сонирхох аж. Тэрнээс гадна бас зугаалга болж байв. Машины то схамар хага ташуулан ханхлуулахын хамт бадралт бишгүүр эгшиг аяыг чих дөжрөм цууриатуулна. Сүмд мөргөхөөр өглөө ирсэн клубын гишүүд, ягаан, ногоон өнгийн тэмдэг зүүж, зарим алиа марзан нэг нь малгайдаа янз бүрийн гялалзсан өд сөд хатгажээ. Амралттай өдрийн баяр наадамд дурамжхан байгаа өвгөн Флетчер, цонхон дээр байгаа гүнדהа цэцгийнхээ цаана хоёр сандал дээр банз тавьж зогсоод ханаа шохойдож байв. Үүд цонх хоёрынхоо хооронд хөлхөн ажиллах нь нүдтэй хэн бүхэнд ил байлаа.

Дөрвөн цагийн алдад Дюний зүгээс нэг танихгүй хүн Айпингэд иржээ. Бүдүүн, балтгар биетэй тэр хүний домбон малгай сүрхий үнгэгдэж, амьсгаа нь давчдан, хацар нь түмбэлзэн хонхолзоно. Толбо дүүрэн нүүрэнд нь айж сүрдсэн шин жил байна. Сандарч мэгдсэн боловч арга буюу албын эрхэнд яваа мэт харагдана. Тэр хүн сүмийн буланд хүрээд “Сүйх тэрэг бөө морьд” гэдэг зочид буудал руу эргэжээ. Түүнийг ажсан хүмүүсийн нэг нь өвгөн Флетчер байв. Флетчер өвгөн хожим ярихдаа тэр тарган бүдүүн эрийн хачин балмагдсныг харж гайхан зогсож байж багстай шохойгоо ханцуй руугаа гоожуулсан юмдаг гэнэ.

Мухлагийн эзний ярьснаар бол тэр хүн ганцаараа ярьж байсан гэнэ. Хекстер ч мөн чингэж байсан гэж баталжээ.

Бүдүүн тарган эр “Сүүх тэрэг ба морьд” гэдэг зочид буудлын гадаа очоод тэр хавиар нь эргэлдэж эргэлдэж дотогш орсон гэж мухлагийн нэг эзэн хэлсэн юм. Тэгээд шатаар өгсөж, зүүн тийшээгээ эргээд гийчний өрөөний үүдийг нээхий нь Хекстер үзжээ. Тасалгааны дотор архи пивоны өрөөнд байсан хүмүүс тэр хүнийг буруу газар луу орчих нь гэж байхыг Хекстер бас сонссон гэнэ.

-Цаана чинь хүн суудаг өрөө шүү! гэж Холл хэлэхэд нөгөө үл таних хүн үүдий нь эв дүйгүй хаагаад архи пивоны өрөө рүү эргэжээ.

Хэдэн минут болоод тэр хүн гарынхаа араар уруулаа арчсаар дахин орж иржээ. Царай зүс нь давгүй мэт харагдсан боловч Хекстер гуайн хэлснээр бол тийм дүр үзүүлсэн байж таарна. Тэр сонин, гийчин түр зуур ийш тийш харан зогсоноо зочны өрөөний цонхны цаадхи хашааны хаалга руу явж хэсэг зуур тээнгэлзсэн байдалтай байснаа дааман хаалганы яс модыг налж зогсоод богинохон гаанс гарган тамхиа нэрэв. Гар хуруу нь үл ялиг чичирч тамхиа арай ядан асааж, элгээ тэврэн хэнэггүй янзтай тамхи татан зогсох боловч хашааны зүг хулгай нүдээр харах нь нэг л биш байлаа.

Энэ бүгдийг Хекстер тамхины хайрцаг хураалттай цонхоороо өлийн харж ажиглаад нөгөө хүний байдал тийм хачин байхаар нь хараад л байж. Гэнэт эгцлэн зогсож гаансаа өвөртлөн хашаан дотор оров гэнэ. Хекстер, тэр хүний хулгай хийхийг нь олж харах, хулгайчийг барих санаатай лангууныхаа цаанаас үсрэн гарав. Энэ үед Марвел малгайгаа духдуулсхийн тавьчихсан нэг гартаа хөх цэнхэр хулдаасанд боосон зөндөө том юм барьсаар цаанаас нь гарч ирэв. Нөгөө гартаа гурван номыг, хожим дуулахад, ламбугайн оймсны татуургаар боогоод барьсан байжээ. Марвел, Хекстерийг үзмэгц хиртхийн цочиж аяархан дуу алдаад шууд зүүн гар тийш эргэж зугатав.” Хулгайчийг бариарай” гэж Хекстер хашхиран хойноос нь хөөв.

Хекстерийн сэтгэгдэл тод боловч товчхон байлаа. Хекстер нөгөө хүний зугтан явахыг харж араас нь гүйсээр сүмийн булангаар тойрч замд орон хөөцөлджээ.

Энд тэндгүй баяр ёслолын туг дарцаг харагдаж, хүмүүс бужигнаж байсан боловч Хекстер руу ганц хоёрхон хүн иржээ.

-Хулгайчийг бариарай гэж Хекстер дахин хашхиран хойноос нь зориглон хөөх гэсэн боловч арван алхам яваагүй байтал гэнэт нэг юм хөлөөс нь барьж чангаагаад явж болсонгүйгээр үл барам, гэнэт улаан нүүрээрээ газар мөргөн унав. Хорвоо тэр аяараа оч дөл болон бутрах шиг санагдаж цаашдын хэрэг явдлыг сонирхох ч сэхээгүй болов.

“СҮЙХ ТЭРЭГ БА МОРЬД” ЗОЧИД БУУДАЛД

Тэр зочид буудлын газар юу болсныг тодорхой мэдье гэвэл Марвел анх Хекстерийн нүдэнд харагдсан цагийг эргэж санах хэрэгтэй юм.

Яг тэр үед Касс, Бантин хоёр зочны өрөөнд байжээ. Сайхь хоёр өглөө болсон хачин жигтэйхэн явдлын тухай хөөрөлдөж, Холл авгайгаас зөвшөөрөл авч үл үзэгдэгч хүний орхисон юм хүмийг нарийвчлан шинжиж байв.

Жефферс овоо сэхээ орж сэргээд хань нөхдөөрөө дэмнүүлж туслуулсаар гэртээ харьжээ. Холл авгай хачин гийчнийхээ энд тэндгүй хаяж шидэж орхисон хувцас хунарыг цуглуулан өрөөг нь янзалжээ. Түүний сууж ажиллаж байсан цонхны дэргэдэх ширээн дээр “Өдрийн тэмдэглэл” гэсэн гурван зузаан гэгчийн дэвтэр байхыг Касс олж үзээд эгүүлэн тавихдаа:

-Өдрийх нь тэмдэглэл байна! Бид юу ч гэсэн бага сага юм олж мэдэх байх аа гэв. Ламбугай ширээг түшин зогсож байв. Касс суунгаа -Өдрийх нь тэмдэглэл байна

гэж дахин хэлээд нэг дэвтрийг нь авч нөгөө хоёр дээр нь хазгайвтар тавьж нээгээд Хм! Цулгүй хуудсан дээр нэрээ бичсэнгүй! Муу яа! ... Нууц бичгээр бичжээ. Тоо л байна, дандаа дүрс тэмдэглэдэг байх чинь гэхэд ламбугай босож очин мөрөн дээгүүр нь шагайн харав.

Касс урам нь их хугарсан янзтай дэвтрийн хуудсыг эргүүлж байснаа- Би ... цөм нууц бичиг... Даанч тусгүй хэрэг ээ.! гэв.

-Зураг диаграмм, тодорхойлсон жишээ загвар ер алга уу? гэж Бантин асуухад, Касс: -Та өөрөө үз л дээ. Зарим газар тоо бодлого, зарим газар орсоор /үсгээр нь үзэхэд тийм л юм шиг байна/, зарим газар грекээр бичсэн байх шиг... Грекээр бичсэн газрыг нь та ... гэтэл Бантин нүднийхээ шилийг авч зүлгэн –Тэгэлгүй яахав! гэж хэлснээ урьд жаахан мэддэг байсан грек хэлнээс нь одоо бараг юм үлдээгүй учир гэнэт өөрт нь сүрхий аягүй санагджээ. Тэгэлгүй яахав, грекээр байгаа бол ч тайлах гогцоо олж болно оо гэв.

-Би танд олзоо үзүүлье.

Бантин нүднийхээ шилийг зүлгэсээр –За яахав, би юу ч гэсэн эхлээд цөмий нь нэг үзээдхэе. Эхлээд ерөнхийд нь үзэж аваад дараа нарийн гогцоогий нь олохыг бодье, Касс аа гэж хэлээд хоолой зассандаа нүднийхээ шилийг зүүж янзлан дахин хоолой засаж, муугаа мэдэгдчихээс өмнө нэг ажил явдал гараасай гэж дотроо залбиран Кассын гараас нэг дэвтрийг залхуу нь хүрсэн янзтай автал ашгүй нэг юм болж хаалга нь гэнэт онгойжээ.

Хоёул их л цочин эргэж харвал нарийн үслэг эсгий малгай өмссөн, улайвтар царайтай нэг хүн байхыг үзээд санаа амартал нөгөө хүн

-Пиво зардаг газар уу? гэж асуугаад ийш тийш харан зогсоход хоёр эрхэм-Биш ээ! гэж нэг дуугаар хариу болгов.

-Цаагуур нь тойроод ор, эрхэм минь гэж Бантин хэлэхэд Касс- Та наад үүдээ хааж үзэхгүй юу! гэж ууртай бувтнав.

Нөгөө орж ирсэн хүн “За” гэж түрүүчийн дуугарч байсан сөөнгөтсөн бүдүүн дуунаасаа гойд өөрөөр “Тэгье” гэснээ “далдраад өгье” гэж анхных шигээ дуугарав.

-Лав усан цэргийн хүн байх. Хөгийн улс шүү. Нээрэн ч далдарч баймаар амьтад! Гарья гэдгээ хэлж байгаа царай нь тэр гэж Бантин хэлэв.

-Нээрэн тийм байх гэж Касс санал нийлээд -Өнөөдөр миний толгой тархи нэг л биш ээ. Үүд нээгдмэгц би бүр босон харайсан шүү гэв.

Бантин өөрөө босон харайгаагүй юм шиг хулмалзан мишээж байснаа:

-За одоо гэж шүүрс алдаад -Өнөөх дэвтэрээ үзье гэнэ.

-Жаахан хүлээж байгаарай! Гээд Касс үүдээ түлхүүрээр түгжин –Одоо бид хоёрт саад хийх хүн байхгүй байх аа гэтэл гэнэт нэг хүн найтаажээ.

Бантин сандлаа ойртуулж Кассын хажууд зэрэгцэн суугаад:

-Айпингэд ойрдоотун хачин юм осолдохгүй л болоод байгаа юм шүү. харин үл үзэгдэгч хүн байна гэдэг яриа ч шал дэмий, худал байх гэв.

-Ер ухаанд багтмааргүй нь ч багтмааргүй хачин хэрэг л дээ. Тэгэхдээ би тэр хүний ханцуй хоосон байхы нь нүдээр үзсэн юм даа гэж Касс үгий нь тасалж хэлэв.

-Гэвч та ... ер нь... жишээ нь толинд ... ер нь тэгж харагдах учир ч байдаг л даа. Та ер нь ёстой чадалтай илбэчнийг үзсэн үү?

-Тантай би дахиж үг булаалцалдах гээд яах вэ гэж Касс хэлээд –Энэ талаар та бид хоёр бишгүй л ярилцсан, Бантин минь. Одоо бидний гарт гурван дэвтэр байна. Харин энэ дэвтэрүүдийг нь үзье... энэ л яг грекээр бичсэн юм шиг байна. Үсэг нь юу ч гэсэн Грек үсэг байна гээд дэвтрийн хуудасны тэг дунд заахад Бантины царай жаахан улайсхийн дэвтрийг шагайн харав.Нүднийх нь шил болохоо байсан бололтой, зайлуул. Мань хүн грек хэл мэдэх талаар дэндүү хуусхан атал нэд тэндээс ирсэн хүн түүнийг грек, эртний европ хэлний эх зохиолуудад цээжтэй хүн гэж боддог байжээ. Гэтэл одоо... зэсээ цухуйлгах уу? Аль тааж буудах уу? гэж бодож байтал ар шилэнд нь нэг хачин юм хүрчээ. Толгойгоо дээш болгох гэтэл ер давшгүй хүч дараад байх шиг болов.

-Битгий хөдөлцгөө эрхэм ээ, эсвэл би гавлыг чинь хага цохино шүү! гэж нэг хүн дуугарчээ.

Бантин Касс хоёрын нүүр тун ойр байсан аж. Хувраг өөдөөс нь хартал цаадхи нь яг адил айж сандарсан байна.

-Би та нартай жаахан ширүүн үзэлцэх нь, их муухай хэрэг, гэсэн ч өөр арга алга даа. Эрдэмтэн хүний хувийн тэмдэглэлийг дураараа үзэж байх занг та нар хэзээ сураа вэ? гэж бас дуу гарав. Хоёулангийх нь эрүү зэрэг ширээ мөргөж шүд нь хавхийв.

-Зовлонд учирсан хүний сууж байсан оронд дураараа орж аашилж байх ёсыг хэзээ сураа вэ? гэж хэлээд бас эрүүгээр нь ширээ мөргүүлэв.

-Миний хувцас хунарыг хааш нь хийчихээ вэ?

-Цонх чинь түгжээтэй байна. Үүдний чинь түлхүүрийг би сугалж авсан. Би угаас тэнхээ ихтэй хүн, шилээвэр гар дор байна. Би бол үзэгдэхээ больсон хүн. Та хоёрыг нядалчихаад амархаан арилчихаж чадна шүү дээ. Мэдэв үү? Ийм л байна. Та хоёрт гар ч хүрэлгүй ингээд орхивол та нар элдвийн дэмий юм яриад байхгүй байж чадах уу? Миний хий гэснийг хийх үү?

Ламбугай эмч хоёр өөд өөдөөсөө харахад эмчийн царай тун биш болжээ."Чадна" гэж эмчийн хэлэхэд ламбугай ч мөн тэгж хэлэв. Тэгтэл шилэн дээр нь юм дарахаа больж, мань хоёр ч толгойгоо өндийлгөж шилэн хүзүүнийхээ чилээг гаргав. Хоёулангийн царай барайжээ.

-Байгаа газраасаа бүү хөдөл! Гэрт байгаа шилээврийг харж байна уу? гэж үл үзэгдэгч хүн хэлээд тэр хоёрын хамрыг шилээврээрээ цохих байдлаар нэг нэг зангаж – Намайг энэ өрөөнд орж ирэхэд хүн лав байхгүй гэж бодсон юм. Бас миний тэмдэглэлийн дэвтэр, хувцас хунар минь байсан газраа байгаа байх гэж бодсон. Миний хувцас хаа байна? ... Байг.. битгий бос. Энд л лав байхгүй байна. Шалдан явахад одоохондоо өдөр нь даарахгүй дулаан байвч орой үдэш баахан жижүүн байна. Надад хувцас, бас өөр бага сага юм хэрэгтэй байна. Энэ хэдэн дэвтрээ ч авъя гэв.

ҮЛ ҮЗЭГДЭГЧ ХҮН ТЭСГЭЛЭЭ АЛДАВ

Бас нэг маш гашуудалт явдлын тухай өгүүлбэр зохих болсон тул энэхүү туужаа энэ удаа бас нэг тасалдан завсарлахгүй бол горьгүй нь ээ. Саяын явдал зочны өрөөнд болж, дааман хаалганы дэргэд налан зогсоод тамхи татаж байсан Марвелыг Хекстер ажиглаж байх үед Холл Тедди Хенфри хоёр, хувраг эмч хоёроос арваад алхам зайтай газар Айпингэд саяхан болсон явдлыг мэл гайхан цэл хөхрөн ярьж суув.

Гэнэт зочдын өрөөний хаалгыг чанга гэгч цохих, хүн дуу алдан хашхирах чимээ гараад төдхөн нам гүм болжээ.

Аяа! гэж Тедди Хенфри дуу алдахад лангууны тэндээс бас нэг хүн дуугарав. Холл хэргийн байдлыг удаан алгуур боловч зөв ойлгон.

-Нэг л биш боллоо гээд лангууны тэндээс зочны өрөөний үүд рүү дөхөж Теддийн хамт тэнд хүрч очив. Тэр хоёрын царайд сэтгэл догдолсон байдал илэрч, нүд нь учир шалтгааныг эрэлхийлсэн янзтай дүрлийнэ.

“Нэг л биш боллоо” гэж Холл хэлэхэд Хенфри толгой дохив. Гэтэл химийн бодисын маш муухай үнэр ханхалж, хүмүүс маш түргэн дүнгэр дүнгэр ярилцах чимээ дуулджээ.

Холл үүдийг тогшиж:

-Зүгээр биз? гэв. Ярилцахаа даруй зогсож түр нам гүм болсноо дахин шивнэн ярилцаж эхлээд гэнэт үгүй! байг! хэмээн чанга чанга дуугарах чимээ гарав. Тэгтэл хөдлөх чимээ гарч шалан дээр сандал ойчих хүмүүс ноцолдох шиг дуулдаад дахин чимээ тасрав.

-Ямар чөтгөр шиг юм бэ? гэж Хенфри гонгинов.

-Хүүш, та нар зүгээр үү? гэж Холл дахин чанга дуугаар асуулаа. Цаанаас нь ламбугай нэг л жигтэйхэн тасалданги дуугаар:

-Зүв зүгээр байна, та битгий саад хий дээ гэв.

-Хачин юм даа! гэж Хенфри хэлэхэд Холл бас:

-Харин тийм! гэв.

-“Битгий саад хий дээ” гэдэг нь юу вэ гэж Хенфри эргэлзэв.

-Тэгнэ л билээ

-Нэг хүн шуухитнаад байна.

Тэр хоёр чагнан зогсоход зочны өрөөнд хүмүүс яах аргагүй ярилцаж байлаа, тэгэхдээ нам дуугаар түргэн түргэн ярилцана. –Би чадахгүй, би тийм юм хийхгүй гэж Бантин чанга хэлэв.

-Юу болоо вэ? гэж Хенфри асуухад Холл:

-Нэг юм хийж чадахгүй гээд л байна. Бидэнд тэгж байгаа юм бол уу?

-Яасан зэвүүн юм! гэсэн Бантины дуу үүдний цаана гарав.

-Яасан зэвүүн юм! гэж байна. Би бүр тод дууллаа гэж Хенфри хэлэв.

-Одоо хэн яриад байна?

-Касс шиг байна. Танд юм дуулдаж байна уу?

Чимээ аниргүй байлаа. Дотор нэг чимээ гаравч чухам юу болох нь үл мэдэгдэнэ.

-Ширээний бүтээлгийг хуулж байгаа юм шиг чимээ гарч байна гэж Холлын хэлэх зуур Холл авгай лангууны цаана гарч ирэв. Холл чимээгүй бай, наашаа хүрээд ир гэсэн дохио өгөв. Чингэхэд нь Холл авгайн гэдэн нь хөдөлж, -Чи тэнд юу чагнаад байгаа юм? Ийм хөлтэй өдөр чамд хийх юм олдохгүй байна уу? гэлээ.

Холл нүд, ам, гар хөлөөрөө элдвээр дохивч гэргий нь зөрүүд зан хөдлөөд дийлсэнгүй, харин ч улам чанга дуугарахад Холл, Хенфри хоёул урам хугарсан царайлан өлмий дээрээ сэмхэн сэмхэн гишгэлсээр лангууны зүг эргэв.

Эзэн авгай, тэр хоёрын ярихыг анхандаа ер тоохгүй байснаа Холл чи дуугүй бай, Хенфри яриг гэв. Ер нь Холл авгай төдий л тоомсорлохгүй, тэнд ламбугай, эмч хоёр л ширээ сандлаа хөдөлгөө биз гэж бодсон бололтой байлаа.

“Яасан зэвүүн юм!” гэж хэлэхий нь би лав дуулсан гэж Холл хэлэв.

-Би ч бас тэгж дуулсан шүү. Холл авгай минь

-Тийм байж болох юм.

-Хүүш! Цонхонд юу дуугарав?

-Аль цонх?

-Зочны өрөөнийх?

Цөмөөрөө чих тавин чагнан дуугүй зогслоо. Гөлрөн ширтэх Холл авгайн нүдэнд, үүд дөрвөлжлөн цэлийн цаана нь зам зурайн, бас зургаан сарын тунгалаг нарны туяанд гялалзан байгаа Хекстерийн мухлагийн үүд харагдана. Мухлагийн үүд гэнэт нээгдэж Хекстер нүдээ хачин бүлтэгнүүлж гараа сарвалзуулсаар гарч ирээд “Хулгайчийг бариарай” гэж хашхиран үүдний дөрвөлжин зайгаар гүйж гараад бараа тасрав.

Тэгтэл зочны өрөөнөөс чанга чанга дуугарах, цонх нь хаагдах чимээ сонсогджээ.

Холл, Хенфри, ер нь тэнд байсан бүхэн санд мэнд гүйлдэн гарав. Гэтэл нэг хүн байшингийн булан жирсхийн тойрч тэнд харагдах зам өөд зугатаж байх бөгөөд Хекстер дээш хачин ойж түрүүлгээ харан ойчих харагджээ, гадаа байсан хүмүүс үүнийг харж гайхан, зарим нь хөдлөхгүй дороо зогсож, зарим нь тэр зүг гүйв.

Хекстер ойчихдоо ухаан алдсан ажээ. Хенфри түүнийг үзэхээр зогсов. Харин Холл, фермийн ажилтан, архи пиво ууж байсан өөр нэг хоёр хүний хамт гарч ирээд учир нь олдохгүй нэг юм үглэсээр гүйж сүмийн булан тойрон алга болж байгаа Марвелыг олж харав. Тэд өнөөх үзэгддэггүй хүн үзэгддэг болчихож гэж бодсон бололтой хойноос нь ухаан зулаггүй хөөцөлджээ. Гэтэл Холл арваадхан алхам хэртэй гүйж байгаад гэнэт хачин дуу алдаж хажуу тийш өнхрөөд явчив. Тэгэхдээ нэг ажилчин хүнээс шүүрэн барьсан боловч түүнтэйгээ хамт ойчив. Холл яг л хөл бөмбөг тоглох хүн заримдаа дайрагдан ойчдог шиг юм болжээ. Нөгөө нэг ажилчин нь л эргэн гүйж ирээд Холлыг өөрөө бүдэрч унасан байна гэж бодоод цаашаа хөөцөлдсөн боловч яг тэр өнцөгт хүрмэгцээ Хекстерийн адил бас ойчжээ. Түрүүчийн ажилчин нь босож завдсан атал хажуу сүвээ рүү нь амбан шарыг ч цохиод унагачихмаар хүчтэй юм дэлсэхэд бас ойчив.

Түүнийг тийнхүү очих яг тэр үеэр тосгоны ногоон зүлгэн дээр зугаалж байсан хүмүүс нөгөө буланд хүрч ирэв. Хамгийн түрүүнд нь өндөр биетэй, цэнхэр өнгийн богино цамцтай, бэтийн самар байт буудлагын тоглоомын эзэн иржээ. Зам дээр гурван хүн дэмий балай өнхөрч хөрвөж байгааг тэр хүн хараад их л гайхан байтал гэнэт хөл нь эвгүй оргин өөрөө ч савж унав. Ойчихдоо нөгөө нэг найз ахайгаа дайрав. Бусад олон хүн тэр хоёрт тээглэн бүдэрч, дарж унахдаа хараал зүхэл болов.

Холл, Хенфри ажилчин гурвыг гүйлдэн гарч явахад олон жилийн туршлага ихтэй Холл авгай гаралгүй, мөнгөнийхөө авдрыг сахин үлджээ. Гэнэт зочдын өрөөний үүд нээгдэж Касс дахин гарч ирээд эзэн авгайг ч олж харалгүй шатаар гүйн бууж булан тойрч: “Тэрүүнийг бариарай!”, “Боодолтой юмы нь битгий хаяулаарай! Боодолтой юмаар нь олж болно шүү!” гэж хашхирлаа.

Касс, Марвел гэж нэг хүн байгааг ер мэдсэнгүй. Үл үзэгдэгч хүн ном, боодолтой юмаа хашаан дотор байхдаа өгсөнийг мэдээгүй ажээ. Кассын царай зүс маш уур хилэнтэй, зориг шийдэмгий харагдана. Өмссөн хувцас нь маш хачирхалтай ганц цагаан банзал мэт хувцастай яваа хүн юм гэж тооцох бол уу даа. Тэгээд: “Бариарай, тэрнийг! Миний өмд мөмд, ламбугайн хамаг хувцас хунарыг аваад явчихлаа шүү! гэж хашгирсаар байв.

-Би одоо очиж тусалъя! гэж Хенфри хашгиран, гулдайн хэвтэж байгаа Хекстерийн дэргэдүүр гүйн өнгөрч булан тойрон үймсэн олонтой нийлтэл бас нэг юманд бүдрэн тун ч аягүй ойчив. Хар хурдаараа гүйж яваа нэг хүн гары нь гишгэчихэв. Касс муухай хашхирч босон харайтал бас дөрвөн хөллөж ойчих шахаад харвал хүмүүс юм хөөж явснаа болиод тосгоны зүг зугтааж явлаа. Касс босоод эргэн гүйх гэтэл чих рүү нь нэг юм дүлийртэл цохиход нэг гуйварч аваад өнөөх зочид буудлын зүг гүйхдээ тэр үе ганцаар хаягдан, зам дээр өндийн сууж байсан Хекстерийн дээгүүр дүүлэн харайлгажээ.

Кассыг зочид буудлын шатаар өгсөж явтал олон хүний шуугиан дотроос нэг онцгой уур хилэн бадруулсан дуу яг хойно нь гарч хэн нэгний хацрыг алгадах чимээ тасхийв.

Эмч, үл үзэгдэгч хүнийг дуугаар нь таньжээ. Дууны нь өнгө юманд гэнэт цохиулаад уурлах хүний уцаар дуу шиг сонсдов. Касс, зочид буудлын гийчний өрөө рүү санд мэнд гүйж ороод:

-Өнөөх чинь бас энд ирээд байна. Бантин аа! Мэдээтэй байгаарай гэв.

Бантин цонхны дэргэд зогсчихоод зуухны хажууд байсан хивс, баруун Серрейн сонины хуучин дугаараар биеэ далдлахыг оролдон байлаа.

-Хэн ирээд байна гэнэ ээ? гэж Касс давхийн цочиход нөгөө хивс сэлт нь арай л мултрад уначихсангүй

-Үзэгддэггүй хүн гэнэ ээ! гэж Касс хэлэнгээ цонхны зүг гүйж –Эндээс зайлсан маань дээр байх аа, галзуу юм шиг нүдэлдээд байдаг шүү, лав солиорсон байх.! гээд төдхөн хашаа руу оров.

Бантины санаа хоёрдож яах ч учраа олохгүй –Ээ, тэнгэр минь! гэж дуу алдтал зочид буудлын гудамд ноцолдоон болж байгаа сонсогдсон тул санаа шуударч цонхоор авиран гарч буугаад биеэ хаасан юмыг жаахан засаж янзлан, богинохон тарган хөлийнхөө байдаг чадлаар тосгон дундуур гүйлээ.

Үл үзэгдэгч хүн уур хилэн бадарсан дуугаар хашхирч, Бантин тосгоны гудамжаар тэгэж гүйж байснаас хойш Айпингэд чухам юу болсныг мэдэхийн аргагүй болжээ. Ер нь Марвелын хувцас хунар, ном дэвтрийг авч явуулах гэж үл үзэгдэгч хүн эхлээд хамгаалсан байж магадгүй гэсэн ч угаас зан авир тийм ч зөөлөн дөлгөөн биш байсны дээр тэр хүн цохиулсандаа уур хилэн нь бадарч замдаа өртсөн бүхнийг балбан зодож, бах таваа хангаж байлаа.

Гудамжаар хүн пиг дүүрэн гүйлдэж, байшин савны үүд хаалга тар түрхийж, хүмүүс толгой хоргодох газрын төлөө амь наана там цаана үзэлцэж байлаа. Үймж сандарсан үй олон хүн өвгөн Флетчерийнд шахалдан орж хоёр сандалд дамнасан банзан дээр гарахад тэр нь нурж нэн их сүйд болов. Савлуур, суудаг дүүжин дээр байсан эр эм хоёр сүнсээ гартал айсан нь харахад хичнээн сонин байв. Тэгсээр хөл үймээн намдаж гоёл чимэглэл болсон Айпингийн гудамжны хүн амьиан харагдахаа больж үл үзэгдэгч хүн л дураараа аашилж байсан бололтой. Энд тэндгүй бэт, нурж унасан даавуун хаалт, тансаг идээний мухлагийн чихэр боов ундуй сундуй хэвтэнэ.

Энд тэндгүй цонхоо хаах, түгжээгээ бэхлэх чимээ гарч хаа нэг хүний нүд цонхны цаанаас бүлтийж харагдсан төдийгөөр хүн амьтан байгаа шинж илэрч байв.

Үл үзэгдэгч хүн, “Сүйх тэрэг ба морьд” гэдэг зочид буудлын цонхны шилийг нэгд нэггүй хагачиж байснаа гудамжны дэнлүүгээр Грогрем авгайн гийчний өрөөний цонхыг хага цохижээ. Эддердиний зам дээрх Хигсинсийн гацааны цаадхи Эддердиний цахилгаан шугамыг лав тэр үл үзэгдэгч хүн тасалсан бололтой. Үл үзэгдэх үлэмж сүрхий чанарын ачаар тэр хүн Айпингээс зайлж тэндээс ул мөргүй эгнэгт алга болжээ. Гэвч Айпингийн эл хуль гудамжинд гарах зоригтой хүн бараг бүхэл хоёр цагийн турш олдсонгүй.

МАРВЕЛ ОГЦРОХЫГ ХҮСЭВ

Үдшийн бүрий барай болж Айпингийнхэн айж эмээх нь арай гайгүй болоод үүд довжоон дээрээ гарч байхад Бремблхерст хүрэх замаар хэсэг ойн цаана тагдгар тарган биетэй, хуучин эсгий малгай өмссөн нэг хүн их л ядрангуй явж байгаа харагджээ. Хээ хууртай гялганасан нарийн бүсэнд боодолтой гурван дэвтэр, бас хөх өнгийн хулдаасанд боосон юм барьжээ. Улаавтар царайд нь гуньж гутсан, ядарч зүдэрсний шинж илэрхий. Алхаж гишгэх нь хүртлэ нэг л биш харагдана. Тэр хүн өөрөө дуугарахгүй атал дэргэд нь хүн дуугарч, үл үзэгдэх гарын хүчинд байн байн татвалзана.

-Чамайг дахиад надаас оргох гэвэл, дахин надаас зайлах гэвэл.. гэж хүн дуугарлаа. –Бурхан минь! гэж Марвел уулга алдаж, миний дал мөр хүн авахын аргагүй хөх няц болжээ гэнэ.

-Чамайг тэгдэг юм бол, би ална шүү, чамайг! гэж бас дуугарав.

-Би ер нь таниас оргож зайлъя гэж бодоогүй гэж Марвел уйлагнан хэлээд –Би тангараглая! Хаашаа эргэхээ мэдэхгүйгээс л боллоо. Би ийш эргэнэ гэж яаж мэдэх билээ? Намайг та дэмийл зодож байна даа гэв.

-Үгэнд орохгүй бол үнэхээр их зодно гэж мэдээрэй гэхэд Марвел дороо дуугүй болж хацраа түмбийлгэн үлээгээд нүд нь цөхрөнгөө барсан хүний шинжийг илтгэж байлаа.

-Тэр тосгоны муусайн хог миний энэ өчүүхэн нууцыг мэдчихдэг тун ч тоогүй хэрэг. Дээр нь та бас номы минь аваад зугтаж зайлах гэсэн чинь бүр их харамсууштай байна. Мөрдөж хөөхөө болиод зугтсан нь тэдний зол болсон юм... би ч хэцүүдлээ... Намайг үл үзэгдэгч хүн гэж хэн ч мэдээгүй байсан юмсан. Одоо яах билээ?

-Харин би л ёсой яах билээ гэж Марвел дорой дуугарав.

-Бүр илэрч гүйцлээ! Сонинд ч бичих л биз. Намайг олох гэж бүгд хайх болно. Цөмөөрөө хардаж сэрдэх болно.

Үл үзэгдэгч хүн уурлаж цухалдан муухай харааснаа дуугүй болоход Марвел цөхрөнгөө барсан царай гарган алхаагаа удаашруулав.

Бушуу яваач гэх дуу гарав.

Марвелын нүүрний улаан улаан толбоны завсраар хөхийж байв.

-Номы минь битгий унагаачих гэж зандрах дуу гараад –Би чамайг ашиглахаа л ашиглана, чи хэдий өөдгүй амьтан ч гэсэн надад өөр арга алга гэлээ.

-Миний тус хэдий юу байв аж дээ.

- Чухам аа

-Танд надаас дээр хүн олдох байсан даа гэснээ түр зуур зүрхшин дуу тасраад –Надад чадал тэнхээ ч гэх ю малга, тийм их чадал тэнхээтэй ч хүн биш гэлээ.

-Тийм бий?

-Зүрх муутай хүн шүү, би чинь саяны тэр ялимгүй хэргийг гүйцэтгэх нь гүйцэтгэлээ. Гэхдээ бурхан мэднэ. Би эгээ л амь тавьчихаагүй юм шүү! гэв.

-Тэгээд яагаав?

Танд хэрэг болох зориг, хүч тэнхээ надад байхгүй дээ

-Яахав, би зориг оруулаад өгөмз.

-Юугаа хийхэв дээ, тэгээд, би таны үйл хэргийг хөөдье гэж бодохгүй ч гэсэн, яаж мэдэх вэ, айж сандарсаар байтал дэмий юм болж юу магад...

-Тэгэхгүй байвал өөрт чинь л дээр байх даа гэж цаадхи нь нухацтайхан дуугарав.

Ингэж байснаас үхсэн дээр санагдаж байна. Арай хэтэрч байна. Та өөрөө мэдэж байгаа шүү дээ бас... яах эрх байх ёстой

-Түргэхэн явж үз! гэж зандрах дуу гарахад Марвел алхаа юугаан арай түргэсгэн нэг хэсэг дуу шуугүй явлаа.

-Даанч хэцүү юм болж шүү гэж Марвел дуугарсан боловч ер тус болох шинжгүй тул Марвел өөр арга хэрэглэхийг оролдож, их л гомдсон байдалтайгаар:

-Надад ер ямар ашиг болох байна даа гэтэл өнөөх дуу гэнэт:

-Дуугүй бай. Би чамайг гайгүй шагнана. Чи дуугүй л хий гэснийг минь хийчихээд бай. Чи чадах нь чадна. Хичнээн тэнэг ч гэсэн дөнгөх хүн...

-Ноёнтон минь, би тэнцэх хүн биш шүү, эрхэмсэглэн соёрхооч, би үнэнээ л хэлж байна

-Амаа татахгүй бол гары чинь хуга мушгина, юм бодоход битгий саад болоод бай.

Модны завсраар шар өнгийн хоёр юм харагдснаа сүмийн дөрвөлжин орой манангийн дунд сүүмэлзэн үзэгдэв.

-энэ тосгоны дундуур явахдаа би чиний мөрөн дээр гараа тавьж явна шүү. Чи дэмийрч маяглахгүй шууд л зүсээд гараарай. Тэгэхгүй бол дэмий юм болно гэж мэдээрэй гэж өнөөх үл үзэгдэгч хүн хэлэхэд Марвел

-Ээ чааваас, мэдлээ гэж өчөөд сүүрс алдан –Сайн мэднээ гэв.

Хуучин эсгий малгайтай тэр хөөрхий хүн юм барьсан хэвээр тосгон дундуур дуугүй явж өнгөрөөд, харанхуйд бараа нь тасрав.

СТОУ ХЭМЭЭХ БООМТ ХОТНОО

Маргааш өглөө нь арван цагийн үед Марвел Стоу боомтын захын нэг жижигхэн зочид буудлын гаднах урт сандал дээр сахал самбайгаа ч хусаагүй сууж байв. Нүүр царай нь замын тоос шороонд дарагдаад хир буртаг болж, гараа халаасандаа хийчихээд ядрангуй, гутрангуй, сэтгэл ихэд уймарч хямарсан байдалтай аж. Байн байн гүнээ шүүрс алдан хацраа бүмбийлгэн үлээж байлаа. Олсоор багласан хэдэн ном дэргэдээ тавьсан байна. Боодолтой юмаа үл үзэгдэгч хүний шинэ төлөвлөгөө ёсоор Бремблхерстийн цаадхи нарсан ой дотор орхисон ажээ. Марвел урт сандал дээр сууж байхад түүнийг анзаарч анхаарсан хүн нэг ч үгүй атал мань бүдүүний дотор маш аягүй догдолсоор ажээ. Өвөр түрийгээ байн байн тэмчинэ. Тийнхүү суусаар бараг л бүх л цаг шахам болсон хойно зочид буудлаас нэлээд ахимаг насны нэг далайч эр сонин барьсаар гарч ирээд хажууд нь сууж,

-Сайхан өдөр байна шүү! гэхэд Марвел нэлээн айсан янзтай тал тал тийш харснаа:

-Тун ч сайхан өдөр байна гэлээ.

Далайч ер хэнэггүйгээр:

-Ёстой л улиралдаа таарсан өдөр байна даа гэхэд Марвел:

-Ёстой тийм байна гэж өчив.

Далайч шүдний чигчлүүр гаргаж шүд амаа төнхсөөр нэлээд хэдэн минут болохдоо дэргэдээ байгаа Марвелийн хог тоосондоо дарагдсан байдал, авч байгаа номыг ажиглах зав гаргажээ. Далайч Марвелийн дэргэд ойртон очтол түүний халаасан дотор мөнгөн зоос хангинах чимээ сонсдов. Гадаад байдал ийм ядуу мөртлөө ингэж чинээлэг хүний байдал мэдэгдэхэд далайч гайхжээ. Гэнэт хачин юм санаанд нь орж ирсэнд шүднийхээ чигчлүүрийг хаяж орхиод:

-Ном уу? гэхэд Марвел давхийн нүдний булангаар номоо хараад –Тиймээ, ном гэв.

-Зарим номонд мөн ч хачин гайхалтай юм бичсэн байдаг юм шүү гэж далайч эр хэлэв.

-Тийм шүү

-Номоор барах уу, өөр өөр сонин хачин юм бишгүй л байдаг даа

Марвел далайчныг нүднийхээ булангаар харж ийш тийш хяламхийснээ:

-тийм ээ тийм гэв.

-Жишээ нь сонинд хачин юм бичсэн байх юм гэхэд

-Байдаг л юм

-Энэ дугаарт бичсэн байна гэж далайчийг хэлэхэд Марвел:

-Үгүй ер гэж болгоомжлов.

-Энд үл үзэгдэгч хүний тухай нэг юм бичсэн байх юм гэж Марвелийн царай руу ширтсээр хэлэхэд Марвел жуумалзан хацраа иож, чихээ улайлган доройхон дуугаар:

-Бичихгүй юм хэзээ байлаа даа, тэгээд хаана тийм юм болоо вэ? Австрид уу, Америкад уу? гэлээ.

-Үгүй чиш! Энд гэнэ!

-Бурхан минь! гээд Марвел босон харайв.

-Энд гэхдээ яг манай тосгонд арай биш юм байх, гэсэн ч манай энэ нутагт л гарсан хэрэг юм байна гэж далайчин хэлэхэд Марвелийн дотор уужран:

Үзэгддэггүй хүн гэнээ! Тэгээд яадаг хүн гэнэ вэ? гэж асуухад далайч Марвелыг сүрхий ажигласаар:

-Хийхгүй юм алга гэнэ! Элдэв дээдийн юм хийж байна гэнэ! гэв.

-Би сонин үзээгүй дөрвөн сар болов.

-Айпингээс эхэлсэн юм гэнэ.

-Нээрэн үү?

-Нээрэн, нээрэн. Чухам хаанаас гараад ирснийг нь мэдэх хүн алга. Харахгүй юу: "Айпингээс ирсэн жигтэйхэн хачин мэдээ" гэ жбайхы нь. Энэ талаар маш их сонирхолтой арвин мэдээ баримт байна гэж бичсэн байна.

-Бурхан минь гэж Марвел дахин дуу алдлаа.

-Ёстой сонин хачин хэрэг байна. Гэрч болох хүмүүсийн дотор тэндэхийн эмч, ламбугай байна. Тэд тэр хүнийг бүр сайн үзсэн, үзсэн ч гэж болохгүй юм байх. Анх нь “Сүйх тэрэг ба морьд” гэдэг зочид буудалд байгаад байсан юмсанж. Тийм тусгүй юм болсны нь мэдсэн хүн байсангүй, харин зодоон нүдээн болж боолты нь аваад хаятал мэдэгдсэн юм байх. Тэгээд толгой нь үзэгдэхгүй хүн байж гэнэ. Тэгэхтэй нь зэрэг бариад авахыг оролдсон чинь зодоон эхэлж гэнэ, гэтэл өнөөх хүн хувцсаа тайчиж хаяад зугтсан гэнэ, тэгэхдээ сүрхий сүүд майд болгож, нутгийн цагдаагийн зоригт дарга Жефферсыг айхтар шархдуулж гэнэ. Хачин юм байгаа биз? Нэр ус дутуу гэх юмгүй цөмий нь бичсэн байна даа!

-Бурхан минь! гэж Марвел дахин нэг дуу алдаж ийш тийш бүлтэлзэн харснаа өвөр доторхи мөнгөө тоолж үзэхийг оролдлоо. Санаанд нь хачин, гайхмаар юм бодогдож

-Мөн ч гайхмаар хэрэг юм даа! гэв. Нээрэн хачин юм шүү! Үзэгдэхгүй хүн байдаг гэж насандаа дуулаагүй, гэтэл одоо чинь хачин юм бишгүй дуулдах болоо шив гэхэд, Марвел тун хэнэггүйгээр,

-Тэрний үйлдсэн ажил ердөө л тэр үү? гэхэд далайч:

-Шалихгүй бага санагдаж байна уу?

-Эргэж ирсэнгүй гэнэ үү? Тэгээд л зугтаачихлаа гэж үү? гэж Марвел сонирхсон янзтай асуухад цаадхи нь: “Тэгээд л гэнэ шүү. Танд л чамлалтай санагдаж байна уу?”

-Хаанаас

-Тийм л баймаар даа. Ер юу гэсэн үг вэ!

Марвелын дотор түгшив.

-Хань хансаа энэ тэргүй юм уу? Хань хамсаатан байсан энэ тэр гэж бичээгүй байна уу?

-Тийм хачин амьтан нэгээс илүү байвал яана! Ай бүү үзэгд нэг л байсан нь зол байж! гээд толгой сэгсрэв.

Манай нутагт тийм хүн явж байгаа гэж бодохоос бие зарсхийх юм. Тэр хүн дураараа явж байгаа гэх, ер нь наашаа дөхөж, Стоу боомтод байхад маань ойрхон ирж байгаа ч байж болзошгүй байна. Ирдэг юм гэлээ гэхэд та бид хоёр яг л зам дээр нь байна даа! Энэ ч Америктай адил холгүй газар байгаа биз дээ! Ямар шиг гай тарих бол, бодоод үзээч, та! Жаахан юм балгачихаад дайрвал яана! Хулгай дээрэм хийвэл яана! Хэн ч саад хийж чадахгүй дээ. Айлын гэрт мэдэгдэлгүй ороод хулгай хийхэд ч давгүй, цагдаагийн хажуугаар гарахдаа бид сохор хүний дэргэдүүр бултаад гарчихаас дутахгүй л байх биз, бүр амар байх, сохор хүн дуу чимээнд сонор гэдэг шүү дээ. Дуртай архи дарсаа зооглоё ч гэсэн тэрний дурны хэрэг байх нь ...

-Жирийн хүнээс давуу сүрхий чадал бишгүй байгаа байлгүй... тэгээд гэж Марвел хэлэхэд, далайч:

-Та зөв хэлж байна, тэр хүн бидэн шиг жирийн амьтныг бодвол есөн шидийн аргатай байж таарна гэлээ.

Марвел энэ зуур байн байн ийш тийш эргэн тойрон харж өчүүхэн төдий чимээ анир гармагц чагнаад, нэг юм шийдэж ядан байх шиг байснаа ханцуйндаа ханиагаад бас дахин нэг эргэн тойрон харж чагнаснаа далайчны зүг бөхийн нам дуугаар:

-Ингэхэд би тэр үл үзэгдэгч хүний тухай жаал зугаа юм мэднэ.. дам сонссон юм шүү гэв.

-Үгүй ерөө! Та юу? гэж далайч дуу алдав.

-Тийм ээ, би...

-Хээн! Тэгвэл надад асуумаар... гэтэл Марвел амаа гараараа таглаж:

-Та их гайхах болно. Ёстой ер бишийн юм болсон шүү! гэв.

-үгүй ер, тийм бий!

Марвлын царай янзтайхан болж:

-Уг нь гэж шивнэснээ гэнэт зүс нь жигтэйхэн хувирч:

-Аяа! гэж дуу алдан болхи хойрго янзтайгаар өндийж, нүрий нь харвал нэг газар нь тун ч их өвдсөн бололтой үрчийж ярвайгаад -Ёо, ёо! гэж хашхирав.

Далайч сэтгэл тэвдсэн янзтай:

-Та яагаав? гэж асуухад Марвел:

-Шүд өвдлөө гээд гараар чихээ барин хажуудхи номоо шүүрэн авч

-Би явалгүй горьгүй нь шиг байна гээд сандал дээрээсээ нэг л хачин маягтай босож явлаа.

-Та дөнгөж сая үл үзэгдэгч хүний тухай ярьж өгье гэсэн чинь яалаа даа?

Марвел дотроо ухаан сийлж учрыг тунгаах янзтай байтал:

-Худлаа! гэж нэг хүний дуу гарчээ.

-Үнэхээр, худлаа шүү! гэж Марвел хэллээ.

-Сонинд бичсэн байна шүү дээ гэж далайч өчихөд Марвел:

-Тэглээ ч гэсэн худал! Энэ цуу үг тараасан чалчаа этгээдийг би мэднэ. Ертөнцөд үзэгдэхгүй хүн гэж ямар ч юм алга... Муусайн худалч золигнууд! гэхэд далайч:

-Сонинд л тэгжээ... хагас хугас нь ч гэсэн үнэн биш гэж үү?

-Үнэн үг ширхэг ч алга! гэж Марвел зориг шийдэмгий хэллээ.

Далайч сонингоо барьсаар Марвелын царай руу ширтэхэд цаадхи нь тавгүй байдалтай ийш тийш гөлөлзөн харна.

-Байзнаарай! гэж далайч энэ үгийг сунжруулан хэлэнгээ өндийн босож –Та ер нь юу гэж хэлэх санаатай байна?... гэхэд Марвел:

-Би худлаа хэлээгүй гэлээ.

-Тэгвэл та юунд миний яриаг чагнаад бүгдийг нь яриулаа вэ? Яах гэж дэмий юмыг чих тавин сонсоо вэ ? гэхэд Марвел хацар түмбийлгэн уушгиныхаа хийг гаргахад далайчийн царай зүс гэнэт барайж гараа атган зангидлаа.

Намайг ярьсаар арваад минут болоход чи муу цүдгэр хог, чөтгөрт алгадуулмар, ядсандаа...

-Та намайг харааж зүхэлгүй ярь л даа!

-Харааж зүхлээ гэнэ! Тэр ч байтугай би бүр...

-Бос! Гэх дуу гарч Марвел нэн даруй дороо эргэлдэнхэн, инээд хүрмээр хачин займчин хөдлөв.

-Хэнийг, тэр байтугай ч бүр гэнэ үү? гэж Марвел муухай дуугараад хачин татвалзан, яаруу мэгдүү алхан гэнэ, гэнэ огло харайх мэт явж байлаа. Зам дээр хүрч очмогцоо хойш урагш хэлэх, өчиж зэмлэх үг сонсдов.

-Мангар чөтгөр! гэж далайчин хараагаад, ташаа тулан алцайн зогсож хойноос нь ажиглан харж байлаа. “ Гайгүй би чамд үзүүлээд өгүүж, намайг хуурах вий чи! Сонинд бичээд байхад” гэнэ.

Марвел нэг юм эсэргүүцэн өчиж байснаа том хаалганы цаагуур орлоо.

Далайч, ярганы тэргийг хажуудаа хүрч иртэл замын тэг дунд сүр бадрангуй алцайн зогсож байснаа Стоу боомтын зүг чиглэн явах зуур,

Орчлонгийн тэнэгүүдийн олныг яана! Намайг л уурлуулах гэж оролджээ... би сониноос олж үзсэн гэж ганцаараа хүүрнэнэ. Нээрэн ч төдхөн яг дэргэд нь урьд хожид үзэгдэж дуулдаагүй хачин юм болжээ.

Ариун Михайл-Лейний ханын хажуугаар их ч үгүй, бага ч үгүй /”атга хэртэй” мөнгө аяндаа сул зорчин яваа үзэгдэв. Өөр нэг далайч найз нь тэр өглөө бас иймэрхүү юм харсан гэж байсан санж. Тэр мөнгийг шүүрэн авах санаатай мань эр ухасхийн сарвайтал яах ийхийн завгүй ойчоод өндийн босвол өнөөх мөнгө нь арилан алга болсон байлаа. Далайч хожим ярихдаа: Би ер нь юм бүхэнд амархан итгэдэг хүн, харин энүүнд тун итгэж өгөхгүй байна гэж ээ. Гэвч хожим тэр талаар бодлоо аргагүй өөрчилсөн ажээ.

Тийнхүү мөнгө нисэж явна гэдэг нь үнэн байжээ.

Тэр мөнгө заримдаа атганд ч байгаа юм шиг, заримдаа юманд боодолтойгоор тэр өдрийн турш үзэсгэлэнт Лондон, хөдөө банкны компаниас авахуулаад Дэлгүүр хоршоо, зочид буудлуудын хаалга үүдээр дамжин /тэр өдөр дулаан сайха байсан тул хаалга үүд нь нээлттэй байв/ хана саравч, харанхуй сүүдэртэй газраар айвуу тайвуу байдалтай айлчлан хэсэж, хүн амьтан шохоорхоод байвал ер андахгүй маягтай, аятайхан зайлчихаад байлаа. Түүний хойноос хүн ер хөөцөлдсөнгүй. Тэр мөнгө яван явсаар Стоу боомтын жижиг зочид буудлын гадаа сэтгэл ихэд үймсэн бололтой, хуучин эсгий малгайтай сууж байсан эрхмийн халаасанд ёс шиг орчихдог байв.

Арван өдрийн дараа Бердокт болсон энэ явдал нэгэнт хуучирсан хойно мань далайч үзэж сонссон бүхнээ эргэцүүлэн бодоод тэр үл үзэгдэгч үнэхээр гайхам хүн гэрт нь хичнээн ойр дөт ирж байсныг боджээ.

ОРГОДОЛ

Үдэш болж байлаа. Кемп доктор бичгийнхээ өрөөнд сууж байв. Тэднийх нэг ухаа дээр байх учир тэндээс Бердок их тодорхой харагдана. Бичгийнх нь өрөө баруун зүүн, хойд гурван талдаа нэжгээд цонхтой тохилог ажээ. Дотроо ном, шинжлэх ухааны сэтгүүл, товхимол тавьсан тавиур, бичгийн өргөн том ширээтэй ажээ. Хойд талын цонхны доор нян хорхой харах дуран авай, шил савнууд, нарийн хэмжүүрийн багаж хэрэгсэл, нян хорхой үржүүлсэн сав хэрэгсэл, урвалтай шил сав байна. Жаргах нарны туяа гийсээр боловч ширээний чийдэнг асааж, харин цонхоор хүн шагайна гэж санаа зовох юмгүй болохоор хөшгөө хаагаагүй байв. Доктор Кемпийн чац өндөр, нас идэр, мөр тэвхгэр, шаргал үс, сахал нь бараг цайчихсан хүн байв. Хийж байгаа ажлаа маш өндөр үнэлж үүгээрээ эх хааны эрдэм номын хүрээлэнгийн гишүүн болохыг горьддог байжээ.

Кемп хийж байгаа ажлаасаа нүд салгаж яг өөрий нь байшингийн эсрэг тэр нэг ухаагийн цаагуур нар жарган алтан туяа нь дээш цацрахыг сонирхож байгаад амандаа үзгээ зууж түр суутал тэр ухаагийн орой дээгүүр нэг бараан өнгийн хувцастай бие жижгэвтэр хүн гарч ирэхийг гайхан ширтлээ. Бортгон малгайтай погдгорхон хүн хар хурдаараа гүйж байв.

-Өнөө өглөө “Үл үзэгдэгч хүн иржээ, ноёнтон минь” гэсээр манайд орж ирсэн муусайн илжгийн нэг нь л байхдаа, бодвол! Хүмүүс ер нь юу боддог болоо юм бол, одоо чинь арван гуравдугаар зууны үе гэж боддог хүн гэж бас байх нь уу? гэж бодоод цонхны дэргэд очиж оройн бүрий барайд бүртэгнэх тэр ухаа, тэр ухаагийн энгэр рүү гүйн бууж байгаа жижигхэн хүнийг ширтэж: мөн ч их яарч явна, янз нь. Гэсэн хирнээ газар ахидаггүй яасан хачин юм. Өвөр дүүрэн хар тугалга хийлээ ч гэсэн энэнээс илүү нүсэр эр явамгүй юм даа гэж бодлоо.

-Эрхэм минь, тэнхээгээ барчихлаа! гэж Кемп ганцаар дооглон хэлэв.

Дэмий удсангүй өнөөх хүн Бердокоос нөгөө ухаа өөд өгсөн шивээ хайсны цаагуур далд орж нэг ил гарч дахин тэндэх байшингуудад гурав дахин таглагдаад сүүлдээ бүр харагдахаа болив.

-Илжиг! гэж Кемп хэлээд өлмий дээрээ эргэж бичгийнхээ ширээний араар оров.

Зам байсан хүмүүс нөгөө хүний тийнхүү хөлс асгаруулан санд мэнд гүйхий нь ойроос харсан болохоор Кемп шиг тэгж зэвүүцсэнгүй.

Тэр хүнийг хажуугаар өнгөхөд амьсгал нь давхцан хүүдийтэй мөнгө нь харжиг шаржиг гэх чимээ гарч явлаа. Тэр хүн хажуу тийшээ ер харахгүй гагцхүү ухаагийн хормойд гэрэл дэнлүү гялалзаж, гадаа гудманд цугласан олон хүний зүг ширьэж, тарчилж зовсон байдалтай ярвайж, ам хамраас нь хөөс сахран амьсгаа нь давхцан хэрчигнэнэ. Түүнтэй тааралдсан хүн болгон гайхан зогсож замын дагуу урагш хойш харцгаан яагаад ийнхүү мэгдэн яваа юм бол, ямар учиртай юм бол, гэж бие биеэс сураглаж байлаа. Тэгтэл нөгөө ухаагийн дээд бэл дээр тоглож байсан нэг нохой ганхийн гасалж ойрхи нэг хашааны том хаалга руу зугтан орохыг хүмүүс хараад их л гайхаж учрыг олж ядан байтал салхи сар сүр хийгээд тэдний хажуугаар нэг юм пад пад, пад падхийн өнгөрөх шиг болжээ.

Хүмүүс үймэлдэн шуугиж, тал тал тийш бутрав. Ухаагийн хормойд байсан хүмүүс ч мөн шуугилдан бутрав. Марвел замын тэг дунд явж байхад тээр дор байсан хүмүүс сандран хашхиралдаж гэр орон руугаа гүйлдэн орж, хаалга үүдээ хаан, түгжиж, аймшигт мэдээг мэдээгүй нэгэндээ санд мэнд хэлж байв. Тэр аймшиг Марвелын хажуугаар нь өнгөрч, өөрөөс нь түрүүлэн, ганцхан хормын дотор хот даяар түгэн дэлгэрчээ. "Үзэгддэггүй хүн ирлээ! Үл үзэгдэгч хүн!..." гэлцэж байлаа.

“НАРГИАНТАЙ КРИКЕТЧИНГҮҮД”

БУУДАЛД БОЛСОН ЯВДАЛ

“Наргиантай Крикетчингүүд” гэдэг буудал яг тэр ухаагийн хормойд морин трамвайн төмөр зам эхэлсэн газар байдаг юм. Чухам тэр үед гуанзны эзэн нь бамбайсан тарган улаан гараар лангуугаа түшин зогсоод, туранхай биетэй нэг улаачтай морь мал ярилцан байлаа. Бас нэг хар сахалтай, саарал өнгийн хувцастай хүн боов бяслаг холин идэж, дарсаар даруулан уух зуур жижүүрийнхээ халааг өгөөд байсан нэг цагдаа хүнтэй америк аялгуугаар ярилцан зогсов.

-Гадаа юун шуугиан гарав? гэж өнөөх туранхай биетэй улаач хэлэнгээ гуанзны намхан цонхны балиар шар хөшигний дээгүүр өнгийж үймээн гарсан зүг харахыг оролдов. Ямар нэг хүн гуанзных нь дэргэдүүр гүйж өнгөрөв.

Гуанзны эзэн:

-Гал түймэр гараа юу? гэж асуулаа.

Гэтэл гүйн ирж байгаа хүний нүсэр чимээ ойртон ойртсоор гуанзны хаалга гэнэт нээгдэж энгэр заам нь уранхай, толгой нүцгэн Марвел уйлан мэгдэн, унан тусан гүйн орж ирээд дутуу хаасан үүдийг гүйцэд хаах санаатай чичигнэн эргэв.

-Ирж явна шүү! гэж айсандаа ер бишийн муухай дуугаар хашхираад -Тэр хүн ирж байгаа шүү! Нөгөө үзэгдэггүй хүн чинь! Миний хойноос хөөж явна. Ай бурхан минь. Ай бурхан минь. Амь авраарай, туслаарай! гэлээ.

-Хаалга үүдээ хаа, ямар хүн ирж байна гэнээ? Юу болоо вэ? гэж нөгөө цагдаа хэлээд өөрөө очиж татуурганы гогцоог гарган үүд хаав. Америк хүн нөгөө үүдий нь хаав.

-Нуугдах газар байна уу? гэж Марвел бүдчин хадчин% уйлагнах мөртөө барьсан номоо хаялгүй –Нуугдах газар! Намайг нэг газар оруулаад түгжчихээч! Миний хойноос хөөгөөд ирж байгаа! Би зугтаж байгаа хүн, намайг ална гэж байна, хэлсэндээ хүрэх амьтан гэлээ.

-Одоо танд айх юм алга. Үүд хаалттай. Ер нь юу болсон юм бэ? гэж хар сахалтай хүн өгүүлэв.

-Намайг нэг газар нуугаач! Гэж Марвел дахин гуйтал хаалттай үүдийг доргитол түгхийлгэн сүрхий шамдангуй түргэн түргэн нүдэж, хүн амьтан шуугилдан хашхиралдахад цагдаа:

-Хүүе! Хэн бэ? гэлээ.

Марвел ханын сарампай мод руу галзуу мэт зүтгэлэн нэвтрэх үүд хаалга эрэн тэмтчиж –Намайг ална тэр чинь, хутга юм уу нэг юм олоод авсан байх, ай бурхан минь! хэмээн тэвдэв.

-За, та нааш ир, энд нуугд гэж гуанзны эзэн хэлээд лангууныхаа сойвч банзыг дэлгэн нээж өгөхөд Марвел тийш шудран тэмүүлж, гадаа дуу чимээ дахин дэгдсэн тул -Үүдээ битгий нээгээрэй! Үүд битгий нээгээрэй! Би хаана нуугдах билээ? гэж хашгичлаа.

Үл үзэгдэгч хүн гэгч тэр үү, тэгээд? гэж хар сахалтай хүн хэлээд өрөөсөн гараар нуруугаа үүрч -Түүнтэй чинь уулзах цаг бүр болоо юм шив дээ гэлээ. Гэтэл гуанзны цонхны шил гэнэт бут үсрэн гудамжинд хүмүүс хашхиралдаад, ийш тийш гүйлдэж үймэх чимээ гарав. Цагдаа урт сандал дээр гарч зогсоод тэргүүнээ гулдайлгаж, хэн үүдээр оролдож байгааг олж үзэх санаатай, тэр зүг ширтэж байснаа доош бууж нүдээ бүлтийлгэн: “Мөн байна” гэв. Буудлын эзэн Марвелын нуугдсан хажуугийн өрөөний үүдэнд шил нь хагарсан цонх руу харж байснаа америк хүн цагдаа хоёрын дэргэд хүрч ирлээ. Гэнэт чимээ аниргүй болов.

-Муна минь байсан ч болоосой гэж цагдаа хэлээд хулгасаар үүд рүү очиж, - Онгойлгонгуут л ороод ирнэ дээ, яаж ч аргалахгүй гэлээ.

-Үүд нээх гэж яарсны хэрэггүй гэж туранхай дэслэгч айсан байдалтай хэлэхэд хар сахалт:

-Түгжээгий нь мулталчих, ороод ирвэл... гээд гар буугаа харуулав.

-Тэгж болохгүй, хүн амины хэрэг болно гэж цагдааг хэлэхэд сахалт:

-Дэгээгий нь мултлаадах, би хөл рүү нь буудна, ямар оронд байгаагаа мэдэж байна шүү дээ гэв.

-Араас минь л битгий пан хийлгэж орхиорой гэж буудлын эзэн хөшигний дээгүүр өнгийн харангаа хэлэхэд хар сахалт:

-За, за гээд бөхисхийн гар буугаа бэлэн болгоод өөрөө дэгээг мултлав. Гуанзны эзэн, улаач цагдаа гурав үүд рүү ширтжээ.

Хар сахалт –За-за одоо ороод ир! гэж нам дуугаар хэлэнгээ гэдрэг болж түгжээгүй болсон үүднээс нүд салгалгүй ширтэн гар буугаа ардаа барьсан байлаа. Хүн ер орж ирсэнгүй, үүд нь хаалттай хэвээр л байв. Тэр таван минут хиртэй хүлээн зогсож байтал хоёрдугаар улаач үүдээр болгоомжтойхон шагайхад хажуугийн өрөөнөөс Марвел ихэд сандарсан байдалтайгаар толгойгоо цухуйлгаж:

-Үүд чинь цөмөөрөө хаалттай биз, өнөөх чинь энэ хавиар л эргэлдэж байгаа байх шүү. Зальтай чөтгөр шүү! гэв.

Буудлын болхи эзэн сая санаа –Бурхан минь! Хаалга яагаа вэ? Энэ үүд хаалгуудыг харж манана гэдэг бас хэцүү еэ! Юу гэхэв дээ таминь! гээд хүн хүн рүү аргаа барсан байдалтай харлаа. Энэ үеэр хажуугийн өрөөний хаалга тасхийн цоожлогдох чимээ дуулдав.

-Энэ өрөөнөөс арын хаалга руу гардаг юм. Арын хаалга ... гээд гарч одсоноо төдхөн гал тогооныхоо нэг том хутгыг барьсаар эргэж ирэн –Арын хаалга онгорхой байна гэж буудлын эзэн хэлээд доод уруул нь унжив.

-Тэгвэл нөгөө үзэгддэггүй хүн чинь гэрт ороод ирчихсэн байж мэдэх л байна даа гэж түрүүчийн нэг улаач хэлэхэд, буудлын эзэн:

-Гал тогоонд ч алгаа. Тэнд хоёр хүүхэн байна. Би энэ махны хутгаар ийш тийш нь хайж сүлбэж үлдсэн. Тэр хоёр хүүхэн ч орж ирээгүй байх гэж байна. Харин тэр хоёр ... гэтэл түрүүний улаач:

-Та тэгээд үүдээ хаав уу? гэв.

-Би хүүхэд биш.

Сахалт гар буугаа далд хийлээ. Яг тэгтэл лангууны орж гарах таг сөхөгдөн, цуурга дуутай гэгч тайлдаж хажуу өрөөний хаалга хүчтэй нээгдэн Марвел баригдсан туулай шиг чахран дуугарсан учир тэд туслах санаатай гүйлдэв. Америк хүн ч буудлаа, өрөөний мухарт байсан толь ч хага үсэрч, шилний хагархайнууд шалан дээр хангинан унав.

Буудлын эзэн тэр өрөөнд гүйн орж ирэхэд Марвел жигтэйхэн атиралдан далдын хүчинд автан тэмцсэн арын хаалга тийш чирэгдэн яваа харагдав. Буудлын эзнийг мэл гайхан зогссоор байтал хаалга нээгдэж Марвел гал тогооны өрөө рүү чирэгдэн орлоо. Хүн айж сандран хашхирав, сав суулга хангинаж жингэнэх дуугарав. Марвел толгойгоо доош духайлган зүтгэж, хэдэрлэн эсэргүүцэвч хүчинд аргагүй

автан гал тогооны өрөөн дундуур чирэгдэв. Тэндээс гадагш гарах үүдний оньс аяндаа мултрав.

Нөгөө цагдаа буудлын эзнээс урьтан тийш орж Марвелын чирэх үл үзэгдэх гарын шуунаас атган авсан боловч нүүр лүүгээ цохиулан арай л ойчсонгүй. Үүд онгойлоо. Марвел ч тэр үүднээс зуурчээ. Яг энэ үед өнөөх улаач нэг юмнаас барьж аваад

-Би бариад авлаа гэж хашхирав.

Буудлын эзэн тарган улаан гараараа хий тэмтэрснээ –Байна, байна! гэж бас хашхирав.

Марвел, хүний гараас сая нэг юм мултран шалан дээр сууж хоцорсноо тэмцэлдэн байгаа хүмүүсийн хөл доогуур гарч зайлахыг оролдов. Цаадуул нь ноцолдсоор үүднээс овоо холджээ. Цагдаа үл үзэгдэх хүний хөлийг гишгичихсэн учир орь дуу тавихад тэд түүний дуу хоолойг анх удаа сонсжээ. Тэгснээ амь тэмцэх адил орилон хашхирч атгасан гараар учир зүггүй балбан улаачийн аймхай мөгөөрс рүү дэлсэв бололтой. Наадхи нь дуу алдан, дугуй хадан унав. Марвел гал тогооны өрөөний хаалга онгойлгон бас хажуугийн өрөөний хаалгыг татан орж зулбалаа. Гадаа хашааны үүдэнд ноцолдож байсан нөгөөдүүл нэг мэдэхэд бие биетэйгээ тулгаран хоосон хий тэмтэрч байв.

-Өнөөх чинь яаав аа, яачив? гэж сахалт хашхиран асуухад цагдаа:

-Хашаа руу орсон байх гээд хаалгаар гарснаа дорхиноо зогсов. Толгойных нь яг хажуугаар нэг тоосго шүргэх шахан өнгөрөөд сав суулга өрөөстэй ширээн дээр тусчээ.

-Гайгүй би чамд үзүүлээд өгөмз! Гэж хар сахалт Америк хэлээд цагдаагийн мөрөн дээгүүр тоосго нисэж ирсэн зүг бууны ган голыг гялалзуулан тав дахин буудлаа. Сахалт, шүрших маягтай буудсан учир сум нь давчуу хашаан дотор дугуйн хигээс хэлбэртэй тусчээ. Нам гүм болоход хар сахалт:

-Таван сум, лав болоо вий! Дөрвөн тамга, гүрэнтэйгээ гэсэн үг шүү дээ! Нэг нь дэнлүү аваад ир, очоод тэмтэрвэл биеийг нь олж болно гэв.

ДОКТОР КЕМПИЙН ИРСЭН ХҮН

Доктор Кемп бичгийнхээ өрөөнд юм бичээд сууж байтал гэнэт буун дуу пис, пас дуугарахыг сонсоод гайхаж “Хү-еэ” гэж дуу алдан, үзгээ амандаа хийж чагнав.

-Бердокт ямар амьтан ингэж гар буугаар бууддаг билээ? Ямар илжиг нь яах гээд байгаа юм бол? гэж бодоод урд талынхаа цонхон дээр очиж нээгээд доош харвал гэрэлтэй олон цонх, пүүс дэлгүүр, завсар хооронд нь харанхуй хашаа, дээвэр холилдон харагдлаа.

-“Крикетчүүдийн” тэнд олон хүн цугларсан шиг байх юм даа гэснээ ажиглан зогсож хараа сунган алсыг ширтвэл хөлөг онгоцны чийдэн дэнлүү гялалзан, буудал зогсоолын өнгө муутай гэрэл, олон талт жижигхэн павильон шар өнгийн эрдэнийн

чулуу мэт гялалзан харагдана. Баруун ухаагийн яг дээр чигт хавирган сар өлгөөстэй мэт гялтайж, од гариг жирвэс жарвас хийнэ.

Доктор, ирээдүйн хүн нийгмийн амьдралын нөхцөл байдлын тухай гүнээ бодол болсноо бодол нь цаг үеийн хязгааргүй их уудамд сарних зургаан минутын төдий болоход шүүрс алдан нэг суниснаа, цонхоо хаагаад бичгийнхээ ширээний дэргэд ирлээ.

Тэндээс хойш нэг цаг хэртэй болсны дараа үүдний нь хонх дуугарчээ. Түрүүнд буун дуу сонсогдсоноос хойш докторын сэтгэл нэг л тавгүй болж тэр тухай байн байн бодогдож, ажлаа хийсэн болж байлаа. Хаалга дуугарахад ажлаа хойш тавьж эгц суугаад чагнав. Шивэгчин нь буугаад үүд тайлах чимээ сонсогдсон тул одоо гийчин орж ирнэ хэмээн хүлээсэн боловч орж ирсэнгүй.

-Юу болоо юм бол? гэж Кемп амандаа хэлээд хийж байсан юмаа оролдох гэсэн боловч шатны талбай дээр гараад шивэгчнийхээ хонхыг дарав.

Шивэгчин шатаар өгсөхөд нь Кемп шатны хашлага налан тонгойж:

-Юу болсон бэ? Захиа ирээ юу? гэж асуухад цаадхи нь:

-Нэг муу дүрсгүй хүүхэд л хонх дарчихаад зугтах шиг боллоо, ноёнтон минь гэв.

“Дотор баахан бухимдаад тавгүй байх чинь” гэж Кемп бодов. Тэгээд бичгийнхээ өрөөнд орж хийж байсан ажлаа зориг шийдэмгий үргэлжлүүлэв.

Нээрэн ч ажлаа маш хичээнгүй хийж чив чимээгүй суухад гагцхүү үзэг чахран, цаг чаг чаг гэх сонсогдоно. Доктор ширээний чийдэнтэй тул бичиж байгаа зүйл нь түүний дугараглан туссан гэрэлд харагдана.

Кемпийг ажлаа дуусгахад шөнийн яг хоёр цаг болсон байв. Кемп босож эвшээгээд, унтлагынхаа өрөөнд орж гадуур цамц, хантаазаа тайлж байтал гэнэт ам нь цангаж юм уумаар санагдснаа сая мэдэж лаа асаан бариад соодтой усны сифон, виск архи олж уух санаатай гал тогооны өрөө рүү явав.

Кемп шинжилгээний ажил хийсээр юм нарийн ажиглах соргог заншилтай болсон тул үүдний өрөөгөөр явж байхдаа шатны шувтарга дээр, сийрсэн дэвсгэрийн дэргэд нэг жаахан хар юм байхыг анзааран өнгөрөн алхсан боловч чухам юу болохы нь мэдэхээр шийдэж, барьсан юм хүмтэйгээ буцаж очоод, сифон лонх хоёроо шалан дээр тавьж хар толбонд гараа хүргэвэл нөжирч буй цусархуу байдалтай юм байхыг олж үзээд дэмий их гайхсан ч үгүй. Шалан дээр тавьсан юм хумаа авч шатаар өгсөж тал тал тийш харан юун цус, хаанаас бий болдог билээ, гэж бодон учрыг нь олж ядан байлаа. Өөрийнх нь өрөөний хаалганы бариул бас цус болсон байхыг үзээд Кемп маш их хирдхийн гайхаж, шатны талбар дээр зогтусан зогсоод, гараа үзвэл цэв цэвэрхэн бөгөөд бичгийн өрөөнөөс гарч доош буухад өөрийнх нь унтлагын өрөөний хаалга бас онгорхой байсныг бас санажээ.

Бариулд нь өөрөө ер гар хүрээгүй гэж санаад, тэр өрөө рүүгээ шууд оров. Кемпийн царайг ажиглавал тун тайван, гагцхүү урьд урьдынхаас ялимгүй шийдэмгий

төлөвтэй байв. Ороод ийш тийш ажиглан харсаар орныхоо бүтээлэг дээр цус дусаж, цагаан даавуу нь урагдсан байхыг олж харав. Кемп орж ирмэгцээ ариун цэврийнхээ ширээ рүү орсон учир үүнийг анзаараагүй байжээ. Бас орны бүтээлэг нь цаад талдаа саяхан хүн суугаад боссон юм шиг атиралдсан байлаа.

Тэгтэл ч “Ай доктор Кемп үү дээ” гэж нэг хүн дуугарах шиг санагдавч Кемп ганц дуу чимээнд итгэх хүн биш байлаа. Кемп атирч хорчийсон бүтээлэгтэй ор руугаа ширтэн нээрэн хүн дуугарав уу гэж гайхаад ийш тийшээ харвал юу ч үзэгдэхгүй, гагцхүү атиралдсан, цус буртаг болсон ор нь л харагдана. Тэгтэл гар нүүр угаадаг газрых нь хавьд хүний хөлийн чимээ тод сонсогджээ. Ямар ч хүнд, хичнээн юм мэдэх боловсролтой хүнд ч гэсэн заавал мухар сүсгийн ур үндэс байдаг юм. Кемпийн дотор нэг л хачин болоод явчихжээ. Тэгээд өрөөний хаалгыг хааж барьж явсан юмаа хувцасныхаа шүүгээн дээр тавиад хартал угаалгын хэрэгсэл, өөрийнх нь бие хоёрын хооронд гэнэт цус болсон даавуун боолт хий агаарт цагираглан байгаа харагдав. Кемп хиртхийн цочив. Хараад байвал боолтон дотор хоосон, ер нь л яах аргагүй сүрхий бэлдсэн хов хоосон боолт байжээ. Доктор түүнд ойртон очиж барин үзэхийг завтал нэг юм биенд нь тулжээ. Яг дэргэд нь Кемп ээ! гэж нэг хүн дуугарав.

-Аан! гэж Кемп асуугаад мэл гайхан зогсов.

-Битгий сандраарай, би үл үзэгдэгч хүн байна.

Кемп хариу юу ч дуугарч чадалгүй нэг хэсэг дэмий л боомт руу гөлрөн байснаа:

-Үл үзэгдэгч хүн гэнэ ээ? гэхэд:

-Би үл үзэгдэгч хүн байна гэж дуугарав.

Тэр өглөө Кемп сонсоод ер итгэхгүй хөх инээд хүрч байсан явдал одоо тархи толгойд нь орж нэг ч айж сүйд болсонгүй, нэг ч их гайхаж сүйд болсонгүй харин дуулсан явдлын үнэн магадтайг ухаараад:

-Би ер шал худлаа гэж бодож байсан юм гэв. Өглөөний эргэцүүлэн бодож байсан элдэв юм санаанд нь оров.

-Та гараа боогоо юу? гэхэд үл үзэгдэгч хүн

-Тиймээ гэв.

-Өө! гэж Кемп хэлээд сэргэж –Тийм байх аа! за энэ ч яахав. Илбэ л биз гэв.Тэгээд урагш ахин алхаж гараар боодлыг тэмтэрвэл хүний үл үзэгдэх хуруу тааралджээ. Кемп давхийн цочиж царай нь хувсхийв.

Кемпээ, битгий ай, бурхан минь! Надад тус бол зүгээр!

Үл үзэгдэгч гар Кемпийн гараас барьж авахад Кемп түүнийг цохиод авав. Цаадхи нь

-Кемп битгий ай, Кемп гээд улам чанга атгалаа. Кемп ямарч гэсэн тэр гараас мултармаар санагдаж оролдсон боловч боолттой гарын хуруу түүний мөрнөөс базан зуурч нэг мэдэхэд Кемп орон дээр араараа ойчжээ. Хашхирах гэж амаа ангайтал ам руу нь орны цагаан даавууны сэжүүр чихэв. Үл үзэгдэгч хүн түүнийг орон дээр нь сүрхий шахан дарав. Гэвч Кемпийн гар сул байсан тул гараар эсэргүүцэн, хөлөөр чадал мэдэн тийрэвч гийчин нь ер давгүй байдалтайгаар,

-Ухаалаг байж үзээрэй! Ингээд байвал би галзуурч мэдэх нь байна! ... Зүгээр л хэвт, тэнэг минь! гэж чихэнд нь шийвэгнэв.

Кемп хэсэг зуур ноцолдсоноо больж хөдөлгөөнгүй хэвтжээ. Үл үзэгдэгч хүн түүний амны бөглөөг авч:

-Хэрэв чамайг бархирвал нүүр нүдгүй болгоно шүү! Би үл үзэгдэгч хүн байна. Илбэ, жилбэ, элдэв худал юм биш. Би ёстой л үл үзэгдэгч хүн. Би танд хор хүргэе гэж бодоогүй, харин таныг хашхичин чагнаад байвал тэгэхээс өөр аргагүй болно гэв.

-Кемп чи намайг мэднэ байх аа? Би чинь их сургуулийн оюутан Гриффин шүү дээ, та бид хамт сурч байсан.

-Би босож сууя, байгаа газраасаа хөдлөхгүй. Тэгээд жаахан сэхээ авъя гэж Кемп хэлээд өндийн сууж хүзүүгээ тэмтэрлээ.

-Би чинь их сургуулийн Гриффин, өөрийгөө үзэгдэхгүй болгочихоод байгаа нь энэ дээ. Би бол таны таил, үзэгдэхгүй л болсноос биш жирийн хүн шүү дээ

-Гриффин гэнэ ээ?

-Тийм Гриффин. Таны доод ангид байсан, цайвар үстэй, нуруу зургаан фут, цээж өргөн, ягаавтар царайтай, улаан нүдтэй хүн байгаагүй юу, химийн талаар медаль авсан шүү дээ.

-Би бүр гайхаад учраа чолохгүй байна. Гриффинд ямар хамаа байна?

-Гриффин чинь би байна.

Кемп бодлогошрон: -Аймаар юм байна. ямар чөтгөр нь зүгээр хүнийг үзэгдэхгүй болгочихдог юм бол?

-Чөтгөр хамаагүй. Харин зүй ёсны ойгож болох процесс...

-Аймаар юм. Ямар процесс гэж?

-Аймаар нь ч үнэхээр аймаар байгаа байх. Гэхдээ би шархдаад өвдөөд байна, ядарч байна.... Кемп чи яасан муу эр вэ! Битгий балмагд! Надад идэж уух юм өгөөч, энд чинь би сууж болно уу?

Кемпийн харсаар байвал өнөөх цагаан боолт өрөөн дотуур дүүлэн явсаар сүлжмэл сандлыг чирч орны дэргэд авчраад тавихад сандал шардхийн дуугарч дээр нь юм суусан бололтой доош ямхын төдий налчисхийв.

Кемп нүдээ нухалж шилбээ бас нэг маажаад:

-Энэ чинь ёстой чөтгөрөөс илүү юм байна даа. гэж хэлэнгээ дэмий инээд алдав.

-Болж дээ, Ухаан мэдрэл чинь одоо л нэг тогтож байх шив дээ?

-Ай, бүү мэд гэж Кемп хэлээд нударгаараа нүдээ арчлаа.

-Надад жаахан архи аль. Би үхэх шахаад байна.

-Би мэдсэнгүй шүү дээ. та ер нь хаана байна? Би босвол эгээ л таны дотор ороод өгөх юм биш биз! Өө! За архи.. энд байна. Яаж өгөх билээ? гэтэл өнөөх сандал шардхийн Кемпийн гараас шилэн хундагатай архийг нэг юм бариад татах шиг болоход ямар ч болтугай зөнд нь тавьсанд тэр нь сандлын дээр хориод ямхын төдий хий байхыг Кемп харж бүр ч их гайхлаа.

-Энэ лав илбэ байх... Та надад илбэ үзүүлээд өөрийгөө харгадахгүй болгоод байх шиг байна.

-Дэмий юм битгий ярь! гэж дуугарав.

-Би солиорох нь байна шүү.

-Миний хэлэх үгийг сонс!

-Би өнөө өглөө үзэгдэхгүй болно гэдэг ч бүтэхгүй зүйл гэж ямар ч гарцаагүй нотлоод орхисон юмсан... гэж Кемпийг ярьтал :

-Юуг юу гэж баталсан чинь хамаа алга! Би өлсөж байна. Шөнө болохтой зэрэг хувцасгүй шалдан хүнд хүйт оргиод байна гэж дуу гарлаа.

-Өлсөж байна гэнэ!

Хундага аянанд хөнтөрч виски архи нь асгаран гоожив. Үл үзэгдэгч хүн хундагыг шалан дээр тавиад -Өмсчих дээл хувцас байна уу? гэлээ.

Кемп аман дотроо нэг юм хэлээд дээл хувцасныхаа савыг онгичин үзэж хүрэн улаан өнгийн дээл гаргаж:

-Энэ таарах бол уу? гэж асуухад үл үзэгдэгч дээлий нь авав. Дээл тэр даруй дээш хөөрөн атиралдан дотроо нэг хүнтэй болох шиг болж товч нь товчлогдож сандал дээр суув.

-Оймс, дотуур өмд, гутал байвал мөн сайнсан. Хоол ч хэрэгтэй байна! гэж үзэгдэхгүй хүнийг дуу гарав. Кемп:

-Юу л бол юу аваарай. Би амьдралдаа, амьдралдаа... Ийм хачин юмыг сая л үзлээ гээд шүүгээгээ уудлаж уг зүйлсийг олж гаргаад доош бууж юм агуулах ерөө рүү

оров. Эргэж ирэхдээ хэдэн ширхэг хүйтэн котлет талх авчирч хөнгөхөн ширээг гийчиндээ ойртуулан дээр нь иавив.

-Хутгаар юу хийх вэ, хэрэггүй гэж гийчин дуугарч котлет нь хийд өргөгдөн зажлах чимээ гарлаа.

-Юм идэхийн өмнө нэг юм суудаг заншилтай хүн юмсан гэж үл үзэгдэгч хүн хэлээд котлетыг ховдоглон идэж:

-Хачин юм болсон шүү! гэхэд Кемп:

-Гар чинь гайгүй юу? гэв.

-Зовох юмгүй, гайгүй.

-Ёстой хачнаас хачин, сониноос сонин...

-Ёстой. Шархаа боох санаатай явж байгаад яг танайд ороод ирнэ гэдэг мөн ч гайхалтай. Надад тохиолдсон анхны аз маань энэ дээ. Ямар ч гэсэн би өнөө шөнө танайд унтана, битгий зовоорой! Таны юм хүмийг цус болгочихсон маань даанч муухай юм боллоо, тиймээ? Тэнд бүр бөөн нөж болчихож. Цус нөжрөхтэйгээ зэрэг үзэгдэх болдог байна шүү. Би амьд эсийг хувилгасан болохоор намайг амьдад үзэгдэхгүй байх юм байна, би танай байшинд орж ирсээр гурван цаг шахуу болж байна!

-Яаж байгаад тэр вэ? Чөтгөр бүү мэддээ! Ер нь эх адгий нь ч олохгүй хачин санагдаад байна! гэж Кемп цөхөрсөн байдалтай ярихад үл үзэгдэгч нь: -Боломгүй хачин юм биш ээ! Тийм биш, ер тийм биш гэнэ Тэр хүн гар сунган явуулж архитай хундагыг авч ховдоглон ууж байгаа бололтой. Кемп дуугүй л ширтэн харж байв. Лааны гэрэл, дээлийн баруун мөрийн дээрх нүхээр зүүн хавирганы дор чигтэй тусахад гурвалжин нүх бий болон харагджээ.

-Яагаад буудсан юм бол? гэж Кемп асуухад үл үзэгдэгч хүн:

-Нэг муу мангуу юм, уг нь надтай хамт ажиллах гэсэн байтлаа мөнгий минь хулгайлаад намайг чадчихдаг хэрэг шүү, муу золигийг доо! гэнэ.

-Тэр бас үзэгддэггүй хүн үү?

-Үгүй, үгүй.

-Тэгээд?

-Бүгдий нь ярихын урьд жаал зугаа юм идмээр байна. Өлссөн гэж танаггүй, гар минь өвдөж байна. Хажуугаар нь та элдвийн юм асууж шаардаад байх. Кемп босож –Та өөрөө буудаагүй юм уу? гэж асуухад гийчин нь:

-Би буудаагүй, ер танихгүй нэг юм л намайг буудсан. Тэр улсын ихэнх нь, ер нь цөмөөрөө надаас айсан байна билээ. Золиг! Жаахан идэх юм өгөөч гэсэн, юу болов Кемп ээ? гэхэд Кемп:

-Би доошоо очоод идэх юм үзээд ирье. Их юм байхгүй болов уу, яадаг билээ гэнэ.

Үл үзэгдэгч хүн яггүй их идчихээд янжуур байна уу гэж янжуур аваад Кемпийг хутга олохын завдалгүй янжуурын ишийг тас хазчихаад гадуурхи хуудсы нь унахад хараал тавив.

Тамхи татахыг нь ажвал ам, хамар, хоолой нь эргэлдэн байгаа утаагаар нь бүрэлдсэн юм шиг харагдав.

-Тамхи татах гэдэг чинь ямар сайхан юм гэж утааг хүчтэй үлээснээ –Кемп ээ, би яаж зэгсэн чамайг олж золгов оо? Чи надад туслах хэрэгтэй. Би одоо тун хэцүү байдалтай байна. Солиорох нь ээ гэж боддог байсан юм. Элдвийг үзэж тамаа цайж явна. Харин чи бид хоёр одоо нийлээд юм хийвэл учиртай л байх шүү.

Үл үзэгдэгч хүн дахин соодтой виски уув. Кемп босож ийш тийш харснаа хажуугийн өрөөнөөс өөртөө нэг хундага авчрав.

-Хачин ч гэсэн яахав, уумаар санагдаж байна.

-Кемп, чи ер ийм олон жил болоод уулзахад хувтраагүй байна шүү. Цайвар царайтангууд барагтай бол хувирдаггүй улс даа. Аашаа ч барьдаг улс аргатай ч улс.... Танд бүгдийг ярьж өгнө. Хоёул хамтарч ажиллууз!

-Мартсан яаж хийв ээ? Та яагаад байгаад ийм болчихов оо?

-За байз, би тамхиа нэг тайван татаадхая, тэгж байгаад ярьж эхэлье гэж үл үзэгдэгч хүн хэлсэн боловч тэр шөнө түүний гар өвдөж, бие халуурч, бас ядарч зүдэрсэн, өдрийн хөөцөлдөж өнөөх ухаа руу уруудан гүйж байсан нь, буудлын газар ноцолдсон нь санагдаж ер амарч чадахгүй тарчилж байлаа. Тэгээд өөрийнхөө түүх намтраас ярьж эхэлсэн боловч больчихоод Марвелын тухай эсэн бусын юм энд тэнд оочин цоочин ярьж байснаа ууртай дуугарч эхлэв. Кемп учры нь ойлгох санаатай чадлаараа анхааран чагнав.

-Тэр хүн надаас айгаад байсан юм. Надаас айгаад байсан юм гэж үл үзэгдэгч гийчин олон дахин хэлээд: -надаас оргож зайлахыг завдан дандаа ийш тийш хулгай нүдээрээ хараад байсан юм. Би гэж нэг тэнэг юм мэдсээр байж! Золиг оо! Миний уур хилэн бадарч, тэрнийг алчихмаар санагдаад байсан ...гэв.

-Та мөнгө хаанаас олж аваа вэ? гэж Кемп гэнэт асуухад үл үзэгдэгч гийчин хэсэг дуугүй болсноо – Одоо ярьж чадахгүй нь ээ гээд гэнэт ёолж, бөхийн, үзэгдэхгүй гараар үзэгдэхгүй толгойгоо тулаад:

-Кемп ээ, би бараг бүхэл гурван хоног бараг унтсангүй. Одоохон унтмаар байна гэв.

-Тэг, тэг, өнөө шөнөдөө миний өрөөнд унт

-Яаж ч унтах билээ? Намайг унтсан хойно оргоод явчихвал яана аа! Яах вэ?

-Таны шарх яаж байна?

-Дажгүй. Жаахан шалбарч, цус гарснаас өөр юмгүй. Ай тэнгэр минь! Унтмаар л байна.

-Унтаач дээ, яагаад байна?

Үл үзэгдэгч хүн Кемпийг ширтэн ажиглаж байгаа бололтой байлаа.

-Өнөөдүүлд чинь баригдчихгүй юсан гэж бодож байна гэж үл үзэгдэгч хүн удаанаар хэлэв.

Кемп давхийн цочив.

-Би ер нь яасан тэнэг хүн бэ? гэж үл үзэгдэгч хүн ширээг чанга шааж өндөр дуугаар хэлээд –Энэ санааг би өөрөө чамд өдөөж өгөв үү дээ! гэв.

ҮЛ ҮЗЭГДЭГЧ ХҮН НОЙРСОВ

Хүч тамир барагдаж , шарх олсон үл үзэгдэгч хүн , зовох юмгүй унтаж болно гэсэн Кемпийн үгэнд төдий л итгэхгүй, унтлагын өрөөний хоёр цонхны хөшгийг татаж, мод хаалты нь нээж арга ядвал түүгээр гарч болно гэж боджээ. Кемпийн үгийг сорьж цонхы нь нээж үзэв. Цонхны цаана нам гүм, харанхуй, шөнийн сар толгойн цаагуур жаргаж байв. үл үзэгдэгч хүн бас унтлагын ба хажуугийн хоёр өрөөний үүдний цоож цуургыг шалган үзэж санаа амран задгай зуухны урдуур дэвссэн хивсэн дээр зогсоод эвшээх чимээ гарав.

-Энэ орой надад учирсан бүх явдлын талаар одоо ярьж өгч чадахгүй нь ээ. Би даанч ядраад байна. Хачин ч байна. Аймшигтай ч байна. Кемп та өнөө өглөө боломжгүй гэсэн ямар ч баталгаа гаргасан бай хамаагүй,боломжтой юм шүү. Би нээлт хийсэн. Энэ нээлтээ ганцаараа эзэмших санаатай байсан юмсан. Чадахгүй. Хамжиж хамтрах хүн хэрэгтэй байна. Тэгэхээр та... бидэнд өргөн их боломж байна. За энэ тухай маргааш ярья. Одоо унтахгүй бол горьгүй нь.

Кемп тасалгаан дунд зогсоод толгойгүй дээлийг ширтэнэ.

-Би эндээс гарах уу даа, үгүй бас санаанд багтамгүй хэрэг ээ. Иимэрхүү юм дахин тохиолдоод миний бат үнэмшсэн юманд цохилт болоод байвал би лав солирох байх. Гэсэн ч яах аргагүй л үнэн байна! За одоо надаар хийлгэмээр өөр юм байна уу?

-Сайхан нойрсохыг ерөөхөөс өөр юм байхгүй гэж Гриффин хэлэхэд, Кемп:

-Сайхан нойрсоорой гэж үзэгдэхгүй гар барьж хаалга руу явлаа. Гэтэл өнөөх дээл гэнэт ойртон ирж:

-Сайн мэднэ биз? Намайг барих марих гэж битгий зовоогоод байгаарай! Тэгвэл ... гэхэд Кемпийн царай хувьсхийн:

-Би танд үнэн үгээ хэлсэн гэж бодож байгаа шүү гээд хаалга зөөлөн хааж гарав. Дотроос нь цоожлох чимээ дуулдав.

Кемпийг тэр өрөөнөөс гараад гайхаш барагдан зогсож байхад дотуур хурдан хурдан алхах чимээ гарч дээл хувцасны өрөө хаалгыг бас дотроос нь цоожлох дуулджээ. Кемп духаа арчиж:

-Би зүүдэлж байна уу? Нэг бол би солиорч, эсхүл ертөнц болохоо байчихаад байна уу? гэж бодоод инээд нь хүрч цоожтой хаалгыг дарж үзээд,

-Өөрийнхөө унтах өрөөнөөс ингэж нэг байж болшгүй хачин юманд хөөгдөх гэж дээ гэв.

Кемп шат өөд өгсөн явахдаа эргэн харж цоожтой хаалгуудыг ажиглан:

-Аргагүй үнэн юм гэж хэлснээ шалбарсан хүзүүгээ гараараа тэмтэрч - Гарцаагүй үнэн баримт байна, гэвч... гээд тэргүүнээ цөхөрсөн байдалтай дохис дохис хийлгээд шатаар уруудав. Кемп гал тогооныхоо өрөөнд орж гэрлий нь асааж янжуур олж аван өрөөн дотуур хөлхөж, гэнэ гэнэ дуу алдах дөхөн юм үглэнэ Гэнэ гэнэ өөртэйгөө маргана.

-Үл үзэгдэгч! Үл үзэгддэг амьтан ер байдаг бил үү, үгүй бил үү? ... далайд.... Байдаг. Түм бумаараа байдаг. Авгалдай мавгалдай гэхшиг элдэв шалдвын нян хорхой шиг амьтан алиныг тэр гэхэв, зөндөө д байдаг далайн залхаг байна! Далайд үзэгдэхээсээ үзэгдэхгүй амьтан олон байдаг. Ийм бодол урьд үе орж ирсэнгүй. Цөөрөм дотор ч гэсэн дээ! Цөөрөмд өнгө зүсгүй, харагдах биегүй амьтан хичнээн байна вэ! Агаар хийд харин тийм юм байхгүй, үгүй гэж үглэснээ –Ер боломгүй юм даа. Яагаад тэр билээ? Хүнийг шилээр хийлээ ч гэсэн заавал үзэгдэнэ дээ

Кемп гүн бодолд автан дуугүй суухдаа гурван янжуур татаж цаган үнс нь хивсэн дээр бутран унасан хойно дуугарахдаа дуу алдчих дөхжээ. Кемп тэндээсээ гарч зөвлөгөө өгдөг жижигхэн өрөөндөө орж гэрэл асаав. Кемп, практик бараг хийдэггүй, том өрөө хэрэггүй гэдэг учраас энэ өрөө нь дэндүү давчхан бөгөөд тэнд сонины сүүлчийн дугаарууд байлаа. Тэдгээрийн дотор өглөөний сонин бас хэвтэж байв. Кемп тэр сонинг аваад эргүүлэн үзвэл далайч, Марвелд үсэглэн уншиж өгч байсан: “Айпингээс ирсэн хачин сонин мэдээ” гэсэн зүйлийг олж үзээд гүйлгэн уншив.

Нүүр царайгаа боож далдлаад байсан гэнэ! “Тэрний золгүй явдлыг мэдсэн хүн байхгүй бололтой шүү!” “Ер нь яах санаатай байсан хүн юм бэ? гэж Кемп үглэв.

Кемп, тэр сонингоо нүдээр хайж байснаа –Аа, энд байна! гэж Жеймсмйн сонины нэг дугаарыг авч -Одоо ч учир нь олдох нь ээ гээд сонинг дэлгэж үзвэл хоёр мөрөнд: “Сассескийн нэг тосгоныхон цөмөөрөө солиоров” гэсэн гарчиг байв.

-Ээ, бурхан минь! Кемп бидний, дээр өгүүлсэн Айпингэд болсон явдлын тухай тодорхой мэдээг маш сонирхон уэшиж, өглөөний мэдээ хоёрдугаар нүүрэнд дахин хэвлэгдээд байсан учир дахин уншив. “Гудамжаар хэн тааралдсан хүн бүрийг баруун зүүнгүй балбан гүйж байлаа. Жефферс ухаангүй хэвтэж байна. Хекстер юу үзсэн харснаа өнөө хүртэл сайн ярьж чадахааргүй өвчтэй хэвээр байна. Ламбугайг айхтар даажигнаж. Эмэгтэйчүүд айсандаа өвджээ. Бүтэн үлдсэн цонх байхгүй, бүгд

хагархай. Энэ хачин явдал лав худал зохиосон хэрэг гэмээр. Гэвч хэвлэхгүй орхих аргагүй дуулиантай юм.” гэсэн байв.

Кемп, уншиж байсан сонингоо доор тавиад алмайрсхийн харж: Лав худал зохиосон хэрэг байх гэнэ! Сонинг дахин авч өнөөх зүйлээ цөмийг дахиад нэг уншив. Тэгээд:

-Тэгвэл тэр тэнүүлч этгээд газрын хаанаас гарч ирсэн юм бэ? Үл үзэгдэгч хүнд тэр тэнүүлч этгээдтэй зууралдаад байх ямар хэрэг байгаа вэ? гэснээ өвчтөн үзэх урт сандал дээр лүгхийн суув.

-Үл үзэгдэхээр барахгүй, солио туссан амьтан байх нь ээ! Хүн алах өвчин тусчээ!..

Гэрэл орж үүрийн бүдэг туяа лааны гэрэл, тамхины утаатай нийлээд ирэх үед Кемп гал тогооныхоо өрөөн дотуур холхин үл ойлгогдох тэр зүйлийн учрыг олох санаатай бодсоор байв.

Кемп сэтгэл их догдлон хөдөлсөн тул унтаж чадсангүй. Шатаар нойрмог бууж явсан зарц шивэгчин нь эзнийгээ ийнхүү унтаагүй босоо байхыг үзээд оюуны хүнд хүчир ажилдаа дарагдсаных биз гэж бодсон ажээ. Гэтэл докторын тодорхой хэлсэн үгийг сонсоод тэд их гайхав. Бичгийн өрөөнд ширээ засаад хоёр хүний идэх хоол унд авчир. Өөрснөө доош буугаарай гэжээ. Тэгээд Кемп гал тогооныхоо өрөөн дотуур хөлхөн хэмжээ авсаар байтал өглөөний сонин авчирч өгчээ. Тэр дугаарт бичсэн зүйл маш их боловч тодорхой юмаар хомсхон, өчигдөр орой болсон явдлыг баталж бас Бердок боомтод болсон сонин хачин явдлын тухай маш бүдэг муу бичсэн байлаа. Гэвч Кемп “Наргиантай Крикетчидэд болсон явдал ба Марвел гэдэг хүний учрыг бараг үнэн голоор нь мэдэж авав. “Намайг бүхэл өдөр шөнө хоёр явуулахгүй бариад байсан” гэж Марвел мэдүүлсэн ажээ. Айпингийн цахилгаан мэдээний утсан шугам гэмтсэн тухай гэх мэт хэд хэдэн жижиг сажиг баримт дурджээ. Гэтэл энэ бүхэн өнөөх гурван дэвтэр, бас мөнгө цэнгий нь өвөртөлсөн Марвел, үл үзэгдэгч хүн хоёрын харьцааг тодруулж өгсөнгүй. Одоо эргэлзэж, үл итгэх явдал нэгэнт үгүй болж, өдий төдий сурвалжлагч нар уг болсон явдлын улыг олох санаатай хөөцөлдөх болсон ажээ. Кемп, тэдгээр сонинд бичсэн бүх мэдээ сэлтийг нэгд нэгэнгүй уншиж дуусаад, өглөөний өөр бусад ямар л сонин байвал аваад ир гэж шивэгчин эмэгтэйг зарж, түүний авчирсан сонинд бичсэн мэдээг бас эхнээс нь аваад дуустал нь уншин шувтарчээ.

-Үзэгдэггүй нь үнэн юм! Сонинд бичсэнээр үзвэл энэ хүн уурлаад солиорох гэнэ. Ер нь яаж ч магадгүй нь! Бодохоос айдас хүрмээр, би яах билээ? Одоо тэр манай дээд өрөөнд салхи шиг сул явж байдаг. Хэрэв... яавал итгэл алдсан, урвасан хөрөвсөн болох болов уу?

Кемп булангийн жижиг ширээн дээр очиж нэг юм бичиж эхэлснээ, түүнийг зурж хаяад дахин эхэлж бичив. Бичсэнээ уншиж үзээд бодлого болсноо нэг дугтуй авч “Бердок боомтын хурандаа Эдайд” гэж нүүрлэв.

Өнөөх үл үзэгдэгч нь яг энэ үеэр сэрсэн ажээ. Үл үзэгдэгч хүн сэрсээр ууртай байсан тул ширүүн дориун хөдөлж чимээ анир бүхнийг сэргэг чагнаж байсан Кемп учрыг

мэдтэл сандал тархийн ойчиж шилэн аяга хага үсрэх чимээ дуулджээ. Кемп яаран сандран дээш гүйж гараад хаалгыг балбав.

ГОЛ ХЭДЭН ЗАРЧИМ

Кемп үл үзэгдэгч хүнийг хаалгаа тайлж өгөхөд:

-Юу болоо вэ гэж асуув

-Юу ч болоогүй

-Үгүй, нэг их дуу чимээ гардаг чинь юу билээ?

-Уурандаа л ингэчихлээ. Гараа шархтайг мартаад хөндчихлөө.

-Та ер нь ингэж уурлаад байдаг болжээ дээ?

-Тийм шүү

Кемп хэд алхаж очоод шилэн аяганы хагархайг түүж авлаа.

Таны тухай нийтэд зарлан тунхаглажээ. Айпингэд болсон хэргийг ч, эндэх ухаагийн хавьд болсон явдлыг ч мэдэцгээсэн байна. Ертөнц үл үзэгдэгч нэг иргэнтэй болсноо мэджээ. Харин таныг энд байгаа гэж мэдэх хүн алгаа гэхэд цаадхи нь хараал тавив.

-Таны нууц илэрчээ. Та ер нь нууц байгаад байх гэж бодож байгаа хүн шив дээ? Би таны юу хийх санаатай байгааг мэдэхгүй байна, гэсэн ч дуртай туслалцах болно.

Үл үзэгдэгч хүн орон дээр суув.

Кемп айвуу тайвуу ярихыг оролдож:

-Хоол цай бэлэн болоод байна, дээшээ гарч идэж ууя гэхэд гийчин нь дуртай зөвшөөрсөн учир Кемпд аятай санагдаж түүнийг дагуулан дээш гарав.

-Давын түрүүн би таны үзэгдэхгүй болсон шалтгааныг жаахан сонсмоор байна гэж Кемп хэлээд хүнд хэцүү ярианд оролцох гэж байгаа хүн шиг цонхоор нэг зэрвэс хараад суув. Кемп энэ бүгдийг үнэхээр үэнэ болж байгаа эсэхэд түр эргэлзсэн боловч ширээний ард толгойгүй, гар харагдахгүй ханцуйтай дээл, дотроо хүнтэй мэт харагдах бөгөөд амны алчуурыг хий агаарт хачирхам барьж үл үзэгдэх уруулыг арчиж байгааг харахтайгаа зэрэг ямар ч эргэлзээгүй болов.

-Их ч амархан, тун ч үнэндээ гэж Гриффин алчуураа хажуу тийш тавиад үзэгдэхгүй толгойгоо үзэгдэхгүй гараар түшиж буй бололтой.

-Танд, бодвол, эхлээд гэснээ Кемп инээд алдав.

-Тийм тийм надад эхлээд бас хачин гайхмаар санагддаг байсан юм. Тэгтэл одоо, ай бурхан минь! Бидэнд хийвэл зохих юм бас ч их байна. Би анх Чезлстод байхдаа ийм юм сэдсэн юм гэхэд Кемп:

-Чезлстоуд уу?

-Би Лондонгоос тэнд очсон юм. Анагаах ухааныхаа мэргэжлийг орхиод физик оролдсныг та мэднэ шүү дээ. Мэргэжлээ солиод гэрлийн асуудлыг сонирхсон юм.

-Өө!

-Юмны харагддаггүй болдог учрыг шүү дээ! Учры нь олоход амаргүй, ээдрээтэй хэцүү асуудал юм. Бодоход элдэв бүдэг таавар санаанд орно. Тэгэхэд би хорин хоёртой байв даа. Зориг ч гэж төмөр, хэлээд яахав. Бүх амьдралаа зориулна, тэгэхэд болох асуудал гэж зүтгэчихсэн юм. Хорин хоёр насандаа бид ч ёстой гал байсныг та юу эс андах вэ!

-Тэр үед тэнэг байж, одоо ч тэнэг байна гэж Кемп хэлэхэд:

-Одоогийн мэдлэг маань хангалттай юм биш. Бүх л зургаан сар толгой өөд татахгүй ажиллачихаад байтал тэр олон санааны дотроос гэнэт нэг гоц асуудал тархинд маань гялсхийн ороод ирлээ шүү. Өнгө хугаралтын нөлөөлөх ерөнхий зарчмыг нээж, геометрийн дөрвөн хэмжигдэхүүний томъёог оллоо. Тийм томъёо молекулын физик судалж байгаа хүнд ямар ач тустайг энгийн мангуу хүмүүс, тэр ч байтугай тоочингууд мэдэхгүй байна. Өнөөх тэнүүлчийн аваад зугтсан миний дэвтрүүдэд ёстой гайхалтай гайхамшигтай юм бий дээ Тэнд аргы нь заасан юм байхгүй. тэгэхдээ аргы нь олж болох санааг заасан байгаа. Тэр аргаар бол эд юмны чанарыг ер өөрчилөхгүйгээр хааяа ганц нэгээс бусад хатуу шингэн бодисоос гэрэл ойж хугалах итгэлцүүрийг багасгаж болох юм. Тэр итгэлцүүрийг яг агаарт гэрэл хугарах итгэлцүүртэй адил болгоод бүр практик юманд хүртэл ашиглаж болох юм.

-Пөөх, хачин юм даа, гэсэн ч би учры нь сайн ухаагүй байна. Ийм аргаар үнэт эрдэнэсийн чулуу сүйтгэж болно гэдгийг би ойлгож байна, гэхдээ хүнийг үзэгдэхгүй болгох гэдэг чинь бас л яггүй хэцүү хэвээр үлдэх шив дээ гэж Кемп ярихад, Гриффин,

-Тун зүйтэй гэж хэлээд үзэгдэгч биетэн гэдэг чинь гэрэлд байхдаа л үзэгддэг учиртайг анзаарах хэрэгтэй.Хамгийн энгийн юмнаас эхэлье л дээ Яахав та мэдэхгүй юм болог. Тэгтэл миний санаа танд тодорхой болно. Аливаа бие, бодис гэрлийг нэг бол ойлгож хугалдаг, эсвэл өөртөө шингээдэг шүү дээ. Заримдаа аль аль нь зэрэг болдог бодис ч бий. Хэрэв бодис гэрлийг ойлгож, шингээх юм уу хугарах чанар байдаггүй бол тэр бодис аяндаа үзэгдэж чадахгүй. Жишээ нь: БИтүү улаан хайрцаг, гэрлийн бусад бүх өнгий нь биедээ шингээчихээд харин үлдэх улаан өнгий нь таны өөдөөс ойлгодог юм. Гэтэл гэрлийг тэгж шингээдэггүй, цөмийг цацраадаг байсан бол мөнгө шиг цав цагаан хайрцаг байхсан. Очир алмаазан хайрцгийн гадаргуугаас төдий л их гэрэлэйж мөнөөрт нь шингээхгүй байхсан. Зөвхөн энд тэнд гэрэл сайн ойхоор өнцөг тал гаргасны ачаар гэрэл ойж, гялалзсан гялталзсан өнгө гарна. Шилэн хайрцаг, гэрлийг багавтар шингээж цацраах учраас очир алмасан хайрцаг шиг тийм их гялтганан гялалзахгүй.Тийм биз дээ? Зарим талаасаа харахад юм нэвт харагдана, зарим шил бүр их тод байдаг, жишээ нь болор шилээр хийсэн хайрцаг жирийн цонхны шилнээс илүү байх ёстой. Жирийн цонхны тун нимгэн шилээр хийсэн

хайрцаг бүдэг гэрэлд бараг харагдахгүй. Яагаад гэвэл тийм шил гэрлийг шингээх, ойлгох, хугалахдаа муу байдаг юм. Хэрэв цагаан өнгийн хавтгай шилийг усанд юм уу уснаас өтгөн шингэн бодис дотор дүрвэл тэр шил чинь бараг үзэгдэхээ болино доо, яагаад тэр вэ гэвэл: Гэрэл, усаар дамжин шилэнд тусахдаа тун ч шалихгүй ойж хугардаг юм. Тэгэхлээр тэр чинь шатах хий буюу устөрөгч хий агаарт байхдаа харагдаггүй шиг үзэгдэхгүй болно. Учир шалтгаан нь мөн адил шив дээ.

-Тийм ээ, тийм! Энэ чинь одоо сургуулийн хүүхэд болгон мэдэх тун амархан зүйл байна гэж Кемп хэлэв.

-Сургуулийн хүүхэд болгон мэдэх бас нэг зүйл бий. Хэрэв хавтгай шилийг хагалаад жижиглэж орхивол агаарт байхдаа тэр чинь түрүүчийнхээ бүтэн байдлаас илүү тод харагдана. Яваа яваандаа цайвар нунтаг болно. Яагаад ийм болох вэ гэвэл гэрэл шингээх, ойлгох хугалах, тал нь олон болно шүү дээ. Бүтэн хавтгай хоёр талтай байдаг. Гэтэл нунтаглачихаар гэрэл орохдоо тэр жижиг хэсэг бүрд хугарч ойно, тэгэхлээр нунтаг дотуур гарах гэрэл тун бага болдог. Гэтэл тэр нунтагласан шилээ усанд хийчихвэл тэр чинь ер үзэгдэхгүй болчихно. Нунтагласан шил ус хоёрын гэрэл хугалах чадал нь бараг адил байдаг, тэгээд ч гэрэл тэр хоёрын нэгээс нөгөөд шилжихдээ хугарах, цацрах нь маш бага болдог юм.

“Шилийг өөртөө нь адил, гэрэл хугалах чадалтай шингэн бодис дотор хийхээр үзэгдэхгүй болж байна. Цайвардуу юмыг бас гэрэл өөртэй нь адил хугалах юман дотор хийвэл мөн үзэгдэхгүй болно. Хэрэв нунтаг шилний гэрэл хугалах чадлыг агаарын гэрэл хугалах чадалтай адил болговол нунтаг шил маань агаарт байхдаа ч үзэгдэхгүй болохыг та бодоод үз л дээ. Тэр хоёрын гэрэл хугалах чадал болчихвол гэрэл, шилнээс агаар хийд шилжихэд түүнийг хугалах цацрах юм ер байхгүй байх болно

-Тийм ээ, тийм, гэсэн ч хүн гэдэг чинь шилэн нунтагтай адилгүй шүү дээ гэж Кемп өчив.

-Яалаа гэж! Хүн гэдэг чинь улам ч илүү тунгалаг байгаа юм! гэж Гриффин хариу болгоход, Кемп –Шал худал! гэв.

-Доктор хүн л ингэж байгаа болохоор яая гэх вэ дээ! Хүн гэдэг чинь мөн мартамтгай амьтан аа! Та чинь арван жил болоход сургуульд үзсэн физикээ мартчихлаа гэж үү, даанч? Тэвэл тэр тунгалаг мөртлөө тийм санагддаггүй бусад бодисыг бодоод үз. Жишээ нь: Цаас бас л тунгалаг ширхэгтээс бүтсэн мөртлөө нунтаг шил шиг бас цайвар тунгалаг биш харагддаг. Та цаасыг сайн гэгчийн тослоод орхи, тэгээд харвал тэр цаас нэвт юм харагдахуйц тунгалаг болно доо. Цаасаар барахгүй хөвөн шандас, зотон шандас, ноосон шандас, модны шандас, яс мас Кемп ээ! чи сонс! үс, Кемп ээ хумс, мэдрэлийн судас, Кемп ээ! Ер нь хүний цусны улаан бөөм, үсний хар өнгө хоёроос л бусад бүх махбодь чинь дандаа тунгалаг, өнгөгүй чанарын эсээс бүрдсэн байлаг юм. Биднийг бие биедээ харагддаг болгодог юм маань, ингэхээр тун яльгүй юм байгаа юм шүү! Хүний махбодийн бусад эс, уснаас дэмий их дутахгүй тунгалаг зүйл байгаа юм.

-Уухай, уухай зөв! гэж Кемп дуу алдаад би урьд шөнөхөн далай дахь авгалдай, замгийн тухай ингэж бодож байсан юм! гэлээ.

-Та одоо миний ярьж байгаа юмны учрыг олжээ Би энэ бүгдийг аль дээр үед Лондонгоос явсан хойтон жил нээж олоод бүхэл зургаан жил дотроо хадгалж явсан хүн шүү. Энүүнийгээ боловсруулахаар ажиллахад ажлын нөхцөл байдал маань даанч бэрх байлаа. Миний шинжилгээний удирдагч багш Хоббема гэж чадвараар базаахгүй хүн, бусдын сэдэж олсон бодол санааны хулгайч байсан болохоор дандаа л шиншилж шалгаагаад болдоггүй байлаа. Энэ шинжлэх ухааны ертөнц гэдэгт чинь өөдгүй хулгай луйвар дэлгэрснийг алийг тэр гэх вэ, та юу андах билээ. Тэрүүнтэй хуваалцахыг бодоогүй тул сэтгэж олсон бодлоо нийтэд зарлаагүй юм. Тэгээд ажиллаад л байв. Зохиосон томъёогоо туршлагаар шалгаж өөрийнхөө сэтгэж олсон бодлоо жинхэнэ үнэн зүйл болгоход дөхсөөр байлаа. Өөрийнхөө хийж байгаа юмыг ертөнцөд гэнэт гаргаж ирж хамаг олонд гайхуулаад өөрөө нэгмөсөн алдар цуутай болох гэж бодсон болохоор урьд нь би хүнд ер хэлээгүй юм. Өнгө зүсийн зүйлийг өөрчлөх асуудлаар оролдоод байтал ер санаандгүй явсаар физиологийн нээлт хийчихсэн юм.

-Тийм үү?

-Цусыг улаан болгож байгаа бодисыг байна аа, чанары нь огт хувиргалгүйгээр өнгөгүй цагаан болгож болох юм, хөөш

Кемп үл итгэсэн янзтай гайхав.

Үл үзэгдэгч хүн босоод тэр жижигхэн өрөөн дотуур хөлхөв."Таны гайхах аргагүй.Би тэр нэгэн шөнийг одоо санаж байна. Шөнө оройсон, өдөр нь ажиллая гэхээр сурагчид харчих гээд болохгүй байхаар нь шөнө үүр цайтал суудаг байсан. Тэгтэл нэг боловсорсон сайхан санаа толгойд гэнэт орж ирлээ. Чимээ аниргүй лабораторитоо гав ганцаар байсан юм. хурц гэрэл гийж нам гүм аятайхан байлаа. "Амьд эсийг үзэгдэхгүй тунгалаг болгож болох нь байна! Амьтныг үзэгдэхгүй болгож болох нь байна! Амьд махбодод өнгө оруулагч бодисоос бусдыг нь үзэгдэхгүй болгож болох нь ээ! Би өөрөө үзэгдэхгүй болж болох нь байнаа, таминь" гэж ганцаар дуугарчихаж билээ. Шүүж тунгааж байсан ажлаа орхичихоод цонхоор гадагш од мичдийг харж байсан юм. "Би үзэгдэхгүй болж болох нь ээ" гэж дахин давтан хэлж билээ.

Нээрэн ингэж чадвал би хамаг ид шидтэнгээс давчих байлаа. Болно гэдэгт хумсын төдий ч эргэлзэхээ болилоо, үзэгдэхгүй болбол ямар их хүч чадал, нууцтай, эрх чөлөөтэй болох вэ! гэсэн санаа орж ирсэн билээ. Муу юм ер бодогдоогүй. Бодоод үз! Над шиг ийм бараг гуйлгачин, жирийн нэг муу лаборант хүн хөдөө очиж мангуу юмнуудад ном зааж байгаад гэнэт ийм болчихно гэдэг чинь хачин хэрэг шүү! Кемп, би чамаас асууя л даа. Энэ зүйлийг мэдсэн хүн болгон ийм шинжилгээ хийхийг завдах бизээ. Би гурван жил ажиллаж хэлж барашгүй их бэрхшээл даван давсаар оройд нь ойртох бүр шинэ шинэ саад тотгор харагддаг байлаа. Тоолбол тоолж баршгүй цөхөрмөөр л байлаа. Нөгөө хөдөөний профессор маань дандаа тагнаад болдоггүй "Хийж байгаа юмныхаа талаар хэзээ хэвлэлд нийтлэх гэж байна?" гэж асууж шалгаагаад зүгээр суулгахгүй байсан юм. Сурагчдыг хэлээд ч хэрэг алга, тэднээс нуух гэж бүхэл гурван жил зовсныг миньяана! Тэгж гурван жил ажиллаад цааш нь тийм янзтай байхын аргагүй болсон юм, үнэхээр яах ч аргагүй болсон юм, үнэхээр яах ч аргагүй болсон юм.

-Яагаад? гэж Кемп асуухад Үл үзэгдэгч хүн:

-Мөнгө хүрэлцэхгүй болсон гэж хэлээд дахин цонхоор гадагш харж байснаа гэнэт огцомхон эргээд:

-Муу өвгөнөө цөлмөсөн, төрсөн эцгийнхээ мөнгийг цөлмөсөн юм. Мөнгө нь өөрийнх нь биш байсан болохоор эцэг маань амиа хорлож үхсэн юм гэлээ.

ГРЕТ-ПОРТЛЕНД-СТРИТ НЭГ БАЙШИНД

Кемп, цонхны дэргэд цааш харан зогсож буй толгойгүй хүнийг түр зуур харж байснаа гэнэт нэг юм бодож үл үзэгдэгч хүнийхээ гараас барьж нааш харуулан:

-Та ядарчээ. Намайг сууж байхад та зогсоод байх юм. Миний сандал дээр суу гээд өөрөө цонх Гриффин хоёрын завсар зогсов.

Гриффин хэсэг зуур дуугүй сууж байснаа гшэнэт:

-Тийм болмогц би Чезлстоуны дээд сургуулийг орхисон юм. Ноднингийн арван хоёрдугаар сард сан. Тэгээд Лондоны Грет-Портлед Стритийн ойролцоо муусайн сууцтай нэг хорооны дэвсгэр дэх нэг том өрөө хөлсөлж суулаа, тэр өрөөнд төхөөрөмж гэх юмгүй байсан юм. Дэмий удсангүй би элдвийн аппарат бгаж хэрэгсэл худалдан авч өрөөгөө дүүргээд орхив. Ажил маань овоо бүтэлтэй болж дуусах шахам байлаа. Гэтэл гэнэт муу юм дуулдаж, би гэдэг чинь гүн ойн дундаас гараад гэнэт гаслант учралд тохиолдсон хүн шиг боллоо. Тэгээд эцгийгээ оршуулах гэж явв. Хийж байсан шижилгээндээ улайрч, хамаг ухаан бодлоо зарсаар байж, үнэн шударга явсан эцгийнхээ нэрийг хамгаалах гэж ёстой л ганц хуруу хөдөлгөөгүй амьтан даа. Эцгийн минь шарилыг нэг муу тэргэн дээр ачиж жаварт салхинд ил нэг толгойн энгэрт оршуулах ёс лорхуу юм хийв. Нутаглуулахад урьд сургуульд хамт сурч байсан бөгтөр, хар хувцас өмссөн архаг ханиад өвчтэй турьгүй нэг муу өвгөн хойтохий нь уншиж байсан юм.

-“Одоо хам хум барьсан хямд муу байшин барилгатай хоторхуу болоод байгаа, урьд тосгон байсан тэр газар оршуулгаас буцаж эл хуль болсон байшинд нь эргэж ирснээ санаж байна. Гудамж бүрийн төгсгөлд хог ургамал, шарилж ургасан эзгүй газар байж билээ. Би гэж нэг муу хар өнгийн хувцастай, бие гэж эцэнхий туранхай юм. Чийг бороонд норж хальтрамтгай гялайж цайсан зам аар гэлдэрч явахдаа тэр газрын хүний өнгө зүтлэгтэй гэмгүй царайлах боловч үнэн чанар панз луйврын байдалтайг бодохоос дотор баахан зэвүү оргиж байсан билээ.

Эцгийгээ нэг их өрөвдөөд байсангүй. Эцэг саань тэнэг нялуун суртахууныхаа уршгаар баларсан юм шиг санагддаг байсан юм. Заншлыг дагаж л би нутаглуулахад нь оролцсон болохоос биш үнэндээ наад нэг их сүйд болсон юмгүй.

Харин Хай-Стрит гудамжаар явж өнгөрөхдөө урьдын маань амьдарч явсан түүх ив ил харагдах шиг болсон. Арваад жилийн өмө танил явсан нэг хүүхэнтэйгээ тааралдаж, хоёр биенийхээ барааг хараад л өнгөрөх гэтэл нэг л уулзмаар санагдан зогсоод, би үг өдсөн юм. Тэр хүүхэн ч яахав нэг л энгийн амьтан байлаа.

Ер нь хуучин нутгаараа очиход зүүд зрэглээ шиг санагдаад болохгүй байдаг шүү. Тэр үед би өөрийгөө гав ганцаар болсон хүн, энэ ертөнцөөс гарч, хоосонд орсон хүн гэж бодоогүй явсан. Тэгэхдээ ер нь л хүний нинжин сэтгэлгүй болж байна гэдгээ мэдэх болж байсан боловч энэ чинь ямар ганц миний гэм биш, нийтдээ л лтийм амьдралтай байгаа хойно гэхихээд л явдаг байла. Аарийнхөө өрөөнд орж ирсэн хойно л би ёстой жинхэнэ үнэн байдалдаа буцаж ирсэн юм шиг санагдсан юм. Миний мэддэг, чаддаг, хайртай друтай эд юмс маань тэнд байдаг байлаа. Туршлагаар шалгахад хамаг юм бэлэн болчихоод аппарат хэрэгслүүд маань намайг хүлээж байлаа. Хамаг бүх бэрхшээлийг нэгэнт даван туулчихаад бага сагаг ялихгүй хэдэн жижиг юм бодох ёстой байлаа.

Кемп минь, би чамд тэр тарийн процессыг хэзэд нэг бүр тодорхой ярьж өгүүж. Одоо нарийн нандин зүйл ярилцах хэрэг алга. Түрүүнд миний яриад байсан өнөөх тэнүүлчний хулгайдаад авчихсан тэр гуван дэвтрийн дотор бараг гол чухал зүйлийг нууцлан биччихсэн байгаа, харин зарим нэг зүйлийг бичээгүй, тархиндаа хадгалж яваа даа, тэр тэнүүлчинг барьж авах хэрэгэтэй! Хамгийн чухал нь ийм байгаа юм. Гэрэл хугалах итгэлцүүрий нь багасгавал зохих тунгалаг биет нэг бодисыг авч эфирт оцгой хэлбэлзэл гаргах илч цацралт хоёр төвийн завсар хийсэн юм. Ээ талаар сүүлд би тодорхой яриулж! Гэхдээ тэр лав рентгений илч биш, чухам хүн, урьд өмнө нээж бичсэн эсэхийг мэдэхгүй, байх нь байгаа өөр нэг илч юм. Түүнийг гаргаж авахдаа би хямдхан, хий хөдөлгүүрээр ажилладаг хоёр жаахан динамо аппарат хэрэглэсэн... эхлэд цагаан ноосон даавууны өөдсөөр туршлага хийлээ. Өрвөлзсөн дөлийн дунд тэр зөөлөн цагаан эд байж байгаад тамхины утаа шиг замхран алга болохыг ажилахад мөн их сонин харагдсан.

Тийм юм хийчихлээ гэж өөртөө ч итгэхэд бэрх байсан юм. Тэгээд гараа сунган тэмтэрвэл даавууны өөдөс маань урьдынхаа янзаар яг хэвээр гарт баригдав. Авахдаа эвгүй бариад газар алдчихсан чинь дараа нь яггүй их эрэл болж байж олдог хэрэг шүү.

Дараа нь ихээхэн сонин туршлага хийж үзлэ. Миний ард мяу-мяу гэх чимээ гарч туранхай цагаан, халтар хултар болсон нэг муур байгшингийн цонхны цаана байгаа харагдав. Нэг шинэ юм бодогдож “Эрхэм минь цөм бэлэн байна!” гэж би хэлээд цонхныхоо дэргэд очиж нээгээд муураа эрхлүүлэн дуудлаа. Муур орж ирээд, хэржигнэн орилж, яах аргагүй өлсгөлөн байхаар нь сүү өгөв. Миний хүнс бүгдээрээ өрөөний булангийн нэг шүүгээнд байдаг байсан. Муур, сүүг идчихээд юм хум шиншлэн өрөөн дотуур явж, энд лав идээших янзтай харагдлаа. Өнөөх үзэгдэхгүй болсон даавууны өөдөс мөр дээр нь тааралдахад хичнээн сүрний гудачсан гэж санана! Тэгээд тэр муураа эвхмэл орныхоо дэрэн дээр аятайхан тавиад цэвэршиг гэж бодоод шар тос өгөв.

-Та тэр мууранд туршлага хийв үү?

-Хийсээн. Мууранд эмнэ өгнө гэдэг чинь хэр баргийн амар хэрэг биш шүү, Кемп минь! Тэгээд ч туршлага маань олигтой болоогүй.

-Олигтой болсонгүй?

-Хоёр зүйл болоогүй: хумс нөсөө хоёр нь шүү. Яахав нөгөө муурын нүдний хойно байдаг. Та мэднэ байхаа?

-Тапетум уу?

-Тийм тийм тапетум. Тэр нь болоогүй. Мууранд цусы нь өнгөгүй болгох бас өөрөө төөр бага сага юм өгсний дараа хар тамхи өгч унтуулаад хэвтэж байсан дэртэй нь хамт аппарат дээрээ аваачиж тавиад ажиллалат муурын бүх бие бүрэлзэн үзэгдэхгүй болоход харин хоёр жижигхэн гялалзсан нүд л харагдаад байв.

-Хачин юм даа.

-Яагаад тийм болчих нь тэр вэ, би учры нь хэлж мэдэхгүй юм. Муураа хүлж баглаад ажилласан л даа. Харин бүр үзэгдэхгүй болохоосоо арай өмнө өнөөх чинь сэрээд мяу гэж дуугараад, тэгтэл ч үүдийг маань нэг хүн тогших дуулдав. Байнга архидаж байдаг нэг ааш муутай чавганц манай доод давхарт суудаг байсан юм. Тэр чавганц намайг амьд амьтанд туршлага хийх нь гэж харддаг байлаа. Тэр муур бол цавганцын энэ ертөнц дээр байгааг хайртай хань нөхөр байсан юм. Би муур руугаа нэг хэсэг хлорформ цацчихаад үүд рүү очив. Нөгөө чавганц:

-Танайд миний муурын дуу гарах шиг болов уу даа? Миний муур байна уу? гэж асуухад, би их л эелдгээр:

-Манайд танай муур байхгүй байна даа гэв.

-Тэр чавганц надад төдий л итгэхгүй, өрөө рүү маань шагайх гэв. Миний өрөөний хана туурга хов хоосон, цонхонд хөшиг байхгүй, эвхмэл ортой, хийн хүчээр хөдлөх оньсон мотор ажиллаж, жижиг жижиг оч бутарч байхыг хараад лав гайхсан байх. Бас хлорформын үнэр ханхалж байсныг яахав. Тэгээд чавганц маань сэтгэлдээ сэвгүй болоод гарах шиг болсон.

-Тэр туршлага хийхд хэр зэрэг удав даа гэж Кемп асуув.

-Мууранд гурав дөрвөн цаг орсон, яс, шөрвөс, бас бараан өнгөтэй үс нь хамгийн сүүлд үзэгдэхгүй болов. Түрүүнд хэлсэн өнөөх нүднийх нь цаад талын солонго шиг өнгөтэй хэсэг нь ер алга болохгүй хэвээр үлдсэн.

Ажил маань дуусаж сайн амжаагүй байтал шөнө боллоо. Муурын нүд хумс л сүүмэлзэн үзэгдэж байсан. Мотороо зогсоогоод муурыг илбж үзэхэд муур бас л ухаангүй байлаа, тэгээд хүлээсний нь тайлаад үл үзэгдэх дэрэн дээр нь орхиод би орондоо хэвтэв. Хойр хүрч өгөхгүй лдвийн юм бодогдоод болдоггүй дэмий л хэвтэж, хийсэн туршлагаа байн байн тунгаан бодлоо. Юм бодогдоод байснаа нүдэнд юм үзэгдээд болдоггүй. Хажуу дэргэдийн юм болгон манан будан шиг замхран алга болоод дор байгаа шал маань хүртэл үгүй болж юу юугүй л ойчиж унамаар тун ч муухай хар дарах шиг болоод байсан чинь, хоёр цагийн алдад өнөө муур өрөөн дотуур хөлхөн мяу мяу гэж дуугарав. Анх нь тэрүүнийг дуугүй болгох гэж элдвээр аргадаж оролдсон боловч сүүлдээ хөөж гаргахаар шийдэд чүдэнз зураад хартал хоёр ногоон нүднээс өр юм юу ч үзэгдэхгүй байхыг хараад хичнээн гайхсан гэж бодно. Сүү байсансан бол өгчихмөөр л байлаа, даан ч байсангүй. Муур маань ер дуугүй болж өгөхгүй болохоор барьж аваад цонхоор гаргаж хаях гээд хөөцөлдсөн чинь ер баригдахгүй алга болчихоод болдоггүй, нэг мэдэхэд л өрөөний өөр нэг буланд дуугараад байлаа. Тэгэхээр нь цонхоо нэгээд их дуу чимээ гаргасан чинь лав

өнөөх муур гараад явчихсан байх, үзэгдэх ч үгүй, дуугаргах чимээ гарах ч үгүй боллоо.

Ингэчихээд хэвттэл бүү мэд яагаад ч тэр юм, эцгийгээ тэр нэг хоосон уйтгарт ухаагийн энгэрт оршуулсан маань санагдаад болохгүй байтал үүр цайлаа. Одоо унтахаасаа өнгөрлөө гэж бодоод босож, өрөөгөө цоожлоод гудамжаар алхахаар явлаа.

-Одоо тэгээд энэ дэлхий дээр үл үзэгдэх тийм нэг муур эрх дураараа явж байгаа гэж үү!

-Алагдчихаагүй бол явж байгаа байлгүй, яахав, яалаа гэж явж байхгүй байх билээ?

-Яагаад? гэж Кемп асууснаа таслах гээгүй юмсан гэв.

Лав алагдсан байх. өрөв хоногийн дараа Грет-Тичфилд Стритийн тэнд нэг байшингийн цонхон дээр өнөөх чинь суучихаад мяу мяу дуугарч байсныг олон хүн сонсоод чухам хаана дуугарч байгаагий нь олж харах санаатай оролдож байсан даг гэж үл үзэгдэгч хүн яриад нэг хэсэг дуугүй болсноо дахин өндөр дуугаар

-Надад ингэж их сонин юм тохиолдохын өмнөх өглөө ив илхэн санагдаж байна.

Би Грет-Портленд Стритээр явж байсан байхаа. Олбэни гудамжинд цэргийн хуаран байдгийг мэднэ, тэндэс морин цэрэг гарч байгаа харагдсан санагдана. Дараа нь би нимбэг цэцэгт ухаагийн орой дээр гарч наранд ээн суухад бие минь маш зовуурьтай, нэг л хачин байлаа. Цас орж, жавар унахын урьд гардаг хэдэн сайхан нарлаг өдрийн нэг, нэгдүгээр сарын их сайхан өдөр байсан юм. Бие минь ядравч юм хумний учир зүйг бодсоор бас хойшид юу хийхээ тогтох санаатай оролдож байлаа.

-“Бүтээсэн юмныхаа үр ашгийг амсая гэд ганц гар сунгахад л болох болоод байсан мөртөө нэг л их баярлахгүй байгаадаа гайхаж байлаа. Үнэндээ бии бүхэл дөрвөн жилийн турш толгой өндийлгүй ажиллаж их ч ядарсан болохоор сэтгэл санаа мөхсөн байгаа биз. Нэг л улбагар унжгар амьтан болчихоод, тэгээд анх нээлтийн төлөө буурал эцгээ ч өрөвдөхгүй шунаглан айсан шигээ урам зориг орохсон гэж ядаад цөхөв. Яахаас ч буцамгүй байлаа, гэхдээ энэ бол зуурдын юм гэдгийг би ойлгож байсан. Сайн амраад эм зэм уувал хуучин хэвдээ орох ёстой. Эхэлбэл уусгах хэрэгтэй гэдгээ би сайн мэдэж, санасан санаандаа захирагдсан хэвээр байсан. Гэтэл мөнгө мань дуусчих гээд байдаг. Явж байсан газраа эргэн тойрон харвал ухаагийн хажууд олон хүүхэд багачууд бужигналдаж, хөвүүд нь наргихад охид нь тэдгийгээ ажиглан байв. Тгээд миний дотор хэрэв хүн үзэгдэхгүй болчихвол ертөнцөд бусдаа айхтар их давуу талтай болох бол уу гэж бодогдсон юм. Тэнд жаал байзнаад гэр өөдөө гэлдэрчэ хариад жаахан юм идэж уугаад стрихнин нэлээд их залгачихаад бүхлээрээ орон дээрээ гарч унтав... Стрихнин гэдэг чинь, Кемп минь бие сулдайгаад байхад сэргээд чадалтай сайхан эд шүү!

-Шулмас шиг эд байхгүй юм! Шилэнд байгаа аймшигт мангас гэсэн үг гэж Кемп хэллээ.

-Сэрсэн чинь тэнхэ тамир ч орчихсон, харин баахан эгдүүцээд байлаа. Мөн үү?

-Мөн мөн тэр чинь тэгж нөлөөлдөг эд.

-Нэг хүн үүд тогших орж ирсэн маань миний байрын эзэн польш нутгийн еврей өвгөн байв. Унжгар урт хар пальто, ул болсон муу шаахай өмсчээ. Баахан юм асууж, занаж сүрдүүлэхээр орж иржээ. Урьд шөнө намайг муур тарчлаасан гэж өвгөн дуулжээ. Чавганцын ам яаж хуурай байх билээ. Байрны эзэн их л олон юмны учир олох гэж орж ирсэн бололтой. Амьд амьтнаар туршлага хийхийг хориглосон хууль их хатуу. Тэгсэн хүнийг гэмт хэрэгт татаж болно гшэлээ. Би муурын талаар юу ч хүлээсэнгүй. Тэр хүн миний хий хөдөлгүүрт аппаратын дуу чимээ байшин доргиулаад байна гэлээ. Энэ ч аргагүй үнэн байсан. Миний хажуугаар бултганан нүднийхээ герман шилэн дээгүүр ийш тийш харж ажиглахад, би зарим нууцы минь мэдэж орхиузай гэж гэнэт бодоод гэрэл туяаг хуримтлан хураахаар зэхсэн аппаратаа биеэр халхлан зогссон чинь тэр хүн улм ч сонирхож, намайг: Ямар юм хийж байгаа юм? Дандаа юунд ганцаар, хүнээс нууцгай байна? Тийм нууц юм байгаа юм уу? Аюултай зүйл үү? Гэж асуулаа. Тэднийх надаас байрны хөлс л авдаг байсан юм.н Тэднийх тэр хавийнхаа олиггүй хөршүүдийнхээ дотор нэлээд хүндтэй айл байжээ. Гэтэл миний уур гэнэт хүрч түүнийг гар гэсэн чинь нөгөөдөх маань тэр дорхиноо гараад явав. Үүдээ хааж түгжээд суухад хамаг бие минь чичирч байлаа. Тэр хүн гадаа нэг хэсэг хашгичсан боловч би тэрний нь анзаараа ч үгүй, тэр ч тэгсгээд цаашаа явсан. Ер нь ийм явдал болсноос болоод нэг тийш болж туйврах цаг ирсэн юм. Тэр хүүг яам, ер нь яах эрхтэйгий нь би мэдээгүй байв. Шинэ байранд орох дээр хүрвэл ажилд маань саад болно. Тэрнээс гадна надад байгаа мөнгшө маань дөнгөж хорин таван фунт стерлинг байдаг, тэрний маань ихэнх нь банкинд хадгаламжтай байсан, хамаагүй үрж тарж болох юм. Нуугддаг юм бил үү? Гэтэл болохын арга байв. Алга болчих уу? Тэгвэл намайг эрж сураглаад өрөөгий маань нэгжих байлаа. Хийж байгаа ажил маань сайхан дуусахын даваан дээр хүн амьтанд мэдэгдвэл яана гэж бодохтой зэрэг шар хөөрч, хүч амтагдад явчихлаа. Тэгэд мөнгөний баримт, өнөөх тэнүүлчийн аваад явчсан гурван дэвтрээ авч гараад тэдгээрийг ойрын нэг шуудан салбар дээрээс Грет-Портленд-Стрит рүү хаяглан явуулав. Тэндээс гарахдаа дуу чимээ гаргахгүйг хичжэ билээ. Буцаал ирэхэд нөгөө эзэн шатаар их л тайван өгсөн яюа харагдана. Намайг хаалгаа цоожилж байхыг сонссон бололтой. Шатны тавцан дээр гараад дэргэдүүр нь өнгөрөхөд тэрний цочиж хажуу тийш үхэт хийснийг харахад хичнээн инээд хүрмээр байсан гэж бодно. Намайг ширэв татан харахад би өрөөндөө бушуухан орж хаалгы нь хамхартал, хамаг байшинг нь доргитол чанга хаасан юм. Байрны эзэн миний үүдэн дээр сэмэрхэн хүрч ирэн чагнаад шатаар уруудах чимээ дуулдав. Бт бэлтгэл ажлаа хий эхлэв.

Тэр үдээс эхлэн шөнө туш ажиллаад дуусгасан юм. Цусны өнгийг алга болгох эмийн зүйлийн үнэр танарт толгой түрүү мансуурсхийн сууж байхад хаалгы маань хүн хэд хэд дахин тогших чимээ гарч байлаа. Хүмүүс байн байн хүрч ирээд л үүд тогиж байгаад явчдаг, дахиад л ирж тогшдог байв. Хаалганы завсар заалхайгаар нэг юм цэнхэр өнгөтэй цаас шургуулах гээд оролдоод байхаар нь уур бүр хүрч тэсэлгүй босож үүдээ цэлийтэл нээж:

-Яах гээд байна вэ? гэж асуувал байрны эзэн маань намайг байрнаасаа хөөх хуудас юм уу даа барьчихсан гараа над руу сунгаад миний гарыг үзээд их л гайхсан бололтой нүүр рүү агшин зуур харж гайхан зогссоноо ер бишийн муухай дуу алдаж,

барьж байсан лаа, зурвас хуудсаа газар алдад харанхуй гудмаар бүдчин хадчисаар шат руу гүйв. Тэгэхлээд нь би үүдээ хааж түгжчихээд толинд очиж харвал тэр хүний айж бачимдсан нь аргагүй байсны учрыг олсон... Миний царай гэдэг чинь өөхөн чулуу шиг цав цагаан болчихсон байлаа.

Аяа! намайг яаж их тарчилсан гэж бодно! Тэгж өвдөж шаналах юм гэж ер бодсонгүй. Тэр оройн туж стгэл нэг их гунигтай болж бөөлжис цутгад, тэнхээ тамир алдраад байлаа. Хамаг бие арьс минь галд шатах шиг болж амь тэмцэж байв. Шүдээ зуураад л хэвтэж байлаа. Өнөөх муур хлорформ түрхэхийн урьд чарлаад байсан учрыг тэгж мэдсэн юм. Аз болоход адад шивэгчин байгаагүй, би ганцаараа суудаг байсан юм. Байн байн сагнаа алдаж, ёолж, ганцаар үглэж байлаа. Гэсэн ч би тэсээд л байснаа...ухаан алдаж харанхуй шөнөөр сэрсэн чинь тамир тэнхээ бүр барагдан харин өвдөх өвчингүй байв. Би ч өөрийгөө алах юм хийгээ шив дээ гэж бодовч за яасан ч яадаг юм гэж би бодлоо. Тэр өглөөний үүр цайхыг би ер мартаггүй. Гараа харсан чинь шил шиг тунгалаг, цийлэгнэсэн юм болчихож, айсан гэдэг жигтэйхэн. Гар минь тэр өдөртөө улам тунгалаг, улам нарийхан болсоор байлаа. Сүүл сүүлдээ тунгалаг болсон зовхио анихад хүртэл өрөөний юм эмх замбараагүй байгаа нь гар нэвт харагдаад, мөч минь шил шиг болж, яс судас маань цайвар болсоор үзэгдэхээ болж, хамгийн сүүлд мэдрэлийн жижиг судас алга боллоо. Шүдээ зуусаар байж дуустал тэслээ. Хумсны үзүүр цайж цийлийж үлдэд, бас хуруун дээр туссан хүчлийн хүрэн бараан ор мөр л үзэгдэж байлаа. Хүчлэн босоод явах гэсэн чинь яг л өлгийтэй хүүхэд шиг хөдлөхөд их эвгүй, үзэгдэхгүй хөлтэй явах хэцүү байлаа. Бие тэнхээ тамиргүй, гэдэс хоосон өлсөж байлаа. Сахлаа хусдаг толиныхоо өмнө очиж харвал хүдний торлог хальсны цаад талын бараг үзэгдэхгүй болсон бүдэг өнгөнөөс өөр юу ч үзэгдэхгүй болчихсон байлаа. Ширээнд биеэ, толинд духаа хүргэж үзсэнээ ихээхэн зориг гарган эргэж аппарат руугаа ирээд уг процессыг дуусгах болсон юм. Тэр өглөө нүдээ гэрлээс халхлах гэж орныхоо бүтээлгээр таглаад үд хүртэл унтаж байтал үүд цохих чимээнээр сая сэрвэл хүч тамир орсон байлаа. Орон дээрээ өндий нсуугаад чагнавал хүн шивэгнэлдэж байв. Тэгэхлээр нь сэмээрхэн босож аль болох чимээ гаргалгүйгэр аппаратаа задалаж хэсэг хэсэг салган учры нь олдоххгүй болгов. Үүд дахин цохих чимээ гарч байрны эзэн бас өөр хоёр хүний дуу гарлаа. Би цаг хожих гэж бодоод хариу дуугарч тэмтрэхэд гарт маань үл үзэгдэх жинтүү хивс тааралдахаар нь цонхоо шонгойлгож байгаад гадагш гарган байшингийн дээвэр дээр шидчив. Намайг цонх нээж байх хоорондуур үүдийг маш чанга нүдээд бас нэг хүн цоож эвдэн орохыг завдсан боловч хэд хоногийн өмнө миний хийсэн цүү цуурга тийм ч амар эвдрэхгүй байсан тул тэр хүн эвдэж дийлсэнгүй. Тэгж намайг дайрч довтлохтой зэрэг би хорсож, хамаг бие чичрэн дагжиж юм хрүмээ яаруу сандруу бэлтгэв.

Хэрэггүй цаас, сүрэл боолтын цаас энэ тэрээ цуглуулж өрөөний тэг дуд овоолж тавьчихаад хийгээ асаахаар нээж байхад үүд жигтэйхэн чанга чанга цохиж байгаа дуулдав. Чүдэнзээ эрээд олдоггүй уур их хүрч, нударгаа зангидж байгаад хана руу шаснаа дахин хаж цонхоор гарч, сэмээрхэн хаав. Тэгээд хэнд ч үзэгдэхгүй, ямар ч аюулд орохгүйгээр байшингийн н дээвэр дээж сууж юу болохыг нь ажиглав. Харин уур хүрээд бие чичирч байсан. Тэ.д хаалга, цоож эвдэн орж ирэв. Байрны эзэн, бас хорин гурав, дөрөв орчин насны хоёр хүү, нөгөө доод давхарт суудаг муу ааштай чавганц тэр хэд байлаа.

Тэднийг тэр өрөөнд орж ирэхэд хүн байхгүй байхлаар тэдний гайхаш тасарчэ. Нөгөө хоёр залуугийн нэг нь цонх руу шууд очин нээгээд гадагшаа харав. Тэрний гөлөлзөн байгаа нүд, зузаан уруултай, сахал самбай болсон нүүр нь надаас ганц

алхмын зайтай байхад нь тэр мангуугийн нүүр лүү дэлсэд авмаар санагдавч тсэж биеэ барьсан юм.

Тэр мий биеийг нэвт хараад, бусад нь ч өөрцгүй мөн нэвт харцгааж байсан юм. Өвгөн эзэн цонхны тэндээс зайлж орон доогуур шагайж харсны хойно цөмөөрөө шүүгээ рүү уралдах шахам очиж үзээд хоорондоо еврейн этгээд хл, тал тул англи хл хольж хутган зөвлөлдөв. Тэд намайг дуугарлаа гэж бодсон боловчи ажиглахад алсын уул хаахалзана гэгчээр худлаа байж гэнэ. Өнөө чавганц тэр гуравтай хамт орж ирсэн тул дөрвүүлээ мий ууцыг мэдэх санаатай муур шиг ийш тийш ширтэхий нь хараад зэвүү хүрч байсан маань гэнэт болиод харин ч омог бардам сэтгэл төрс байсан юм.

Өвгөн эзэн чавганц хоёрын этгээд муухай холимог яриаг чагнахад тэр хоёр намайг амьд амьтнаар туршалаг хийдэг хүн гэж хоёул ам нийлж байгаа бололтой. Гэтэл хоёр хүү нь тэгж бодохгүй динамо мотор радиотор хоёр руу заагаад намайг цахилгааны мэргэжилтэй хүн гэнэ. Тэд орох хаалгаа хаачихаад орж ирсэн хэр нь намайг одоо л ороод ирэх байх гэж тэсэж ядан хүлээж байлаа. Өнөө чавганц, миний орон доогуур шагайж шүүгээгий минь нээж үзлээ. Миний сууж байсан өрөөний эсрэг нэг өрөөнд махны нэг худалдагчтай хамт суудаг миний хөрш доншуур худалдаачин шаты тавцан дээр гарч ирэх харагдмагц нөгөөдүүл түүнийг дуудаж, дотогш оруулаад учир тоймы нь олоход бэрх юмыг урьд хойно нь оруулан ярьцгаав. Миний хэрэглэж байсан тэр тусгшай гадиоторыг юмны учир ажилглаж олдог мэргэжлийн хүн үзвэл маш их зүйлийг тааварлаж магад гэж надад гэнэт санагдахтай зэрэг би, бололцоо харж байгаад цонхны ирмэг дээрэс дотогш буун орж өнөө чавганцыг түлхэн зайлуулаад давхарлаастай байсан хоёр динамо аппаратын нэгий нь шүүрэн аваад нөгөөгий нь цохиж хоёуланг ь эвдлэн, хэмх хамх цохив. Тэждний айж бачимдсаныг яана гэж санана!...

Тэднийг тийнхүү мангууран мэл гайхаж байх завсар би гараад шатаар сэмэрэхэн уруудаж зочных нь нэг өрөөнд ороод хүлээж байтал тэд марган булаацалдсаар бууж ирлээ. “Онцын аюултай муу юм” олоогүйдээ тэд баахан гогсор байв. Бас намайг тэгш дайрснаа хуулийн үүднээс зөв сэхэд эргэлзэж тийнхүү гонсгордуу байжээ.

Тэднийг доод давхар луу бууж ирмэц, би хайрцаг чүдэнз барьж дээш гараад өнөө овоолсон цаас маасаа асааж дээр нь сандал, орны даавуугаа хийж, өнөө хийгээ хаймран хоолойгоор тавих.

-Та тэр байшинд гал тавиа юу? гэж Кемп асуухад үл үзэгдэгч хүн:

-Тэгсээн, гал тавьсан! Тэгэхээс аргагүй байсан юм, өөрөөр яаж мөрөө баллах билээ? Байшингийн нь аюулаас хамгаалан даатгах газраас харж үзсэн байх л даа. Тэгээд би орох хаалгыг дашгүй тайван нээж гараад явсан юм. Би нэгэнт үзэгдэхгүй хү нболж үзэгдэхгүй болсон маань надад тун их ачтай болохыг мэдэж эхэлсэн юм. Ер биүшийн зоригтой санаа бордол төрс, түүнийгээ зоргоороо хийж болох санаа аанай төрсөн билээ.

ОКСФОРД ГУДАМЖНАА

Шатаар ураадахад хөл маань үзэгдэхгүй анх тун хэцүү санагдаж, хоёр ч удаа бүдэрсэн. Ер нь нэг л эвгүй санагдаад байсан боловч тэгш газраар доошоо харалгүй явахлаар дажгүй болсон юм.

Сэтгэл санааны хувьд их догь байсан. Ер нь хүн амьтан нь цөм таг сохор тийм хот дотуур зөөлөн ултай гутал, чимээ гардаггүй хувцас өмсчихсөн яваа юм шиг санагдаж байлаа. Хүн амьтны нуруу руу нь алгадаж, малгайгий нь авч хаян, айлгаж сандаргаад, өөрийнхөө ер бишийн давуу чанараар бусдыг даапаалан дамшиглаад баймаар хорхой хүрч байлаа.

Тэгээд Грет-Портленд-Стритээр дөнгөж ороод явж байтал /миний сууж байсан газрын дэргэд бөс барааны том дэлгүүр байсан юм/ нэг юм таржиг түржиг дуугараад араас минь цохиод авмагц эргээд харвал нэг хүн барьж явсан шилтэй ундаатай сагс руугаа ширтэж мэл гайхан зогсож байлаа. Миний бие өвдөж цочсон боловч тэр хүний гайхсан нь тун ч инээдтэй харагдах учир тэсэж чадсангүй чанга гэгч нь инээд алдав. “Сагсан дотор чөтгөр шүгэлж дээ, хө” гэж би хэлээд тэрний нь татахад тэр хүн ч цааргалсангүй, тэрний нь өргөж байтал нэг муу тэнэг тэрэгчин, пивоны газраас гарч ирээд гараа сарвайхад тэр нь миний чихэнд хүрч их өвтгөв. Би өнөөх сагстай юмыг нь тавьчихсан чинь улаачийн дээрээс хүчтэй гэгч нь унаж, ойр хавийн мухлаг, сүүх тэргэнд байсан хүмүүс гүйлдэг гарч бөөн хөл үймээн болоход л би дэмий юм хийснээ ухаарч биеэ зүхээд эвгүй байдлаас гарахыг бэлтгэн мухлагийн цонх налан зогслоо. Тэгэхгүй бол олны дотор гарах газаргүй болж хоригдоод мэдэгдчих байсан юм. Махны дэлгүүрийн худалдаачийн жаалыг түлхэж зайлуулаад /зэгсэн, тэр жаал нь эргэж харсангүй/ хөлсний дөрвөн дугуйт тэрэгний цаагуур оров. Тэнд цааш нь юу болсныг бүү мэд. Би тэр чигээрээ цаш явж тэр үед хүн амьтан нэлээн сийрэг байсан нэг замаар ороод л яаран сандран явлаа. Түрүүчийн болсон явдалд баахан зовж байж яам будлиад Оксфорд гудамжинд оройн цагаар зугаалж байгаа олны дунд мэдэгдэлгүй ороод явчив. Би тэр улсын дотор орох гэсэн чинь даанч бие багатахын аргагүй ширүүн байснаас гадна өсгийгий минь нэг хүн гишгвэ. Тэгэхээр нь явган хүний замаар явсан чинь хөлд хатуу ширүүн оргиод, өвтгөөд ер болдоггүй. Нэг морин тэрэг дэргэдүүр гарахдаа далны мөгөөрөс хавиар тун их хүчтэй шүргэж өвтгөв. Тэгэхлээр нь хажуу тийш зайлтал хүүхдийн түрдэг тэрэгтэй арай л мөргөлдчихсөнгүй, зайлж гараад өнөөх морин тэрэгний яг араар нь очлоо. Тэгтэл дотор шинэ бодол төрж тэр аяархан яваа морин тэрэгний хойноос дагаж явлаа. Би тийм болж, тамаа цайх болсноо бодохлоор гайхаш тасарч, хамаг бие минь чичрэн байв. Сэтгэл санаа дэнсэлснээс хамаг бие минь чичрэхээр барах уу, бие чармай нүцгэн бөгөөд нэг сарын тунгалаг сайхан өдөр гэвч гуамжны шавар шавхайн өнгө зарим газраа царцан хөлдөж байсан тул би даарч чичирч явсан юм. Одоо бодоход хичнээн тэнэг санагдавч би ер нэг зүйлээс бодсонгүй, юу гэвэл хүн гэгч үзэгдэхээр байсан, эс үзэгдэхээр байсан ч байгаль, байгалийн үзэгдлийн эрхшээл нөлөөнд байдгийг мартжээ. Тийнхүү явж байтал бас шинэ бодол дотор орж өнөөх тэрэгний хажуугаар гүйн очиж дотор нь орж суув. Тэгээд хамаг бие бас л чичирсээр, айдас ч хүрч, даарч хөрснийх гэмээр найтаалган эхэлж, нуруунд олсон шарх минь өвдөж байлаа. Миний сууж явсан тэр тэрэг Оксфорд гудамжаар явсаар Корт-ордыг өнгөрөв. Миний зан араншин эгшин зуур эрс өөр болоод байв. Үзэгдэхгүй болсон маань гай боллоо! Одоо явал ийм байдлаас гарч хуучин хэвдээ орох билээ гэж л бодох болсон юм.

Мьюдийн номын сангийн хажуугаар өнгөрөн явтал гартаа тав зургаан ном барьсан нэг өндөр авгай миний сууж байсан тэргийг дуудахад би ам мөлтөс буув. Тэгээд яарч сандарч байж трамвайн дор арай л орчихсонгүй. Тэндээс Блюмзберийн

талбай чиглэн Британы музейн хойгуур орж хүн цөөнтэй газар орохыг санагалзан их л жихүүцэн даарч, ийм айхтар хачин байдалтай болсондоо бухимдаж, гүйн гүйн явах зуураа гуньж гонсойн байлаа. Тэгтэл эм найруулах нийгэмлэгийн захиргааны баруун булангаас нэг жаахан нохой над руу шууд давхин ирж газар шиншлэн хойноос минь дагаад байлаа.

Урьд би нохойн хамар гэдэг чинь хүний нүднээс өөрцгүй гэгчийг ер бодсонгүй. Хүн харагдах юмыг андахгүй үзэж чаддагийн адил нохой бол хажуугараа өнгөрөх юмыг мөн андахгүй үнэрлэдэг ажээ. Тэр нохой бүр ч хуцаж эхлээд намайг тойрон гүйж бүр л олоод харсан юм шиг хоргов. Би эргэн эргэн харсаар Грит-Рассель-Стритийг хөндлөн гарч Мантагю гудамжаар орон нэлээд гүйж явснаа өмнөөс минь юу ирж байгааг сая ажсан юм.

Харсан чинь хөгжим дуугарч, Расселийн чөлөөгөөр, улаан өнгийн богино дээлтэй олон хүн гарч явна. Аврах армийн тугийг өмнөө намилзуулан барьжээ. Тугийн хойноос гудамж явган хүний зам хоёулангаар хүн пиг дүүрсэн харагдах тул надад сэм нэвтрэн гарах зай байсангүй. Буцаад явъя гэтэл айдас хүрээд бас ч нэг байшингаас холдохыг хүссэнгүй. Даруй зориг шийдэж музейн харалдаа тэр байшингийн цагаан довжоон дээр гарч жагссан олны явж өнгөрөхий нь хүлээлээ. Ашгүй өнөөх муу нохой хөгжмийн дуу сонссоноо сүүлээ хавчин зогсохийснээ Блюмсберийнхээ талбай руу буцан давхилаа.

Хөгжмийнхөн ч ойртлоо. "Царай юугий чинь хэзээ нэг үзэх бол" гэсэн дуу аялах нь намайг дамшиглах мэт. Тэднийг өнгөрөн өнгөртөл маш удах шиг санагдлаа. Хөгжмийн бөмбөр түн, түн дуугарч байлаа. Миний харалдаа хоёр хүүхэд зогсож байсныг би нэг хэсэг анзаарсангүй. "Хараач" хүүе" гэж хэлтэл нөгөө нь "Юу, хараач гэж?" гэж асуухад түрүүсийнх нь "Яахав хөлийн ором, нүцгэн хөлийн мөр байна. Шавартай хөл шиг байна" гэв.

Доошоо харсан чинь өнөө хоёр хүүхэд миний цайвар болсон хөлийн мөр, саяхан цэвэрлэсэн шохойдсон довжоон дээр гарсныг хараад зогсож байлаа. Жагсаал дагаж яваа олон хүн шахцалдан хоёр хүүхдийг хажуу тийш түлхсэн боловч тэр хоёр хүүхэд миний мөрийг сонирхоод ер салсангүй.

"Түн, түн, царай юугий чинь түн, хэзээ нэг түн. үзэх бол? Түн, Түн"

Хөл нүцгэн хүн довжоогоор дээш явсан шиг байх юм, ер мэдэх юм алгаа, явж өнгөрөөд буцаж яваагүй байна. Хөлөөс нь цус гарсан байна гэж нэг хүүхэд нь хэллээ.

Олон хүний ихэнх өнгөрлөө.

-Хараач Гедди! Гэж нэг бага шиг жигтэйхэн гайхсан янзтайгаар миний хөл рүү шууд заалаа. Би доошоо харвал хөл минь шавар болсон учир хөлийн мөр сүүмийн харагдах тул нуруугаар хүйт оргив.

-Үгүй ер! Мөн хачин юм аа! Чөтгөрийн мөр үү дээ! гэж ахмад нь хэсэг зуур эргэлзэн байснаа миний зүг гараа сунгав. Нэг хүн юу барих гэж байгааг нь сонирхон шууд хүрч ирэв. Бас нэг охин ирэв. Би тэр чигээрээ зогсоод байсан бол өнөөх жаал миний биед хүрэх байсан юм. Тэгэхлээр аргагүй цааш алхтал тэр жаал дуу алдан хашгирч гэдрэг боллоо. Би ч шаламгайлан хөдөлж, хөрш байшингийн довжоон дээр

очлоо. Тэгсэн чинь өнөөх жижигхэн жаалын адтай гэдэг нь аргагүй, миний явахыг ажиглаад довжооноос уруудан бууж явган хүний замд орж амжаагүй байтал гайхаж алмайрахаа болж тийшээ нэг хүний хөл даваад явчив гэж хашгирав.

Тэд хуйлран бөөгнөрөөд миний хөлийн шинэхэн мөр довжооны доод гишгүүр, явган хүний зам дээр гарсныг ажиглав.

-Юу вэ? гэж нэг хүн асууна.

-Хөл! Хараач! Хөл явж байна! Намайг мөрөөр минь хөөж байгаа гурван багачуудаас бусад нь Аврах армийнхан араас дагаж байсан болохоор тэд ганц миний мөр дээр байтугай мөрдөн хөөгч нарт маань ч саад болж байлаа. Хүмүүс бие биенаас асууж лавлан гайхалдаж л байлаа. Би нэг залууг түлхэж унагаачихаад цааш нэвт гараад Кассель талбайг тойрон хар хурдаар гүйхэд зургаа долоон хүн миний мөрийг харж гайхалдан байлаа. Тэд учры нь тайлж чадахгүй мэл гайхчихаад байснаас биш тэр олон хүн мэдсэн бол миний араас нөмрөөд ирэх байсан байлгүй дээ. Би хажуугийн гудамжаар хоёр дахин өнгөрч, явган хүний замаар гурав дахин орж өөрийнхөө хөлийн мөр гарсан газар эргээд ирэхэд хөл маань халууцаж, наалдсан шавар нь хатаж, явсан газар мөр гарахаа больсон байлаа. Тэгээд жаахан амарч болохоор болохтой нь зэрэг хөлдөө наалдсан шавар шавхайг арилгаж бүр үзэхгүй болсон юм. Тависток талбайд гарсан миний мөрийг хамгийн сүүлд нь арваад хүн үзээд Робинзон Крузо элсэн дээр ганц хүний хөлийн мөр олж үзэд учрыг олж ядан жигтэйхэн их гайхаж байсан шиг алмайрч байгаа харагдав.

Тэгж гүйж харайсаар бие минь овоо дулаацлаа, хүн цөөнтэй ч газраар орлоо. Нуруу хөшилдөж өвдөөд, өнөөх нэг морин тэрэгчний хуруу хумс хүрсэн чихний хавьд хөндүүрлэн өвдөж, ялангуяа хөл их өвдөөд, нэг тавхай минь шалбарснаас ялимгүй доголлон болоод байлаа. Нэг сохор хүн миний чанх өмнөөс ирж буй харагдахаар хурц сонороос нь айж бушуухан шиг буруулж зайллаа. Анзааралгүй байж хоёр гурван хүнтэй мөргөлдөж, чихэнд нь баахан харааж харааж орхиход тэдний гайхсаныг хэлж баршгүй. Гэнэт нүүрэн дээр нэг зөөлөн юм сэмхэн буув. Цас ажээ. Тэр талбай дээр цасан гадаргуу тогтлоо. Бие даарч, яаж ч хичээсэн болохгүй жигтэйхэн найтаалгах болов. Хажуугаар явсан нохой болгон үнэрлэж шивлэн гайхахад айдас хүрч байлаа.

Тэгтэл хүмүүс гүйлдэн хойноос нь хүүхэд шуухад хойно хойноосоо гүйлдэн хашгиралдахы нь сонсвол нэг газар гал гарсан бололтой. Миний сууж байсан байшин тийш л яваад байх шиг болохоор нь тэр зүг харвал байшингуудын дээвэр, төмөр утасны модон дээгүүр өтгөн хар утаа багшран олгойдох харагдав. Миний сууж байсан байр лав мөн байх. Дээл, хувцас, аппарат, хамаг юм хүм минь шатаж байгаа ажээ. Харин чи, гурван дэвтэр маань Грейт-Портленд-Стрит дахь шуудан тасагт байсан билээ. Галын аюул! Байшин шатсан хойо тэнд байсан хамаг юм маань үгүй болох нь тэр! гэж үл үзэгдэгч хүн ярьж дуусаад бодол болон суулаа. Кемп сэтгэл баахан түгшсэн янзтай цонхоороо харснаа:

-За тэгвэл цааш нь яасан бэ?

ИХ ДЭЛГҮҮРТ

-Тэгээд ээ жилийн нэгдүгээр сард тэр нэгэн цасан шуургатай орой /цасан шуурга ширүүсээд, намайг цасаар дарсан бол би илэрчих байсан юм!/ би гэдэг хүн

ядарч зүдрэн даарч бээрэн, энд тэндгүй өвдөж, хэлж баршгүй, их зовлонд учран, үзэгдэхгүй болсондоо төдий л итгэж чадахгүй, яах ч аргагүй ийм шинэ амьдралд ороод толгой хоргодох орон, бие хучих хувцас, итгэх хань нөхөдгүй болчих нь тэр. Өөрийнхөө нууцыг хүн амьтанд хэлчихвэл би өөрийн эрхгүй болж, хүн болгоны сонирхож шохоорхох үзвэр болж хувирах байсан юм. Гэсэн ч гудамжинд ямар нэг хүнийг дуудаж зогсоогоод үнэнээ хэлж хайр хишгий нь гуймаар гуймаар санагдаж байна. Гэвч тэгвэл хэн ч гэсэн ухаангүй айж, дэндүү хортой юм болно гэдгийг би бас сайн мэдэж байсан юм. Гадаа тиймэрхүү янзтай яваа хүн хожим хойныг бодох сэхээгүй амьтан болдог байна. Хаанаас толгой хоргодох орон, биед өлгөх хувцас хунар олж дулаацах билээ? гэсэн ганц бодолд автлаа. Тэгсэн цагт яах ийхээ бодож болох байв. Лондоны хамаг байшин барилга дандаа хаалттай, түгжээтэй байх учир үл үзэгдэх надад хүртэл орох юм амар олдсонгүй. Хүйтэрч, цасан шуурга тавьж шөнө оройтож, миний нууц илэрнэ гэдгийг би сайн мэдэж байлаа. Гэтэл толгойд минь нэг мэргэн ухаан орж ирлээ. Гауэр гудамжнаас Готтенхе-Корт-род орох нэг гудамжаар явж “Омниум” дэлгүүрийн яг үүдэнд очлоо. “Омниумыг” та мэдэх байх. Мах, ногоо, даавуу, модон хэрэглэл, хувцас хунар, зураг мураг худалдах, ер нь өдий төдий олон хоршоо нэг хоршоо болоод нийлчихсэн тийм нэг их дэлгүүр шүү дээ. Үүд хаалгууд нь онгорхой бол уу гэсэн чинь цөм хаалттай байлаа. Яах ч учраа олохгүй, нэг хаалганых нь өргөн тавцан дээр зогсож байтал морин тэрэг гарч ирээд дотроос нь дүрмийн хувцастай, малгай дээрээ “Омниум” гэсэн үсэгтэй хүн гарч ирээд үүдийг түргэн нээхэд би хажуугаар нь орж амжив. Тэр хүнийг дагаад явтал элдэв тууз, бээлий, оймс мэтийн юм худалдах тасагт оров. Цааш нь явтал нэг их зайтай өрөөнд сүлжмэл сандал ширээ мэтийн хэрэгсэл, сүлжмэл сагсууд байлаа. Хүмүүс доогуур нь ийш тийш хөлхөлдөөд санаа амар явах аргагүй болохоор нь би дээш давхарт гарч олон ортой нэг тасагт ороод орон дээгүүр нь дамжин явсаар овоолттой матраасан дээр очиж орогнов. Тэр тасагт гэрэл асаж тун аятай дулаан боллоо. Би тэндээ хоргодоод байхаар санаа шийдсэн боловч дэлгүүрийг хаан хаатал хоршоон дотуур хэсээд байсан хэдэн хүнх, хоёр гурван харуулын хүнийг нүд алдалгүй харж байв. Тэгж байгаад идэш уушных нь тасагт орж хувцаслана. Өөрийгөө далдлах арга олно. Тэгээд дэлгүүр дотуур явж үзээд шөнийн хоногоо нэг орон дээр нь өнгөрүүлнэ гэж бодож суулаа. _ Болмоор юм л санагдаж байлаа. Биеэ битүү хцувцаслаж орхивол баахан баглаатай мэт болох боловч яахав зүгээр хүн шиг дүрстэйгээ болох юм даа, тэгээд бас мөнгө олж авбал шуудан дээр байгаа боодолтой юм, дэвтэр энэ тэрээ олж аваад нэг газар байр хөлсөлж орохсон гэж бодож байсан юм. Ингэсэн хойно л үзэгдэхгүй болсон чанарынхаа давуу талыг яаж ашиглахаа сайн боловсруулъя гэж бодсоор байлаа.

Дэлгүүр хаах цаг нь хариугүй ойртлоо. Намайг орны матраасан дээр очиж сууснаас хойш нэг цаг хэртэй болоход цонхны хөшиг буулгаж, дэлгүүр дотор байсан улс гарах хаалгын зүг явцгаалаа. Хэдэн залуу лангуун дээр дэлгэж тавьсан барааг их л авхаалжтай эвхэн хурааж байв. Гадны хүмүүс гараад явчсан хойно би хоргодож байсан газраасаа гарч яг ид цэвэрлэж байгаа хэсэгт нь очив. Залуухан залуухан хар хүү, бүсгүйчүүл өдөр худалдах гэж дэлгэж задлаад хаячихсан бараа, ширээгээ тун түргэн шаламгай хураан далд хийж байгаагий нь хараад гайхмаар бхйдаг шүү. Хайрцагтай юм хум, өлгөөстэй эд бараа, нэхмэл торгон бараа, хайрцагтай чихэр, үзүүрт байгаа элдэв бараа таваараа цөмийг хураан авч эвхэж янзлан бат бөх авдар саванд хийж, харин далд хийхийн аргагүй эд хэрэгслийнхээ зүйлийг зотон даавархуу муу бараагаар бүтээж байлаа. Дараа нь шалаа цэвэрлэх гэж бүх сандлыг лангуун дээгүүрээ уруу харуулан тавилаа. Тэд ажлаа ингэж дуусгачихаад даруй гарах хаалга руу маш их баясгалантай явцгаахы нь харвал би ер тийм ажилтай улс ийм

баясгалантай байхы нь ховор үзсэн юм. Тэд ч гарлаа оронд нь модны үртэс цацсаар, гартаа бас хувин сав, шүүр барьсан олон залуус орж ирээд цэвэрлэгээ хийхэд би тэндээс зугтан зайлж байсан боловч модны үртэс хөлд минь өргөс шаачих гээд аягүй оргиод байлаа. Хүн амьтангүй харанхуй тасалгаануудаар нь тэмтчин явсаар чагнахад цэвэрлэгээ дуусаагүй шүүрний хамах дуу сонсдож байснаа дэлгүүр хаасны дараа лав нэг цаг болсон байх, сая нэг цэвэрлэж дуусахчаан болоод хаалга үүд хааж байгаа дуулдав. Дэлгүүрийн дотор ёстой чимээ аниргүй болж би ч ганцаараа орох гэсэн газраараа орж хэсүүчлэх бололцоотой болов. Готтенхам-Корт-родоор гардаг нэг хаалганы хавьд очиход гадаа явж байгаа хүний хөлийн чимээ сонсдож байсан юм.

Би оймс, бээлий худалдаж байсан тасагт нь хамгийн түрүүн орлоо. Пад харанхуй байсан учраас чүдэнз олох гэж зөндөө их эрэл болж болж, адаг сүүлд нь нэг ширээний нүднээс олохчоон болж бас лаа олж авлаа. Олж авах гэсэн юмаа эрсээр хичнээн олон хайрцаг савны таглаа онгойлгож онгичсон гэж санана, тэгж тэгж дотроо ноосон эд бараа бий гэсэн бичигтэй нэг хайрцаг олоод дотроос нь оймс, хүзүүнитий ороолт аваад бэлэн хувцасных нь тасагт орж гадуур өмд, цамц, пальто, хувраг нар өмсдөг дэлбэгэр хүрээтэй зөөлөн эсгий малгай олов. Сая ёстой хүн болдох шиг санагдаад даруй хоол бодогдлоо.

Дээд давхарт нь гуанз байсан тул тийшээ ороход хүйтэн мах, кофе цай байлаа. Шатах хий асаан цай халааж, ууж идэхэд тун ч аятайхан санагдаж билээ. Тэндээсээ гараад орны бүтээлэг олж авах санаатай тэнэн явж байсан чинь нарийн боовных нь тасагт ороод өгчээ, шоколад, жимсний үнэр учиргүй их ханхалж идэх дур ч гутах шиг болов. Тэрүүхэнд нь бургундийн цагаан архи ч байв. Бас дэргэд нь хүүхдийн тоглоомын тасаг тааралдсан. Гэтэл надад шинэ санаа төрж хиймэл хамар хэд хэдийг авч мөн нүдний хар шилтэй болохыг бодов. Харин “Омниум”-д шил, дурангийн тасаг байхгүй байсан болохоор хамраа яадаг билээ гэж баахан зовоод бас будаг шунх олон хэрэгтэй болов. Бас хиймэл үс, баг мэтийн аахар шаахар хиймэл юм хэрэгтэй байлаа. Тэгж байзнаад ноосон бүтээлэг дээр гараад унтахад дулаан, биед их эвтэйхэн сайхан байсан сан. Тэгээд унтах гэж байхад ийм болж хувирснаасаа хойш ер бодоогүй сайхан сайхан юм бодогдож билээ. Бие минь амарч байсан болохоор сэтгэл санаа минь амрав. Өглөө болоход хувцастайгаа сэмээрхэн сугаран гарч цагаан ороолтоор нүүрээ таглаад хулгайлж авсан мөнгөөрөө нүдний шил олж авбал хэрэг бүтнэ гэж бодож байсан. Тэр шөнө нойр муу хүрч, сүүлийн хэдэн өдөр болсон элдэв явдал хачин хачин болж хувиран зүүдэнд ороод байв. Байрны эзэн царай муутай атигар еврей өрөө тасалгаа дотуур хашгиран гүйж байгаа, бас тэрний хоёр хүү мэл гайхан зогсож байгаа, өнөөх нүүр царай нь атираагаар дүүрсэн чавганц муураа сураглаад орж ирж байгаа, өнөөх ноосон эдийн өөдөс цайрсаар цайрсаар үзэгдэхгүй алга болж байгаа нь үзэгдэж дотор хачин болоод салхи салхилсан ухаагийн бэлд очиж эцгийг нутаглуулахад сөөнгө хоолойтой нэгэн хувраг түргэн түргэнээр: “Газар газар болон үнс үнс болон, чандруу чандруу болон хувилна” гэж байсан нь бас, энэ бүгд цөм нүдэнд харагдаж, чихэнд дуулдах шиг болж хар дарж байлаа. Тэгтэл-Чи ч гэсэн тэр дээ? гэж нэг хүн намайг авс руу түлхэхэд би тэмцэн хашгиран, олон хүнийг дуудахад тэр ер огтхон ч жишимгүй зогсож ёслолоо гүйцэтгээд байлаа. Настай хувраг агшин зуур ч зогсхийлгүй уншлага хийн нусаа татаж байв. Би нэг их хүчинд аргагүй автсан, хүмүүс намайг харахгүй, миний дууг ч сонсохгүй байгаагийг нь ойлгов. Дэмий л харилцан ноцолдоход намайг авсанд хийгээд хавхийтэл таглалаа. Дээрээс элс, шороо хүрздэн буллаа, намайг өмөөрсөн

хүн ч гарсангүй, үзэж ажигласан хүн ч гарсангүй гэж зүүдэлж байгаад сэртэл хамаг бие чичирч байлаа.

Лондонд үүрийн цайвар гэрэл гийж, их дэлгүүрийн цонхны хөшигний хажуу заалхайгаар гэгээ орж иржээ. Өндийн суугаад харвал содон хэрэгсэлтэй, лангуунуудтай энд тэндгүй бараа ширээтэй, орны бүтээлэг, дэр жинтүү овооролдсон, ширмэн баганатай ийм газар чинь юу байдаг билээ гээд ухааны нь сайн олж амжаагүй байгаад сая учрыг олтол хүн хоорондоо ярилцах чимээ гарлаа. Тэгтэл нэг тасгийн цонхны хөшгийг бүр сойж сөхөөд нэлийсэн гэрэлд хоёр хүн миний зүг чиглэн ирж байхыг би хараад босон харайж хаана орж нуугдах билээ гэж ийш тийшээ харлаа. Гэтэл би босохдоо чимээ гаргачихсан учир тэр хоёр намайг мэдэж намайг олоод харчихсан бололтой, нэг нь

-Хэн бэ? гэж хашгирахад нөгөө нь:

-Хүүе! Зогс! гэж хашгирлаа

Би ч цааш нь зугтан булан ороогоод гүйтэл арван тав орчим насны туранхай жаалтай тулгарав. Би малгайгүй байсан болохоор толгой нь харагдахгүй, хүний дүрс байхгүй юу даа! Тэр жаал дуу алдан хашгирлаа, би тэрнийг түлхэж ойчуулчихаад цааш нь нэг булан ороотол лангууны ар талд нуугдах санаа зэгсэн төрсөн юм. Төдхөн хүмүүс гүйлдэн ирж цөмөөрөө “Үүдээ хаагаарай!” гэж хашгиралдаад “юу болов!” гэж асуулцан, тэгээд барь, ингээд барья гэлцэнэ. Би бүр айчихаад яах ч учраа олохгүй, шалан дээр хэвтэж байлаа. Хувцас хунараа таслаад орхичихвол зохих байсан боловч тэгийг гэж надад ер бодогдсонгүй, яагаад тэгж санаагүй юм, бүү мэд. Би ер хувцас хунартай болоод гарчихъя гэж их санаж байсан болохоор лав тэгээ биеээ. Тэгтэл лангууны нэг үзүүрээс “Өнөөх чинь тэнд байна!” гэж нэг хүн хашгирахад нь би босон харайгаад лангууны тэндээс нэг сандал барьж аваа тэр хашгирч байгаа хүнийг цохиж, араа нь хажуу тийшээ зугатаж бас нэг булан ороон гүйхдээ нэг хүнийг арай л дайрчихалгүй явсаар шатаар өгсөв. Гэтэл тэр муу золигийн хүн учиргүй хашгичин араас минь хөөцөлдөөр байлаа. Шатны дээр гарахад янз бүрийн хээ угалз болсон сав.. юу гэдэг билээ дээ? эгнээстай байлаа.

-Ваар сав байлгүй дээ гэж Кемп хажуугаас нь хэлж өгөв.

-Тийм тийм. Шатны дээд талд гарч эргэн, нэг тийм ваар шүүрч аваад намайг хөөж яваа тэнэгийнхээ толгой руу шидлээ. Ваар ч хэмх үсэрлээ, хүн хашгирах чимээ ч гарлаа, тал талаас хүмүүс энэ зүг гүйлдлээ. Би тэндээс гуанз руу хар хурдаараа гүйн ортол тэнд байсан цагаас хувцастай, лав тогооч байх нэг хүн намайг бас өөдөөс хөөв. Эргээд зугаттал шил дэнлүү, төмөрлөг барааны тасагт ороод явчив. Лангууных нь ар талд орж нуугдаад түүний хүрч ирэхийг хүлээж байтал өнөөх чинь хамгийн түрүүнд дайран орж ирэхэд гэдэс рүү нь дэнлүүгээр цохиод авлаа. Тэр ч унаад өгөв, би ч лангууны цаана суугаад хувцсаа бушуухан тайчиж эхлэв. Пальто, гадуур өмд, цамц, шаахайгаа амархан тайлчихсан, харин ноосон цамц гэдэг чинь хүний биед арьснаас дутахгүй наалддаг эд юм! Хүмүүс ирж байгаа чимээ мэдэгдэж байсан боловч харин өнөөх тогооч лангууны нөгөө талд цохиулж гэмтсэн юм уу, эсхүл айгаад ухаан алдсан юм уу дуугүй, хөдлөхгүй хэвтэж байлаа. Би ч бутан дотроос боссон туулай шиг бас л цаашаагаа зугтлаа.

-Цагдаа, наашаа явуулаарай! гэж хүн хашгирах дуулдав. Би өнөө ор, матраастай, дээлийн өлгүүртэй газраа дахин орж шалан дээр нь хэвтээд цамцаа оролдон байсаар тайлж хаяад өнөө цагдаа, дэлгүүрийн ажилчин гурван хүний хамт булан ороогоод хүрч ирэхий нь өмнө дахин чармаа шалдан хүн болоод айж чичрэн зогсож байсан юм. Тэд миний хантааз дотуур, гадуур өмднөөс шүүрэн барьж байлаа."Хулгайлж авсан юмаа хамж эхэлж байна. Лав энэ хавь ойрхон байгаа байх" гэж нэг залуу нь хэлэв.

Гэсэн ч тэд намайг олоогүй юм. Тэд намайг хэрхэн хайж байхы нь би хараад зогсож байлаа. Олж авсан хувцас хунараа алдаж, бүтэлгүй болсондоо би гонсгор байлаа. Тэгээд гуанзад нь орж жаахан сүү уугаад галынх нь дэргэд өөрийнхөө байдлыг эрэгцүүлэн бодож суусан юм.

Дэмий удсангүй хоёр залуу орж ирээд, юу болсон тухай маш тэвдэнгүй хачирхан шал дэмий юм ярилцаж байв. Тэр хоёр миний үйлдсэн хэргийг дэндүү хэтрүүлэн давсалж, намайг хаана байдаг тухай шал худлаа юм ярьж байв. Би ч өөрөө одоо яах билээ гэж бодож суутал ялангуяа ийм хөл үймээн болчихсон газраас юм авч гарна гэдэг тун бололцоогүй санагдлаа. Агуулах газарт нь орж юухан хээхэн боож аваад нэг тийш нь явуулчихъя гэж бодовч журмыг нь мэдсэнгүй. Арван нэгэн цагийн үед гадаа цас хайлж дулаан болсныг үзээд тэр дэлгүүрт байхын зэрэг алга боллоо. Тэгж бүтэлгүй болсондоо дотор минь цухалдаж, цаашдаа яах ийхээ ч сайн бодож чадахгүй байлаа.

ДРЮРИ ЛЭЙНД

Үл үзэгдэгч хүн ярихдаа би ямаршуу хэцүү байдалтай болсныг та одоо ухаарч байгаа биз. Би хоргодох орон, өмсөх хувцасгүй болоод байна. Хувцас өмсөе гэхлээр хамаг хүчтэй чанараа алдаад хүн амьтанд аймаар, жигшигдмээр хачин юм болчих байлаа гэв.

-Энүүний чинь тухай ер бодсонгүй шүү гэж Кемп дуугарав.

-Би өөрөө ч тийм болно гэж бодсонгүй. Сүүлдээ мэдээд цэнэж явалгүй горьгүй нь гэж бодож билээ. Цас над дээр орвол хүн мэдчих тул цас орохоор нь гарч явж чадахгүй байлаа. Бороо орвол бас усан шугамаар хүний дүрс маягтай юм болон бүрэлзэж байла. Түүгэр ч барахгүй Лондоны гудамжаар явахад агаарын хөө тортог, хир тоос хөлөөр барахгүй биед наалдан наалдсаар хамаг бие маань үзэгдэхүйц болж магадгүй байв. Лондонд нэг их удалгүй тийм болчих газар шүү дээ.

-Тэгээд Грейт-Портленд-стритийн тэртээх борчуул суудаг хэсэг рүү явж өөрийнхөө сууж байсан гудамжны адагт хүрээд очсон чинь миний галдсан байшингийн утаа уугин манарч, үй олон хүн язганасаар байв. Цаашаа явж чадсангүй. Би ер нь юу юуны өмнө хувцастай болох зорилготой байсан юм. Тэгээд нэг жижиг дэлгүүр орсон чинь сонин, чихэр, тоглоом бичгийн аар саар юм, шинэ жилээр хэрэглэдэг юм хум зардгаас гадна бас хиймэл хамар, толгойд өмсөх баг байхыг үзээд "Омниумын" хүүхдийн тоглоомын тасагт ороод бодож байсан маань санагдаж, одоо яахыгаа мэдээд буцаж аль хүн цөөнтэй газраар явсаан Стрендыийн хойгуурхи гудамжуудаа хувцасны дэлгүүр хэд хэдн байдаг учир тийшээ явсан юм.

Тэр өдөр жихүүн салхи үлээсэн нэлээд хүйтэн өөр байлаа. Би хүнд л мэдэгдчих вий гэхээс айж уулзвар газар бүр аюултай санагдаж, хажуугаар өнгөрч

яваа хүн бүрийг сайн ажиглаж өнгөрөөхгүй бол болохгүй байсан юм. Бедфорд гудамжийн эхээр ороон урдаа явж байсан нэг хүнийг гүйцэж, түрүүнд нь гарах санаатай тулаад очтол өнөөх хүн гэнэт эргэж натай тулгараад түлхчихсэн чинь би арай л нэг морин тэрэгний дугуйн дор орчихсонгүй. Тэрэгний зогсоол дээр байсан хүмүүс бодохдоо тэр хүнийг саа өвчинд дайруулав уу гэж бодсон ажээ. Тэр хүнтэй тэгж мөргөлдөхөд дотор бухимдан харанхуйлж Ковентын ногоо жимсний зах зээл тийш бушуухан эргэж, нил цэцэг худалддаг мухлагийн хажуу, хүн амьтан цөөнтэй нэг өнцөгт хэсэг зуур амсхийн суухад хамаг бие дагжин чичирч байв. Бие даарч хөрсөн учир хамрын шуухинаа хүрч найтаалгамаар болоод байхаар нь хүнд сэжиг авахуулахгүйг бодож тэнздээсээ зайлахаас өөр замгүй болж яв явсаар очих гэсэн газраа олж Дрюри Лейний ойролцоо доголд байдаг ялаа батганы баас болсон муухай балиар мухлагт хүрч ирсэн юм. Цонхон дээр нь алтан утас хатгамалдсан дээл хувцас, хуурамч, чулуу, нарийн эдлэл, хиймэл үс, гутал, даалуу, театрын хбологдолтой гэрэл зургууд харагдана. Энэ бол харлаж барайсан өнгөтэй таван давхар байшингийн доод давхарт байдаг их л эртний маягийн бүдэг гэрэл, намхан дээвэртэй мухлаг юм.

Цонхиор нь харахад дотор нь ганц ч хүн байхгүй тул оров. Харин хаалгы нь нээхтэй зэрэг цаана нь дохионы хонх дуугарахаар нь хаалгыг онгорхой хэвээр орхиод дээлийн хоосон өлгүүрийн хажуугаар өнгөрч хүний бүх бие харагдах том тольтой буланд нь очив. Дэмий их удсан ч үгүй, цаад талын өрөөнөөс хүн ирж явах хөлийн нүсэр чимээ сонсдоод нэг хүн гарч ирэв.

Би төлөвлөгөөгөө нарийн боловсруулчихаад тэр байшинд орж шатны хавьд нэг газар нуугдаж байгаад хүн амьтны хөл татарч үгүй болохтой зэрэг хиймэл үс, баг, нүдний шил, хувцас сэлт хулгайлан авч өсөөд гаръя гэж бодож байлаа.

Тэгвэл хачин нь хачин боловч хүнэрхүү харагдах байсан юм. Бас мөнгө байгаа л юм бол авчихна гэж бодлоо.

Мартсанаас цаад талын өрөөнөөс гарч ирсэн хүн мань намхавтар, яльгүй бөгтөр, сөрөвгөр хөмсөгтэй, гар урт, хөл нь хариугүй бгино мөртлөө майга. Намайг хонх дуугарахад лав хоолоо идэж байсан бололтой. Ямар хүн ирэв гээд хүлтэлзсэн янзтай ийш тийш харснаа гайхаж, хүн ердөө байхгүй болохоор уур нь хүрч:

-Муусайн золигийн хүүхдүүдийг! гэж хараал тавиад үүдэндээ очиж гадагш шагайж хара босгон дэрээ нэг хэсэг зогсож байснаа хаалгыг хөлөөрөө чанга хааж аман дотроо нэг юм үглэсээр мухрынхаа өрөө рүү явлаа.

Би хоргодож байсан газраасаа гарч тэр хүний арас даган орохыг завдтал нөгөө хүн анир аван зог тусахад би түүний чих хичнээн сонорыг гайхан бас дороо зогсов. Тэгтэл өнөөх чинь өөрийнхөө өрөөнд орж, хаалгаа хавхийтэл хаав. Би яг дэргэд нь очоод хоцрох нь тэр. Тэгээд яаж ийхээ сайн мэдэхгүй тээнэгэлзэн зогсож байтал түргэн түргэн алхлан ирэх хөлийн чимээ гарч үүд нь нээгдэж өнөөх маань гарч ирээд сэтгэл тогтож тайвшрахгүй байгаа янзтай лангууныхаа хоёр талаар өнгийж үзээд модон хэрэглэлийнхээ доогуур шагайсанаа ийш тийшээ харж зогсон өөрийнхөө хаалгыг онгорхой орхиод байсан болохоор би хажуугийн өрөө рүү сэмхэн ороод өгөв. Тэр өрөө нь жижиг, доторхи засал ядмаг, нэг буланд нь хэд хэдэн том толгойн баг байгаа харагдана. Ширээн дээр нь тэр хүний идэж байгаад орхисон хоол байв. Тэрний ууж байсан кофейн үнэр үнэртэхэд тэр хүнийг хоолоо идэхэд мииний хорхой

хүрсний хэлээд яахав Кемп минь. Тэр хүний хоол ч хоолой руу нь олигтой явж өгөхгүй байгаа бололтой. Өрөө нь гурван тийшээ хаалгатай, хожим мэдэхэд нэг нь дээш, нэг нь доош гарах хаалга байжээ. Намайг ороод байхад бүх хаалга нь хаалттай байсан юм. Тэр хүнийг өрөөндөө байгаа цагт би гарахын аргагүй байв. Түүний чөтгөр шиг сонороос би ер өчүүхэн ч хөдөлж чадахгүй байхад гай болж араас хүйтэн салхи үүгээд хоёр дахин арай л найтаачихсангүй.

Юм хүм харж суухад сонин хачин байсан боловч тэрнийг хоолоо идэж суутал бие минь чилж эгдүү хүрч байлаа. Хоолоо идэж дуусахчаа болоод муу санаа хар өнгийн төмөр тавиур дээр тавьж гичинд халтар хултар болсон ширээнийхээ бүтээлэг дээрх үртсийг хамж авав. Гартаа юм барьсан уёчир хаалгаа хааж чадалгүй явав. Хаалга үүдээ тэрүүн шиг хаах дуртай хүнийг би ер үзээгүй! Хойноос нь дагаж яваад доод талын өрөөнд орвол тэнд маш заваан, гал тогоо, юм агуулах газар байв. Тэр хүний сав суулгаа угааж арчихы нь харж байснаа хүйтэн шалан дээр дэмий зогсоод яахав гэж бодоод дээш гарч задгай галын дэргэд байсан түүний сандал дээр суув. Гал нь унтарч нүүрс нэмж хийв. Ингээд байж миний гаргасан чимээг тэр хүн сонсоод юу юугүй эргэн ирж өрөөн дотуураа нэлээд зовсон янзтай харж явахдаа намайг эгээ л дайрчихсангүй. Хайгаад хайгаад юм олж үзээгүй боловч нүдэндэ итгэхгүй бололтой, гарахдаа үүдэнд зогсоод эргэн тойрон их л анхааралтай харж харж явлаа. Удаж удаж ирэхэд нь би түүний өрөөнд хүлээж байсан юм. Тэгээд дээшээ гарахад нь бас дагаж гараад явж байтал өнөөх чинь шатан дээр гэнэт зог туссан чинь би арай л мөргөлдчихсэнгүй. Тэр хүн яг мииний нүүр лүү эргэж хараад чагнаж:

-Андгайлсан ч болохоор л байна даа!.. гэж шивнэснээ үс элбэгтэй урт гараар доод уруулаа чимхэн шатны дээш доош ээлжлэн харснаа нэг юм амандаа бувтнаад цааш явлаа. Орор өрөөнийхөө хаалганы бариулаас барьснаа гэнэт зогсож бас л гайхсан цөхөрсөн байдалтай ийш тийш ширтлээ. Араасаа дагаж явсан миний чимээг сонсчээ. Чих шиг чихтэй эр байсан юм. Уур нь гэнэт хүрч:

-Хэрэв манайд хүн орж ирсэн байдаг бол доо гэж хэлээд хараал тавин занаж зүхэнгээ өврөө тэмтэрч нэг юм эрснээ олоогүй, миний дэргэдүүр сүр сархийн өнгөрч шатааруу уруудав. Би хойноос нь дагаж явсангүй эргэж ирэхийг нь хүлээгээд шатны тавцан дээр сууж байв. Тэгтэл дэмий удсангүй өнөөх чинь нэг юм бувтнасаар буцаж ирээд өрөөнийхөө хаалгыг нээж намайг орж амжихаас урьд хаачихваа. Тэгэхлээр нь тэднийхийг сайн ажиглаж юм юмы нь мэдэх санаатай энэ тэрүүгээр аль болох чимээ аниргүйхэн хэсэв. Тэдний байшин их хуучирч муудсан, чи ихтэй болохоор хананд наасан цаас нь хүртэл ховхорчээ. Харх хулгана ч гэж тоо томшгүй байв. Ихэнх хаалганых нь бариул эргэхдээ дургүй юм, тэгэд би оролдпохоосоо айж байв. Миний орж үзсэн хэд хэдэн өрөөнд ер юм байхгүй, зарим хэдэд нь хүнээс дамжуулж авсан бололтой театрын элдэв новш байв. Нөгөө хүний орсон өрөөний яг хажуугийн өрөөнд олон хуучин дээл байхаар нь үзэж онгичихдоо өнөөх хүнийхээ чихний адтай сонорыг мартчихжээ. Хүн сэмэрхэн ирж байгаа хөлийн чимээ гарахад нгь толгойгоо өндийлгөн үүдний зүг харвал өнөөх хүн хуучин цагийн гар буу барьчихсан орж ирээд зогсож байв. Би тэр дороо хөдлөхгүй болохродд минь хүн бүр гайхан нүд хэсүүлэн харснаа:

-Энэ лав... юу... байхаа гэж сунжруулан хэлээд-Чөтгөрт алгадуулсан муусайн золигнууд! гээд гарч үүдийг аяархан хааж цоожлоод цаашаа явах хөлийн чимээ гарсанд би тэр өрөөнд түгжигдсэнээ сая мэдэж баахан сандраад цонхоор гадагш нэг харж яах учраа олохгүй уур их хүрсэн боловч юу ч гэсэн тэнд байгаа хувцас хунарыг

эхлээд сайн үзэхээр шийдсэн юм. Тэгээд онгичиж эхэлтэл дэд талын тавиур дээр байсан бөөн хувцас хунар над дээр унахад өнөөх эзэн чөймээ гарахыг сонсоод ёстой их уурлан орж ирээд миний биед тулгарсан тул давхийн цочиж ухасхийн буцаад тасалгааны тэг дунд мэл гайхан зогссоноо дэмий удалгүй тайвширч:

-“Энэ хархнуудыг уу” гэж нам дуугаар хэлээд хуруугаараа уруулаа имэрнэ. Нэлээд байсан байхаа, би хажуугаар нь сэмээрхэн гараад явж байтал хөл дор шал дуугарчихав. Тэгтэл тэр муу майга золиг үүдээ цоожлон түлхүүрээ өвөрлөж нэг бодолтой байгаг нь би тааж мэдмэгцээ жигтэйхэн зэвүү хүрч олдсон завшааныг ч ашиглахгүй өнгөрч мэдэх байлаа. Ганцаар байгааг нь нэгэнт мэдсэн учир эвий тааруулж байгаа толгой руу нь дэлсэв.

-Толгой руу нь дэлслэ гэж үү? гэж Кемп зуураас нь асуухад үл үзэгдэгч хүн:

-Тэгсэн, шатаар гүйж явахад нь шатны тавцан дээр муурч унахад нь цохиод авсан юм. Яг л муусайн гутал чихчихсэн шуудай шиг шалхаг гэд ойчино билээ.

-Хээн хүний үр болдоо чи.

Ердийн хүнд хүний ёс таарахаас биш... Кемп минь, би тэндэс баг, хувцас хунар өмсөөд өөрт нь харагдахгүй гарах ёстой байлаа шүү дээ. Өөр арга бодоод олдсонгүй. Аманд нь арван дөрөвдүгээр Людовик хааны үеийн хийцтэй дотуур хантааз чихэж орхиод орны цагаан даавуунд хүлчихсэн юм.

-Орны цагаан даавуунд хүлчихсэн гэнэ ээ?

-Тийм, яг шуудайтай юм шиг болгосон. Тэгсэн маань тэр галзууг гайгүй сайн айлгаж хашгичиж, тайчлэхгүй болгосон тун сайн арга болсон юм. Тэгж хүлүүлчихсэн хүн тийм амар сул болж яагаад ч чадахгүй. Кемп минь чи над руу ингэж нүд үзүүрлэн айхтар хараад яахав, би ямар хүн алсан биш. Тэр хүн гартаа гар буутай байсан юм. Намайг нэг үзчихвэл цагдаад ийм тийм хувцас хунартай, ийи тийм янз төрхтэй гээд мэдүүлчихнэ шүү дээ.

-Гэлээ ч гэсэн. Одоо үед Англи оронд хүн өөрийнхөө гэрт байхад орж очоод юмы нь дээрэмддэг чинь гэж Кемп хэлтэл

-Дээрэм! Битгий дэмийр! Чи намайг ингэсгээд хулгайч гэх нь шив дээ Кемп, чи юмны учир олохгүй тийм мангуу амьтан биш шүү дээ. Би ямар байдалтай болоод байгааг чит ер ухаарахгүй байна гэж үү? Гэж үл үзэгдэгч хүн асуув.

Тэр хүний байдлыг ч гэсэн ... гэж Кемп өчтөл үл үзэгдэгч хүн давхийн босож-Та ер юу гэх гээд байна? гэлээ.

Кемпийн царай үл ялиг хувьсхийсэн боловч нэг юм хэлэх гэснээ хэлсэнгүй биеэ барьж байдлаа хувирган “Бодоход нээрэн яах ч аргагүй юм болжээ, гэхдээ... гэв

-Би аргагүй аргагүй гэхэд даанч аргагүй болсон юм. Нэмэрт нь буу барьчихаад байшин дотуур намайг мөрдөөд байн байн үүд хаалгаа нэг цоожилж, нэг нээгээд ер зүгээр байлгахгүй байсан юм л даа. Миний буруу гэхгүй биз? Үгүй биз?

-Би ер нь хүнийг хэзээ ч буруушааж үзээгүй. Ийм ёсыг орхисон хүн шүү. Тэгэд та дараа нь яав даа?

-Их өлсөж байсан болохоор доош бууж тэндээ бөмбөнцөг боов, бяслаг зөнд нь идлээ. Бас жаахан архи устай хольж уугаад дээшээ гарч өнөөх шуудайтай хүний дэргэдүүр гарахад тэр хүн ер хөдлөхгүй номхон хэвтэж байлаа. Тэгээд хуучин хувцас хунартай тасалгаанд нь оров. Тэр тасалгааны хир буртагт дарагдаж бараан өнгөтэй болсон торон хээтэй сиймхий хөшигтэй хоёр цонх нь гудамжин талдаа байв. Цонхы дэргэд хүрч очоод гадагш харвал миний байгаа байшингийн доторхи бүдэг гэрлээс шал ондоо, нүд гялбам жигтэйхэн тунгалаг өдөр байна. Гудамжны хөдөлгөөн жигтэйхэн их, жимс ногоо ачсан тэрэг, загас ачсан тэрэг явж байв. Эргээд харахад тэр бүхэн нь нүдэнд эрээлжлэн харагдах шиг байлаа. Сэтгэл хөдөлж дотор хачин болж байснаа төдхөн тэлэрч одоо би ямар байдалтай болчихоод байгаагаа дахин бодож үзэв. Тэдний байшин нэл бензин тосны үнэр ханхлахы нь бодвол хувцас хунар арчихдаа хэрэглэдэг тосных нь үнэр билээ. Тэдний юми хүмийг нэг захаас нь аваад нэгд нэггүй үзэж эхлэв. Тэр бөгтөр хүн сүүлийн хэд хогног гэртээ лав ганцаараа байгаа бололтой. Надад хэрэгтэй гэсэн юмнуудаа дээл хувцас агуулах өрөөнд оруулж нэг дор цуглуулж байгаад сайн үзэж өөртөө таарах нэгий нь шилж авлаа. Бас нэг хөвхөн хайрцаг авсан маань их л үнэтэй цайтай олз болсноос гадна бас жаахан нүүрийн оо, улаан будаг, наалдах тууз авав.

Тэгээд дахин үзэгддэг болохын тулд нүүр, хүзүү, гар хөлөө будаж оодъё доо гэж бодож байсан боловч скипидар бас бусад юм олох хэрэгтэй байсны дээр эргээд үзэгдэхгүй больё гэвэл их цаг хэрэгтэй болох байсан юм. Хамгийн сүүлд нь нэг хиймэл хамар тааруулж авлаа. Жархан инээд хүрмээр боловч тийм хамартай хэн зөндөөн байдаг. Нүдний хар шил, хууз, хиймэл үс авав. Гөлөнгөр даавуун эд, хүзүүний кашемир даавуун ороолтноос өөр дотуур өмсөх юм олдохгүй байхаар нь тэдгээрийг хэрэглээд гадуур гарахдаа худалдаад авчихна гэж бодлоо. Оймс олдохгүй байсан ч гэсэн өнөөх бөгтрийн шаахай миний хөлд яг таарлаа. Тэр дэлгүрийн кассинд гурван соверн, гучин шиллинг байсныг аваад бас тэдний суудаг өрөөний цоожтой хайрцгийг эвдэн нээгээд алтан фунт стерлинг найм байсны нь аваад одоо ч гадагш гарахад дажгүй боллоо гэж бодсон юм.

Гэтэл гадаад байдал маань хүн амьтанд үнэхээр аятайхан харагдах болуу, яах бол? гэж бодохоос их эргэлзээ төрөв. Тэгээд ариун цэврийнх нь өрөөний жижигхэн толинд биеэ эргэн тойрон үзэж мартаж орхисон зүйл байгаа эсэхээ шалгаж үзлээ. Цөм зүгээр болсон шиг харагдсан. Театрын нэг инээд хүрэм жүжигчин мэт байдалтай болсон боловч ерөнхийдөө сэжиглэмээргүй байв. Дотор овоо онгойж, жижигхэн толий нь барьсаар гарч их өрөөний булан дахь гурван талтай том толинд бие байдлаа дахин нэг сайн ажиглаж явлаа. Хэдэн минут болоход дотор маань нитлээд уужирч өнөөх паадгар эрхмийгээ өөрөө яаж ийгээд боодлоосоо гарна бие гэж орхичихоод дэлгүүрээс гарав. Таван минут орчим өнгөрөхөд өнөөх дэлгүүрээс тав зургаан байр алгасан холдлоо. Намайг нягталж ажигласан хүн гарсангүй. Санаа амарч болохоор аятай санагдав гэж яриад үл үзэгдэгч хүн дахин дуугүй болов. Кемп:

-Тэр бөгтөр хүнээ яагаа бол гэж та зовсонгүй юу? гэхэд цаадахи нь:

-Үгүй. Юу болсныг би дуулаагүй. Яаж ийгээд учры нь олоод тайлсан, эсхүл даавуугаа ураад гарсан бйх. Сүрхий чанга боосон юм аг гээд дуугүй болж цонх руу харлаа.

-Стрэнд рүү гарснаас хойш яасан бэ дээ?

-Яах юу байхав, бас л жигтэйхэн юм болсон! Одоо зовлонгоос гэтлэлээ, нууцаа л мэдэгдчихгүй бол юу хийе гэснээ хийж чадах боллоо гэж бодож байсан юм! Юу ч хийгээд ямар ч байдалд орлоо гэсэн хувцсаа тайлчихлаар үзэгдэхгүй болох юм чинь айх юмгүй болно. Намайг хэн барьж чадах вэ, мөнгийг хаа байгаа газраас нь авчихна гэж бодож явсан юм. Тэгээд хоол сайнг идэж аваад эг сайн гэгчийн зочид буудалд суугаад шинэ юм хүмтэй больё гэж бодож их догь явсныг яаана, Хичнээн тэнэг бодсоноо одоо санахаас аягүй байх юм. Гуанзанд ороод яг хоол захиж байтал би чинь хоол идэхдээ үл үзэгдэх нүүрээ ил гаргахгүй бол болохгүй шүү дээ гэж бодогдоод захиалахаа больж арваад минут болоод ирнэ гэж хоол зөөгчид нь хэлчихээд цухалдан гарч одов. Хоол идэх дураа тэгж их хүргээд хоосон өнгөрч байсан удаа танд тохиолдсон эсэхийг би мэдэхгүй юм даа.

-Тийм айхтар хорхойгоо хүргээд орхиж байгаагүй, гэсэн ч ерөнхийдөө төсөөлж байна гэж Кемп хэлэв.

Уур хүрч ухаан мунхрах шиг болж нэг гуанзанд ороод тусгай өрөөнд орж аятайхан хоол идэхээр шийдэв. "Миний нүүр хүн харахын аргагүй их гэмтсэн юм" гэж тайлбарлав.

Тэд над руу сонирхон харсан боловч ямар ч байсан тэдэнд хамаагүй тул надад хоол авчирч өгөв. Хоол маань базаалтай сайн биш байсан гэвч цадталаа идчихээд янжуур татан суух зуур цааш яах ийхийгээ боловсруулан бодлоо. Гадаа цасан шуурга тавьж балаа. Ийм хүйтэн сэрүүн муухай улиралтай, хүн амьтан ингэж үймэлдсэн боловсон хот болох тусам үл үзэгдэгч хүнд улам бэрхшээл учрах юм байна гэдгийг улам илүү ухаарч байлаа. Кемп ээ. Ийм тэнэг дэмий туршлага хийхээсээ өмнө би хэнээс ч өдий төдий мянган давуу талтай болно гэж бодож байсан бол туршлагаа хийсэн анхны өдрөөс сэтгэл чилж цөхрөхөөс өөр юм бодогдохгүй болсон юм. Хүн хүссэн бүхнээ биелүүлье гэхэд юу юу хэрэгтэй болохыг би бодлоо. Үзэгдэхгүй болсныхоо ачаар хүссэн бүхнээ олж авч чадах боловч түүнийгээ ашиглах бололцоогүй юмаа. Хүний санаа бас хачин шүү. Хэрэв өөрөө тухлан сууж чадахгүй юм бол гоё сайхан эдлэнгээр ч яах юм. Нөхрийхөө нууцыг дайсанд нь өгөөд байх юм бол тийм хүүхний хайр сэтгэл гэгч ямар хэрэг байна? Би ер улс төрийн бодлого, хоосон алдар, ачтаны ёс, биеийн тамир гэх мэтэд дурладаг хүн биш. Тэгсэн мөртлөө? Биеэ баглаж хучсан хүний дүрстэй ийм амьтан болох хэрэг юу байваа гэж бодох юм.

Үл үзэгдэгч хүн ингэж яриад дуугүй болохы нь ажвал цонх руу харж байх шиг байлаа.

Кемп зочноо цааш нь яриулах гэж:

-Та тэгээд Аипинтэд яаж ирэв? гэхэд цаадхи нь:

-Очиж ажиллах гэж тийшээ явсан юм. Надад горьдах юм ганц байлаа. Горьдлого л байснаас илүү юм биш. Одоо ч горь тасраагүй байна. Горь тасрах байтугай найдвар төрөх болов. Хуучин байдалдаа эргэж орох арга алга. үзэгдэхгүй цагтаа хийх гэсэн бүхнээ хийчихээд дараа нь үзэгдэг болох юмсан. Энэ бол бодлогынхоо талаар тантай зөвлөмөөр байна... гэв

-Та Айпинг рүү шууд явсан уу?

-Тэгсэн. Тэмдэглэл бүхий гурван дэвтэр, мөнгөнийхөө чекийг олж аваад дотуур хувцас худалдаж авсан, хэрэглэгдэх химийн бодис захиалж аваад явсан юм. Сүүлд дэвтрээ олж аваад танд бүх тооцоогоо үзүүлэмэ: Ай бүү үзэгд! Тэр удаагийн цасан шуургыг яана. Зузаан цаасан хамар дээр минь цас ороод муухай болгочих гээд, хичнээн зовж явсан гэж бодно...

-Сонинд бичсэнийг үзвэл та чинь мэдэгдэхийнхээ өмнө урждар... яасан юм?

Нутгийн цагдаагийн тэнэг даргыг алчихав уу, гэж байна уу?

-Үгүй, үгүй. Тэр ч сэхэх төлөвтэй байна гэжээ.

-Тэгвэл овоо азтай эр юм. Би бүр галцуурах дөхсөн, муусайн малнуудыг! Ер нь намайг амар заяа үзүүлэхгүй байсан улс. Тэр нэг балай худалдаачин яагаа бол?

-Хүний амины хэрэг гараагүй юм байхаа.

-Миний өнөө муу тэнүүлч яагаа бол, мэдсэн юм алга шив дээ гэж үл үзэгдэгч хүн зэвүүрхэн инээснээ-Тан шиг амьдралтай хүмүүс уур хүрнэ гэж яадгийг лав мэдэхгүй, Кемп ээ... Өдий олон жил ажил хийж хийж, толгойгоо эргүүлж эргүүлж төлөвлөж төлөвлөчихөөд байтал адаг сүүлд нь аль нэг усан тэнэг, мулгуу мунхаг этгээд хүний мөр дээр тээглэж хөндөлдөөд ирэхий нь яана! Хаа газрын зүсэн бүрийн тэнэг балай юмнууд дандаа л сайд хийдэг байсан юм... Дахиад тийм амьтад тааралдвал би ёстой галзуурах шиг галзуурч нүдэндээ өртсөн бүрийн бодий нь хөтлөх юм хуна. Тэд л ерөөсөө миний ажлыг түм дахин нарийн түвэгтэй болгоод байгаа юм гэхэд нь Кемп:

-Эргэлзээ алга. Тун тоогүй юм болжээ гэв.

УРАГШГҮЙ БОЛСОН ТӨЛӨВЛӨГӨӨ

-Тэгээд одоо яах билээ? гээд Кемп цонх руу хяламхийн харж ухаа өөд тун удаан мацаж буй мэт явах гурван хүн гийчнийг маань харуузай хэмээн болгоомжилж биеэрээ халхлах санаатай ойртож суулаа.

-Порт Бердок руу явахдаа та яая гэж бодож байв? Ер нь танд тодорхой байв уу?

-Энэ орноос зайлъя гэж бодож байсан юм. Гэтэл тантай ингэж уулзсанаас хойш тэр болоо орхилоо. Анх цаг уур дулаан ер нь үзэгдэхгүй байгаад байх боломжий нь бодоод өмө зүг явъя гэж бодож байсан юм. Мийн нууц илрээд одоо хүн бүр дэндэсхийвл нүүр толгойгоо жаахан далдалсан хүнийг хардаад байх болсон ийм цагт уг нь эндэс зайлбал сайн байсан юм даа. Эндээс чинь Франц руу галт онгоц явдаг шүү дээ. Нэг дээр нь суугаад азаа үзвэ гэж бодож байсан юм. Францаас цаашаа төмөр замаар яваад Испанид юм уу эсхүл Алжирт хүрч очно. Нэг их дааж давшгүй бэрхшээлсээд байх юмгүй сэн. Тэнд хүнд үзэгдэхгүй хэвээр амьдраад байж болох газар байгаа юм. Ажиглаж ч болоох газар. Нөгөө тэнүүлчийг би мөнгө

хадгалагч, юм зөөгчөө болгон ашиглаж харин тэр юм хүмээ яаж өөрийн очих газрыг олж явуулдаг билээ гэж бодож явсан юм.

-Ойлголмжтой байна.

-Тэгтэл л тэр муу мал чинь намайг дээрэмдэх нь тэр! Дэвтрүүдий чинь авчихсан Кемп ээ, дэвтрүүдий минь!, Тэр золиг!

-Дэвтрүүдээ л давын өмнө олж авах хэрэгтэй юм байна даа.

-Хаана байгаа бол? Та мэдэж байна уу?

-Хотын цагдаагийн газар өөрөө очиж хамгший бат бөх гянданд ороод цоожлуулчихаад байгаа гэнэлээ.

-Өөдгүй новш!

-Ямарч ч болсон таны төлөвлөгөөнд саад болж дээ.

-Тэр дэвтрүүдээ заавал олж авах хэрэгтэй, авалгүйгээр юу ч бүтэхгүй.

Кемп гадаа хүн байх юун магад хэмээн чагнаснаа:

-Тэгэлгүй яахав. Дэвтрүүдээ л олж авах хэрэгтэй. Танд авч өгөх гэж байгааг л мэдэхгүй бол өгөхгүй гэхгүй биз.

-Нээрэн тийм ээ гэж үл үзэгдэгч хүн хэлээд хэсэг бологоширов.

Кемп яриагаа үргэлжлүүлэх санаатй ярих юмаа олж цөхөж байтал цаадхи нь:

-Би бодож төлөвлөж байснаа танайд орж ирснээс хойш өөрчлөв. Та миний явдлыг ухааж мэдэх ухаантай хүн. Иймэрхүү юм болж, миний нууц илэрч, хэрэгтэй дэвтэр маань алдагдсан ч гэсэн хийж болох юм их байна... гэж ярьж байснаа-Намайг байгаа гэж хүнд хэлээгүй биз гэж гэнэт асуув.

Кемп хариу хэлэхдээ түгдэрч,

-Яалаа гэж дээ гэхэд Гриффин,

-Хэнд ч хэлээгүй юу? гэж асуув.

-Ганц ч амьтанд хэлээгүй!

-За тэгвэл... гэж үл үзэгдэгч босоод нуруугаа үүрээд өрөөн дотуур холхиж-Би алдаа хийжээ. Ийм ажлыг ганцаараа оролдсон маань их алдаа болжээ, Кемп. Тэгснээс олбж би хүч чадал, цаг хугацаа, аятай нөхцөл бололцоог дэмий алджээ. Ганцаар ... хүн ер ганцаар бол газар авдаггүй юм байна. Аар сархан хулгай луйвлраас юу хэтрэх вэ? гэснээ надад туслах хүн, суух орон хэрэгтэй байна. Кемп ээ, Сэтгэл тайван унтаж амрах, идэж ууж байх бололцоотой, идэх хоолтой байвал би мянга түмэн үйлийг бүтээж чадах байна. Саяхан хүртэл би мухар сохор ажиллаж

байлаа. үзэгдэхгүй чанар юу бүтээж чадах, юуг эс чадахыг хоёул дэнсэлж үзье. Үзэгдэхгүй боллоо гээд чимэ анир гаргахгүй явах бололцоогүй учир чагнаж тагнах зэргий нюманд бол тусаар бага байна. Айл тонох, хулгай мэтийн ажил хийхэд бас л тавих юм алга. Намайг барьж авах амаргүй, барьсан хойноо шоронд хийхийн зовлон алга. үзэгдэхгүй чанар маань хоёрхон их давуу талтай байна. Бултаж зайлах, мярааж ойртоход л сайн. Ийм учраас ялангуяа хүн алах л их амархан. Ямар ч зэвсэгтэй хүнээс бултан зайлж, тойрч очоод дуртай газраа цохиод дуртай зүг рүүгээ арилчихна.

Кемп сахлаа имэрч:

-Дор юун чимээ гарав? Гэхэд

-Алах л хэрэгтэй болно доо, Кемп ээ!

-Тийм болох нь ээ, би таны ярьж байгааг анхааралтай чагнаж байна. Гэсэн ч юун төлөө хүн алах юм бэ? Би энүүнийг чинь зөвшөөрөхгүй!

-Дэмий юунд алах вэ, зорилготой бодлоготой ална л даа. Үл үзэгдэгч хүн бий гэж хүмүүс мэдэж байгаа. Чи бид хоёр шиг л мэдэж байгаа. Одоо хядлага хийх хэрэгтэй байна. Гайхах юмгүй, би үнэнэсээ хэлж байна, хядлага хийх хэрэгтэй байна. Үл үзэгдэгч хүн танай Бердокорхуу ийм нэг хотыг эзлэн авч тэнд ноёрхох ёстой, алж хядаж байгаад ч гэсэн эрхэндээ цөмийг оруулах ёстой. Зарлиг тушаалыг өөрийн санаснаар гаргана. үүнийг мянга түмэн аргаар биелүүлж болно. Үүд хаалганд бичиг сачиг нааж байгаад ч гэсэн. Үгэнд орохгүй бүрий нь алах хэрэгтэй, өмөөрсний ч албал зохино.

-Хм гэж Кемп дуугарсан боловч Гриффиний үгийг сонсохоосоо дор үүд нээгдэх чимээг илүү сонирхон сонсож байв.

-Гриффин, тэгвэр таны туслагч хүн яггүй хүнд байдалд орох нь ээ? гэж Кемп түүний үгийг анхааралтай сонссон царайлж асуухад,

Миний туслагч гэж хэн ч мэдэхгүй гэж Гриффин тас зөрөн хэлснээ гэнэт зог тусан- Хүүе юу болж байна? гэв.

-Юу ч болоогүй байна гэж Кемп хариу болгоод чанга дуугаар: -Гриффин, би таны бодолтой санал нийлж чадахгүй ээ. Нээрэн чадахгүй нь. Болж бүтэхгүй юмыг дэмий мөрөөдөх хэрэг юу байна? Танд жаргал болох гэж үү? Хөдөөгийн хөх чоно адил болж яах юм бэ. Та нж олсон зүйлээ зарлаж тунхагла, дэлхий даяар тунхаглахыг хүсэхгүй байгаа бол өөрийнхөө үндэстний дотор зарла. Олон сая хүн танд тусалбал хичнээн их зүйлийг хийж чадах вэ гэдгээ бод, гэв.

Үл үзэгдэгч хүн Кемпийн яриаг таслан:

-Шатаар хүн явж байна гэж аяархан хэлээд

-Үзээд ирвэ гэж гараа сунган үүд рүү явахад Кемп:

-Юу л байв даа гэж хэлээд түр тээнэгэлзснээ гүйж очоод өмнө нь хөндөлдөв. Үл үзэгдэгч нь давхийн цочсоноо зог тусан:

-Урвагч! гэж хашгирав. Дээл нь сандал дээр палхийн уналаа. Мань эр хувцсаа тайлж байгаа бололтой. Кемп үүдний зүг яаравчлан хэд хэд алхтал хашгиран харайв. Кемп үүдээ цэлийтэл нээхэд дороос хүмүүс гүйлдэг ирж байгаа хөлийн чимээ болон ярилцах чимээ тодхон дуулдана.

Кемп, үл үзэгдэгч хүйг хажуу тийш түлхээд гудпманд гаран хаалгаа хав хийтэл хаалаа. Түлхүүрээ урьдаас гадна нь шургуулсан байжээ. Тийм учраас Гриффин тэр тасалгаанд ганцаар цоожлогдох байсан боловч түлхүүрийг мөчид шургуулсан байсан тул үүдийг чанга түлхэхэд доргионд нь түлхүүр хивсэн дээр харжигнан унав.

Кемпийн царай зэвхий дааж хоёр гараар хаалганы бариулаас барьж дарсан боловч хүчинд автагдахад хаалга нь зургаан ямхын төдий онгойв. Кемп хүчлэн хааж орхилоо. Дараа нь хаалга дахин хагас алд хэртэй онгойход завсраар нь улаан дээл цухуйн гшарч ирээд үл үзэгдэгч гар Кемпийн багалзуураас зууран авахад Кемп амиа хаацайлахын эрхэнд хаалганыхаа бариулыг тавьжээ. Гэтэл түүнийг шатны тавцангийн булан хүртэл хүчтэй түлхэв. Хоосон дээл толгойг нь бүтээлээ.

Шатан дээр Кемпээс захиадл хүлээн авсан Бердкийн цагдаагийн хурандаа Эдай зогсож байжээ. Эдай, Кемпийг тийнхүү гэнэт гарч ирсэн, бас хувцасны зүйл хөндий хөдөлж савчин байхыг хараад их айжээ. Харсаар байтал нь Кемп унаж тусаад явах гээд ганц алхмагцаа шалан дээр дахин ойчиж байв. Гэтэл өөрийн нь нэг юм гэнэт хоосон газраас цохиод орхив. Биен дээр нь нэг их хүнд юм унах шиг болжээ. Ямар нэг хүний гар багалзуурдаж, бас ямар нэг хүний өвдөг нь цавь руу нь ёворсон тул эрхэм хурандаа шатаар онхолдон ойчив. Нуруун дээр нь үл үзэгдэх хөл гишгэж, шатаар нүцгэн хөлний пад пад явах чимээ гарахад үүдний өрөөнд байсан хоёр цагдаа хоёул дуу алдан зугтав. Орох хаалга тархийн чанга хаагдлаа.

Хурандаа өндийн босож суугаад ийш тийш мэл гайхан харвал дээрээс Кемп доголсоор ирж байх бөгөөд хувцас хунар нь хог шороо болж, үнгэгдэн навсайж, өрөөсөн хацар нь хөхөрсөн байв. Уруул нь шалбарч цус урсаж байна; гартаа улаан хүрэн дээл, бас бус юм барьжээ.

-Ай бурхан минь! Золигтлоо. Явчлаа шүү, өнөөх минь! гэж хашгирав.

ҮЛ ҮЗЭГДЭГЧИЙН ХОЙНООС ХӨӨЦӨЛДӨВ

Кемп эхэндээ даанч авцалдаагүй яаруу сандруу ярьсан тул Эдай дөнгөж сая яах ийхийн зуургүй болоод өнгөрсөн явдлын учрыг олж чадсангүй. Тэд шатны давцан дээр зогсох бөгөөд Кемп, Трифориний тайчиж орхисон хачин өмсгөлийн зүйл гартаа барьж сандчин ярина. Эдай одоо л чухам юу болсон учрыг ойлгож эхэллээ. Кемп,

-Ээ тэр бол галзуу, хүний үнэргүй, маш хэрцгий, хар амиа бодсон этгээд, өөрөө л олз омогтой, өөртөө л амар байвал бусдыг юман чинээ үздэггүй хүн, ганц амиа боддогоо надад өнөө өглөө илэн далангүй ярьж байсан юм... аанай хэд хэдэн хүн зэмдэглэжээ. Амжиж арга хэрэглэхгүй бол хүн алахаас ч буцахгүй амьтан. Сүйд

хийнэ. Яахаас ч буцахгүй, түүнийг юу ч дийлэхгүй болно. Одоо галзууртлаа уурлаад зоргондоо яваа!

-Барих л хэрэгтэй юм байна гэж Эдай хэлэв.

-Яая гэж бодож байна? гэж Кемп хэлсэн даруй толгойд нь янз янзын бодол төрж –Та нар шалавхан хөдөлж үз. Та хөдлөх хөлтэй, үзэх нүдтэй эрчүүлийг хөдлөг. Энэ хавиас бүү гарга. Гаргачихвал газар сайгүй явж, дуртай хүнээ алж сүйдэлнэ шүү, тэгнэ гэж байсан хүн. Цуст яргалал хийх гэж байгаа этгээд би худал хэлж байгаа юм биш шүү! Бүх зам харгуй, хөлөг онгоц, галт тэргийг хянаж шалгах хэрэгтэй. Хүчин туслалцуулахаар цэргийн анги дууд. Цахилгаан явуулж туслалцаа шаардах хэрэгтэй. Өөрийнхөө туйлын эрхэмлэдэг тэмдэглэл бүхий хэдэн дэвтрээ яаж ийгээд олж авах санаатай энд хоргодож магадгүй. Энийг танд хэлчихье! Танай цагдаагийн газар Марвел гэдэг нэг хүн бий!

-Мэднэ, мэднэ. Бас дэвтрий нь ч мэднэ. Харин тэр тэнүүлч... гэж Эдай хэлэхэд:

-Өөртөө байхгүй гэж байна лээ. Тэнүүлчид л байгаа гэж бодож байна билээ. Нөгөөтэйгүүр юм идэж уух, амарч, унтах бололцоо олгохгүй байх хэрээгтэй. Орон даяар өдөр шөнөгүй сэрэмжтэй байх хэрээгтэй. Идэш уушны бүх зүйлийг цоожилж, эвдэхээс нааш авахын аргагүй болго. Орох ч газаргүй болговол зохино. Тэнгэр биднийг тэтгэж хур бороотой хүйтэн шөнө болоосой. Энэ нутгийн хүн толгойтой болгон түүнийг нэхэж, цөхрөлтгүй хөөцөлдвөл таарна. Эдай, тэр хүн гамшиг зовлон учруулах аюултай этгээд шүү! Тэрүүнийг одоохон барьж хор хөнөөлгүй болгохгүй бол ямар ч муу юм болж мэднэ!

-Тэгвэл одоо яах вэ? гээд Эдай-Ямар ч болтугай би одоохон явж зохион байгуулъя. Та ч гэсэн цугтаа явна байгаа? Явъя явъя! Очоод цэргийн зөвлөлгөөнөрхүү юм хийж Хописоор, бас төмөр замын эздээр туслуулъя. Бүү үзэгд! Түргэлье! За явъя, замдаа ярилцъя. Өөр яах вэ? Наадхи барьж байгаа юмаа хая цаашаа яах юм гэв. Тэгээд Эдай шатаар түрүүлэн буухад урд хаалга нь онгорхой байсан бөгөөд цаана нь зогсох цагдаа нар хий хоосон руу ширтэж нэг нь

-Өнөөх чинь гараад явчсан гэхэд Эдай:

-Шцулууухан яваад ерөнхий газар очье. Та нары нэг нь одоохон түрүүлж яваад нэг морин тэрэг явуулаад орхи, бушуул! Тэгэхлээр одоо, Кемп ээ, одоо яах вэ? гэв.

-Нохой, нохой ол! Олж харахгүй ч гэсэн үнэртээд мэднэ шүү дээ! Нохой ол! гэж Кемп санал тавилаа. Эдай:

-Зүгээр, олон хүн мэдэхгүй нэг нууц хэлье. Холстедийн шоронгийн удирдах газрынхан үнэрч нохойтой хүн байдгийг мэддэг юм гэнэ билээ. Нохой ч яахав болох байх. Өөр яах вэ?

-Идсэн уусан юм нь шингээгүй цагт үзэгддэг гэж байгаа! Тийм учраас цаадхи чинь хоол идчихээд нэг газар нуугдах болно. Та нар мөрдлөгөө зогсоож болохгүй. Бөглүү далд, өнцөг бүрийг нарийвчлан хрж, эрж хайх хэрэгтэй! Зэр зэвсгээ, зэр зэвсэг болж болох аливаа зүйлсийг далд хийх хэрэгтэй. Тийм юм биедээ удаан авч

чадахгүй. Тийм учраас шүүрэн авч болох бэлэн зэлэн юм болгоныг далд хийх хэрэгтэй гэж Кемп хэлэхэд Эдай:

-Энэ бас зүйтэй шүү. Чамайг барихаа л барина даа.

-Бас зам дээр нь... гэж Кемп хэлээд, түгдрэхэд Эдай:

-Юу гэнэ ээ? гэж яаран асуухад цаадхи нь:

-Буталсан шил асгавал, нүнжиггүй нь нинжиггүй ажил, гэхдээ тэр хүн яаж ч магадгүй юм шүү дээ! гэв.

Эдай чиш-ш гэснээ

-Арай ч дэндүү хүний үнэргүй юм болох бай, Мэдэх юм алга. Гэвч би буталсан шил бэлдүүлье. Дэндвэл олоо яая гэх вэ гэлээ.

-Тэр бол хүн чанараа алдсан амьтан гэдгийг танд дахин хэлье. Эндээс зайлан гарч амсхиймэгцээ л алж хядах санаагаа гүйцээнэ гэж би лав бодож байна. Энэ тухай би одоо танд хэлж байгаа шигээ хатуу итгэж байна. Бидний ганц горьдлого бол түүнээс урьтах явдал мөн. Тэр чинь өөрөө өөрийгөө хүн төрөлхтнөөс тусгаарласан юм. Тэгэхлээр өөдөө хаясан чулуу нь өөрийнх нь толгойг цусдаг.

ВИКСТИДИЙГ АЛАВ

Үл үзэгдэгч хүн Кемпийнхээс галзуурах дөхөн гарч одсон бололтой. Даман хаалганы дэргэд тоглож байсан нэг хүүхдийг зам дээрээс зайлуулах гэж шүүрч аваад шидчихсэн нь шагайгий нь булгалжээ. Тэрнээс хойш, хэдэн цагийн турш хаанач байгаа нь ер мэдэгдсэнгүй. Хаа, юу хийж явааг нь хэн ч мэдэхгүй байна.

Гэвч зургадугаар сарын аагим халуун тэр өглөө ухаа өгсөн гүйж цааш нь Порт-Бердокийн нүцгэн талаар хувь тавилангаа харааж зүхэн явсаар эцэст өлсөж цангаж эцэж туйлдаад хүн төрөлхтнийхөө эсрэг дахин хорон санаа боловсруулах санаатй Хинтондины шугуйд орж хоргодсон бол уу хэмээн тааварлаж болох байжээ. Тэнд л хорогдсоноос зайлахгүй, яагаад гэвэл өдөр хоёр цагийг алдад мань хүн тэнд байгаа балчиг муухай явдлаараа илчилсэн байв.

Тэр үед түүнтэй сэтгэл санааны байдал ямаршуу байсан бол, яая гэж бодож байсан бол, мэдэхэд бэрх байлаа.

Кемп итгэлий нь эвдсэнэс түүний уур хорсол бадарсан нь эргэлзээгүй.

Кемпийн ч ингэсний бид аргагүй зөв гэж ойлгохын хамт үл үзэгдэгч хүнийг ч бас арга байж уу хэмээн зарим талаар зөвтгөж болох юм.

Кемпээр туслуулан аллага хялага хийнэ гэж бодож байтал хэрэг ядал өөрөөр эргэмэгц анх Оксфорд гудамжаар ороод явж байснаасаа дутахгүй их балмагдан зовж явсан байх. Ямар ч гэсэн үдийн алдад ор сураггүй алга болж хоёр цаг хагас хүртэл юу хийж явсны нь хэн ч мэдэхгүй байв. Түүний ийнхүү зүгээр байсан нь бусад хүмүүст завшаан байсан боловч өөрт нь гай болжээ. Тэр хооронд олон хүнийг

дайчлан гаргажэ. Өглөө үл үзэгдэгч хүн үлгэр домог мэт санагдаж байсан бол одоо Кемпийн ажил хэргийн чанартай сүрхий гэрчилж ярьсны улмаас тэр хүний аюултай этгээд гэж мэдэж авсны дээр бас түүнийг шархдуулж барьж аваад устгаж болох юм байна гэдгийг ч мэдэж авсан байна. Тулалдаанд газар сайгүй маш түргэн бэлтгэж эхлэв. Зөвхөн хоёр цагаас өмнө тр ямар нэгэн галт тэргэнд сугаад явчихаж болох байв. Гэтэл хоёр цагаас хойш чингэх аргагүй болжээ. Саутгемптон, Винчестр, Брайтон болон Хоршийн хоорондхи дөрвөлжилсөн эх нутгийн замаар явах бүх суудлын галт тэрэгний үүд хаалгыг түгжиж ачааны галт тэрэг явуулахыг бараг бүрмөсөн больжээ. Дорт-Бердокын эргэн тойрон хорин бээр өргөн газар буу барьсан, нохо дагуулсан хүмүүс гурав дөрвөөрөө нийлж төмөр зам, тал хөндийгүй эрэлд гарчээ. Морьтой цагдаа нар давхилдан, айл бүрийн үүдэнд очиж үүд хаалгаа түгж, буу зэвсэггүй гэрээсээ цухуйж хэрхэвч болохгүй гэдгийг хүмүүст анхааруулж байв. Бга сургууль өдрийн гурван цагт хичээлээ завсрлаж, айж цочсон хүүхдүүд хэсэг хэсгээрээ гэрийн зүг яарцгаана. Дарав таван цагийн алдад үзвэл Эдайн гарын үсэг зурсан Кемпийн уриалгыг энд тэндгүй наасан байв. Тэр бичигт үзэгдэхгүй хүнийг нойр хоолгүй байлгах хийгээд түүнтэй тэмцэх аргыг товч тодорхоы заажээ. Түүнчлэн ямагт сонор соргог байж, түүний хаана байгаа талаар шинж илэрмэгц нэ даруй мэдэгдэхийг шаардсан байна. Засаг, захиргааны байгууллагуудаас ийм жигтэйхэн амьтан үнэхээр байна гэдэгт хүмүүсийг итгүүлэн маш шаламгай шийдэмший ажилласан тул шөнө болохын хэрд тэр хэдэн зуун шоо дөрвөлжин бээр нутаг гзрын хүмүүс цөм хорьсон байдалтай болсон байлаа. үдшийн бүрий болж байх үеэр айж тэлмэж айсан олон түмэн Викстидийг алчихжээ гэсэн аймшигт мэдээг хүн хүний амаар дамжин сонсчээ.

Үл үзэгдэгч хүний Хинтондийн шугуйд бүгсэн байж магадгүй гэсэн таавар үнэний хувьтай байсан бол тэр хүн үд дундын үеэр зэвсэг хэрэглэн ямар нэг хэрэг үйлдэх зорилготой тэндээсээ дахин гарч явсан байх ёстой.

Тэрхэн үед юу бодож явсны нь бид мэдэхгүй боловч Викстидтэй уулзахаас өмнө урт бөөрөнхий төмөр барьж явсан нь миний л бодоход лав гарцаагүй. Чухам яасан ийсэн болохыг бид яаж мэдэх билээ. Уг хэрэг Бердок ноёны эдлэнгийн хаалганаас хоёр зуугаад алхам зайтай орших хайрганы задгай уурхайн эрэг дээр болжээ.

Викстид олон газар шархдаж, таяг нь хугарч, хөлийн ором мөр чийрлэн үлдсэн зэргийг үзвэл амь тэмцэн ноцолджээ. Харин яах гэж алсан шалтгааны нь мэдэх бололцоо алга. Гэвч энэ бол ухаан балартаж солиорсны гэрч бизээ. Викстид бол нас дөчин тав зургаатай, Бедок ноёныд даамлын албатай, зан авиры хувьд хэнд ч гэм хоргүй, мөрөөрөө явдаг, хүний зэвүү хүргэж хэрүүл зодоонд хүрэх тийм хүн огт биш ажээ.

Үл үзэгдэгч хүн эвдэрхий хашаанаас сугалан авсан төмөр саваагаа зэвсэг болгон хэрэглэжээ.

Үдшийнхээ хоолыг идэх гэж гэр лүүгээ тайван алхаж явсан тэр томоотой хүнийг дайран довтолж гары нь хугалан дайрч ойчоод гавлы нь бяц цохижээ.

Грффин, Викстидтэй тааралдахаасаа өмнө тэр төмрийг хашаанаас сугалж аваад явж байсан байх л даа. Дээр өгүүлснээс гадна өөр хоёрхон зүйлийг нэмэн хэлбэл уг хэргийг бага сага тод болгох байна. Нэг нь тэр хайрганы задгай уурхай бол

Викстидийн харих зам мөрд байдаг биш харин түүний замаар хоёр зуу орчим алхам гажуу байдаг ажээ. Нөгөө нь үдээж хойш хичээллэдэг, сургуулийн сурагч нэг жижиг бүсгүйн хэлснээр бол Викстид тэр задгай уурхайн зүг хөлөө чирэн их л хачин явж байхы нь харсан гэнэ. Тэр охины дүрслэн ярихы нь анхаарвал Викстид газраар нэг юм хөөцөлдөн тэрнийгээ гэн гэн таягаараа цохиж байх шиг байжээ. Тэр Охин Викстидийн амьд байхыг үзсэн хамгийн сүүлийн хүн юм. Викстид тэр хавийн нэг жаахан хонхор газар бөөн модон дотуур ороод үзэгдэхээ больж тийнхээ үхлээ үзсэн бололтой.

Ингэхлэр тэр хүнийг яах гэж алсн учир шалтгааныг энэ тууж ичиж байгаа би л лав огт тухайлахгүй байна. Гиффин тэр төмөр савааг зэвсг болгон хэрэглэх гэж авсан явсан нь магадгүй боловч харин заавал хүн алах гээгүй байж болох юм. Викстид тийм төмөр савааг гэнэт хий агаарт өөрөө хөдлөн явахыг олж харсан байж магадгүй, ер нь Бердик боомтноос арваад бээрийн зайтай энэ газрын хүн, үл үзэгдэгч хүн байна гэдгийг сонсоогүй байгаад тийм үл үзэгдэх хүчээр юм хөдлөхийг харахтайгаа зэрэг хойноос нь сонирхон хөөсөн байж юун магад! Цаад хүн бусдад мэдэгдчихгүйг бодоод айвуу тайван зайлж явтал Викстид, түүний авч яваа юмыг олж харан гайхаж хачирхаад хойноос нь дагасаар таягаараа цохиод үзсэн байж ч юун магад.

Жирийн нөхцөлд байдалд бол үл үзэгдгч хүн, тэр хүнээс зайлаад ячихаж ядаж цөхөх юм ер байхгүй билээ, гэтэл түүний үйл лайгаар үл үзэгдэгч явсаар хаашаа ч гарахын аргагүй нэг их хонхор нүх халгай руу ороод явчих дөхжээ. Үүнийг яагаад мэдэв гэвэл Викстидийн хүүр байгаа газрын байдлаас үзэхэд тэгж санагдлаа.

Гэвч энэ бүгд маань дан таавар байгаа юм. Хүүхэд багачуудын ярьсанд итгэхийн аргагүй байдаг болохоор гарцаагүй үнэн баримт нь Викстидийн хүүр бас халгайн дунд хаягдсан, цус нөж болсон төмөр саваа л байгаа юм. төмөр саваагаа тэнд хаячихаад явчсаны нь бодоход Гриффин урьд бодож төлөвлөж явсан юм байсан бол тэр бодлоо ийм явдал болсны дараа орхисон бололтой Гриффин хэдий хар амиа бодсон, чулуу шиг зүрхтэй хүн гэвч анхных нь алагдаж буй хүн нь цус нөжөө гоожуулан, нүднийх нь өмнө тарчлахыг үзээд өрөвдөх гэгчийг аль хэдийн больсон өр зүрх нь бага зэрэг халирч түрүүн шийдсэн бодлоо орхисон байж магадгүй.

Үл үзэгдэгч Викстидийг алчихаад дов толгодын зүг зугтсан бололтой. Ферн Боттомын ойрхи тариалангийн талбай дээр ажил хийж байсан хоёр хүн тэр орой нар жаргахын алдад хүн байн байн мэгшин уйлах, инээх ёолох, хашгирах чимээ гарахыг сонссон гэжээ. Тэдэнд тийм юм дуулдах лав аятайхан байгаагүй бизээ.

Тэр хүний дуу хошоонгорын талбайн тэг дунд хавиас сонсогдон дов толгодын бэлд замхарч байжээ.

Кемп, итгэж ярьсныг нь нэн даруй ашигласныг үл үзэгдэгч хүн мэдсэн байх ёстой. Үүд хаалга бүхэн хаалттай түгжээтэйгээ биз. Төмөр замын өртөө, дин буудлуудаар явж үзээ л биз, энд тэндгүй наасан бичиг уриалгыг үзэд өөрийнхөө эсрэг ямар их аян дайн эхэлснийг ойлгосон байх ёстой. Үдэш болоход зэвсэглэсэн хүмүүс гурав дөрвөөрөө энд тэндгүй хөлхөж бас ноход хуцан хүн агнах анд гарсан тэц дайсан этигээдтэй дайралдвал бие биедаа яаж туслалцаа үзүүлэх талаар тусгай заавар авсан байжээ. Гэвч үл үзэгдэгч хүн тэднээс буруулсаар байгаад. Тэр хүн хамаг үнэнээ тоочиж ярьчихсаныхаа уршгийг одоо амсаж байгаадаа хичнээн их

цухалдан байгааг бид гадарлаж болох байна. Тэрд өдөр Викстидтэй тулалдсаны нь эс тооцвол бусад цагт нь үл үзэгдэгч хү шархдсан араатан шиг мөрдөгдөж байсан болохоор сэтгэл санаагаар лав унаж авсан байхр. Харин тэр шөнөдөө юм хүм олж идэж уугаа амарч унтсан бололтой. Яагаад гэвэл, мргааш өглөө нь үл үзэгдэгч хүн дахин зориг орж уур хилэн, хорсол занал нь бадарч, хүн чадал, заль мэхээ хэрэглэн энэ ертөнцтэй халз үзэлцэх сүүлчийнхээ их тулалдаанд бэлдсэн байжээ.

КЕМПИЙН БАЙШИНГ БҮСЛЭВ

Тос болсон цаасан дээр харандаагаар бичсэн хачин захидал Кемпэд иржээ. Түүнд бичсэн нь “Та их мэрийж, их ч удаан сийлжээ. Гэвч та юу горьдож ингэснийг чинь би мэдэхгүй байна. Та намайг дайсагнаж, нойр хоолгүй байлгах гэж бүхэл өдрийн турш оролдлоо. Гэсэн ч би хоол унд идэж уусан, амарч унтлаа. Одоо би юу хийхээ үзүүлэх болно. Одоо л тоглоомоо эхэлж байна гэж мэдээрэй. Алж талж эхлэхээс өөр арга алга боллоо. Өнөөдөр аллагын анхны өдөр шүү. Порт-Бердок одоо хатан хааны мэдлээс гарч, миний эрхэнд орсон гэж чи, цагдаагийнхаа хурандаа болон бусдадаа хэлээрэй! Өнөөдөр үл үзэгдгч хүний үе эхэлж байгаа анхдугаар жилийн анхдугаар өдөр гэж мэдээрэй. Би анхдугаар үл үзэгдэгч хүн мөн. Миний захиргаа эхлээн зөөлөн байх болно. Анхны өдөр жишээ болгож Кемп гэгч нэг хүний амиийг авна. Түүний үхэх цаг өнөөдрөөс эхэллээ. Хаалга үүдээ хааж түгжлээ ч, энд тэнд нуугдсан ч хуяг бамбай өмчлөө ч, харуул цэргээр мануулсан ч үхэл, үл үзэгдэгч үхэл чам руу очиж яна. Байдаг бүх арга чаргаа хэрэглэвэл хэрэглэг, тэгэх тусам миний харъяат нарт улам сайн ойлгогдох болно. Үхэл өнөөдөр үд дунд шуудангийн хайрцагас эхэлнэ. Шуудан зөөгчийг яг ирэхийн өмнө шуудан хайрцагт захиа ороод цааш явна даа! Тоглоом эхэлсэн шүү! Үхэх цаг ирсэн. Миний харъяат нар амиа үрэхэд хүрэгүйн тул Кемпэд битгий туслаарай. Кемп өнөөдөр үхэх ёстой” гэжээ.

Кемп тэр захидлыг хоёр дахин уншаад- Энэ ч тоглоом биш шүү! Түүний үг мөн. Хийх гэснээ л хэлж буй амьтан гэлээ.

Кемп , дугтуйн ар талыг үзвэл “Хинтондин”, “Хоёр мөнгө төл” гэсэн шуудангийн тэмдэг байлаа.

Тэр захидал үдийн нэг цагт Кемпийг бага үдийнхээ хоолыг идэж байхад нь ирсэн тул мань эр хоолоо дутуу орхиод дээш гарч ажлынхаа өрөөнд ороод нярав авгайгаа дуудаж, одоохон гарч байшингаа эргэн тойрон явж бүх цүү цуурга, цоож түгжээг ашлга, цонхны хаалт модуудыг хаа гэв. Харин ажлынхаа өрөөний цонхны хаалтыг Кемп өөрөө хаажээ. Унтлагынхаа өрөөнд байгаа цоожтой хайрцагнаас жижигхэн гар буу гарган авч нарийчвлан шалгаж үзээд гэртээ өмсдөг хөвөнтэй тоодгор цамцныхаа халаасанд хийв. Тэгээд хэд хэдн зурвас бичив. Нэгий нь хурандаа Эдайд бичжээ. Тэдгээр зурвасаа зарлагадаа өгч эздэд нь хүргүүлэх болов. Кемп түүийг байшингаас гарч явахдаа ямархаалгаар яаж гарч барих талаар маш нарийн заавар өгчээ.

-Аюул байхгүй гэж кемп хэлээд “Танд” гэдгий нь хэлэлгүй дотро бодов. Ингээд нэг хэсэг бологошрон сууснаа хөрч үлбийсэн хоолоо идэхээр буув. Кемп хоолоо идэхдээ бодол болж алмайран сууж байгаад гэнэт зангидсан гараар ширээгээ хүчтэй цохиж,

-Чамайг барьж авахаа л авна! Би урхи нь болууж. Дэндүү даврах нь! гэж өндөр дуугаар хэлэв.

Тэгээд өөдөө гарахдаа хамаг үүд хаалгаа хичээнгүй түгжиж байжээ.

-Тоглоом. Ер бишийн тоглоом юм. Эрхэм Гриффин чи үзэгдэхгүй, зоригтой ч гэсэн дийлэх хувь тавилан миний талд байна. Гриффин ганцаараа бүх дэлхийн эсрэг өс хонзон авах гэнэ! гэж Кемп ганцаар ярина.

Тэгээд цонхныхоо дэргэд зогсож наранд налайн дуниартах уулын бэл ширтлээ.

Өдөр бүр идэх юмны хойноос хөөцөлдөхгүй тэр хаа зайлах вэ. Атаархмаар ч юм алга даа. Урьд шөнө тайван унтлаа гэдэг нь үнэн болуу? Гадаа хүн амьтны хөлгүй газар олсон байх нь ээ... Ийм халуун шатахын оронд гайгүй сайн хүйтэрч, цас бороо ордог ч болоосой... Намайг одоо ч гэсэн яг хараад зогсож байж ч магадгүй еэ гэж Кемп бодон цонхондоо бүр тул очсоноо цочиж ухасхийв. Цонхны жаазны хана руу нэг юм сүрдхийх шиг болжээ.

-Мэдрэл маань баахан үймж байгаа юм байна гэж Кемп аман дотроо хэлээд таван минут хэртэй хөдлөлгүй зогсож байснаа цонх руугаа дахин очиж –“Бор шувуу байсан байх нь ээ” гэв.

Гэтэл үүдний хонх дуугармагч нарийвчлан очиж дэгээ мулталж түлхүүрээ эргүүлэн гинжийг ажиглан харж бэхлээд өөрөө хаалганы хацрыг ар талд орж аяархан онгойлгосхийтэл таитл хүний дуу гарсан нь хурандаа Эдай байлаа.

-Танай шивэгчинг дайрсан байн гэж Эдай үүдний цаанаас хэлэхэд Кемп:

-Юу? гэж дуу алдав.

Таны явуулсан зурвасыг булаагаад авчээ. Өнөөх чинь энэ хавьд л байгаа юм байна. Алив намайг оруулаач.

Кемп дөнгөж Эдайн бие багтахаар сулруулан түүнийг ормогц хаалгаа түгжин санаа амарсан байдалтай шүүрс алдав.

-Зурвасыг гараас нь булаан авчээ. Таны зарц их айсан байна. Одоо миний хэсэг дээр байгаа, галзуурах шахжээ. Өнөөх чинь энэ хавиар байгаа юм байна. Чи юу гэж бичсэн юм бэ? Кемп хараан зүхэж

-Миний тэнэгээс л боллоо. Эндээс Хинтиндин хүртэл цаг хүрэхгүй явдаг шүү дээ. мэдсээр байж! Аанай ирчихсэн байх нь! гэхэд Эдай

-Юу болоо вэ? гэж асуув. Кемп:

-Үз л дээ! Эдайг ажлынхаа тасалгаа руу аваачиж үл үзэгдэгч хүний бичсэн захидлыг гардууллаа. Цаадхи нь уншиж үзээд шагшран

-Та тэгээд яав даа? гэвэл

-Би уг нь түүнийг барьж авах урхи зохиосон юм. Тэрнийгээ шивэгчингээрээ та нарт явууллаа гэсэн чинь түүний гарч оруулчихдаг мангуу байжээ. Эдай түүний харааж зүхэхийг тэсвэртэй сонсож байгаад:

-Зугтаад алга болох юм байна гэхэд Кемп:

-Үгүй зугтахгүй гэлээ.

Гэтэл хангинах чимээ гарч шил хагарав. Эдай, Кемпийн халаасанд жижигхэн гар буу цухуйж байгааг ажив.

-Ажлын тасалгаа хавьд дуугарав! гэж Кемп хэлэд шатаар түрүүлэн өгстөл нь бас чимээ гарлаа. Ажлын тасалгааны гурван цонхны хоёр нь хагарч шалан дээр нэл хагархай шил болж, бичгийн ширээн дээр нь нэг том чулуу унасан харагдана. Тэр хоёр эвдэрч хэмхэрсэн байдлыг хараад хараад босгон дээр зогсож байна. Кемп бас хараал тавьтал гурав дахь цонх хага үсэрч буу дугарах шиг чимээ гарч шилний хагархайнууд шалан дээр нь бус үсрэв.

-Яах гэж ингэж байгаа юм бол? гэж Эдай асуухад Кемп:

-Эхэлж байгаа нь энэ байж гэнэ

-Ороод ирэх бололцоо байхгүй биз?

-Муур ч орох зайгүй.

-Хаалт модгүй юм уу?

-Энэ өрөөнийхөд байхгүй.Доод талын өрөөнүүэд... Аяа! Шал хагарах чимээ бас дор дуулдаж байна.

-Чөтгөр аваачсан золигийг, энэ лав унтлагын өрөөнийх байх. Байшинг цөмийг нь эвдэх санаа хадгалжээ.Тэнэг амьтан. Хашилт мод хаалттай, шил нь гадагшаа унана. Хөлөө зүсэв дээ.

Бас нэг цонхны шил хагарах чимээ гарлаа. Кемп Эдай хоёр нэг яах учраа мэдэхгүй шатны тавцан дээр зогсож айв.

-Надад нэг муна юм уу, тиймэрхүү нэг юм аль. Би захиргаан дээр очоод нохой ирүүлье. Тэгээд бариад авъя. Үнэрч ноход ирүүлье гэж Эдай хэлэв.

Бас нэг цонх хагарах чимээ гарлаа.

-Гар буу байхгүй юу гэж Эдай асуухад, Кемп халаас руугаа гараа явуулж хулчганав:

-Байхгүй, Ямар ч гэсэн илүү юм алга гэнэ.

-Би буцааж өгнө шүү дээ. Танд одоо айх юм алга гэхэд Кемп ичсэндээ гар буугаа өгөв.

-Одоо үүднээ нээе, явъя гэж Эдай хэллээ. Тэр хоёрыг үүд рүү очиж зориглдохгүй тэр хавьдаа эргэлдэн байтал доод давхрын нэг цонх бас хагарах чимээ гарав. Кемп үүдэндээ сэмээрхэн очиж дэгээгий нь аль болох болгоомжтойхон тайллаа. Царай нь ердийнхөөсөө нэлээд цайсан байв. Тэгээд

-За шулуухан гараад яв гэхэд Эдай түргэн гарч довжоон дээр хүрэхэд Кемп үүдээ онислов. Эдай үүдийг нуруугаар налан зогсосхийн түр тээнэгэлзэв. Тэгэд биеэ эгцэлж довжооны гишгүүрээр зоригтой алхлан бууж шалбааг гатлан хамар хаалганд дөхөж очив. Өвсөн дээгүүр салхи сэрвэгнэх шиг харагдаад хажууд нь нэг юм хөдлөв.

-Жаахан хүлээ гэж хүн дуугарлаа.

Эдай биеэ хураан гар дахь бугаа чанга атган зогсож бие нь чичрэн, царай нь цайж

-Юу вэ? гэхэд

-Тэр байшиндаа эргэж очвол надад их сайн болох нь ээ гэж үл үзэгдэх хүн Эдай шиг дуугарав.

-Тун тоогүй хэрэг байна гэж Эдай сөөнгөдүү дуугараад, хатсан уруулаа долооно. Хүний дуу зүүн гар талд нь гараад байх шиг санагджээ. Буудчихлаа азаар онож орхих юм биш байгаа гэж бодно. Гэтэл өнөө дуу нь:

-Та хаашаа яах гэж явсан юм? гэв.

Хоёул түргэн хөдлөхөд Эдайн халаасан дахь гар буу наранд гялсхийв.

Эдай санаснаасаа буцаж бодол болж удаанаар

-Хаашаа ч явсан миний дур гэж хэлтэл хүзүүнээс нь үл үзэгдэх гар барьж нуруу руу нь өнцөг тулган ар голоор нь ойчуулав. Эдай бугаа гарган таамгаар буудтал шүд рүү нь хүчтэй юм цохиод бугий нь булаан авав. Эдай бултан зайлж байгаа үл үзэгдэгч хөлнөөс дэмий л шүүрэн барих гэж оролдож, өөрөө босох гэсэн боловч дахин ойчиж

-Золиг! гэж дуу алдахад үл үзэгдэгч хү инээж:

-Би чамайг албал алж орхихоор байна. Ганцхан сумаа л хайрлаж байна гэв.

Эдайн өмнө зургаан тохой орчим зайтай хий агаарт гар бууны ам онгойн харагджээ.

-Яах вэ? гэж Эдай өндийн суунгаа асуухад, үл үзэгдэгч хүн

-Бос гэв. Эдай бослоо.

-Сонсож бай! гэж үл үзэгдэгч хүн хэлээд

-Битгий түвэг удаад бай! Чи миний царайг олж харж чадахгүй байхад би чинийхийг харж байна шүү дээ, сайхан мэдээрэй буцаад яв! гэж зориг шийдэмгий хэлэв.

-Намайг оруулахгүй гэж Эдай өчихөд үл үзэгдэгч хүн:

-Тоогүй хэрэг ээ, чи бид хоёр муудаагүй шүү дээ гэв.

Эдай уруулаа бас л долоолоо. Эдай бууны амнаас дальдарч алсыг харвал үдийн наранд гүн цэнхэр далай алс гялалзан, ногоон торго өмссөн юм шиг дов толгод хад цохиотой цагаан хошуу, хүн олонтой хот харагдахад амьдрал гэгч хичнээн сайхан бэ гэж бодогдов. Тэгээд өөрөөс зургаан тохой шахам зайтай газар агаарт байгаа жижиг төмөрлөг зэвсгийг дахин хараад их л гонсойсон маягтайгаар

-Тэгээд би яах юм бэ? гэж асуулаа.

-Би яах юм бэ гэнэ ээ? Чи надад тус бол. Тэр байшинд л очвол боллоо.

-Оролдъё доо. Намайг оруулбал та миний хойноос орохгүй байх уу?

-Би тантай муудаагүй шүү дээ

Гэртээ үлдсэн Кемп энэ үед яав гэвэл Эдайг гарсан хойно хагархай шилэн дундуур болгоомжтой явж ажлынхаа тасалгааны цонхоор доош хартал Эдай, үл үзэгдэгч хүнтэй ярилцаж байгааг мэдсэн байна.

-Яагаад буудахгүй байна даа гэж Кемп амандаа үглэтэл гар буу өөр тийш шилжиж нарны гэрэлд гялсхийв. Кемп гэрлээс дальдарсан боловч тэр нүд гялбам туяаны хөдөлгөөнийг даган харах гэж оролдлоо. Тэгснээ:

-Ингэдэг бий. Эдай буугаа өгчихвөө! гэнэ.

Гэтэл энэ үед Эдай

-Миний хойноос дагаж орохгүй гэж ам өгөөч. Дийлсэндээ гаарах хэрэггүй. Хүнийг бас бодож үз л дээ гэхэд цаадхи нь:

-Буцаад яв! Чамд ямар ч ам өгөхгүй, шууд хэлчихье гэнэ.

Эдай гэнэт санаа шулуудсан бололтой: Кемпийн байшин тийш эргэж нуруугаа үүрэг аажим алхав.

Кемп тэр хоёрыг ажиглан тэвдэж байлаа. Гар буу наранд нэг гялсхийн нэг алга болон бас дахин гялсхийнэ. Кемп нүднийхээ харааг дайчлан харвал Эдайн ар талд жижигхэн хар юм дагаж явав. Цаашдын явдал гялбаа мэт хурдан болжээ. Эдай гэнэт эргэж үсгэн гар бууг шүүрэн барих гэсэн боловч чадсангүй хүчиндээ газар мөргөж ойчлоо. Гэтэл хөх цэнхэр утаа манасхийв. Кемп буу дуугарах чимээ сонссонгүй. Эдай хэд хэд татваганан хөдөлж өрөөсөн гараа түшин өндийхийг оролдсон боловч нүүрээрээ дахин савч ойчоод хөдлөхөө болив.

Кемп, Эдайн хөдөлгөөнгүй болсон биеийг хэсэг ширтэн харж зогсов. Тэр өдөр халуун бөгөөд салхигүй, ер нь бүх дэлхий хөдлөхөө больчихсон юм шиг санагдана. Хамар хаалга, байшин хоёрын хоорондох бутны дундуур хоёр шар эрвээхэй хөөцөлдөн нисэх харагдана. Эдай, хамар хаалганы дэргэдэх шалбаагийн дэргэд хэвтэж байлаа. Тэр ухаагийн зуслангийн бүх байшингийн цонхны хөшиг буулгаастай бөгөөд гагцхүү ногоон өнгийн нэг жижигхэн сэхээвчинд цагаан юм харагдах нь нэг өвгөн зүүрмэглэн суугаа бололтой. Кемп байшингийнхаа ойр хавиар гар бууны бараа олж харах гэж их л ажиглах боловч алга болжээ. Кемп Эдайг дахин нэг харав. Уг тоглоом сүрхий эхэлжээ.

Нэг хүн хонх дарж гадна хаалгыг нь цхисноо ойр ойр хонхдож улам хүчтэй цохиход Кемп зарц шивэгчин нараа өрөө өрөөндөө түгжээстэй суугаад бай гэжээ. Тэгж тэгж чимээ тасрав. Кемп нэг хэсэг чагнан сууснаа гурван цонхоор гадагш ээлжлэн харав. Параа нь шатан дээрээ их л түгшсэн янзтай чагналаа. Тэгснээ унтлагынхаа өрөөнөөс талынхаа шилээврийг авч зэвсэглэн доод талын давхрын цонхнуудын дотуурхи бүх түгжээг шалгаж үзэхээр явлаа. Цөм найдваратай ба бөх байв. Тэгээд дээш буцаж гарав. Эдай түрүүчийн хэвээр замын хажууд хэвтсээр харагдана. Зуслангийн байшингуудын хажуу замаар нөгөө зарц хүүхэн нь хоёр цагдаагийн хамт ирж яваа харагдлаа.

Цөм нам гүм байв. Кемпэд тэр гурван хүн даанч удаан явах шиг санагдана. Кемп дайснаа одоо юу хийж байгаа бол гэж дотроо бодсоор ажээ. Доод давхарт тар түрхийх чимээ гармагц Кемп гэнэт авхийн цочлоо. Гэнэт бүх байшингийн нь хүчтэй цохин доргиулж мд хугарах чимээ гарч, цонхны хаалтны түгжээ төмрүүд хангинан тар няр хйилээ. Кемп гал тогооныхоо өрөөнд орох цоожийг гаргав. Яг энэ үед цонхы хаалт модны хөрөөдүүлж, огтлуулсан хэсгүүд долтогш бутран унав. Кемп айн сүрдэж балмагдан зогсов. Цонхны жааз нь нэг хөндлөвч эвдэрснээс биш бүтэн байв, харин шил гэх юмгүй хагархай ёзоорууд нь жазны угт арзайн үлджэ. Цонхны хаалтыг сүхээр хэмх цохиж, цонх хамгаалсан төмөр тор, жаазыг хүчтэй хүчтэй нүдэж байв. Гэтэл сүх нь гэнэт хажуу тийш болон алга болов. Байшингийн хажуугаар гарсан нарийн зам дээр гар буу байж байснаа гэнэт хөдлөн үсрэх шиг болов Кемп ухасхийв. Тэгтэл буун дуу гарч Кемпийн хааж байсан хаалганаас мод хотрон толгой дээгүүр нь гарав. Кемп үүдийг хааж цоожлоход Грффин хашгиран инээх сонсогджээ. Дахин сүхдэх чимээ гарлаа.

Кемп ухаан сийлэх снаатай гудмандаа зогсож байв. Үл үзэгдэгч хүн гал тогооных нь өрөөнд одоохон орж ирэх байлаа. Тэр үүд удаан тэсэж чадахгүй тэгээ...

Гадаа хаалганы хонх дуугарлаа. Цагдаа нар байх ёстой. Кемп үүдний өрөө рүү гүйн очиж гинжий нь бэхлээд дэгээг мултлав. Кемп хэн бэ гэж асуун зарц хүүхдий дууг сонсож байж гинжийг тавихад цаадхи гурав нь ум хумгүй чихэлдэн орлоо. Кемп ч үүдээ түгжиж авлаа.

-Өнөөх чинь! Гар буутай байна. Хоёр сум үлдсэн. Эдайг алсан. Лав л буудаад унагачихсан. Шалбаагийн тэнд байхы нь үзсэнгүй юу, тар? Тэнд байгаа гэж Кемп хэлэхэд, нэг цагдаа

-Хэн? Гэхэд

Эдай гэв.

-Бид арын хаалгаар орж ирлээ гэж шивэгчин хариулав.

-Юун чимээ вэ? гэж нөгөө нэг цагдаа нь асуухад Кемп:

-Өнөөх чинь гал тогооны өрөөнд орчихсон юм уу. Ороод ирэх гэж байгаа байх. Сүх олж авсан байна.

Гэтэл гал тогооны үүдийг сүхээр цохих чимээ гэнэт гарлаа. Шивэгчин хүүхэн үүд рүү шагайж харснаа чичрэн дагжаад хулчийн ухарч идээний өрөө рү орлоо. Кемп, юу болсон айдлыг хагас зэрэгдэглэн тайлбарласан болж байв. Гал тогооны өрөөний хаалга эвдрэн нэвтрэн чимээг цөм сонсов.

-Наашаа, наашаа гэв. Кемп хэлээд хоёр цагдааг идээ цайны өрөө рүү оруулав. Өөрөө юу ч хийхээс буцахгүй зориг бадарчээ.

-Шилээвэр! Гэж Кемп хашгираад зуух руу гүйв. Унтлагын өрөөнөөс авчирсан шилээврээ цагдаагийн нэгд нь гал тогооны өрөөнөөс авчирснаа нөгөөдөхөд нь өгөв. Тэгээд өөрөө гэнэт гэдэргэ ухасхийв. Нэгэн цагдаа ухасхийгээд шилээврээрээ өнөөх сүшхийг тээглүүлэн тогтов. Гар буу дуугарч цагдаагийн ханцуйг цоо буудав. Нөгөө цагдаа нь тэ жижигхэн зэвсгийг ял алах гэж байгаа юм шиг цохиход тэр нь шалан дээр түр тархийн улналаа.

Тийнхүү тулалдаан эхэлмэгц өнөөх шивэгчин хашгирч чарлан зуухны дэргэд зогсож байснаа хагархай цонхоор гарч амь зулбах санаатай хаалгы нь авч байлаа.

Өнөөх сүх гудманд гарч шалаас дээш гуруван тохой өндөрт тогтож үл үзэгдэгч хүн их амьсгаадах чимээ дуулдаж байлаа.

-Та хоёр зайлж бай. Наад Кемп л хэрэгтэй гэж үл үзэгдэгч хү хэлэхэд цагдаагийн нэг нь:

-Харин та бид хоёрт хэрэгтэй байна гэж дуу гарсан зүг хэлээд ухасхийн алхаж шилээврээр чичив. Гэтэл үл үзэгдэгч хүн зайлж амжсан тул шилээвэр нь шүхрийн тавиурыг чичив. Тэр цагдаа арай л ойччихсонгүй мунгинаж байтал толгой дээр нь сүх бууж төмөр малгай нь цаасан малгай шиг ялбийн унаад гал тогооны өрөө рүү орох шатаар өнхрөв. нөгөө нэг нь сүхний хойноос нь хөөж таамгаар цохиход нэг зөөлхөн юм тааралдаж ёолох дуу гарч сүх нь шалан дээр уналаа. Цагдаа сүхэн дээр өрөөсөн хөлөөрөө гишгэж байгаад дахин нэг цохисон боловч юм тааралдсангүй. Тэгээд шилээврээ бэлтгэн ямар нэг хөдөлгөөн гарах чимээ чагнан их л анхааралтай зогсов.

Тэгтэл хоол цайны өрөөний цонх нэгдэж хурдан хурдан алхах хөлийн чимээ гарчээ. Нөгөө цагдаа нь нэг хөрвөөд өндийн суухад чамархайнаас нь цус гарч буй харагдлаа. Шархадсан цагдаа:

-Өнөөх чинь хаана байна? гэхэд нөгөөдөх нь

-Бүү мэд. Би онож цохисон. Чиний дэргэдүүр гараад чвчаагүй бол үүдний өрөө хавьд байгаа байх. Доктор! Хүүе! Кемп! гэв. Хариу байдаггүй. Доктор Кемпээ! гэж цагдаа дахин дуудлаа.

Шархадсан цагдаа арайхийн босов. Гэтэл гал тогооны өрөө орох шатаар хөл нүцгэн хүн яваа чимээ гарлаа. Шилээвэр барьсан цагдаа

-Уухай! Гэж хашгираад тэр зүг шилээврээ шидэхэд тэр нь хийн халаагуурын залгааг хага цохижэ. Цааш нь хөөцөлдөх гэснээ больж идээ ундны өрөөнд ороод:

-Доктор Кемп ... гэж шууд эхэлснээ даруй зогсож

-Гайгүй зоригтой эр юм даа, ээ доктор Кемп чинь гэж нөгөө нөхөртөө эргэж харахад нь хэлэв.

Идээ ундны өрөөний цонх цэлийтэл онгойосон байлаа. Шивэгчин Кемп хоёрын аль нь ч алга.

Доктор Кемпийн тухай өөрийн бодлыг хоёр дахь цагдаа товчлон бөгөөд хүчтэй илэрхийлжээ.

АНЧНЫГ АГНАВ

Кемпийн байшин бүслэгдмэл байдалтай болж байхад тэдний хажуу зуслангийн эзэн Хилас сэхэвчин дотроо унтаж байлаа. Хилас бол үл үзэгдэгч хүни тухай “дэмий ярианд” хэрхэвч итгэхгүй байсан цөөхөн хүний нэг юм. Харин түүний гэргий цуу үгэнд итгээд энэ тухай түүнд хожим дандаа ярьдаг байжэ. Хилас гэрээс ер ажиггүй гарч цэцэрлэг дотуураа зугаалан явж байгаад үдийн хоол идсэний араа урьдын дадсан заншил ёсоор унтсан ажээ. үл үзэгдэгч хүн Кемпийн цонхыг хагалан балбаж байхад Хилас санаа амар унтаж байв. Гэтэл нэг л аягүй санагдаж сэрэв. Хилас Кемпийн рүү харж, нүдээ арчих дахин харав. Тэгээд хөлөө буулган суугаад чагнаж үзлээ. Дэмийрч байна уу гэж бодтол хачин юм хэвээр харагдсаар балаа. Кемпийн байшин жигтэйхэн тонуулаад бүхэл сар эзгүй хаягдсан юм шиг харагджээ. Бүх шил цонх нь хагархай, дээд талын өрөөний цонхнуудаас бусад нь цөм дотросоо хаалттай байгаа үзэгдлээ.

Хилас цагаа харж-Хориод минутын өмнө яах аргагүй зүгээр байсан даа гэлээ.

Нлээд хол нэг юм аяар, жигд цохих, шил хагарах чимээ дуулдав. Хиласыг мэл гайхан байтал бүр ч хачин юм харагджээ. Кемпийн хоол ундны өрөөний цонхны хаалт нээгдэн тэдний шивэгчин эсгий малгай, пдальтотойго цонхон дээрээ гарч жаазыг дээш болгох гэж чичргэнэж байв. Гэтэл тэр эмэгтэйн дэргэд өөр нэг хүн хүрч ирээд туслалцлаа. Докирох Кемп байжээ. Төдхөн цонх нээгдэж, оноох шивэгчин гарч ирээд гүйсээр бутан дотор орж нуугдав. Хилас тийм хачин юм болж байгааг харж гайхсандаа босож учяир нь лдохгүй юм үглэж байв. Түүнийг харсаар байтал Кемп цонхны тавцан дээр гарч гадагш үсрэн буугаад таримал буттай замд нэг юмнаас нуугдаж байгаа аятай бөхийчихсэн гүйж, алтан тэрэлжний цаагуур орж алга болсноо дахрин гарч ирээд задгай тийш харсан хашаа руу авирч шалавхан цааша даваад яг Хиласын сууж байгаа сэхээвч чиглэн ураадан гүйв.

Аймаар юм бодож сандарсан Хилас –Ай бурхан минь! гэж дуу алдаад –Энэ лав өнөөх гайхал, үл үзэгдэгч хүн нь биз. Нээрэн үнэн байх нь ээ! гэв. Хилас ингэж бодсоноос хойш арга эрэх хэрэгтэй гэж үзээд гэрийн зүг чадал мэдэн харайв. Үүнийг дээд давхраас тогооч нь ажиглаж их гайхав.

-Юунаас ингэж айсан юм бол? Яагаад ухаан зулааггүй ингэж гүйнэ вэ? гэнэ.

Хилас гүйж ирээд хаалгаа тархийтэл хааж, хнх дуугарган:

-Хаалга үүдээ хаа! Цонхоо хаа! Цөмийг хааж түгж! Үл үзэгдэгч ирж явна! гэж хоолой мэдэн хашгирав. Тэднийхэн цөм хөл үймээн бол хашгиралдан бужигнав. Хилас өөрөө гүйн харайж тагтныхаа хаалгыг хаахаар очиход сараалчин хашаан дээгүүр доктор Кемпийн толгой, мөр өвдөг харагдав. Төдхөн доктор Кемп ногоо тарьсан газраар туучин, теннисийн талбайгаар гүйсээр байшинд нь хүрч ирэв.

-Болохгүй гэж Хилас түгжээгээ оньслох зуур хэлээд –Таныг хойноос чинь хөөж яваа бол би таныг гэртээ оруулж чадахгүй нь ээ. Яая гэх вэ гэв.

Айж сандран нүд нь рой дээрээ гарсан Кемп саравчны цонхны шилэнд нүүрээ нааж үүдийг учир зггүй балбан бариулы нь галзуурсан мэт угзчив. Тэр талаар орж болохгүйг Кемп мэдээд дээгүүр давж цэцэлэгт нь ороод хажуу талын хаалган дээр очив. Тьэгснээ хажуугийн хамар хаалгаар гарч байшинг нэг тойрон замаар орж гүйв. Айж санчин цонхоороо харж байсан Хиласын нүдэнд Кемп харагдахгүй болон далдартал өнөө таримал ногоог бас нэг үл үзэгдэгч хөл хайр найргүй гишгин гарав. Хилас шатаар өгссөн учир уг агнуурын цаашдын явцыг харж чадсангүй. Гэвч дотоод шатныхаа цонхны дэргэдүүр гүйн гартал нь хажуугийн халга нь тархийв.

Кемп замаар ороод өөрийн эрхгүй уруудан гүйсэн учир дөнгөж дөрөв хоногийн өмнө нэг хүн тэгж гүйн байхыг ажлынхаа өрөөний цонхиоор харж байсан бол одоо өөрөө тийм зовлон амсаж авлаа. Кемп гүйн дасгал хийгээгүй их удсан боловч энэ удаа овоо сайн гүйж цроай зүс цйж, хөлс их асгаравч ухаан бодол нь самуураагүй дажгүй байв. Кемп хол хол гүйж үсчин явахдаа хөөж яваа этгээдийнхээ үл үзэгдэгч хөлийг хорлох гэж аль бартаатай, эвгүй нарны гэрэлд гялалзан харагдах шилний хагархайтай газраар гүйж явлаа.

Тэр ухаагийн зам маш урь эл хуль, хормойд нь байгаа хотын зах ер бишийн хол байдгийг Кемп насандаа анх удаа мэжээ. Гүйх шиг хэцүү, удаан, зам хороодоггүй хөдөлгөөн байдаггүй аж. _ Үдийн наранд дүнсийн харагдах байшин барилгууд цөм жин тан хаалттай, түгжээтэй харагдана. Өөрийх нь заавраар л тийм байгаа ажээ. Хжуудаа юу болж байгааг харах хүн ганц ч билээ гараасай. Алсад хотын бараа харагдан тэнгис далдарч, тээр догуур хүмүүс үзэгдэх болов. Тэртээ нэг ухаагийн хормой руу нэг морин трамвай явж байна. Тэнд цагдаагийн газар байдаг. Гэтэл ар талд нь юу дуулдав, хүний хөлийн чимээ юу? Бушуулаарай.

Хүмүүс өөрийг нь хараад нэг хоёр нь зугатан цааш гүйж эхлэв. Кемпийн амьсгаа давхцан хэрчигнэж эхлэв. Морин трамвайд ойртлоо. “Наргиантай крикетчүүд” гэсэг архи пивоны газрынха үймэлдэж үүд хаалгаа хааж эхлэв. Морин трамвайн ар талд намаг хатаахад хэрэглэх овгр товгор, хагархай чулуу хайрга харагдаж байлаа. Кемп тэр морин трамвайн дотор гүйж ороод хаалгы нь хаачихъя гэж бодсоноос болиод шууд цагдаагийн газар луу гүйжээ. Төдхөн “Наргиантай крикетчүүд”-ийг өөгөрөн гудамжны үзүүр хүрээд хүмүүсийн дотор оров. Морин трамвайн улаач, туслах хоёул морьдоо хөллөөстэй хэвээр орхиод ум хумгүй сандчин гүйх Кемпийг гайхан зогсчээ. Овоолгоостой чулуун цаанаас тэнд ажил хийж байсан хүмүүс мөн гайхан харжээ.

Кемп, хурдаа ялимгүй сасан боловч мөрдөгчийн хөлийн чимээ пад пад ойртон дуулдахад ахин хурдлав.

-Үл үзэгдэгч хүн! гэж Кемп хашгиран ар тийшээ, учир нь үл мэдэгдэхээр заагаад суваг дээгүүр дажгүй харайн гарч хэдэн булиа эрийн цаагуур оров. Кемп цагдаагийн газар очихоо больж нарийн гудамжаар орж ногоо худалдагчийн тэрэгний дэргэдүүр гүйн өнгөрч, боов чихрийн мухлагийн үүдэнд жаахан тээнэгэлзсэний, гол гудамж ордог модтой гудамжаар орж гүйв. Модон дотор тоглож байсан хүүхдүүд түүнийг хармагц тал тал тийш бутран зугтав. Зарим айлын цонх нээгдэж уурласан эхчүүд түүний хойноос хараал тавин хашгирч байлаа. Кемп дахин морин трамвайн буудлаас нэлээд зайтай Килл-Стрит гудамж руу гүйхэд маш, лон хүн үймэлдэн хашгиралдан зүг зүг бутрах харгджээ.

Кемп ухаагийн наадхи гудамж тийш хялахмхийн харав. Том биетэй нэг чулуучин эр хойно нь тун ойрхон чанга хашгичин хүрзээ хүчлэг далайж явна. Түүний хойноос морин трамвайн кондуктор гар зангидан гүйж явна. Тэр хоёрын хойноос өөр хүмүүс чанга чанга хашгиралдан нэг юм руу далайн цохих харагдлаа. Нөгөө талаас хотын зүг бас бүстэй бүсгүй хүмүүс яаран гүйж байх ба нэг мухлагаас гартаа муна барьсан нэг хүн гүйн гарахыг Кемп харав.

-Бүслээд аваарай! Бүслээд аваарай гэж нэг хүн хашгирна. Уг байдал одоо ямар болсон учрыг Кемп ухаарав. Кемп амьсгаа давхцан арай ядан зогсож байлаа.

-Өнөөх чинь энэ хавьд л байна, бүслээрэй гэж Кемп хашгирав.

Гэтэл Кемпийн чих рүү нэг хүн чанга цохиход Кемп гуйвран унах дөхөж дайсан руугаа эргэн ноцох гшэж оролдсон боловч хий цохиж өөрөө арай л ойччихсонгүй. Гэтэл үл үзэгдэгч хүн эрүү рүү нь дэлсэн унагаагаад орон дээр нь өвдөглөж багалзууры нь хоёр гараараа шахав. Нэг гар нь хүч муутай байжээ. Кемп үл үзэгдэгч хүний царвууг хар чадлаараа базлахад цадхи нь чанга гэгч ёолов.

Гэтэл Кемпийн толгой дэгүүр чулууны хүрз гялсхийн нэг юм онов. Кемпийн нүүрэн дээр нэгэн шингэн юм дусчээ. Багалзуурдаж байсан гар ч сулраад өгөв. Кемп арай чарай босож дайсныхаа зөөлөн болсөн мөрнөөс барьж дарж ойчин үл үзэгдэгч толгойг дарав.

Тэгээд

-Би бариад авлаа! Туслаасрай! Туслаарай! Өнөөх чинь энд байна! Хөлөөс нь бариад аваарай! Гэж хашгирав.

Тэр тэмцэл болсон газар үй түмэн хүн агшин зуур цуглан иржээ. Учры нь олоогүй хүн бол хөл бөмбөгний сүрхий ширүүн тэмцээн болж байгаа юм байна гэж бодох биз ээ.

Кемпийн ярьснаас хойш дуугарсан ярьсан хүн ер гарсангүй, харин цохиж нүдэх, хөлөөр дэвслэх чимээ хүний давхацсан амьсгаа сонсдож байв.

Үл үзэгдэгч хүн ер бишийн хүч гарган хэдэн хүнийг түлхээд босож чадсан байна. Кемп буга гөрөөсөнд ассан анч нохой шиг зуурчихаад ер салсангүй. Үл

үзэгдэгчийг өдий төдий оло н мянган гар урж, нүдэж сэглэв. Морин трамвайн кондуктор түүнийг багалзуурдан бариад дахин унагав. Дахиад л нэг газар шавааралжээ. Үнэнийг хэлэхэд даанч хайр гамгүй нүдэцгэжээ. Гэнэт:

-Амь өршөөгөөч! Амь өршөөгөөч! гэсэн аймаар дуу гарснаа төдхөн сулхан ёолох дуугаар солигдон чимээ тасрав.

-Хойшоо болцгоо, малууд аа! гэж Кемп сөөнгө дуугаар хэлэхэд хүмүүс арагш болов. Шархадсан байна,, та нар хойшоо болцгоо!

Зодоонд улайрсан хүмүүс жаахан гэдрэглэхчээ болоход Кемп газраас арван таван ямхын төдий хөндий харагдах бөгөөд үл үзэгдэгч хүний гарыг дарна. Нэг цагдаа үл үзэгдэгч хүний хөлөөс зуурчээ.

-Битгий тавиарай! гэж нөгөө бүдүүн чулуучин хашгирч цус нөж болсон хүрэээрээ далай

-Залилж байгаа юм шүүл, наадхи чинь гэв. Кемп , их л болгоомжтойгоор өвдгөө дээшлүүлж –Залилаагүй, гэсэн ч би тавилгүй барьж байя гэв. Кемпийн црай хөхөрч, хавдаж эхэлсэн байна. Хэл нь эдэрч, уруулаас нь цус гарна. Кемп өрөөсөн гараа суллаж үл үзэгдэгч хүний нүүрийг тэмтрэх шиг харагдана. Тэгээд –Ам нь шал нойтон байна, -Ай бурхан минь! гэлээ. Тэгснээс гэнэт босон харайж дахиад сөгдөв. Хүмүүс дахин шахцалдан бүчиж, сонирхн гүйдэж, ирэх хөлийн чимээ сонсоно. Байшин бүрээс хүн гарч байв. “Наргиантай крикетчүүд”-ийн хаалга цэлийтэл нээгджэ. Харин хүмүүсийн ярилцах нь бага байв. Кемп, хий агаарт юм тэмтэрч харагдсанаа

-Амьсгалаа хураажээ, зүр нь цохихгүй байна. Хажуу бие нь, аяа! гэв.

Нэг чавганц өнөөх булиа чулуучны суган догуур шагай, мойног хуруугаараа зааж гэнэт чанга дуугаар

-Хараач! Хараач! гэв. Хүмүүс харвал хөдөлгөөнгүй гарын дүрс газарт цийлэгнэн тодорч, яг шил шиг бөгөөд үх нарийн бүдүүн судас, яс шөрмөс нэгд нэгэнгүй илэрчээ. Тэгснээ хүмүүсийн харсаар байтал тунгалаг байдлаа алдаж барайн харлаж эхлэв.

-Хүүеэ! Хөл нь харагдаж эхэллээ шүү! гэж цагдаа дуугарав.

Ийнхүү гар хөлөөс эхлэн бүх эрхтэн нь аажмаар үзэгдэх болж бүх биеийн дүрс илэрчэ. Биех биеэр нь хор гүйн тарж буй юм шиг харагдана. Эхлээд нарийхан судас шөрмөсүүд үзэгдэн биеийн ерөнхий дүрсийг бий болгон дараа нь манан шил шиг бүрэлзсэн улчин, арьс зэгдээд яваандаа нягтран бараавтар болов. Төдхөн хэндэг нь хэмх дарагдсан, мөр нь гэмтсэн, нүүр царай нь шархдаж гэмтсэн байдал ялгаран харагдах болов. Хүмүүс гэдрэглэн зай тавихад Кемп эгцлэн зогсов. Гучаад насны хүний нүцгэн, эрэмдэг сэглэгдсэн бие газар хэтэж байгааг хүн бүр олж харав. Үс сахал нь өндөр настныхтай адил цал буурал биш чандган цагаан, нүдп нь ув улан байв. Гараа тэс атгаж, нүд нь харсан хэвээр, царайд нь уур хилэн, цөхөрч тарчилсан байдал харагдана.

-Нүүрий нь бүтээгээч! Ай бүү үзэгд Нүүрий нь бүтээгээч! гэж нэг хүн хэлэв.

“Наргиантай крикетчүүд” мухлагаас цагаан даавуу авчирч биеийг нь бүтээгээд байшинд оруулав.

Тийнхүү харанхуй шахам давчхан өрөөнд ор дэвсгэрийн оронцог болсон юман дээр нүд хальтрам шархдаж сэглэгдсэн хүүр үймж шуугих өөдгүй олон хүний шохоорхол дунд хэвтэх нь урвагч хар санааны нүнжиггүйн балгаар амь алдсан Гриффин мөн бөгөөд энэ бол анх удаа өөрийгөө үзэгдэхгүй болгосон хүн, дэлхийд урьд хожид үзээгүй хамгийн авъяаслаг физикч Гриффин өөрийнхөө хачирхам аймшигт хүсэл зорилгоо хэмгүй сүйрлээр ингэж төгөсгөсөн нь болой.

ТӨГСГӨЛ

Үл үзэгдэгч хүний хийсэн ер бишийн бөгөөд хөнөөл ихтэй туршлагын тухай тууж ингээд төгсөж байгаа юм. Хэрэв та цааш нь лавтайхөн мэдэж авъя гэвэл Порт-Стоугийн дэргэдэх жижигхэн гуанзад ороод эзэнтэй нь ярилцаарай. Тэр гуанзны таних тэмдэг нь бүрх малгай, шаахай зураастай хоосон самбар, хаяг нь энэ номын гарчиг юм.

Гуанзны эзний бие тагдгар, хамар монцгор, үс нь хялгаслаг ширүүн, нүүр нь улаах савхтай. Тэнд ороод архи дарс хичнээн уувал дээр өгүүлсэн явдлаас хойш юу болсныг танд төчнөөн их ярьж өгнө, бас түүнээс олдсон мөнгий нь шүүгчид хурааж авах гэж оролдсон тухай ярьж өгнө.

-Тэр мөнгө чухам хэнийх байсныг нь олохгүй болохтойгоо зэрэг намайг газраас малтаж олсон олзтой хүн мэтээр үзэх гэдэг байна шүү, бурхан минь, та өөрөө хараад үз л дээ, би газар доороор малтаж гаргасан олж шиг байна гэж үү? Намайг нэг эрхэм, Эзэнт төрийн хөгжмийн их танхимд аваачиж үзсэн харсныг минь нэгд нэггүй яриулаад орой бүр нэг гиней өгдөг байв” гэх байх даа.

Хэрэв та ярихы нь зогсооё гэвэл тэр явдалд чинь гар бичмэл гурван дэвтэр холбогдсон байна уу, үгүй юу гэхэд л болох нь тэр. Тэгвэл тийм ном дэвтэр байх нь байсан, харин тэр нь надад байгаа байх гэж зарим нь боддог, надад үнэхээр байхгүй шүү. Үл зэгдэгч хүн өөрөө надаас булаагаад авчихсан, намайг Порт-Стоу руу зугатаж байхад булаагаад авчихсан. Надад байгаа гэж Кемп носн худал хэлж байгаа юм гэнэ. Тэгээд бодол болон зогсож, таныг хулгай нүдээрээ ажиглан, шилэн аягуудыг байн байн арчиж байснаа гараад явчихна. Энэ хүн бол ганц бие, өвгөн хүн, дандаа гоонь явсан учир тэднийд бүсгүй хүн ганц ч байдаггүй. Түүний гадуур хувцас нь товчтой /энэ бол түүний ажлын байдлаас аргагүй болдог/ боловч татуурга гэх мэтийн дотуур элдэв бусын хэрэгсэл нь товчгүй, дандаа оосор бүчтэй байдаг ажээ. Ажилдаа авхаалж муутай боловч гуанзныхаа нэрийг сүрхий бодно. Хөдлөх барих нь болхи, элдвийн юм бясалгах царайтай. Хавийнх нь хүмүүс түүнийг уран ухаантай хүн гэнэ, гамнаач, арвич занг нь хэн бүр хүндэтгэнэ. Өмнөд Английн зам харгуйн тухай ямар ч тайлбарчаас илүү мэднэ.

Жилийн ямар ч улиралд гадна ертөнцтэй холбоо бүр тасрах үедаа ням гаригийн өглөө, ням гариг бүрийн өглөө өдөр бүр оройн арван цагаас хойш мань эр, ялимгүй шингэлсэн жин архи нэг шил аяга хийж аваад гуанзныхаа гийчин хүлээж авах өрөөнд орж аягатай архиа нэг юман дээр тавиад үүдээ түгжиж, цонхныхоо хөшгийг шалгаж, бас ширээн доогуураа шагайж харна. Тэгээд өөрөө үнэхээр ганцаараа байгаа юм байна гэж лавтай итгэмэгцээ нэг шүүгээний цоож онгойлгон

цоожтой хайрцаг гаргаж ирээд хайрцагныхаа шургуулга дотроос хүрэн өнгийн гөлөнгөр хавтастай гурван боть гарган авч ширээнийхээ тэг дунд их ёслолын байдалтай тавина. Хавтас нь уучирч ноорсон, зарим газраа хөгцөнд идэгдсэн байна. Яагаад тийм болж вэ гэвэл урьд нэг гуун дотор өнжүүлчсэн юмсанжээ. Тэгээд хэд хэдэн хуудастай үзэг бохир усанд норж арилан балархай болжээ. Гуанзны эзэн түшлдэгтэй зөөлөн сандал дээр сууж урт шавар гансандаа тамхи чихэх бөгөөд тэр гурван дэвтрээс нүд үл салгана. Тэгснээ нэгий нь авч хуудсы нь эргэн эргэн уншиж судалж эхэллээ. Хөмсөг нь атирч уруул нь жимийн хөдлөнө.

-Зургаагийн тоо байх юм, дээр нь жижигхэн хоёр, загалмай, дэгээ ч байх шиг. Ай, бурхан минь, мөн ч толгойтой эр байж шүү! гэнэ. Тэгэхийгээд чархмайлт нь суларч сандлынхаа түшлэгийг налан гэдийж бусдын нүднээ үл үзэгдэх юм харж байгаа мэтээр тамхиныхаа утаан дундуур тасалгааныхаа гүзгий рүү ширтэн –Нууц юм хичнээн их байна. гайхмаар нууц юм байна! Учры нь олох юм бол. Бурхан минь! Би тэрүүн шиг тэгэхгүй дээ. Би л бол ... ээ! гэж хэлээд тамхиа нэрнэ. Тэгээд амьдралынхаа арилж мөхөшгүй ид шидэт хүслэнгийн тухай бясалга сууна. Цуцахыг эс мэдэх Кемп хичнээн эрж хайвч үл үзэгдэх чанарын болон бусад гайхамшигтай нууцыг хадгалсан тэр хэдэн дэвтэр хаана буйг тэрхүү гуанзны эзнээс өөр хэн ч мэдэхгүй, түүнийг амьд мэнд яваа цагт өөр хэн ч мэдэж чадахгүй ажээ.

ТӨГСӨВ.

Эх сурвалж:

www.e-pada.com

Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf хэлбэр уруу хөрвүүлсэн:

The Weatherman

<http://weatherman.blog.baniig.net/>